

ЕСҮС ХРИСТИЙН  
ХОЖМЫН ҮЕИЙН  
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

Хагас жил  
тутмын 182 дахь  
Ерөнхий  
Чуулган

*2012 оны 10-р сарын 6–7*

Хэвлэсэн  
Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм  
Юта муж, Солт Лейк хот

© 2012 Intellectual Reserve, Inc.  
Бүх эрх хамгаалагдсан

Англи эхийн зөвшөөрөл: 12/11  
Орчуулгын эрх: 12/11  
*182nd Semiannual General Conference*-н орчуулга  
Mongolian  
PD50045288 000

---

# Гарчиг

## БЯМБА ГАРАГИЙН ӨГЛӨӨНИЙ ХУРАЛДААН

Чуулганд тавтай морилно уу   <i>Томас С.Монсон</i> .....	1
Та нар одоо тийн мэдэрч чадаж байна уу?   <i>Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын</i> .....	5
Би үүнийг мэднэ. Би үүний дагуу амьдардаг. Би үүнд хайртай.   <i>Анн М.Дибб</i> .....	14
Бурханы өгүүлшгүй бэлэг   .....	20
“Би амьд учраас, Та нар ч мөн амьд”   <i>Далын гишүүн</i> .....	26
Номлогч нараас асуу! Тэд танд тусалж чадна!   <i>Рассел М.Нелсон</i> .....	33
Харуусал ба шийдвэрүүдийн талаар   <i>Тэргүүн Зөвлөлийн Хоёрдугаар Зөвлөх</i> .....	41

## БЯМБА ГАРАГИЙН ҮДЭЭС ХОЙШХИ ХУРАЛДААН

Сүмийн албан тушаалтнуудыг дэмжүүлэн баталсан нь   <i>Хенри Б.Айринг танилцуулав</i> .....	50
Сайн эцэг эх болох нь   <i>Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын</i> .....	52
Санаа сэтгэлээ бүрэн зориулсан байх нь   <i>Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын</i> .....	59
Надад ирэгтүн, Ай Израилын угсаа Та нар!   <i>Далын</i> .....	66
Амиа сольж авахын тулд хүн юугаа өгөх юм бэ?   <i>Далын</i> .....	71
Ариун сүмийн стандарт   .....	77
Итгэлийн тань сорилт   <i>Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын</i> .....	82
Хүүхдүүдээ хамгаал   <i>Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын</i> .....	90

## САНВААРТНЫ ХУРАЛДААН

Ах нар аа, бидэнд хийх ажил байна   <i>Арванхоёр Төлөөлөгчийн Чуулганы</i> . . . . .	99
Зориг, хүч чадал хийгээд эрч хүчээрээ үлэмж баатарлаг бай   <i>Тэргүүлэх Бишоп</i> . . . . .	108
Өөрсдийн талаар болгоомжтой бай   <i>Далын</i> . . . . .	114
Санваартан хүний баяр баясгалан   <i>Тэргүүн Зөвлөлийн Хоёрдугаар Зөвлөх</i> . . . . .	122
Өндөр зорилго тавихад нь хүүхдүүддээ тусал   <i>Тэргүүн Зөвлөлийн Нэгдүгээр зөвлөх</i> . . . . .	130
Бусдыг ирээдүйд ямар хүмүүс болсон байхаар нь харж сур   <i>Томас С.Монсон</i> . . . . .	140

## НЯМ ГАРАГИЙН ӨГЛӨӨНИЙ ХУРАЛДААН

Асар хаана байна вэ?   <i>Хенри Б.Айринг</i> . . . . .	149
Цагаатгал   <i>Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын</i> . . . . .	158
Эхлээд ажигла, тэгээд үйлчил   <i>Линда К.Бертэн</i> . . . . .	165
Зүрх сэтгэлээрээ сурах нь   . . . . .	171
Эхний агуу зарлиг   <i>Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын</i> . . . . .	176
Адислалуудын тухай тунгаан бод   <i>Томас С.Монсон</i> . . . . .	182

## НЯМ ГАРАГИЙН ҮДЭЭС ХОЙШХИ ХУРАЛДААН

Илүү Христтэй адил Христийн шашинтан байх нь   <i>Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын</i> . . . . .	190
Нас барагсдын авралаас ирдэг баяр баясгалан   <i>Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын</i> . . . . .	196
Аврагчид нэг алхмаар ойртох   <i>Рассел Т.Осгуторн</i> . . . . .	203
Итгэлээр бүх зүйл гүйцэлддэг   <i>Далын</i> . . . . .	209
Жинхэнэ шавь болох нь   <i>Далын</i> . . . . .	215
Ариун ёслолын адислалууд   <i>Далын</i> . . . . .	220
Их Эзэнд хөрвүүлэгдэв   <i>Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын</i> . . . . .	226
Биднийг дахин уулзтал Бурхан та нартай хамт байх болтугай   <i>Томас С.Монсон</i> . . . . .	234

## НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН БҮЛГИЙН ЕРӨНХИЙ ЧУУЛГАН

Есүс Христийн цагаатгалд итгэх итгэл бидний зүрхэнд бичигдсэн үү?   <i>Линда К.Бөртэн</i> .....	237
Үүрэг хариуцлагадаа үлэмж сэргэг байх нь   .....	246
Их Эзэн та нарыг мартаагүй   <i>Линда С.Ривис</i> .....	253
Халамжлагч   <i>Тэргүүн Зөвлөлийн Нэгдүгээр зөвлөх</i> .....	259



# Чуулганд тавтай морилно уу

Ерөнхийлөгч Томас С.Монсон

---

*Бид Их Эзэний сүнсийг мэдэрч, биднийг мэдээсэй хэмээн түүний хүсч байгаа тэдгээр мэдлэгүүдийг хүлээн авч болохын тулд захиасуудыг анхааралтайгаар сонсоцгооё.*

---

Миний харж байгаагаар арын хэдэн суудлаас бусад нь бүгд дүүрсэн байна. Энэ нь үлдсэн хүмүүст зориулсан суудал бөгөөд замын түгжрэлээс болж бага зэрэг хоцорч ирэх тэдэнд суудлаа олох сайхан боломж юм.

Энэ бол гайхамшигтай - чуулганы өдөр билээ. Бид гайхамшигтай найрал дуу дуулахыг мөн сүр жавхлантай хөгжмийг сонслоо. Би найрал дуу, үлээвэр хөгжим эсвэл төгөлдөр хуур сонсох болгондоо, ээжийнхээ надад хэлсэн “чамд өгөгдсөн бүх зүйлд, чиний эзэмшсэн мэдлэгт болоод чиний хийсэн бүх ажилд би хайртай. Гэвч миний харамсдаг ганц зүйл бол чиний төгөлдөр хуураа орхисон явдал юм” гэж хэлдэг байсныг би санадаг. Баярлалаа ээжээ, Би төгөлдөр хуураа орхиогүй ч байсан болоосой.

Ах эгч нараа та бүхнийг Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн хагас жил тутмын 182 дахь ерөнхий чуулганд тавтай морилно уу гэж урихдаа би баяртай байна.

Зургаан сарын өмнө биднийг уулзсанаас хойш гурван ариун сүм онцгойлон адислагдаж, нэг ариун сүмийг дахин онцгойлон адисаллаа. Тавдугаар сард Канзас хот дахь

Миссурийн үзэсгэлэнт Ариун сүмийг онцгойлон адисалж, энэ үйл явдлыг тэмдэглэсэн соёлын үйл ажиллагаанд оролцох онцгой аз завшаан надад тохиосон билээ. Энэхүү соёлын үйл ажиллагааны тухай би маргаашийн хэлэх үгэндээ маш дэлгэрэнгүй ярих болно.

Бразилчуудын удаан хүлээсэн Манаусын ариун сүмийг Ерөнхийлөгч Диетер Ф.Угдорф зургадугаар сард онцгойлон адисалсан бол, Ерөнхийлөгч Хенри Б.Айринг 9-р сарын эхээр Аргентины Буэнос Айрес дахь шинэчлэн засварласан ариун сүмийг дахин онцгойлон адисаллаа. Энэ ариун сүмийг 27 жилийн өмнө онцгойлон адислах аз завшаан надад тохиосон билээ. Ердөө хоёрхон долоо хоногийн өмнө Ерөнхийлөгч Бойд К.Пакер өөрийнхөө төрж, өссөн Бригам хотод үзэсгэлэнт сайхан ариун сүмийг онцгойлон адисалсан.

Сүмийн барилга байгууламжуудаас хамгийн чухал, хамгийн агуу ач холбогдолтой нь ариун сүм юм гэдгийг миний бие өмнө нь мэдэгдэж байсан. Өнөөдөр дэлхий даяар үйл ажиллагаа явуулж байгаа 139 ариун сүм бидэнд байна. Зарлагдсан буюу баригдаж байгаа ариун сүм 27 байна. Эдгээр ариун барилга байгууламжуудын төлөө, бидний амьдралд эдгээрийн авчирдаг адислалуудын төлөө бид баярлан талархаж явдаг.

Өнөөдөр өглөө би ирэх жил саруудад баригдах хоёр шинэ ариун сүмийг зарлаж байгаадаа таатай байна; эдгээр нь Аризона мужийн Тюсон хотод мөн Перу улсын Арикюпа хотод баригдана. Шаардлагатай зөвшөөрлүүдийг авсны дараа тодорхой нарийвчилсан мэдээллийг хойшид гаргах болно.

Ах эгч нар аа, би одоо номлолын үйлчлэлд анхаарлаа хандуулан, тэр талаар ярья.

Тэргүүн Зөвлөл болон Арван Хоёр Төлөөлөгчийн Чуулгаас хэсэг хугацааны туршид, 18 нас хүрсэн, дунд сургуулиа төгссөн, зохистой, чадвартай, мөн үйлчлэх чин хүслээ илэрхийлсэн залуу эрэгтэйчүүдэд номлолд үйлчлэхийг нь тодорхой хэдэн оронд зөвшөөрсөөр ирсэн билээ. Энэ нь тухайн улс орны нөхцөл байдлаас үндэслэсэн бодлого бөгөөд мянга мянган залуу эрэгтэйчүүдийг номлолдоо хүндэтгэлтэйгээр үйлчилж мөн цэрэгт үйлчлэх шаардлагат



үүрэг хариуцлага болон боловсрол олох боломжийг нь гүйцээж өгч байсан.

18 настай номлогч нарын талаарх сэтгэгдэл маань өөдрөг байлаа. Тэд нарын номлолын ерөнхийлөгч нар нь тэднийг дуулгавартай, итгэлтэй, төлөвшсөн мөн адилхан номлолд үйлчилж байгаа өөрсдөөс нь арай ах номлогч нартай л адилхан үүрэг гүйцэтгэх чадвартай гэж бидэнд мэдэгддэг. Тэдний итгэлтэй байдал, дуулгавартай байдал болон төлөвшсөн байдал нь, аль ч улс орных байсан хамаагүй, бүх залуу эрэгтэйчүүдэд илүү эрт номлолд үйлчлэх тэрхүү боломжийг өгөх хүслийг бидэнд төрүүлсэн юм.

Яг одооноос эхлэн, бүх зохистой мөн чадвартай залуу эрэгтэйчүүд, дунд сургууль юм уу түүнтэй тэнцэх сургуулиас төгссөн бол, хаана амьдарч байгаагаасаа үл хамааран, 19 настайгаасаа биш, харин 18 настайгаасаа эхлэн номлолын үйлчлэлд үйлчлэх боломжтой болж байгааг би зарлан мэдэгдэхдээ баяртай байна. Бүх залуу эрэгтэйчүүд энэ илүү залуухан насандаа үйлчлэх ёстой гэж би хэлж байгаа юм биш. Харин, өөр өөрсдийн хувийн нөхцөл байдал дээр үндэслэн, мөн санваартны удирдагч нарын шийдвэр дээр үндэслэн, энэ боломжийг бүгдэд олгож эхэлж байгаа юм.

Залуу эрэгтэйчүүд хэдэн насандаа номлолд үйлчилж эхэлж болох талаар залбиралтайгаар эргэцүүлэн бодож байх зуураа, түүнчлэн бид залуу эмэгтэйн үйлчилж болох насын талаар мөн эргэцүүлэн бодож үзсэн билээ. Өнөөдөр, үйлчлэх хүсэлтэй, зохистой, чадвартай залуу эмэгтэйчүүдийн номлолын үйлчлэлд үйлчилж болох насыг 21 нас биш, харин 19 нас болгон өөрчилж байгааг зарлан мэдэгдэж байгаадаа баяртай байна.

Номлогчийн ажил бол санваартны үүрэг хариуцлага бөгөөд би зохистой, бие махбодийн болон оюун ухааны чадвартай бүх залуу эрэгтэйчүүдийг үйлчлэх дуудлагад хариулаач хэмээн бид урамшуулж байна. Олон залуу эмэгтэйчүүд мөн үйлчилдэг хэдий ч, тэд нар залуу эрэгтэйчүүдийн адил тэгэх шаардлагатай биш юм. Гэхдээ, Сүмийн залуу эгч нар номлогчийн ажлаараа маш үнэтэй хувь нэмэр оруулдаг болохоор бид тэдний үйлчлэлийг дуртайгаар хүлээн авах болно гэдгийг бид баттайгаар хэлж байна.

Бидэнд гэр бүлийн улам олон ахмад номлогчид хэрэгтэй байна. Та бүхнийг тэтгэвэрт гарсныхаа дараа амьдралын нөхцөл, боломж, эрүүл мэндийн байдлаа харгалзан бүрэн цагийн номлолын үйлчлэл хийхэд би уриалан дуудаж байна. Тэнгэрлэг Эцэгийнхээ хүүхдүүдэд хамтдаа үйлчилснээр нөхөр, эхнэр хоёул агуу баяр баяслыг олох болно.

Ах эгч нар аа, ирэх хоёр өдөр бидэнд өгөгдөх захиасуудыг бүгдээрээ анхааралтай сонсож, Их Эзэний Сүнснийг мэдрэн, бидэнд эзэмшүүлэхийг Түүний хүсдэг мэдлэгийг эзэмшихийн төлөө шамдан хичээцгээе. Үүний төлөө би Есүс Христийн нэрээр залбирч байна, амен.

---

# Та нар одоо тийн мэдэрч чадаж байна уу?

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын

Ахлагч Квинтин Л.Кук

---

*Сүмийн зарим гишүүд Алмагийн асуултанд тийм хэмээн баттайгаар хариулж чадахгүй байгаад гайхах зүйл алга. Тэд гэтэлгэлийн баяр баясгаланг “одоо мэдрэхгүй” байна.*

---

Ерөнхийлөгч Монсон бид танд хайртай бөгөөд таныг хүндэтгэн, дэмждэг. Номлогчийн үйлчлэлийн талаарх энэхүү түүхэн ач холбогдолтой мэдэгдэл нь үнэхээр сэтгэл хөдөлгөм байлаа. 1960 онд номлолд үйлчлэх номлогч нарын насыг 20 байсныг 19 болгон өөрчилсөн тухай би санаж байна. Тэр үед би Английн номлолд дуудагдсан 20 настай шинэхэн номлогч байв. Манай номлолд ирсэн хамгийн анхны 19 настай номлогчоор гайхалтай номлогч болох Ахлагч Жеффри А.Холланд 20 нас хүрэхээсээ хэдхэн сарын өмнө ирсэн юм. Түүнээс хойш нэг жил орчмын хугацаанд манай номлолд 19 настай олон номлогч ирсэн. Тэд дуулгавартай, итгэлтэй номлогчид байсан бөгөөд номлолын ажил ч маш урагштай байсан. Зөв шударга бас номлогчийн ажилдаа үнэнч номлогч нар Аврагчийн сайн мэдээг зааж, Түүний зарлигуудыг биелүүлж, илүү их ургацыг хураах болно гэдэгт би итгэлтэй байна.

Миний бодлоор та нарын энэ үеийнхэн урьд урьдны бүх үеийн залуучуудаас илүү сайн бэлтгэгдсэн. Ялангуяа судрын талаарх та нарын мэдлэг үнэхээр гайхалтай. Хэдий тийм боловч, номлолд үйлчлэхээр зэхэж буй та нарт тулгарч буй сорилт бэрхшээлүүд нь Сүмийн бүх гишүүдэд тулгарч буй сорилт бэрхшээлүүдтэй ижил байдаг. Дэлхийн ихэнх соёл, ёс

заншил нь зөв шударга бас сүнслэг байдалтай нийцдэггүй гэдгийг бид бүгдээрээ мэднэ. Түүхийн туршид Сүмийн удирдагчид хүмүүст анхааруулж мөн наманчлалын тухай заасаар ирсэн. Мормоны Номын залуу Алма шударга бус, хариуцлагагүй хүмүүсийн төлөө ихэд санаа зовнин, Нифайн хүмүүсийн удирдагч буюу ерөнхий шүүгчийн суудлаасаа татгалзан, хамаг хичээл зүтгэлээ өөрийн бошиглолын дуудлагад зориулсан юм.<sup>1</sup>

Судар дахь хамгийн мэргэн шүлгүүдийн нэгэнд Алма “Хэрэв та нар зүрх сэтгэлийн өөрчлөлтийг эдэлсэн бол, мөн хэрэв та нар гэтэлгэх хайрын дуут дуулмаар санагдсан бол, би асууя, та нар одоо тийн мэдэрч чадна уу?”<sup>2</sup> хэмээн тунхагласан байдаг.

Сүмийн гишүүд, ялангуяа залуучууд маань хэзээ ч өнөө үеийнхэн шиг ийм хүчирхэг байгаагүйг дэлхий дахины орон нутгийн удирдагчид цохон тэмдэглэж байна. Гэхдээ тэдгээр удирдагчид хоёр асуудлын талаар санаа зовнидог: нэгдүгээрт, дэлхийд шударга бус байдал ихэссээр байгаад, хоёрдугаарт, зарим гишүүдийн хайхрамжгүй байдал буюу Сүмээ гэсэн сэтгэл дутмаг явдал. Аврагчийг дагаж, бат бөх бөгөөд үүрдийн хөрвөлтийг хүлээн авахад нь гишүүдэд хэрхэн туслах талаар тэд санаа тавьж байна.

“Та нар одоо тийн мэдэрч чадна уу?” гэсэн асуулт олон зуун жилийн дараа ч чухал хэвээр байсаар байна. Есүс Христийн сайн мэдээний бүрэн байдлын Сэргээлт, асар олон сүнслэг бэлгүүд, тэнгэрийн маргашгүй адислалууд зэрэг энэ эрин хүлээн авсан бүх адислалуудаа бодоод үзэхээр Алмагийн уг асуулт бидэнд хэзээ хэзээнээс илүү чухлаар тавигдаж байна.

1943 онд Эзра Тафт Бенсон Төлөөлөгчөөр дуудагдсаны дараахан Ерөнхийлөгч Жорж Алберт Смит<sup>3</sup> түүнд “Чиний үүрэг бол . . . аль болох эелдэгээр энэ дэлхийн өвчлөлтүүд буюу зовлон зүдгүүрээс анагаах цорын ганц эм нь наманчлал байх болно гэдгийг. . . хүмүүст анхааруулах явдал юм”<sup>4</sup> хэмээн зөвлөсөн байдаг. Энэ мэдэгдлийг хийх үед бид Дэлхийн II дайны аюулд жинхэнэ нэрвэгдсэн үе байлаа.

Өнөөдөр ёс суртахуунгүй байдал дэндүү газар авчээ. Саяхан нэг алдартай зохиолч, “Соёл боловсрол хордож

байгааг хүн бүр мэдэж байгаа ч, хэнд ч үүнийг өөрчлөх хүсэл алга”<sup>5</sup> хэмээн хэлжээ. Орчин цагт өдөр тутам үлгэр дууриалгүй хүчирхийлэл ба ёс суртахуунгүй байдлыг дуу хөгжим, үзвэр, урлаг ба бусад хэвлэл мэдээллээр дүрслэн үзүүлж байна. Бусдын хүндэтгэлийг хүлээсэн Баптист шашны нэгэн номлогч энэ талаар “Бүхэл соёл иргэншлийн сүнслэг дархлааны систем шархадсан байна” хэмээн эмгэнэлтэйгээр дүрслэн хэлсэн.<sup>6</sup>

Сүмийн зарим гишүүд Алмагийн асуултанд тийм хэмээн баттайгаар хариулж чадахгүй байгаад гайхах зүйл алга. Тэд гэтэлгэлийн баяр баясгаланг “одоо мэдрэхгүй” байна. Тэд сүнслэг байдлын ган гачигт оржээ. Зарим гишүүд ууртай, гомдсон эсвэл сэтгэл санааны уналтанд орсон байна. Хэрэв эдгээр дүрслэл та нарыг ямар нэг байдлаар илэрхийлж байгаа бол,<sup>7</sup> яагаад та нар гэтэлгэлийн баяр баяслыг “одоо мэдэрч чадахгүй” байгаадаа дүгнэлт хийх хэрэгтэй байна.

Сүнслэг ган гачигт орсон, тууштай биш олон хүн ноцтой гэм нүгэл буюу зөрчил үйлдэхгүй байгаа ч ухаалаг бус сонголтуудыг хийдэг. Зарим нь өөрсдийн нандин гэрээнүүдэд хайхрамжгүйгээр ханддаг. Зарим нь ихэнх цаг, эрч хүчээ чухал бус, ач холбогдолгүй зүйлст зарцуулдаг. Зарим нь тэдний Есүс Христийн сайн мэдээнд үнэнч байх байдлыг нь сулруулах соёлын эсвэл улс төрийн үзэл бодолд гүнзгий автсан байдаг. Нөгөө хэсэг нь интернетэд хэт автаж, өөрсдийгөө түүнд умбуулсан байхад, зарим гишүүд Сүмийн эртний удирдагчдын дутагдал, өө сэвийг өөртөө давтах нь бий. Дараа нь тэд гэрчлэлд нь муугаар нөлөөлөх буруу дүгнэлтүүдийг гаргадаг. Эдгээр сонголтыг хийсэн аливаа хүн наманчилж мөн сүнслэгээр дахин шинэчлэгдэж болно.

Судруудад умбан орох нь сүнслэг тэжээлд маш чухал ач холбогдолтой.<sup>8</sup> Бурханы үгс тууштай байхыг уриалж, гомдол, уур хилэн болон гутралыг эдгээх эм болж чаддаг.<sup>9</sup> Ямар нэгэн шалтгаанаар тууштай байдал маань сулрах үед наманчлал бидэнд асуудлаа шийдвэрлэхэд туслах болно.<sup>10</sup> Тууштай байдал, наманчлал хоёр хоорондоо нягт холбоотой.

Английн үргэлжилсэн үгийн зохиолч, нийтлэлч, хичээл зүтгэлтэй, прагматик Христийн шашинтан Слайв Стэйл Луис үүний талаар хурцаар ёжлон бичсэн байдаг. Христийн шашин

хүмүүст наманчлахыг уриалж, тэдэнд уучлалыг амладаг хэдий ч хүмүүс уучлах хэрэгтэй юм байна гэдгийг өөрсдөө ухаарч, мэдрэх хүртэл Христийн шашин тэдэнд ярьдаггүй хэмээн мэдэгдсэн. Тэр “Та нар өвдсөн үедээ л эмчийг сонсох болно”<sup>11</sup> гэсэн байдаг.

Бошиглогч Иосеф Смит хэлэхдээ: “Баптисм хүртэхийнхээ өмнө та нар сайн ба муу хоёрын хоорондох завсар байдаг. Харин энэ Сүмийн гишүүн болохдоо та нар Бурханд үйлчлэхээр бүртгүүлдэг. Та нар үүнийг хийсэн бол завсрын байдлаа орхиж, дахин хэзээ ч буцаж [явж] чадахгүй” хэмээн хэлсэн билээ. Үүгээр тэр бид хэзээ ч Эзэнийг орхих ёсгүйг бидэнд зөвлөсөн юм.<sup>12</sup>

Наманчилдаг хүмүүст Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан, “нигүүслийн мутар сунгагдсан” хэмээн Алма онцлон хэлсэн.<sup>13</sup> Дараа нь тэр Та нар Бурхантай уулзахад бэлтгэсэн үү? Та нар өөрсдийгөө толбогүй байлгаж байна уу? зэрэг чухал асуултуудыг асуудаг. Бид бүгд эдгээр асуултын талаар тунгаан бодох ёстой. Өөрийн итгэлтэй эцгийг дагахдаа бүдэрч, дараа нь уучлал түүнд хэчнээн их хэрэгтэйг мэдэрч, гэтэлгэх хайрын дууг дуулах нь ямар утга учиртай болохыг ойлгосон Алмагийн хувийн туршлага хүчирхэг бөгөөд итгэл төрүүлэм билээ.

Тууштай байхад саад болдог маш түгээмэл бөгөөд, том хоёр саад бэрхшээл байдаг. Нэгдүгээрх нь еелдэг бус байдал, уур хилэн ба гэр бүлийн хүчирхийлэл. Хоёрдугаарх нь бэлгийн ёс суртахуунгүй харьцаа ба цэвэр бус бодол санаанууд. Эдгээр нь биднийг тууштай байхад саад болдог.

Эдгээр зүйлд бид хэрхэн хандах вэ? Орон гэртээ уур хилэн, хүчирхийлэл, бүдүүлэг, хүндэтгэлгүй байдал гаргах нь хүлээн зөвшөөрөгдөшгүй зүйл бөгөөд—насанд хүрэгчид болон өсвөр насныханд байж болшгүй зүйл. Аав маань Сүмийн идэвхгүй гишүүн байсан ч ялангуяа ээжтэй харьцдаг байдлаараа гайхалтай сайн үлгэр жишээ үзүүлдэг байсан. Тэр “эрэгтэйчүүд эхнэрийнхээ урсгасан нулимс бүрийн төлөө Бурханы өмнө хариуцлага хүлээх болно” гэж хэлдэг байсан. Үүнтэй ижил “Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг бичигт “Ариун явдлын гэрээгээ зөрчин, хань ижил, үр хүүхэдтэйгээ зүй бусаар харьцсан, гэр бүлийнхээ өмнө хүлээсэн үүргээ

биелүүлээгүй хувь хүн хожмын нэг өдөр Бурханы өмнө өчиг мэдүүлэх болно”<sup>14</sup> хэмээсэн байдаг. Бидний өсч хүмүүжсэн улс орон, орчин ахуйгаас шалтгаалан эсвэл эцэг эх маань биднийг хүчирхийлэн, зүй бусаар харьцдаг байсан гээд бид өөр хэн нэгнийг бие болон сэтгэл санаагаар дарамтлан эсвэл хэл амаар хүчирхийлэн доромжлох ёсгүй.

Өнөө үед эелдэг боловсон харьцаа урьд урьдынхаас илүү шаардлагатай байна. Нинжин сэтгэл ба эелдэг байдлын үндэс суурь бол гэр орноос эхлэлтэй. Гэр бүл салалт, хүмүүсийн ерөнхий зан төлвийн доройтолт хоёр яг ижил түвшинд очсонд гайхах зүйл алга. Гэр бүл бол хайр ба сүнслэг байдлыг хадгалах үндсэн суурь мөн. Гэр бүл бол шашны зан үйл цэцэглэн дэлгэрэх уур амьстлыг дэмжин тэтгэдэг газар. “Гэр бүлийнхэн бие биенээ хайрлах юм бол гэрт үргэлж мөнхөд аз жаргал бялхаж байх болно.”<sup>16</sup>

Бэлгийн ёс суртахуунгүй харьцаа ба цэвэр бус бодол санаанууд Аврагчийн бий болгосон жишигтэй харшилдаг.<sup>17</sup> Бэлгийн ёс суртахуунгүй харьцаа нь бидний хамгийн том саад бэрхшээл байх болно гэдгийг энэ эрин үеийн эхлэлээс л бидэнд анхааруулсан.<sup>18</sup> Наманчлахгүй байх нь сүнслэг байдлын ган гачиг ба тууштай бус байдлын үндэс болдог. Кино, зурагт ба интернетээр ихэвчлэн хор хөнөөлтэй захиас болон дүрсүүдийг нэвтрүүлэн дамжуулж байна. Ерөнхийлөгч Диетер Ф.Угдорф бид хоёр саяхан Амазоны ширэнгэн ой дахь тосгонд очиж, бүр жижигхэн энгийн урцанд хүртэл хиймэл дагуулын антен байхыг харлаа. Энэ алслагдсан газарт мэдээллийн хэрэгсэл ашиглаж байгаад бид баярлаж байлаа. Бид мөн дэлхий дээр бузар булай, ёс суртахуунгүй мөн бэлгийн дур хүслийг өрнүүлсэн дүрс бичлэг хүрээгүй газар гэж үгүйг анзаарсан юм. Энэ нь яагаад порнограф өнөөгийн гай гамшиг, аймшигт тахал болсоны нэг шалтгаан юм.

Би саяхан 15 настай Аароны нэгэн санваартантай гайхалтай яриаг өрнүүлж билээ. Тэр надад интернет ашиглагч залуучууд санамсаргүйгээр хэрхэн маш хялбархнаар цэвэр бус тэр бүү хэл порнографийн дүрснүүдийг үзэж болдгийг тайлбарласан. Тэр Сүмийн заадаг ихэнх зарчмуудыг гуйвуулж мөн тамхи татах, мансууруулах бодис болон согтууруулах

ундааг хэрэглэх нь эрүүл мэнд ба сайн сайхан байдлыг сүйтгэх нөлөөтэйг нийгэмд тодорхой түвшинд ойлгосон байгааг онцлон хэлсэн. Гэвч порнограф эсвэл ёс суртахуунгүй байдлын талаар ямар нэгэн анхааруулга байхгүй байгааг тэр мөн анзаарсан гэдгээ надад хэлсэн.

Хайрт ах эгч нар минь, энэ залуугийн дүгнэлт зөв юм шүү. Хариулт нь юу вэ? Олон жилийн турш бошиглогчид ба төлөөлөгчид гэр орондоо шашны зан үйлийг сахих нь ач холбогдолтой гэдгийг заасаар ирсэн.<sup>19</sup>

Сүмийн цуглаанууд болон хөтөлбөрүүдэд гэр бүлээрээ тогтмол, идэвхтэй оролцох нь маш их ач холбогдолтой ч хүүхдүүддээ ёс суртахуунтай, өв тэгш амьдрах мөн Их Эзэний өмнө үнэнч шударга алхахыг заах нандин үүрэг хариуцлагаа гүйцэлдүүлэхэд хангалттай биш болоод удаж байна. Ерөнхийлөгч Монсоны энэ өглөөний мэдэгдлээс харахад нинжин сэтгэл, уучлал, үнэн ба зөв шударга байдлыг орон гэртээ итгэлтэйгээр төлөвшүүлдэг байх нь маш чухал байна. Эцэг эхчүүд хүүхдүүдийнхээ үзэж сонсдог интернет, зурагт, кино болон дуу хөгжмийг хянах буюу тохиргоо хийх зоригтой байх хэрэгтэй. Эцэг эхчүүд үнэнийг хамгаалж, хүчирхэг гэрчлэлээ хуваалцан үгүй гэж хэлэх зоригтой байх ёстой. Хүүхдүүд тань та нарыг Аврагчид итгэх итгэлтэй, Тэнгэрлэг Эцэгээ хайрладаг мөн Сүмийн удирдагчдыг дэмждэг гэдгийг тань мэддэг байх хэрэгтэй. Гэр оронд тань сүнслэг боловсрол олгогддог байх ёстой. Энэ ерөнхий чуулганаас хүн бүр өнөөгийн ёс суртахууны асуудлуудын талаар гэр бүлээрээ хэлэлцэх ёстой гэдгээ ухамсарлан гарна гэдэгт би итгэж байна. Бишоп, санваартан ба туслах бүлгийн удирдагчид гэр бүлүүдийг дэмжиж, гишүүдийн гэр оронд сүнслэг зарчмууд заагдаж байгаа эсэхэд анхаарах шаардлагатай. Гэрийн болон айлчлагч багш нар эцэг эхчүүдэд ялангуяа хүүхэдтэй ганц бие эцэг эхчүүдэд туслах ёстой.

Миний дээр дурдсан хөвгүүн порнограф ба цэвэр бус бодол санаануудын эсрэг хамгаалах сургалтыг хэзээ зааж эхлэх ёстойг Төлөөлөгчид мэддэг эсэхийг чухалчлан асуусан юм. Зарим нэг газруудад бүр Хүүхдийн Хэсэгт энэ тухай зааж эхлэх нь зүйтэй гэдгийг ч тэр онцлон хэлсэн.



Бага наснаасаа ёс суртахуунгүй дүрс бичлэгийг үзсэн залуус номлолын үйлчлэл болон нандин гэрээнүүдийг хийхэд өөрсдийгөө аль хэдийнээ зохисгүй болсон гэж эмээдэг.<sup>20</sup> Үүний үр дүнд тэдний итгэл маш их сулардаг. Залуучууд аа, наманчлалаар дамжуулан тэнгэрийн бүх адислалыг хүлээн авч чадна гэдгийг та нарт заасан. Үүнд та нарыг итгээсэй хэмээн би хүсч байна. Аврагчийн Цагаатгалын учир утга үүнд л оршдог юм. Эцэг эх эсвэл итгэдэг зөвлөгч болон бишоптойгоо зөвлөлдөн, тэдэнтэй ярилцаарай.

Ёс суртахууны талаар зарим насанд хүрэгчид зөвхөн хүмүүнлэгийн үйл ажиллагаа эсвэл зарчимд анхаарлаа хандуулан Аврагчийн сургаалыг чанд дагаж чаддаггүй. Тэд бэлгийн буруу явдал нь “жигжиг нүгэл . . . [би] эелдэг, энэрэнгүй хүн хэмээн өөрсдөдөө хэлдэг.”<sup>21</sup> Ийм бодол нь өөрийгөө маш ихээр мэхэлж байна гэсэн үг юм. Зарим залуус надад орчин үед зөв шударга зарчмуудын дагуу тууштайгаар амьдрах болон зарим нэг зүйлсийг хийх нь хоцрогдсон зүйл хэмээн хэлдэг.<sup>22</sup> Ийм урхинд бүү ороорой.

Баптисм хүртэхдээ бид өөрсөд дээрээ “[Есүс] Христийн нэрийг авч, эцсээ хүртэл Түүнд *тууштай* үйлчилнэ гэсэн амлалтыг өгдөг.”<sup>23</sup> Ийм гэрээ нь биднээс зоригтой хичээл зүтгэл, тууштай байдал ба шударга шулуун байдлыг шаарддаг. Бид гэтэлгэлийн хайрын дууг үргэлжлүүлэн дуулах юм бол жинхэнэ ёсоор хөрвөгддөг юм.

1924 онд Францын Парис хотноо болсон Олимпид оролцсон Английн тамирчин бүх насны хүмүүст эр зориг ба тууштай байдлын агуу жишээг үзүүлсэн.

Эрик Лидделл Хятадад үйлчилсэн, сүсэг бишрэлтэй, Шотланд номлогчийн хүү байв. Түүнд бүр маш их дарамт шахалт үзүүлсэн ч, тэрээр ням гарагт 100 метрийн гүйлтэнд гүйхээс татгалзан, Английн Олимпын наадмын зохион байгуулагчдыг хилэгнүүлсэн билээ. Эцсийн дүндээ тэр 400 метрийн гүйлтийн аварга болсон юм. Ням гарагт гүйхээс татгалзсан Лидделлийн үлгэр жишээ нь үнэхээр урам зориг оруулам түүх.

Түүнийг хүндэтгэх дурсгалын үйл ажиллагаа дээр Исаиагийн “Харин ЭЗЭНд найдагчдын хүч нь шинэчлэгдэнэ.

Тэд бүргэд мэт жигүүр дээрээ элин халина. Тэд гүйхдээ үл ядран, алхахдаа үл цуцна”<sup>24</sup> гэсэн сүнслэг үгсийг эш татжээ.

Лидделлийн бишрэм үйлдэл бага хүүт маань ням гарагт спортын үйл ажиллагаануудад оролцохгүй байхад нь мөн хамгийн чухал нь өөрийгөө зөв бус, дэлхийн зүйлсээс хол байх шийдвэр гаргахад нь маш их нөлөө үзүүлсэн юм. Тэр сургуулийнхаа төгсөлтийн номонд Исаиагаас эш татсан. Зарчимдаа зориг шийдэмгий, тууштай байхын хүчирхэг үлгэр жишээг Эрик Лидделл бидэнд үзүүлсэн юм.

Өсвөр үеийнхэн маань Ерөнхийлөгч Монсоны зөвлөгөөг даган номлолд үйлчлэхээр бэлтгэн мөн бид бүгдээрээ Аврагчийн заасан зарчмуудын дагуу амьдарч, Бурхантай уулзахдаа бэлтгэх<sup>25</sup> аваас илүү чухал гүйлтийн тэмцээний ялагч болох болно.<sup>26</sup> Бид сүнслэг удирдамжийг эрэлхийлэх үедээ Ариун Сүнстэй байх болно. Эмх цэгцгүй амьдарч байгаа хэн боловч Аврагчийн Цагаатгалыг итгэл ба амьдралынхаа үндэс болгоход хэзээ ч оройтохгүй гэдгийг санаарай.<sup>27</sup>

Исаиагийн үгсийн дагуу “Та нарын нүглүүд час улаан мэт боловч цас шиг цагаан болно. Тэдгээр нь хүрэн улаан боловч ноос шиг болох болно.”<sup>28</sup>

Хүн бүр чин сэтгэлээсээ гэтэлгэлийн хайрын дуут дуулж болохын тулд *яг одоо* Сүнсийг мэдрэхэд туслах үйлдлийг *хийх болтугай* хэмээн би чин сэтгэлээсээ залбирч байна. Аврагчийн Цагаатгалын хүчийг Есүс Христийн нэрээр гэрчилж байна, амен.

#### Эшлэл

1. Алма 4:15–19-г үзнэ үү.
2. Алма 5:26.
3. Жорж Алберт Смит нь 1945 оны 5-р сарын 21 хүртэл Сүмийн Ерөнхийлөгч байгаагүй, харин Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ерөнхийлөгч байсан юм. (*Deseret News 2012 Church Almanac* [2012], 98-г үзнэ үү.)
4. Жорж Алберт Смит, Шери Л.Деугийн, *Ezra Taft Benson: A Biography* (1987), 184.
5. Пегги Нунан, ““The Dark Night Rises,”” *Wall Street Journal*, 2012 оны 7-р сарын 28–29, А17.
6. Доктор Р.Алберт Мохлер бага, ерөнхийлөгч, Өмнөд Баптистын Бурханы номтны семинар, шашны удирдагч нарын танилцуулга, New York City, Sept. 5, 2012
7. 2 Нифай 2:27-г үзнэ үү.
8. Иохан 5:39; Амос 8:11; мөн Жэймс Е.Фауст, “A Personal Relationship with the Savior,” *Ensign*, 1976 оны 11-р сар, 58–59
9. Алма 31:5-г үзнэ үү.
10. Алма 36:23–26-г үзнэ үү.
11. С.С.Левайс, *Mere Christianity* (1952), (31–32). Левайс нь

- Оксфордын их сургуулийн Англи хэлний хүрээлэнгийн гишүүн байсан. Дараа нь Кембриджийн их сургуулийн Дундад Зуун ба Сэргэн Мандалтын үеийн Англи хэлний тэнхимийн эрхлэгч байсан.
12. *Сүмийн Ерөнхийлөгчдийн Сургаалаас: Иосеф Смит* (2007), 324; мөн Итчлэлт 3:15–16-г үзнэ үү.
  13. Алма 5:33.
  14. “Тэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг бичиг,” *Лиакхона*, 2010 оны 11-р сар, 129.
  15. Ричард Г. Скотт, “Removing Barriers to Happiness,” *Ensign*, 1998 оны 5-р сар, 85–87. Зарим соёлын захирангуй байдлууд Аврагчийн сургаалтай харшилдаг ба биднийг замаа алдах байдал руу хөтөлж болно. Би Өмнөд Номхон далайд байхдаа би олон жилийн турш Сүмийн сонирхогч байсан нэгэн эрэгтэй хүнтэй уулзсан. Санваарын чуулган дээр Сүмийн нэг удирдагчийн заасан “Өмнө нь хүүхдүүдээ зоддог байсан гар одоо хүүхдүүдээ адислахаар ашиглагдаж байна” хэмээн заасан зүйл түүний сэтгэлийг маш их хөндсөн гэдгийг хэлсэн байв. Тэр номлогчдоос хичээл хүлээн авч, баптисм хүртэн, агуу удирдагч болсон.
  16. “Тэр бүлийн хайр,” *Сүмийн дуу* 44.
  17. Алма 39
  18. Эзра Тафт Бенсон, “Cleansing the Inner Vessel,” *Ensign*, 1986 оны 5-р сар, 4-г үзнэ үү.
  19. Ерөнхийлөгч Гордон Б. Хинкли “Тэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг бичиг”-ийг 1995 онд болсон ерөнхий Нийгмийн Халамжийн чуулган дээр танилцуулсан. Ерөнхийлөгч Томас С. Монсон *Гарын авлага 2: Сүмийг удирдах нь* (2010), “Бурханы төлөвлөгөөн дэх Сүмийн гэр бүлүүд”-ийн эхний бүлгийг өөрчлөх ажлыг тэргүүлсэн.
  20. Алма 13:27–30; 41:11–15-г үзнэ үү.
  21. Росс Даухат, *Bad Religion: How We Became a Nation of Heretics* (2012), 238; мөн Алма 39:5-г үзнэ үү.
  22. Хүчирхийлэл, ёс суртахуунгүй байдлаар дүүрсэн, та нарын итгэлд саад учруулах Аврагчийн заасан зарчмуудын дагуу амьдрагч хүмүүсийг шүүмжлэгч нийгмийг битгий хүлээн зөвшөөр. Яруу найрагч Вордсвортын эелдгээр бичиглэсэнчлэн, “[Өөрийн оюун ухааныг] хэзээ ч дийлэгдэшгүй эсвэл [та нарын] урамтай итгэлийг гуйвуулах хилэнцтийн үг хэл, хөнгөмсөг шүүлт, элэг доог тохуугаар бус гайхамшигтай бодол санаануудаар тэжээ” (“Lines Composed a Few Miles above Tintern Abbey, in *The Oxford Book of English Verse*, ed. Christopher Ricks [1999], 346).”
  23. Моронай 6:3; тодотгол нэмсэн; мөн Мозая 18:13-г үзнэ үү.
  24. Исаиа 40:31; мөн Роберт Л. Бакман, “Day of Delight,” *New Era*, June 1993, 48–49 – г үзнэ үү.
  25. Алма 34:32-г үзнэ үү.
  26. 1 Коринт 9:24–27-г үзнэ үү.
  27. Хиаламан 5:12-г үзнэ үү. Оливэр Вэндэл Холмэс Ахмад, “Энэ дэлхийд миний олж мэдсэн агуу зүйл бол бидний байр суурь хаана байгаад бус харин бид аль зүгт явж байгаа нь чухал юм”. Тэнгэрийн боомтонд хүрэхийн тулд бид заримдаа салхины дагуу заримдаа сөрж залуурдах ёстой. Бид залуурдах ёстой болохоос биш зангуун дээрээ хэвтээд урсгалаар хөвөх ёсгүй юм” хэмээн зөвлөсөн. (*The Autocrat of the Breakfast-Table* [1858], 105)
  28. Исаиа 1:18.

# Би үүнийг мэднэ. Би үүний дагуу амьдардаг. Би үүнд хайртай.

**Анн М.Дибб**

*Залуу Эмэгтэйчүүдийн Ерөнхий Ерөнхийлөгчийн зөвлөлийн  
хоёрдугаар зөвлөх*

---

*Бид Аврагч Есүс Христийн дагалдагч нар билээ.  
Ийм хөрвөлт ба итгэл нь шаргуу, тууштай  
хичээсний үр дүн юм. Энэ нь хүн бүрт өөр өөр  
байдаг. Энэ бол насан туршид үргэлжлэх үйл явц  
юм.*

---

Сүмийн үнэнч шударга гишүүд болон залуучууд та бүхний үзүүлдэг үлгэр жишээ намайг *гайхируулдаг*. Та бүхэн Аврагчид зоригтойгоор найддаг. Та бүхэн итгэлтэй, дуулгавартай мөн цэвэр ариун билээ. Сайн үйлсийнхээ төлөө хүлээн авдаг та бүхний адислал зөвхөн та нарын болон миний бас бусад өчнөөн олон хүмүүсийн амьдралд гайхамшигтайгаар ихэнхдээ үл анзаарагдам байдлаар нөлөөлж байдаг.

Хэдэн жилийн өмнө би хотынхоо нэгэн хүнсний дэлгүүрт худалдаа хийхээр дугаарлан зогсож байв. Миний өмнө 16 орчим насны нэгэн залуу эмэгтэй зогсож байлаа. Тэр өөртөө итгэлтэй, аз жаргалтай харагдаж байв. Би түүний футболкийг хараад түүнтэй ярихгүй байж чадаагүй юм. “Чи өөр мужаас ирсэн юм уу?” гэж би түүнээс асуув.

“Тиймээ, би Колорадогоос ирсэн. Та яаж мэдсэн юм бэ?” гэж тэр гайхан хариулав.

Түүний футболкон дээрх “Би Мормон. Харин Та мөн үү?” гэсэн үгсийг уншаад өөрийн бодлоо хэлснээ хэлэв.

Би цааш нь, “зоримог тунхаглалыг агуулсан футболк өмсөж, бусдаас ялгарах өөртөө итгэлтэй байдалд чинь гайхширч байгаагаа би хэлэх хэрэгтэй байх. Чамайг бусдаас ялгаатайг би харж байна. Сүмийн залуу эмэгтэй, гишүүн бүр чамтай адил үзэл бодол, бат итгэлтэй байгаасай гэж би хүсч байна” гэж хэлэв. Бид худалдаагаа хийгээд баяртай гэж хэлэн явцгаав.

Өдөр хоногууд, хэдэн долоо хоног урсан өнгөрсөн ч өдөр бүр тохиолдож болох энэхүү санамсаргүй тохиолдол бодлоос минь салахгүй байлаа. Колорадогоос ирсэн энэ залуу эмэгтэй Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүн гэдгээ яаж ингэж бат итгэлтэйгээр эзэмшиж чадсаныг би мэдэхийг хүсч байв. Миний итгэл ба гэрчлэлийг илэрхийлэх утгыг агуулсан ямар хэллэгийг өөрийн футболкон дээр хэвлэхээр сонгох талаар би бодохгүй байж чадаагүй юм. Би маш олон хэллэгүүдийн талаар бодсон. Эцэст нь би бахархалтайгаар өмсөж чадах “Би Мормон хүн. Би Үүнийг мэднэ. Би үүний дагуу амьдардаг. Би үүнд хайртай” гэсэн тунхаглалыг бодож олсон юм.

Өнөөдөр би өөрийнхөө ярианд энэхүү зоригтой, итгэлтэй тунхаглалын талаар онцлон ярихыг хүсч байна.

Тунхаглалын эхний хэсэг нь өөртөө итгэлтэй, бахархалтайгаар: “Би Мормон хүн” гэсэн мэдэгдэл юм. Хүнсний дэлгүүрт миний танилцсан тэр залуу эмэгтэй Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүн гэдгээ дэлхийд мэдэгдэхээс айгаагүйн адил бид “Би Мормон хүн” гэдгээ хэзээ ч айж эсвэл ичиж дургүйцэлгүй хүлээн зөвшөөрнө хэмээн би найдаж байна. Бид Төлөөлөгч Паул, “Би Христийн сайн мэдээнээс ичихгүй. Яагаад гэвэл тэр нь итгэгч хүн бүрийг. . . авралд хүргэх Бурханы хүч мөн”<sup>1</sup> гэж тунхагласан шиг бат итгэлтэй байх хэрэгтэй. Гишүүдийн хувьд бид Аврагч Есүс Христийг дагагчид нь юм. Ийм хөрвөлт ба итгэл нь шаргуу, нягт хичээсний үр дүн юм. Энэ нь хүн бүрт өөр. Энэ нь насан туршид хийгдэх үйл явц мөн.

Тунхаглалын дараагийн хэсэг нь “Би үүнийг мэднэ” гэдгийг баталдаг. Өнөө үед алхам тутам бидний анхаарлыг

татахаар өрсөлдөж буй олон янзын үйл ажиллагаа, юмс ба сонирхол татсан зүйлс байдаг. Бидний санаа бодлыг сарниулах ийм олон зүйлсийн дунд хамгийн чухал зүйлүүд дээрээ анхаарлаа төвлөрүүлэх бат бөх байдал, дэг журам, үүрэг хариуцлага бидэнд байна уу? Сайн мэдээний үнэнийг бид хичээл, ажил, сонирхдог зүйл эсвэл утсаар болон интернетээр мессеж бичдэг шигээ сайн мэдэж хийдэг үү? Асуултандаа хариулт олохын тулд бид судраас, бошиглогчдын сургаалуудаас хичээнгүйлэн идэвхтэй эрэлхийлдэг үү? Бид Ариун Сүнсний баталгааг эрэлхийлдэг үү?

Мэдлэг олж авахын чухал ач холбогдол нь мөнхийн зарчим юм. Бошиглогч Иосеф Смит “ зөв шударга хүчнийх нь төлөө мэдлэгтэй байх дуртай байсан”<sup>2</sup>. Тэрээр “Мэдлэг нь бурханлаг байдал болон амьдралд зайлшгүй зүйл. . Сонсогтун, ах нараа, энэ агуу түлхүүр болох мэдлэг нь авралд хүргэх Бурханы хүч юм”<sup>3</sup> гэж хэлжээ.

Бүх үнэн ба мэдлэг нь чухал ч гэлээ өдөр тутам байнгын сарниулах зүйлсийн дунд бид сайн мэдээний зарчмуудыг амьдралдаа хэрхэн хэрэгжүүлэхээ ойлгохын тулд ялангуяа сайн мэдээний мэдлэгтээ онцлон анхаарах хэрэгтэй.<sup>4</sup> Бидний сайн мэдээний мэдлэг өсөхөд гэрчлэл маань бат итгэлтэй болж, “Би үүнийг мэднэ” хэмээн тунхаглаж чаддаг.

Дараагийн тунхаглал нь “Би үүний дагуу амьдардаг”. Судрууд бидэнд “сонсогчид биш, үгийг хэрэгжүүлэгч”<sup>5</sup> байх хэрэгтэй гэж заадаг. Бид итгэлээ хөгжүүлж, дуулгавартай байж, бусдыг хайрлан тэдэнд үйлчилж мөн Аврагчийн жишээг дагаснаар сайн мэдээний дагуу амьдарч, “үгийг хэрэгжүүлэгч” болдог. Биднийг хэн нэгэн харж байна уу эсвэл үгүй юу гэдэг нь хамаагүй, “ямар ч цагт мөн бүх зүйлд мөн байж болох хаана ч гэсэн”<sup>6</sup> бид шударга үнэнээр үйлдэж, зөв гэдгийг нь мэдэх зүйлсийг хийдэг.

Мөнх бус амьдралд бидний хэн маань ч төгс биш юм. Сайн мэдээний дагуу амьдрахыг хамгийн ихээр хичээж буй үедээ ч бид бүгд алдаа гаргаж, нүглийг үйлддэг. Аврагчийн гэтэлгэх золиослолоор дамжуулан бид өршөөгдсөн мөн дахин цэвэр болж чадна гэдгийг мэдэх нь ямар сайхан баталгаа билээ. Үнэн наманчлал болон уучлалын энэхүү үйл явц нь бидний гэрчлэл болон Их Эзэний зарлигуудад дуулгавартай байж, сайн

мэдээний жишгээр амьдрах шийдвэрийг маань хүчирхэгжүүлдэг.

“Би үүний дагуу амьдардаг” гэдэг тунхаглалыг бодох үед Кариган нэртэй нэгэн залуу эмэгтэй санаанд маань орж ирдэг. Тэр “Би Сүмийн гишүүн болоод жил гаран болж байна. . . . Миний хувьд сүмийн сонирхогч байх үед даруу зан мөн жишгүүдийг заадаг сүмийг олсон нь энэ Сүм үнэн гэдгийн нэгэн тод тэмдэг байсан юм. Зарлигуудыг үл тоомсорлон, буруу замыг сонгосон тэдгээр хүмүүст юу тохиолддогийг би өөрийн нүдээр харсан. Би анхнаасаа л ёс суртахууны өндөр жишгээр амьдарна гэж шийдвэр гаргасан. . . . Үнэнийг олж, баптисм хийлгэж агуу адислалыг авах болсондоо би маш их баяртай байна.”<sup>7</sup> гэж бичжээ.

Миний хамгийн сүүлийн тунхаглал нь “Би үүнд хайртай”. Есүс Христийн сайн мэдээний мэдлэгтэй болж, өдөр бүр хичээнгүйгээр сайн мэдээний зарчмуудын дагуу амьдрах нь сүмийн олон гишүүдийг маш бахархалтайгаар, “Би сайн мэдээнд хайртай!” гэж хэлэхэд хүргэдэг.

Энэ мэдрэмж нь бид бол Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүд, Тэрээр биднийг ойлгож мэддэг мөн бид зөв зам дээр зогсож байна гэдгийг Ариун Сүнс бидэнд гэрчлэх үед ирдэг. Бид Түүнийг дагаж, Түүнд дуулгавартай байх хүсэлтэйгээ харуулснаар Тэнгэр дэх Эцэгийнхээ хайрыг мэдэрч, Аврагчийн бидэнд амласан амар тайванг мэдрэх үед сайн мэдээг хайрлах хайр маань улам өсдөг билээ.

Бид насан туршдаа сүмийн гишүүн байсан ч бай, шинэ гишүүн байсан ч бай амьдралын өөр цаг үеүдэд тэр урам зоригтой өөдрөг байдал уруудах үе гарч болох юм. Энэ нь заримдаа хүнд бэрхшээлтэй тулгарсан үед тохиолдход бид тэвчээртэй байж сурах хэрэгтэй. Заримдаа энэ нь бидний хамгийн элбэг дэлбэг, баяр хөөртэй үед ч тохиолддог. Энэ мэдрэмж төрөх бүрд би сайн мэдээний мэдлэгээ хөгжүүлж, сайн мэдээний зарчмуудын дагуу илүү бүрэн дүүрэн амьдрахыг хичээх хэрэгтэйгээ мэддэг.

Хамгийн үр дүнтэй бөгөөд заримдаа дагахад амаргүй байдаг сайн мэдээний зарчмуудын нэг нь даруу байдал ба Бурханы хүсэлд хүлцэнгүй байх явдал юм. Гетсеманий цэцэрлэг дэх залбиралдаа Христ, “Миний хүсэл бус Таны

хүсэл биелэгдэг”<sup>8</sup> гэж хэлдэг. Бид мөн ийнхүү залбирах ёстой. Ихэнх тохиолдолд эдгээр нам гүм, залбиралтай мөчид бид Тэнгэрлэг Эцэгийн хайраар хүрээлэгдсэнээ мэдэрч, тэдгээр баяр хөөртэй, хайрын мэдрэмжүүд маань сэргээгддэг.

Орегоны Южинд болсон Залуу Эмэгтэйчүүдийн удирдагчдын хурал дээр Ками Вилбэргэр эгчтэй танилцаж, ярих завшаан надад олдсон юм. Вилбэргэр эгчийн хуваалцсан түүх нь сайн мэдээг мэдэж, Үүний дагуу амьдарч мөн хайрласан нэгэн залуу эмэгтэйн хүчирхэг байдал ба адислалын нэгэн нотолгоо байсан юм.

Хэдэн жилийн өмнө Вилбэргэр эгчийн 19 настай охин, Брүүк нь их сургуулийн эхний жилээ дуусгаад зуны амралтынхаа үеэр харамсалтайгаар амиа алджээ. Вилбэргэр эгч, “Энэ нь манай гэр бүлийн хувьд маш хүнд, харанхуй үе байв. Гэвч Брүүк бидэнд агуу бэлгийг өгсөн юм. Үүнийг бид өсөж торних үед нь анзаараагүй ч богино амьдралынхаа жил, мөч бүрт Брүүк бидэнд охин нь эцэг эхдээ өгч болох хамгийн агуу бэлгийг өгсөн юм. Брүүк Бурханы зөв шударга охин байсан. . . . Энэ бэлгийн ачаар ялангуяа цагаатгалын улмаас би хүч чадал, тайвшрал болон Аврагчийн амласан амар амгаланг би олж авсан юм. Одоо Брүүк хаана байгаа вэ гэдэгт би эргэлздэггүй, бидний дахин нэгдэх сайхан мөчийг л би хүлээж байна даа”<sup>9</sup> хэмээн дурсан ярьсан юм.

Надад Тэнгэрлэг Эцэгийн мөнхийн аз жаргалын агуу төлөвлөгөөний тухай гэрчлэл бий. Тэрээр биднийг мэддэг бөгөөд бидэнд хайртай гэдгийг би мэднэ. Биднийг урамшуулан дэмжиж, тусалж мөн Түүн рүү эргэн очиход биднийг удирдах бошиглогч Ерөнхийлөгч Томас С. Монсоныг Тэрээр бидэнд илгээсэн гэдгийг би мэднэ. Хүн бүр өөртөө итгэлтэйгээр, “Би Мормон. Би үүнийг мэднэ. Би үүний дагуу амьдардаг. Би үүнд хайртай” гэж тунхаглахыг хичээх болтугай хэмээн би залбирч байна. Эдгээрийг би даруухнаар Есүс Христийн нэр дээр хэллээ, амен.

*Эшлэл:* Би та бүхэнд үргэлжлүүлэн сурахыг хүсвэл Алма 32 болон Даллин Х.Өүкс ахын “The Challenge to Become” (Лиакхона, 2001 оны 1-р сар, 40–43) хэлсэн үгийг уншихыг санал болгож байна.



*Эшлэл*

1. Ром 1:16.
2. Жорж К.Каннон, *Сүмийн Ерөнхийлөгчдийн Сургаалаас: Иосеф Смит*(2007), 261
3. *Сүмийн Ерөнхийлөгчдийн Сургаалаас: Иосеф Смит*, 265; мөн Martha Jane Knowlton Coray, өдрийн тэмдэглэл, Сүмийн Түүхийн Номын сан, Солт Лейк хот.
4. *Залуу Эмэгтэйчүүдийн Хувийн хөгжил дэвшил*(товхимол, 2009), 38
5. Иаков 1:22.
6. Мозая 18:9.
7. Хувийн захидал.
8. Лук 22:42.
9. Хувийн захидал.

---

# Бурханы өгүүлшгүй бэлэг

Далын Ерөнхийлөгчийн Зөвлөлийн

Ахлагч Крэйг С.Крисченсен

---

*Ариун Сүнс нь Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христтэй төгс нэгдэлтэй ажиллаж, олон чухал үүргүүд мөн онцгой хариуцлагуудыг гүйцэтгэдэг.*

---

1994 онд Ерөнхийлөгч Ховард В.Хантер Сүмийн бүх гишүүдийг “ариун сүмийг [өөрсдийн] гишүүнчлэлийн агуу бэлэг тэмдэг болгохыг”<sup>1</sup> урьсан билээ. Тэр жил нь Баунтифул Ютагийн Ариун Сүмийн барилгын ажил бүрэн дуусжээ. Олны адил бид залуу гэр бүлээрээ онцгой адислалын өмнөх нээлттэй өдөрт оролцохоор сэтгэл догдолж байлаа. Бид хүүхдүүдээ ариун сүмд ороход нь бэлтгэж, ариун сүм тэдний амьдралд чухал байр суурийг эзэлж сүнслэг туршлага бий болгохын төлөө чин сэтгэлээсээ залбирч, хичээнгүйлэн хөдөлмөрлөсөн.

Ариун сүмд хүндэтгэлтэйгээр алхах зуураа би багана мэт урт цонхоор тусах гэрэл, олон сүнслэг сайхан зурагнууд, сүрлэг уран барилга, гоёмсог байгууламжийг харан гайхан биширч явлаа. Энэ ариун барилгын юм бүхэн үнэхээр төгс тансаг байв.

Селестиал өрөө рүү орохдоо би зургаан настай бага хүү Бенийгээ хөлнөөс минь зуурсныг анзаарлаа. Түүний сэтгэл догдолж, магадгүй бага зэрэг сандарсан мэт байв.

“Яасан бэ? хүү минь” гэж би шивнэлээ.

Тэрээр хариуд нь “Аав аа, энд юу болоод байгаа юм бэ? Би өмнө нь хэзээ ч ийм зүйлийг мэдэрч байгаагүй” гэлээ.

Бага хүү маань анх удаа Ариун Сүнсний нөлөөг ийм хүчтэйгээр мэдэрч байгааг ойлгонгоо би түүний хажууд шалан дээр өвдөг сөхрөн суулаа. Бусад айлчлан ирсэн хүмүүс биднийг тойрон гарах зуур Бен бид хоёр хэдэн минут зэрэгцэн

суугаад Ариун Сүнсний талаар хамтдаа суралцсан юм. Энэ нандин мэдрэмжийг ийм хялбархан ярилцаж чадсандаа би их гайхаж билээ. Би түүнтэй ярих зуур Бенд юу харсан нь биш, харин юу мэдрэгдсэн нь хамгийн ихээр сүнслэгээр нөлөөлж байсан нь илт болсон - бидний эргэн тойронд буй үзэсгэлэнт зүйлс биш харин түүний зүрхэн дэх Бурханы Сүнсний намуун зөөлөн дуу хоолой байлаа. Түүний гайхширсан байдал хүүхэд ахуйг минь эргэн санагдуулж, би түүнтэй Бурханы бэлэг болох Ариун Сүнсний өгүүлшгүй бэлгийн<sup>2</sup> төлөө талархдаг өөрийн суралцсан хувийн туршлагаасаа хуваалцсан.

### **Ариун Сүнс гэж хэн бэ?**

Ариун Сүнс бол Бурхан тэргүүтэний гурав дахь гишүүн, тиймээс яг л Бурхан Эцэг, Есүс Христийн адил, Тэр бидний бодол санаа, зүрх сэтгэлийн хүслийг мэддэг.<sup>3</sup> Ариун Сүнс бидэнд хайртай ба биднийг аз жаргалтай байхыг хүсдэг. Бидэнд тулгарах саад бэрхшээлүүдийг мэддэг болохоор Тэр биднийг Тэнгэрлэг Эцэгтээ эргэн очиж, Түүнтэй дахин амьдрахын тулд бидний хийх ёстой бүх зүйлийг удирдан, зааж чадна.<sup>4</sup>

Өргөмжлөгдсөн мах, ясан биетэй Тэнгэрлэг Эцэг ба Есүс Христ хоёртой адилгүй нь Ариун Сүнс мэдрэмж ба сэтгэгдлээр<sup>5</sup> дамжуулан бидний сүнстэй харьцдаг сүнсэн биет юм. Сүнсэн биет учраас Тэр хувийн илчлэлтийг хүлээн авах зэмсэг болох онцгой үүрэг хариуцлагатай. Сударт Ариун Сүнс нь ихэвчлэн Ариун Сүнс, Их Эзэний Сүнс, Амлалтын Сүнс эсвэл энгийнээр Сүнс<sup>6</sup> гэж өгүүлэгдсэн байдаг.

### **Ариун Сүнс ямар үүрэгтэй вэ?**

Ариун Сүнс нь Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христтэй төгс нэгдэлтэй ажиллаж, олон чухал үүргүүд мөн онцгой хариуцлагуудыг гүйцэтгэдэг. Ариун Сүнсний гол зорилго нь Бурхан Эцэг болон Түүний Хүү Есүс Христийг<sup>7</sup> гэрчилж, бидэнд бүх юмсын<sup>8</sup> үнэнийг заах явдал. Ариун Сүнсний баттай гэрчлэл нь бусад аливаа эх сурвалжаас ирсэн гэрчээс илүүтэй тодорхой бодит байдлыг дамжуулдаг. Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смит “Бурханы Сүнс хүмүүний сүнстэй ярьж, хувийн харьцаагаар түүнчлэн тэнгэрлэг нэгэнтэй<sup>9</sup> хийсэн харьцаагаар дамжин ирсэн үнэнээс ч илүүтэй хамгийн

агуу нөлөө болон ойлголттойгоор үнэнийг дамжуулах хүчтэй байдаг” хэмээн заасан.

Ариун Сүнсийг мөн Тайвшруулагч<sup>10</sup> хэмээдэг. Сэтгэл зовнисон, цөхөрч аргаа барсан эсвэл зүгээр л Бурхан ойр байгаа гэдгийг мэдэх гэсэн үед Ариун Сүнс бидний сүнсийг өргөж, бидэнд найдварыг өгөн “хаант улсын амар амгалан зүйлүүдийг”<sup>11</sup> зааж, “бүх оюун ухаанаас дээгүүрх Бурханы амар тайванг”<sup>12</sup> мэдрэхэд тусалдаг.

Хэдэн жилийн өмнө хамаатан садан, гэр бүлийнхэн маань баярын оройн зоог барихаар хамтдаа цугларсан үед аав минь олон ач зээтэйгээ тоглоом тоглож эхэллээ. Гэнэт ямар ч шинж тэмдэггүйгээр тэр сулран унаж, тэр дороо нас нөгчсөн. Энэ санаандгүй явдал ялангуяа хариулахын аргагүй хүндхэн асуултуудыг тавьж байсан түүний ач зээ нарт маш хүндрэлтэй байж болох байлаа. Гэвч хүүхдүүдээ тойруулан суулгаад бид залбиран, амьдралын зорилгын тухай Мормоны Номын бошиглогчдын үгсээс уншихад Ариун Сүнс хүн бүрийг тайвшруулсан юм. Үгээр тайлбарлахад хэцүү мөчүүдэд бидний эрэлхийлж байсан хариултууд зүрх сэтгэлд минь ил тодоор ирсэн. Тэр өдөр үнэхээр бидний ойлголтоос хэтэрсэн амар амгаланг мэдэрч билээ. Ариун Сүнсний гэрчлэл тодорхой, үгүйсгэхийн аргагүй, үнэн бодитой байв.

Ариун Сүнс нь багш ба илчлэгч<sup>13</sup> мөн. Бид сайн мэдээний талаар судалж, тунгаан бодож, залбирах үед Ариун Сүнс бидний оюун ухааныг гэгээрүүлж, ойлголтыг<sup>14</sup> түргэсгэдэг. Тэр бидний бодгалд үнэнийг арилахгүйгээр бичигдсэн байхаар болгож, зүрх сэтгэлийн агуу өөрчлөлтийг авчирдаг. Эдгээр үнэнийг гэр бүлийнхэнтэйгээ, Сүмийн найз нөхөдтэйгөө мөн эргэн тойрны хүмүүс, хөршүүдтэйгээ хуваалцахад Ариун Сүнс сайн мэдээг “хүмүүний үрсийн зүрх сэтгэлд”<sup>15</sup> хүргэгчийн хувьд тэдний багш нь болдог.

Ариун Сүнс биднийг бусдад хүрч үйлчлэхээр өдөөдөг. Миний хувьд бусдын төлөөх үйлчлэлд Ариун Сүнсний шивнээг анхааралтай сонсож бодит амьдрал мөн үйлсээрээ үлгэр жишээ болсон Ерөнхийлөгч Томас С.Монсон хэлэхдээ, “Бидний үүрэг хариуцлагуудын гүйцэтгэлд, намуухан шивнээг анхааралтай сонсож, түүнийг тэр даруй үйлдэх үед Тэнгэрлэг Эцэг бидний үйлдлүүдийг удирдаж, амьдралыг

маань адисалдаг гэдгийг би сурсан. Нэгэн шивнээг анхааралтай сонссоноор чамаар дамжуулан өөр хэн нэгний залбиралд Их Эзэн хариулсан гэдгийг олж мэдэхээс илүүтэй сайхан, тааламжит, үнэт мэдрэмж гэж үгүй болохыг би мэднэ.”<sup>16</sup>

Нэгэн энхрий сэтгэл догдлом туршлагыг би хуваалцъя. Ерөнхийлөгч Монсон бишопоор үйлчилж байхдаа түүний тойргийн гишүүн Мари Ватсон эгч эмнэлэгт хэвтэж байгааг мэджээ. Түүнийг эргэхээр очих үедээ тэр том өрөөнд бусад олон өвчтөнтэй хамт байгааг олж мэджээ. Тэр Ватсон эгч рүү ойртон очих үед хажуугийн орны өвчтөн толгойгоо хөнжил доогуур хурдхан нуухыг анзаарчээ.

Ерөнхийлөгч Монсон Ватсон эгчтэй уулзаж, санваарын адислал өгснийхөө дараа гар барьж, баяртай гэж хэлээд явахаар завдав. Гэтэл энгийн мөртлөө гайхамшигтай зүйл тохиожээ. Одоо би энэ явдлын тухай Ерөнхийлөгч Монсоны өөрийнх нь хэлсэн үгсээс эш татъя:

“Би түүний хажуунаас холдож чадсангүй” гээд тэр “Энэ нь яг л үл мэдэгдэх гар мөрөн дээр хүрэх шиг болж, бодгальд минь: ‘Чамайг орж ирэхэд нүүрээ тагласан хажуугийн орны жижигхэн эмэгтэй рүү оч’ гэж хэлэх шиг болов. Би яг л дагалаа. . . .

“Нөгөө өвчтөний орны дэргэд очиж, эелдгээр түүний мөрөнд хүрч, болгоомжтойгоор нүүрээ тагласан хөнжлийг нь хойшлууллаа. Юу вэ! Тэр бас манай тойргийн гишүүн байв. Би түүнийг эмнэлэгт хэвтсэнийг мэдээгүй. Түүнийг Катрин Маккий гэдэг. Бидний харц тулгарах үед тэрээр нулимс дуслуулан, ‘Бишоп минь, таныг хаалгаар орж ирэхэд би таныг надтай уулзахаар залбирлын минь хариу болон ирлээ гэж бодсон. Намайг энд байгааг мэдээд таныг ирлээ гэж их баярлаж байсан ч өөр орны дэргэд очиход зүрх минь зогсох шиг болж, надтай уулзахаар ирээгүйг тань мэдсэн’ хэмээн уулга алдан хэлж билээ.

“Би Маккий [эгчид]: ‘Таныг энд байгааг мэдээгүй минь чухал зүйл биш. Харин Тэнгэрлэг Эцэг мэдэж, та санваарын адислалын төлөө залбирч байсан чинь чухал зүйл. Энэ бол миний дотор тань руу оч хэмээн сүнслэгээр өдөөсөн Тэр байсан юм”<sup>17</sup> гэжээ.

### **Ариун Сүнс бидэнтэй хэрхэн ярьдаг вэ?**

Бид бүгд хэдийгээр Ариун Сүнсийг мэдэрдэг ч түүнийг үргэлж таньдаггүй. Оюун ухаанд сүнслэг бодол санаанууд орж ирэхэд бид тэдгээрийг зүрх сэтгэлд маань орж ирэх сүнслэг мэдрэмжээр энэ нь үнэн гэдгийг мэддэг. Ерөнхийлөгч Байд К.Пакер: “Ариун Сүнс *сонсохоос*. . . илүүтэй *мэдрэх* дуу хоолойгоор ярьдаг. Бид Сүнсний шивнээтэй ‘сонсох’ байдлаар ярилцахад ихэвчлэн нэг нь сүнслэг өдөөлтгөөр ‘Надад . . . . . байна’”<sup>18</sup> гэж хэлдэг. Ариун Сүнснээс ирсэн эдгээр нандин мэдрэмжүүдээр дамжуулан судар дээр хэлсэнчлэн “илчлэлтийн сүнс”<sup>19</sup> тунхаглах мэт Бурхан биднийг юу хийхийг хүсч байгааг бид мэддэг.

### **Ариун Сүнсний бэлэг хүлээн авна гэдэг юу гэсэн үг вэ?**

Би зургаан настай хүү Бендээ зааж байхдаа Ариун Сүнсний нөлөөгөөр тэр юу мэдэрч байгаа болон баптисмын дараа хүлээн авах Ариун Сүнсний бэлэг хоёрын хоорондох ялгааг тайлбарлахын чухлыг ойлгосон. Баптисмын өмнө шударга мөн үнэнийг чин сэтгэлээсээ эрэлхийлэгчид Ариун Сүнсний нөлөөг мэдрэх болно. Гэхдээ Ариун Сүнсстэй байнга нөхөрлөх болон үүнтэй холбоотой адислалуудын *бүрэн байдлыг* зөвхөн зохистой, баптисм хүртсэн гишүүд Бурханы санваарын эрх мэдлийг атгагч ах нарын гар тавилтаар Ариун Сүнсний бэлгийг авснаар хүлээн авч чадна.

Ариун Сүнсний бэлгээр дамжуулан бид нэмэлт хүч чадал, сүнслэг бэлгүүд, нэмэлт илчлэлт ба хамгаалалт, баттай удирдамж ба чиглүүлэлт, селестиал хаант улсын ариун гэгээрэл ба өргөмжлөлийн амлагдсан адислалуудыг хүлээн авдаг. Эдгээр бүх адислал тэдгээрийг хүлээн авах хувийн хүслийн үр дүнд, амьдралаа Бурханы таалалтай нийцүүлэн, Түүний байнгын удирдамжийг эрэлхийлэх үед өгөгддөг.

Баунтифулын Ариун Сүмд өөрийн туршлагыг Бенийхтэй харьцуулан үзэхэд надад олон тааламжтай мэдрэмж болоод сэтгэгдэл төрсөн. Нэгэн тод дурсамж бол намайг сүр жавхлант тансаг байдалд нүд алдан байхад миний дэргэдэх бяцхан хүү зүрх сэтгэлдээ хүчирхэг нөлөөг мэдэрч байсан явдал юм. Нэгэн эелдэг сануулагч надад хэсэг зуур амьсгаа авч, өвдөг сөхрөхийг хэлээд зогсохгүй мөн даруу, номхон, шударга, Түүний Сүнсний намуун зөөлөн шивнээг сонсоход бэлэн бяцхан хүүхдийн адил болж, Аврагчийн дуудлагыг анхааралтай сонсохыг сануулсан.

Ариун Сүнс амьд бөгөөд бодит, Ариун Сүнсний бурханлаг үүрэг ба хүчээр бид бүх зүйлүүдийн үнэнийг мэдэж чадна гэдгийг би гэрчилж байна. Ариун Сүнсний бэлэг нь Түүний Хүүд ирж, Түүний нэрээр баптисм хүртэж, Түүний Сүмийн гишүүний баталгаагаар дамжуулан Ариун Сүнсийг хүлээн авсан бүх хүнд өгөгдсөн Тэнгэрлэг Эцэгийн үнэт бөгөөд өгүүлшгүй бэлэг гэдгийг би гэрчилж байна. Эдгээр бүх хувийн гэрчлэлийг Есүс Христийн ариун нэр дээр хэллээ, амен.

### Эшлэл

1. Жэй М.Тодд дээрх, Ховард В.Хантер, Howard W. Hunter: Fourteenth President of the Church," *Ensign*, 1994 оны 7-р сар, 5; мөн Ховард В.Хантер, "The Great Symbol of Our Membership," *Tambuli*, 1994 оны 11-р сар, 3.
2. Сургаал ба Гэрээ 121:26-г үзнэ үү.
3. Алма 12:7; 18:16–18; Сургаал ба Гэрээ 6:15–16-г үзнэ үү.
4. 2 Нифай 32:5-г үзнэ үү.
5. Сургаал ба Гэрээ 130:22-г үз.
6. Лук 4:1, 18; 11:13; Иохан 1:33; Ефес 1:13; Сургаал ба Гэрээ 88:3-г үзнэ үү.
7. 2 Нифай 31:18; 3 Нифай 28:11; Сургаал ба Гэрээ 20:27-г үзнэ үү.
8. Моронай 10:5-г үз.
9. Жозеф Фиелдинг Смит, *Doctrines of Salvation*, ed. Брюс Р.МакКонки, 3 дахь хэвлэл. (1954–1956), 1:47–48.
10. Иохан 14:26; Сургаал ба Гэрээ . 35:19-г үзнэ үү.
11. Сургаал ба Гэрээ 36:2.
12. Филиппой 4:7.
13. Лук 12:2; 1 Коринт 2:13; Сургаал ба Гэрээ 50:13–22; *Сүмийн Бошиглогчдын сургаалууд: Иосеф Смит* (2007), 132–133.
14. Сургаал ба Гэрээ 11:13-г үзнэ үү.
15. 2 Нифай 33:1.
16. Томас С.Монсон, "Peace, Be Still," *Лиахона*, 2002 оны 11-р сар, 55.
17. Томас С.Монсон, "Christ at Bethesda's Pool," *Ensign*, 1996 оны 11-р сар, 18–19.
18. Бойд К.Пакер, "Personal Revelation: The Gift, the Test, and the Promise," *Лиахона*, , 1997 оны 6-р сар, 10;.
19. Сургаал ба Гэрээ 8:3; мөн шүлэг 2.

# “Би амьд учраас, Та нар ч МӨН АМЬД”

Далын гишүүн

Ахлагч Шэйн М.Боуэн

---

*Бидний Аврагч Есүс Христийн учир уй гашуу,  
ганцаардал, цөхрөл нэг л өдөр бүрэн дүүрэн баяр  
баясгалангаар солигдох болно.*

---

Чилид залуу номлогчоор үйлчилж байхдаа, би ам бүл долуулаа нэгэн гэр бүлтэй уулзсан билээ. Ээж нь таван хүүхдийн хамт долоо хоног бүр цуглаанд ирж оролцдог байсан юм. Бид тэднийг Сүмийн гишүүд болоод удаж байгаа гэж боддог байв. Нэлээд хэдэн долоо хоногийн дараа бид тэднийг баптисм хүртээгүй болохыг нь олж мэдэж билээ.

Бид тэр даруй мөнөөх гэр бүлтэй холбоо барьж гэрт нь очиж тэдэнд хичээл зааж болох эсэхийг лавлан асуулаа. Аав нь сайн мэдээний талаар суралцах хүсэлгүй байсан ч өөрийн гэр бүлдээ заалгахад эсэргүүцэл үзүүлээгүй билээ.

Хичээлийн явцад Рамирез эгч маш эрчимтэй сүнслэг байдлаар өсч байв. Тэр бидний заасан бүх сургаалуудыг тун идэвхийлэн сурч байлаа. Нэгэн үдэш бид нялх хүүхдүүд баптисм хүртдэг эсэх талаар ярилцаж, тэд гэм зэмгүй учир баптисм хүртэх шаардлагагүй тухай заав. Бид түүнээс Моронайн номноос дараах үгсийг уншихыг хүссэн юм:

“Болгоогтун энэ зүйлийг та нар заах болно гэдгийг би чамд хэлье—хариуцлага хүлээх мөн нүгэл үйлдэж чадахуйц тэдэнд наманчлал мөн баптисмыг; тийм ээ, тэд наманчилж мөн баптисм хүртэн, мөн бага насны хүүхдүүдийнхээ адил өөрсдийгөө даруухан болгох ёстой, тэгвэл тэд бүгдээр бага насны хүүхдүүдийнхээ хамт аврагдах болно гэдгийг эцэг эхчүүдэд заагтун.



“Мөн тэдний бага насны хүүхдүүдэд наманчлал ч, бас баптисм ч огт хэрэггүй болой. Болгоогтун, нүглийн ангижралыг авах зарлигуудыг биелүүлэхийн тулд баптисм нь наманчлалд хүргэдэг.

“Гэвч бага насны хүүхдүүд бүр дэлхийн үүслээс Христээр амьд; хэрэв тийм бус аваас, Бурхан нь ялгаварладаг Бурхан, мөн түүнчлэн хувирамтгай Бурхан, мөн нүүр тал харагч болно; учир нь хэчнээн олон бага насны хүүхдүүд баптисмгүйгээр нас нөгчсөн билээ!”<sup>1</sup>

Энэ судрыг уншсаныхаа дараа Рамирез эгч учир зүтгүй уйлж эхлэв. Хамтрагч бид хоёр ихэд сандарцгаав. Би түүнээс, “Рамирез эгчээ, бид таныг гомдоох ямар нэгэн зүйл хэлж эсвэл хийчихэв үү?” гэж асуув.

Тэр өгүүдрүүн: “Өө үгүй ээ, Ахлагч аа, та нарт ямар ч буруу байхгүй. Зургаан жилийн өмнө би нэг нярай хүүтэй байсан юм л даа. Бид түүнд баптисм хүртээхээс өмнө тэр маань өөд болчихсон юм. Нэгэн санваартан лам түүнийг баптисм хүртэж чадаагүй тул мөнхөд хоёр ертөнцийн заагт үлдэх болно гэсэн билээ. Зургаан жилийн турш би тэр зовлон, гэмийг үүрсээр ирсэн. Энэ судрыг уншсаны дараа би Ариун Сүнсний хүчээр энэ бол үнэн гэдгийг мэдэж байна. Нуруунаас маань хүнд ачаа авагдсан мэт санагдсан болохоор би баярын нулимс унагаж байна” гэлээ.

Түүний хэлсэн үг надад бошиглогч Иосеф Смитийн заасан дараах тайтгаралын сургаалыг санагдуулсан юм: “Их Эзэн олныг бүүр тэдгээр нялх хүүхдүүдийг ч магадгүй хүмүүсийн атаархал, одоогийн энэ дэлхийн харуусал, бузар муухайгаас зугтаалгахын тулд, мөн тэд дэлхийд амьдрахад хэтэрхий цэвэр, хайр булаам байсан учраас өөртөө эргүүлэн авдаг. Зөв талаас нь бодож үзвэл, тэдний араас гашуудахын оронд бузар муугаас холдсоных нь төлөө баярлах шалтгаан бас бидэнд байгаа шүү. Бидэнд хэзээд тэдэнтэй уулзах цаг тохиох болно.”<sup>2</sup>

Бараг тэвчихийн аргагүй зовлон шаналал, уй гашуугаар зургаан жилийн турш зовсны эцэст Тэнгэр дэх хайрт Эцэгийн маань амьд бошиглогчоор дамжуулан илчлэгдсэн үнэн сургаал энэ тарчлан зовсон эмэгтэйд гайхамшигт амар амгаланг авчирчээ. Рамирез эгчид найм болон түүнээс дээш

настай хүүхдүүдтэйгээ баптисм хүртсэн тухайд зүйрлэж хэлэхийн аргагүй байсан буй за.

Би энэ тухай болон Есүс Христийн сайн мэдээний дахин сэргээгдсэн энгийн бөгөөд үнэт үнэнүүдийн тухай мэдлэгтэй болсондоо зүрх сэтгэлдээ хэчнээн их талархаж байгаа талаар гэр бүлийнхэндээ бичсэнээ санаж байна. Энэ гайхамшигтай үнэн зарчим ирээдүйн он жилүүдэд маань надад эргэн ирж Гилийдайгийн гавар байхаа батална гэж би хэзээ ч төсөөлөөгүй билээ.

Би хүүхдээ алдаад “Яагаад би гэж?” гэж асуух эсвэл, магадгүй Тэнгэр дэх хайрт Эцэгтээ итгэх өөрийн итгэлдээ эргэлзэж буй тэдгээр хүмүүст хандан ярихыг хүсч байна. Би өөрийгөө Ариун Сүнсний хүчээр ямар нэг хэмжээгээр найдвар, амар амгалан, мөн ойлголтыг авчраасай хэмээн залбирч байна. Би хувьдаа бүх зүйлсийг мэддэг мөн бидний гай зовлонг туулж үзсэнээр нь Түүнийг мэдэж бас хайрлаж мөн Түүнгүйгээр бидэнд юу ч байхгүй гэдгийг ойлгоосой хэмээдэг Тэнгэр дэх хайрт Эцэгтээ итгэх итгэлийн тань сэргээлтийг авчрах зэмсэг нь байхыг хүсч байна.

1990 оны хоёрдугаар сарын 4-нд манай гурав дахь хүү буюу зургаа дахь хүүхэд маань мэндэлж, бид түүнд Тайсон гэдэг нэр өгсөн юм. Тэр хөөрхөн бяцхан хүү байсан бөгөөд бид гэр бүлээрээ түүнийг зүрх сэтгэлээсээ гар дэлгэн хүлээн авч билээ. Түүний ах эгч нар нь түүгээр маш их бахархаж байлаа. Бид бүгд түүнийг хамгийн төгс төгөлдөр бяцхан хүү гэж бодож байсан юм.

Тайсон найман сартай байхдаа хивсэн дээрээс олсон шохойны хэлтэрхийг залгичихсан юм. Шохой Тайсонгийн хоолойд тээглээд тэр амьсгалж чадахгүй байв. Түүний ах Тайсонг дээд давхарт аваачин, “дүү амьсгалахгүй байна, дүү амьсгалахгүй байна” хэмээн бачимдан хашгирч байлаа. Бид хиймэл амьсгал хийж, тэр даруй түргэн тусламж дуудав.

Түргэн тусламж ирэн Тайсонг эмнэлэг рүү яаралтай авч явав. Хүлээлгийн өрөөнд сууж байхдаа хичээнгүйлэн залбирлаа үргэлжлүүлэн Бурханаас бидэнд гайхамшиг үзүүлэхийг гуйж байлаа. Амьдрал зогсчих шиг санагдсан тэр мөчид эмч өрөөнд орж ирээд, “Намайг уучлаарай. Бид чадах

бүхнээ хийсэн. Та нар одоо түүний байгаа өрөө рүү орж болно” гэж хэлээд гараад явав.

Бид Тайсонгийн хэвтэж байсан өрөө рүү орж амьгүй болсон бяцхан баяр баясгалангаа харж билээ. Түүний бяцхан биеийг тойрон селестиел цацраг цацарсан байх шиг санагдаж билээ. Тэр маш их гэгээлэг, цэвэр тунгалаг байсан юм.

Тэр мөчид л энэ ертөнцийн төгсгөл ирсэн юм шиг санагдаж билээ. Бид гэрт үлдсэн хүүхдүүддээ буцаж очоод, Тайсоны гэртээ ирэхгүй болсныг хэрхэн тайлбарлах билээ?

Би энэ тохиолдлын дараах хэсэгт зөвхөн өөрийнхөө мэдрэмжийн тухай ярих болно. Би энэ зовлон зүдгүүрийг тэнгэр элч мэт өөрийн эхнэртэйгээ хамт туулсан ч, би эх хүний сэтгэлийг илэрхийлэхдээ тааруухан учир хэлэх гэж оролдохын ч хэрэггүй биз ээ.

Амьдралынхаа тэр үед мэдэрч байсан олон янзын мэдрэмжүүдийг дүрслэн хэлэх боломжгүй юм. Надад ихэнхдээ маш эвгүй хар дарсан зүүд шиг санагдах агаад тун удалгүй сэрмэгц мөнөөх хар дарсан зүүд алга болох мэт санагддаг байв. Олон шөнөөр би унталгүй өрөө хооронд хэрэн алхаж, хүүхдүүдийнхээ аюулгүй байгаа эсэхэд анхааран шалгаж болгоомжилдог байлаа.

Өөрийгөө буруутгах мэдрэмж нь сүнсийг маань тарчлаан зовоож байлаа. Би өөрийгөө буруутган, бохирлогдсон нэгэн мэт санадаг байв. Би түүний аав байж, түүнийг сэргийлэн хамгаалж чадах ёстой байсан. Би ердөө л энийг эсвэл тэрийг хийчихсэн бол гээд л харамсан боддог байв. Заримдаа тэртээ 22 жилийн өмнө өнгөрсөн тэдгээр мэдрэмжүүд одоо ч зүрх сэтгэлд минь эргэн ирдэг бөгөөд би тэдгээрээс аль болох хурдан салахыг хичээдэг. Учир нь тэд сүйрүүлэх аюултай.

Тайсонг нас барснаас хойш нэг сарын дараа би ахлагч Дийн Л.Ларсентай ярилцлаганд орсон юм. Тэр цаг гарган намайг сонссон бөгөөд би түүний зөвлөмж, хайранд ямагт талархалтай байдаг. Тэрээр, “Би Их Эзэн чамайг бяцхан хүүгийнхээ үхлийн төлөө өөрийгөө шийтгэхийг хүсч байгаа гэж бодохгүй байна” гэж хэлсэн. Би Тэнгэрлэг Эцэгийн хайрыг Түүний сонгосон нэгнээр дамжуулан тийн мэдэрч билээ.

Хэдий тийм ч тарчлаан зовоогч бодлууд маань над руу довтолсоор байсан бөгөөд удалгүй би уур уцаартай болж

эхэлсэн. “Энэ шударга бус байна! Бурхан надад яаж ингэж хандаж чадав аа? Яагаад би гэж?” Би үүнийг хүртэхээр юу хийсэн юм бэ? Би бүр намайг тайвшруулахыг оролдож байсан тэдгээр хүмүүст хүртэл уурлаж байв. Би найз нарынхаа, “Би чамд ямар байгааг мэдэж байна” гэж хэлэхэд нь би өөрөө өөртөө, “Чи миний юу мэдэрч байгааг яаж мэдэхэв дээ. Зүгээр л ганцааранг минь орхи” гэж боддог байв. Миний ингэж өөрийгөө өмөөрөх нь удалгүй намайг улам доройтуулна гэдгийг ойлгосон юм. Би өөртөө туслахыг оролдож байсан найз нарынхаа талаар эелдэг бус бодолтой байсандаа өөрөөсөө ичиж байна.

Би өөрийгөө буруутгаж, уурлаж, мөн өөрийгөө өмөөрөх тусам энэ нь намайг дотроос минь идэж байсан тул зүрх сэтгэлийн өөрчлөлтийг хүсэмжлэн залбирдаг байлаа. Маш нандин бөгөөд хувийн тохиолдлуудаар Их Эзэн надад зүрхийг минь шинэчлэн өгч, хэдийгээр хаа нэг ганцаардан шаналдаг ч миний бүхий л үзэл бодол өөрчлөгдсөн юм. Би хэн нэгэнд дээрэмдүүлж байгаа бус харин хэрэв би итгэлтэйгээ батлах юм бол агуу адислалууд хүлээж байгааг мэдсэн билээ.

Миний амьдрал өөрчлөгдөж, горьдлого цөхрөлтэйгөөр өнгөрснөө харж байснаас илүүтэйгээр найдвар дүүрэн ирээдүйг харж чаддаг болсон юм. Би энэ амьдрал төгсгөл биш гэдгийг гэрчилж байна. Сүнсний дэлхий бол бодит юм. Үхлийн дараах амьдралын тухай заасан бошиглогчдын сургаал нь үнэн юм. Энэ амьдрал бол бидний Тэнгэрлэг Эцэгтээ эргэн очих аялалын маань дайран гарах ёстой нэгэн алхам юм.

Тайсон гэр бүлийн маань нэгэн салшгүй хэсэг хэвээр үлдсэн юм. Олон жилийн турш манай гэр бүлд Тайсонгийн нөлөөллийг мэдэгдэхүйцээр мэдрэх боломжийг олгосон Тэнгэр дэх хайрт Эцэгийнхээ энэрэл, нинжин сэтгэлийг харах гайхамшигтай байсаар байна. Би гивлүүр маш нимгэн гэдгийг гэрчилж байна. Хайртай хүмүүсд маань хөшигний нөгөө талд гарахад бидний бие биедээ үнэнч байх, хайр болон гэр бүлийн нэгдмэл байдалд төгсгөл ирдэггүй харин ч эдгээр мэдрэмжүүдийг улам эрчимжүүлж байдаг.

Заримдаа хүмүүс, “Энэ бүгдийг даван туулахад хэр хугацаа хэрэгтэй байсан бэ?” гэж асуудаг. Үнэнийг хэлэхэд бид хагацаж одсон хайртай хүмүүстэйгээ дахин уулзтал хэзээ

ч бүрэн дүүрэн даван туулдаггүй. Би Дахин Амилуулалтын эхний өглөө гэр бүл маань бүхлээрээ эргэн нэгдэх хүртэл бүрэн дүүрэн аз жаргалыг мэдрэхгүй юм.

“Учир нь хүмүүн бол сүнс юм. Элементүүд мөнх юм, мөн салшгүй холбогдсон сүнс ба элемент нь баяр хөөрийн бүрэн байдлыг хүлээн авдаг;

“Мөн эдгээр нь салахад, хүмүүн баяр хөөрийн бүрэн байдлыг хүлээн авч чадахгүй.”<sup>3</sup>

Гэвч энэ хооронд Аврагчийн заасан шиг бид үргэлжлүүлэн зоригтой байж чадна.<sup>4</sup>

Гашуун бөгөөд бараг тэвчихийн аргагүй шаналал нь биднийг Тэнгэрлэг Эцэг рүүгээ хандан, Түүний төлөвлөгөөний дагуу, Түүний Хүү Есүс Христ, болон Түүний Тайвшруулагч болох Ариун Сүнсээр дамжин ирэх Түүний тайтгаралыг гуйснаар л амтлаг болдог тухайд би тийнхүү суралцсан юм.

Энэ бидний амьдрал дахь ямар дуурсгалт адислал билээ. Хүүхдээ алдчихаад агуу ихээр гашуудах сэтгэл төрөхгүй байх нь эмгэнэлтэй бус гэж үү? Тэнгэр дэх Эцэг минь биднийг гүн гүнзгий хийгээд мөнхөд хайрлах боломжийг олгосонд би Түүнд ямар их талархалтай байна вэ. Би мөнхийн гэр бүлүүдэд ямар их талархалтай байна вэ. Тэр Өөрийн амьд бошиглогчдоороо дамжуулан агуу гэтэлгэлийн төлөвлөгөөг дахин илчилсэнд би ямар их талархалтай байна вэ.

Хайртай нэгнийхээ салах ёслолд оролцоод оршуулгын газраас харихаар явж байхдаа авсыг нь хараад зүрх зүсэгдэх мэт болсон мөчөө эргэн санаарай.

Бидний Аврагч Есүс Христийн учир уй гашуу, ганцаардал, цөхрөл нэг л өдөр бүрэн дүүрэн баяр баясгалангаар солигдох болно гэдгийг би гэрчилж байна. Би Түүнд бид бүхэн найдаж болно гэдгийг гэрчилж байна. Тэрээр хэлэхдээ:

“Би та нарыг өнчрүүлж орхихгүй. Би та нар руу ирнэ.

“Хэсэг хугацааны дараа ертөнц намайг дахиж харахгүй. Харин та нар Намайг харна. Би амьд учраас, Та нар ч мөн амьд”<sup>5</sup> гэжээ.

*Миний Сайн Мэдээг Номло*, номонд хэлсэн байдаг шиг, “Бид Есүс Христийн Цагаатгалд найдвар тавих аваас өөрсдийн зовлон зүдгүүр, өвчин эмгэгийг тэвчихэд Тэрээр бидэнд

тусалж чадна. Бид баяр хөөр, амар амгалан хийгээд тайтгаралаар дүүрэн байж болно. Авралын талаарх шударга бус юм бүхэн Есүс Христийн Цагаатгалаар дамжин зөв болгогдож болно”<sup>6</sup> гэдгийг би гэрчилж байна.

Дахин амилуулалтын дуурсгалт нарлаг эхний өглөө та нарын болон миний хайрт хүмүүс Их Эзэний Өөрийн амласны дагуу булшнаасаа босч ирснээр бид бүрэн дүүрэн баяр баясгалантай болно гэдгийг би гэрчилж байна. Яагаад гэвэл Тэр амьд, тиймээс тэд мөн бид ч амьд байна. Есүс Христийн нэрээр, амен.

#### Эшлэлүүд

1. Моронай 8:10–12.
2. *Сүмийн Ерөнхийлөгчдийн Сургаалууд: Иосеф Смит (2007), 176.*
3. Сургаал ба Гэрээ 93:33–34.
4. Иохан 16:33-ыг үз.
5. Иохан 14:18–19.
6. *Миний Сайн Мэдээг Номло: Номлогчийн Үйлчлэлд Зориулсан Удирдамж (2004), 52.*

# Номлогч нараас асуу! Тэд танд тусалж чадна!

Ахлагч Рассел М.Нелсон

*Арванхоёр Төлөөлөгчдийн Чуулга*

*Залуу, ахмад гээд бүх номлогч нар бусдын альдралыг сайжруулах гэсэн найдварыг сэтгэлдээ тээн үйлчилдэг.*

Хайрт ах эгч, найз нар минь, бид хайр дүүрэн мэндчилгээгээ та бүхэндээ дэвшүүлж байна. Номлогчийн үйлчлэлд үйлчлэх боломжтой насыг залуу эрэгтэйчүүдийн хувьд 18 нас, залуу эмэгтэйчүүдийн хувьд 19 нас болгон өөрчилж байгаа талаарх Ерөнхийлөгч Томас С. Монсоны энэ өглөө зарласан мэдэгдлийг хүлээн авсандаа бид туйлын баяртай байна. Энэ боломжоор дамжуулан, илүү олон залуу номлогч номлолын адислалыг эдлэх боломжтой болох юм.

Хоёр жилийн өмнө Ерөнхийлөгч Монсоны хэлсэнчлэн “зохистой, боломж бүхий залуу эрэгтэй бүр номлолд үйлчлэх бэлтгэлтэй байх хэрэгтэй. Номлогчийн үйлчлэл бол санваартны үүрэг бөгөөд бидэнд хэмжээлшгүй ихийг өгдөг Их Эзэний биднээс хүсдэг үүрэг даалгавар юм”<sup>1</sup> хэмээн зарласан нь өнөө өглөө батлагдлаа. Мөн, залуу эгч нарын хувьд, тэднийг номлолд үйлчлэхийг дуртай хүлээн зөвшөөрдөг хэдий ч, заавал хийх ёстой үүрэг хариуцлага гэж үзэхгүй хэмээн тэр тайлбарласан билээ. Мөн дахин тэрээр ахмад хосуудад номлолд үйлчлэхийг урьсан билээ.

Номлолд бэлтгэх нь маш чухал зүйл билээ. Номлол гэдэг нь Бурханд болоод хүмүүн төрөлхтөнд үйлчлэх сайн дурын үйл хэрэг юм. Номлогчид энэхүү үйлчлэлдээ хувийн хадгаламжаа зарцуулдаг. Эцэг эхчүүд, гэр бүлүүд, найз нөхөд болон хандивлагчид Номлогчийн Ерөнхий Санд хандив өргөн

дэмжиж болно. Бүхий л залуу болон ахмад номлогчид бусдын амьдралыг сайжруулах чин хүсэлтэйгээр үйлчилдэг.

Номлолд үйлчлэх шийдвэр нь номлогчийн болон түүний хань ижлийн мөн тэдний одоогийн амьдралд улмаар ирээдүйн үр удмынх нь сүнслэг хувь заяанд нөлөө үзүүлдэг. Үйлчлэх хүсэл нь тухайн хүний хөрвүүлэлт, зөв зохистой болон бэлтгэгдсэн байдлаас гарч ирдэг жам ёсны үр дагавар юм.

Энэ өргөн уудам дэлхий даяар чуулганыг үзэн суугаа та бүхний дунд Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүн бус, бидний болон манай номлогч нарын талаар маш бага мэдээлэлтэй олон хүн байж магадгүй юм. Мормончуудын талаар болон манай номлогч нарын заадаг зүйлсийн талаар илүү ихийг мэдэхийг хүссэн учраас та энэхүү чуулганыг үзэн суугаа байж болох юм. Бидний талаар илүү ихийг мэдэх тусам бидний эрхэмлэдэг олон зүйл таныхтай адил байдгийг та олж мэдэх болно. Үнэн бөгөөд сайн болох бүх зүйлсийг хадгалж үлдээхийг тань бид урамшуулж байна, тэгээд бид таны эрхэмлэдэг тэдгээр үнэн дээр нэмж чадах эсэхийг харна уу. Энэ дэлхий сорилт бэрхшээлээр дүүрэн байдаг учраас заримдаа бидэнд тусламж хэрэгтэй болдог. Шашин шүтлэг, мөнхийн үнэн болон манай номлогч нар энэхүү шаардлагатай тусламжийн амин чухал хэсэг нь болдог юм.

Манай залуу номлогч нар өөрсдийн боловсрол, ажил төрөл, болзоо болон тэдний үе тэнгийнхний хийж буй тэдгээр бүхий л зүйлсээ хойш тавьдаг. Их Эзэнд үйлчлэх чин хүсэлдээ хөтлөгдөн тэд 18-аас 24 сарын турш дэлхийн зарим нэг зүйлээс татгалзаж өнгөрөөдөг.<sup>2</sup> Мөн зарим номлогч нар маань нэлээд нас тогтсон хойноо номлолд үйлчилдэг. Тэдний гэр бүлийнхэн нь адислагддаг болохыг би мэднэ. Миний өөрийн гэр бүлээс одоогоор гурван охин маань нөхрүүдтэйгээ ахмад номлогчоор, нэг зээ охин мөн нэг зээ хүү нийлээд найман хүн бүрэн цагийн номлолд үйлчилж байна.

Та нарын зарим нь *Мормон* гэдэг нэрний талаар гайхаж байж магадгүй юм. Энэ нь бидний хоч юм. Бид Мормончууд гэдгээрээ олонд танигдсан ч энэ нь бидний жинхэнэ нэр биш



бөгөөд энэ нь Мормоны Ном гэдэг ариун судраас гарал үүсэлтэй билээ.

Сүмийн маань жинхэнэ нэр нь Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм юм. Есүс Христийн анхны Сүмийг дахин сэргээн байгуулсан нь энэ билээ. Мөнх бус амьдралынхаа явцад Тэрээр өөрийн сүмийг зохион байгуулсан билээ. Тэрээр Төлөөлөгчид, Далын гишүүд мөн бусад удирдагчдыг дуудан Өөрийнх нь нэр дээр үйлдэх санваарын эрх мэдлийг өгсөн юм.<sup>3</sup> Христ болон Түүний Төлөөлөгчид нас барсны дараа хүмүүс сургаал болон ёслолуудыг өөрчилсөн байдаг. Анхны Сүм болон санваар нь тэр үед авагдаж үгүй болсон билээ. Үнэнийг үл ойшоон, мухар сүсэг дэлгэрсэн тэрхүү цаг үеийн дараа Тэнгэрлэг Эцэгийн удирдлага дор Есүс Христ Өөрийн Сүмийг буцаан авчирсан юм. Одоо тэр сүм нь дахин оршиж, сэргээгдсэн бөгөөд Түүний тэнгэрлэг удирдлага дор үйл ажиллагаагаа явуулж байна.<sup>4</sup>

Бид Есүс Христийг дагаж, Түүний тухай заадаг. Үхлийг давсан агуу ялалтынхаа дараа дахин амилсан Их Эзэн нэлээд хэдэн тохиолдлоор Өөрийн төлөөлөгчдөдөө үзэгдсэн гэдгийг бид мэднэ. Тэрээр тэдэнтэй хамт хооллосон. Тэдэнтэй хамт алхаж байсан. Сүүлийн удаа дээш одохоосоо өмнө, Тэрээр “Явж . . . бүх үндэстнүүдэд заа. Эцэг, Хүү, Ариун Сүнсний нэрээр тэдэнд баптисм хүртээ”<sup>5</sup> хэмээх үүргийг тэдэнд өгсөн. Төлөөлөгчид тэрхүү зааврыг дуулгавартай дагасан. Түүнчлэн тэд Их Эзэний тушаалыг биелүүлэхэд нь туслах хүмүүсийг дуудсан.

Өнөөдөр орчин үеийн төлөөлөгчид, бошиглогчдын удирдлага дор үүнтэй адил үүрэг хариуцлага нь Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн номлогч нарт өгөгдсөн. Эдгээр номлогч нар 150 гаруй үндэстэнд үйлчилдэг. Их Эзэн Есүс Христийн төлөөлөгчдийн хувьд тэд, Их Эзэний өөрийнх нь шинэчилсэн тэрхүү ариун зарлигийг биелүүлж, сайн мэдээний бүрэн байдлыг далайн чанадад хүргэж, газар сайгүй хүмүүсийн амьдралыг адислахаар хичээн үйлчилдэг.<sup>6</sup>

Залуу номлогч нар маань хорь гаруйхан настай дэлхийн амьдралын туршлага багатай хэдий ч Их Эзэний хүчирхэг элч төлөөлөгчид болгодог чадвар бүхий Ариун Сүнсний хүч,

Бурханы хайр, үнэний гэрчлэлүүд гэх мэт бэлгүүдээр тэд адислагддаг юм. Номлогчдын захиасыг дагасан тэдгээр бүгдэд үнэн баяр баясал, үүрдийн аз жаргал авчрах сургаалын сайн мэдээг тэд хуваалцдаг. Ихэнх тохиолдолд тэд номлолоо гадаад оронд, гадаад хэл дээр хийдэг билээ.

Номлогч нар Есүс Христийн хэл яриа, үйлдэл аль алинаар нь дагахыг хичээдэг. Тэд Есүс Христ болон Түүний Цагаатгалыг номлодог.<sup>7</sup> Тэд Их Эзэний хожмын үе дэх анхны бошиглогч Иосеф Смитээр дамжин сэргээгдсэн Христийн эртний Сүмийн бодит сэргээлтийн талаар заадаг.

Та урьд нь манай номлогч нартай тааралдаж байсан эсвэл тэднийг үл ойшоож байсан байж магадгүй юм. Та тэднээс айж эмээлгүй, харин тэднээс суралцаасай хэмээн би найдан хүсч байна. Тэд таны хувьд тэнгэрээс илгээгдэх тэрхүү боломж тань байж мэднэ.

Яг л ийм зүйл Аризона мужийн Меса хотод амьдардаг 60 гаруй настай Протестант шашинтан Жерри хэмээх нэгэн эрэгтэйд тохиолдсон юм. Жерригийн аав нь Баптист сүмийн тэргүүн, ээж нь Методист сүмийн тэргүүн байжээ. Нэгэн өдөр Жерригийн дотны найз Присила төрөхийн хүндрэлээс болж хүүхдээ алдаж мөн удалгүй хүнд бэрхшээл дагуулсан гэр бүл салалтаас мэдэрсэн зовлонгуудаа түүнтэй хуваалцжээ. Ганц бие зүдэрч буй дөрвөн хүүхдийн ээж Присила нь гурван охин, нэг хүүтэй байв. Жеррид зүрх сэтгэлээ нээн зовлонгоо уудлах зуураа тэрээр амиа хорлох тухай бодолтой байснаа ч илчлэн хэлжээ. Жерри бүх чадлынхаа хэрээр түүнд амьдралынх нь үнэ цэнийг ойлгуулахыг хичээсэн бөгөөд мөн түүнийг өөрийнхөө сүмд ирэхийг урьсан боловч Присила Бурханд найдахаа больсон тухай тайлбарлан хэлжээ.

Жерри хэрхэхээ мэдэхгүй хэсэг байсны дараа нэг удаа хашаан дахь модоо усалж байхдаа Бурханаас удирдамж хүсэн залбирав. Тэрээр маш их итгэлтэй нэгэн байлаа. Залбирч байхдаа тэрээр “Дугуйтай хөвгүүдийг зогсоо” гэсэн дуу хоолойг зүрх сэтгэлдээ сонсжээ. Жерри, энэ нь юу гэсэн утгатай юм бол доо гэж гайхшран хэсэг тээнэгэлзэн зогсов. Энэ сүнслэг удирдамжийг тунгаан бодох зуураа Жерри гудамж тийш харвал зангиа бүхий цагаан цамцтай хоёр залуу түүний гэрийг чиглэн дугуйтай ирж харагдлаа. Энэ сонин

тохиолдолд балмагдсандаа тэднийг харсаар байж хажуугаараа өнгөрүүлэв. Тухайн нөхцөл байдал түүнийг үйлдэл хийхийг шаардаж буйг анзаарангуут, “Хөөе, та нар зогсоорой! Би та нартай ярих хэрэгтэй байна!” гэж хашгирчээ.

Эргэлзсэн хэдий ч цоглог харцтай хоёр залуу номлогч саатан зогсов. Тэднийг ойртон ирэхэд Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн номлогч хэмээн тодорхойлох нэрийн тэмдэг зүүсэн байхыг нь Жерри анзаарчээ. Жерри тэдэн рүү хараад “Та нарт бага зэрэг хачирхалтай санагдаж магадгүй, гэхдээ саяхан намайг залбирах үед ‘дугуйтай хөвгүүдийг зогсоо’ гэсэн заавар надад ирэхийг мэдэрлээ. Тэгээд намайг гудамж руу хартал, та хоёр явж байх юм. Та нар надад тусалж чадах уу?” гэж асуув.

Номлогч нар инээмсэглэн “Тиймээ, бид танд тусалж чадна.” хэмээн хариулав.

Жерри тэдэнд Присилагийн талаар санаа зовж байгаа тухайгаа тайлбарлав. Удалгүй номлогч нар Присила, түүний хүүхдүүд болон Жерритэй уулзан, тэд амьдралын зорилго болон тэдэнд зориулсан Бурханы мөнхийн төлөвлөгөөний талаар хэлэлцэн ярилцацгаажээ. Чин сэтгэлийн залбирал хийн, Мормоны Номноос суралцан мөн Сүмийн гишүүдийн хайр дүүрэн нөхөрлөлөөр дамжуулан Жерри, Присила, мөн түүний хүүхдүүдийн итгэл өсөн нэмэгдсэн юм. Жеррид байсан Есүс Христэд итгэх хүчтэй итгэл нь улам хүчирхэг болсон байна. Присилагийн эргэлзээ болон амиа хорлох гэсэн бодлууд нь аз жаргал, итгэл найдвараар солигджээ. Тэд баптисм хийлгэн Христийн сэргээгдсэн Сүмийн гишүүд болцгоосон юм.<sup>8</sup>

Тийм ээ, номлогч нар олон янзаар тусалж чадна. Жишээлбэл, та нарын зарим нь өвөг дээдсийнхээ талаар илүү ихийг мэдэхийг хүсдэг байж болно. Та ээж аав, хоёр эмээ, хоёр өвөөгийнхөө нэрийг мэддэг байж магад, тэгвэл элэнц хуланцынхаа талаар юу мэдэх вэ? Та тэдний нэрсийг мэдэх үү? Тэдний талаар илүү ихийг мэдмээр байна уу? Номлогч нараас асуу! Тэд танд тусалж чадна!<sup>9</sup> Тэдэнд Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн асар том гэр бүлийн түүхийн баримтуудыг хялбархан ашиглах боломж байдаг.

Та нарын зарим нь сүмийн гишүүн хэдий ч одоогоор сүмийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцдоггүй байж болно. Та Их Эзэнд хайртай мөн Түүний сүрэгт буцан нийлэх талаар үргэлж боддог байх. Харин та яаж эхлэхээ мэдэхгүй байгаа байх. Та нарыг номлогч нартай уулзаж асуу!<sup>10</sup> гэж зөвлөмөөр байна. Тэд танд тусалж чадна! Тэд бас таны хайртай хүмүүст зааж тусалж чадна. Бид номлогч нарын адил та бүгдэд хайртай бөгөөд сайн мэдээний гэрэл болон баяр баяслыг таны амьдралд буцаан авчрахыг хүсэж байна.

Та нарын зарим нь хэрхэн донтолтыг даван туулахаа эсвэл хэрхэн урт насалж, илүү сайн эрүүл мэндтэй болох талаар мэдэхийг хүсч байж магадгүй. Номлогч нараас асуу! Тэд танд тусалж чадна! Бие даасан судалгаануудаас үзэхэд Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийнхнийг бүлэглэлийн судалгаагаар эрүүл мэнд сайтай хүмүүс гэсэн байдаг. Урт хугацаанд хийгдсэн аливаа нарийвчилсан бүлэглэлийн судалгаанууд дотроос тэдний нас баралтын түвшин нь хамгийн бага, урт наслалтын хэмжээ нь өндөр гэж одоогоор дүгнэгдээд байна.<sup>11</sup>

Та нарын заримын тань амьдрал ухаан жолоогүй, завгүй мэт санагдавч зүрх сэтгэлийнхээ гүнд та зүг чиггүй, зорилгогүй мэт хоосон сэтгэл зовнилыг мэдэрдэг биз. Номлогч нараас асуу! Тэд танд тусалж чадна! Тэд энэ дэлхий дээр та яагаад ирснийг мөн үхлийн дараа хаашаа явах зэрэг амьдралын үнэн зорилгын талаар сурахад танд тусалж чадна. Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээ нь одоогоор таны төсөөлж байгаагаас илүүтэйгээр таны амьдралыг хэрхэн адисалж болохыг та мэдэж чадна.

Гэр бүлийнхээ талаар санаа тань зовж байгаа бол номлогч нараас асуу! Тэд танд тусалж чадна! Гэрлэлт болон гэр бүлийг хүчирхэгжүүлэх гэдэг нь Хожмын үеийн Гэгээнтнүүдэд асар чухал зүйл байдаг. Гэр бүлүүд мөнхөд хамтдаа байж чадна. Таны гэр бүл хэрхэн үүрд хамт байх боломжтой талаар номлогч нараас асуу.

Номлогч нар бас таны илүү ихийг мэдэх хүсэлд тань тусалж чадна. Хүмүүний сүнс нь гэгээрлийг маш ихээр хүсдэг. Шинжлэх ухааны лаборатороос эсвэл Бурханы илчлэлтээр

үнэн л гарч ирж байвал бид түүнийг эрэлхийлдэг. Бурханы алдар суу бол үнэхээр оюун билиг юм.<sup>12</sup>

Мэдлэгийн өсөлт дотор сүнслэг болон дэлхийн түр зуурын мэдлэгүүд багтдаг. Бид ариун судруудыг ойлгохын чухлыг онцолдог. Саяхны нэгэн бие даасан судалгаагаар Хожмын үеийн Гэгээнтнүүд нь Библи болон Христийн шашны талаар хамгийн их мэдлэгтэй нь хэмээн тогтоогдсон.<sup>13</sup> Хэрвээ та Библийг болон Мормоны Номыг илүү сайн ойлгохыг, бүх хүн төрөлхтний ахан дүүсийн барилдлага болон Бурхан Эцэгийн талаар өргөн ойлголтыг олж авахыг хүсвэл Номлогч нараас асуу! Тэд танд тусалж чадна!

Та нарын олонх нь тусламж шаардлагатай хүмүүст туслах чин хүсэлтэй байдаг. Бид Есүс Христийг дагадаг учраас, Хожмын үеийн Гэгээнтнүүд ч бас тэрхүү дуусашгүй хүсэл эрмэлзлээр бялхаж байдаг.<sup>14</sup> Дэлхийн хаана ч гамшигт нэрвэгдсэн тэдгээр хүмүүст дэмжлэг үзүүлэхэд, мөн тусламж хэрэгтэй хүмүүст туслахад та нарын хэн нь ч бидэнтэй нэгдэж болно. Хэрвээ та үүнд хамрагдахыг хүсвэл номлогч нараас асуу! Тэд танд тусалж чадна!

Мөн хэрвээ та үхлийн дараах амьдралын талаар, тэнгэрлэг зүйлийн талаар, танд зориулсан Бурханы төлөвлөгөөний талаар илүү ихийг мэдэхийг хүсвэл, түүнчлэн Их Эзэн Есүс Христ, Түүний Цагаатгал, анх байгуулсаны адил Дахин сэргээгдсэн Түүний Сүмийн талаар илүү мэдэхийг хүсвэл номлогч нараас асуу! Тэд танд тусалж чадна!

Би Бурхан амьд гэдгийг мэднэ. Есүс бол Христ. Түүний Сүм дахин сэргээгдсэн. Бурхан та бүгдийг болон бидний эрхэм номлогч нарыг нэг бүрчлэн адислаасай хэмээн би чин сэтгэлээсээ залбирч байна. Есүс Христийн нэрээр, Амен.

### Эшлэлүүд

1. Томас С. Монсон, “Биднийг дахин уулзтал,” 2010 оны 10-р сарын чуулган дээр хэлсэн үгс, 2010 оны 11-р сар, 5–6
2. Сургаал ба Гэрээ 4:3-ыг үз.
3. Матай 10:1; Лук 6:13; 10:1; Ефес 4:11–12-ыг үз.
4. Сургаал ба Гэрээ 1:30-ийг үз.
5. Матай 28:19.
6. Сургаал ба Гэрээ 68:8; 84:62; 112:28.
7. 1 Коринт 2:2; 2 Нифай 25–26.
8. Аризона Меса Номлолын ерөнхийлөгч байсан В. Трэси Уотсон, Ахлагч Нелсон нарын найзын харилцаанаас.
9. “Номлогч нараас асуу” хэмээх урилгыг хэлсэн минь та нар

- Сүмийн гишүүн найзаасаа ч асууж болно гэсэн үг юм шүү.
10. Сүмийн идэвхтэй гишүүн хамаатнууд, найз нөхөд болон Сүмийн удирдлагууд ч гэсэн дуртай туслах болно.
  11. Жеймс Е. Энстром болон Лестер Бреслоу нарын , “Lifestyle and Reduced Mortality among Active California Mormons, 1980–2004,” *Preventative Medicine*46 (2008), 135-ийг үз.
  12. Сургаал ба Гэрээ 93:36-г үз.
  13. Пью Судалгааны Төвийн *U.S. Religious Knowledge Survey* (Sept. 28, 2010), 7-ийг үз.
  14. Рам Наан, Ван Эванс, Даниел В. Көртиснарын *Called to Serve: The Prosocial Behavior of Active Latter-day Saints*, Пенсилвань Их Сургуулийн Нийгмийн Бодлого болон Дадлагын Тэнхим (2012), -ийг үз.  
<http://www.mormonnewsroom.org/article/mormon-volunteerism-report>; Пью Судалгааны Төв, *Mormons in America; Certain in Their Beliefs but Uncertain of Their Place in Society* (2012), 43; Роберт Д. Путнам болон Дэвид Е. Кэмбилл, *American Grace: How Religion Divides and Unites Us*(2010), 444–54.

# Харуусал ба шийдвэрүүдийн талаар

Тэргүүн Зөвлөлийн Хоёрдугаар Зөвлөх

Ерөнхийлөгч Диетер Ф.Угдорф

---

*Аз жаргал, ариун зүйлсийг олж авахын төлөө бид өөрсдийгөө хэдий чинээ дайчлана төдий чинээ хожим харамсах шалтгаан маань багасна.*

---

## Харууслын талаар

Ерөнхийлөгч Монсон бид танд хайртай. Шинэ ариун сүмүүдийг барих болон номлогчийн үйлчлэлийн талаар илчлэгдсэн мөн түүхэн мэдэгдлийг өгсөнд тань баярлалаа. Үүгээр дамжуулан бидэнд мөн ирээдүйн олон үе удамд аугаа их адислалууд ирэх болно.

Ах, эгч, хүндэт найз нараа! Бид бүгдээрээ мөнх бус. Энэ нь хэний ч гайхалыг төрүүлэхгүй байх гэж би найдаж байна.

Бид дэлхий дээр нэг их удаан амьдрахгүй. Дэлхий дээр бид үнэт хэдэн жилийг өнгөрөөдөг ч, мөнх амьдралтай харьцуулахад энэ нь нүд ирмэх шиг л богинохон.

Тэгээд бид энэ амьдралаас хагацан оддог. Бидний сүнс “[өөрсдөд нь] амьдралыг өгсөн Бурханд, гэртээ аваачигддаг.”<sup>1</sup> Бид махбодоо орхин, энэ дэлхийн эд юмсаа ардаа үлдээж амьдралынхаа дараагийн орчинд шилжин ордог билээ.

Залуу байхдаа бид мөнх амьдрах юм шиг л боддог. Бидэнд бидний амьдралын өдрүүд хязгааргүй юм шиг, ирээдүй маань дуусахгүй үргэлжлэх зам шиг санагддаг.

Харин нас ахих тусам, бид өнгөрсөн үеэ эргэн дурсаж, тэрхүү зам ямар богинохон байсныг мөн тэр жилүүд ямар хурдан өнгөрсөнийг гайхдаг. Тэгээд бид гаргасан сонголтуудаа, хийсэн зүйлсээ тунгаан бодож эхэлдэг. Энэхүү

явцад бидний санаа сэтгэлд дулааныг, зүрхэнд баяр баясгаланг өгсөн мөчүүдийг дурсан санадаг. Бид бас харамсаж явдаг эргэж очоод өөрчилчих юмсан гэсэн тэдгээр зүйлээ эргэн санадаг билээ.

Эдгэршгүй өвчтэй хүмүүсийг асардаг нэгэн сувилагч энэ амьдралаас одох гэж буй өвчтөнүүдээсээ нэгэн энгийн асуултыг асуудаг байжээ.

Тэрээр “Танд харамсдаг зүйлс бий юу?” хэмээн асууна.<sup>2</sup>

Мөнх бусын эцсийн өдөрт тулан очиход бодол санаа маань тодорхой болж, ухаарал мөн алсын хараа нээгдэнэ. Тэдгээр хүмүүсээс харамсаж явдаг зүйлсийнх нь талаар асуухад тэд зүрх сэтгэлээ нээцгээжээ. Цаг хугацааг эргүүлж чаддагсан бол тэд юуг өөрчлөх байсан талаараа бодож эхэлсэн байна.

Тэдний хэлснийг бодох тоолонд, дагах л юм бол Есүс Христийн сургаалын үндсэн зарчмууд үнэхээр бидний амьдралыг сайн сайхан руу хөтлөх юм байна гэдэг нь улам тодорхой болж байсан юм.

Сургаалын зарчмуудад учир битүүлэг зүйлс нэгээхэн ч байхгүй. Бид тэдгээрийг судраас суралцаж, Ням гарагийн хичээл дээр бие биетэйгээ ярилцаж, өгч байгаа яриануудаас олон удаа сонсож байсан. Энэхүү тэнгэрлэг зарчим болон жишгүүд нь энгийн бөгөөд ойлгомжтой; тэд гайхалтай, төгс, мөн агуу хүчтэй; бас бидэнд ирээдүйд харамсах зүйлс хийхгүй байхад тусалдаг.

### **Хайртай хүмүүстэйгээ илүү их цагийг өнгөрөөх минь яав даа**

Хоногоо хүлээж буй өвчтөнүүд хайртай хүмүүстэйгээ илүү их цаг өнгөрөөгөөгүйдээ харамсаж байсан нь нийтлэг байсан юм.

“Амьдралынхаа хамаг цагийг [өдөр тутмын] ажил дээрээ өнгөрүүлсэндээ маш их харамсдаг”<sup>3</sup> гэх үгсийг дэлхий нийтээрээ, тэр дотроо эрчүүд илүү ихээр хэлдэг юм. Маш олон хүн гэр бүлийнхэн, найз нөхөдтэйгөө хамт байсан сайхан дурсамжуудыг бүтээх боломжоо алдсан байдаг. Өөрсөддөө хамгийн чухал тэдгээр хүмүүстэйгээ гүн гүнзгий холбоог байгуулж чадаагүй байдаг юм.

Бид ихэвчлэн маш завгүй байдаг нь үнэн биз дээ? Тэр ч бүү хэл бид завгүй байдлаа хүндэтгэлийн хэргэм мэт зүүж, завгүй



байх нь амжилт, илүү сайхан амьдралын бэлэг тэмдэг хэмээн үздэг нь үнэхээр харамсмаар.

Энэ тийм гэж үү?

Бидний Их Эзэн мөн Жишээ Үзүүлэгч Есүс Христ, Түүний Иерусалим болон Галилын хүмүүсийн дунд өнгөрүүлсэн богинохон амьдралынх нь талаар би боддог юм. Би Түүнийг хурлаас хурал руу гүйж байгаагаар эсвэл яаралтай зүйлүүдээ амжуулах гэж сандарч байгаагаар төсөөлөх гэж оролддог.

Ёстой болдоггүй юм.

Харин би нигүүлсэнгүй, энэрэнгүй Бурханы Хүү өдөр болгон зорилготойгоор амьдарч буйг хардаг. Тэрээр эргэн тойрныхоо хүмүүстэй харьцахад, тэд чухал, хайрлагддаг болохоо мэдэрдэг байсан юм. Тэр уулзсан хүн болгоныхоо хязгааргүй үнэ цэнийг мэддэг байсан. Тэр тэднийг адислаж, тэдэнд тохинуулж байлаа. Тэр тэднийг өргөж мөн эдгээж байсан. Өөрийн цаг заваа тэдэнд нандин бэлэг болгон барьсан юм.

Өнөө үед бусадтай хамт байгаа мэт дүр эсгэх нь хялбархан болж. Компьютерийн товчлуурын хэдхэн даралтаар бид хэдэн мянган “найз” нартайгаа нэгнийх нь ч царайг харалгүйгээр “холбогдох” нь олонтоо. Технологи нь гайхалтай зүйл байж болно. Хайртай хүмүүсийнхээ ойр байх боломжгүй үед их тус болдог. Эхнэр бид хоёр хайрт гэр бүлээсээ хол амьдардаг. Тийм болохоор энэ нь ямар байдгийг мэднэ. Гэхдээ интернет дээр инээдтэй сонирхолтой зураг тавьж, ямар ч ач холбогдолгүй зүйлс бие бие рүүгээ илгээж эсвэл тэдэнд өөр интернетийн сайт санал болгосноор гэр бүл, найз нөхөдтэйгээ холбогдохлоо гэж үздэг болж байгаа нь бид буруу хөгжөөд байна уу даа гэсэн бодлыг төруулнэ. Хааяа нэг ингэх хэрэг гарах л байх, гэхдээ бид үүнд хэр их цаг хугацаа зарцуулаад байна аа? Бидэнд үнэхээр чухал хүмүүстээ цаг гаргаж, тэдэнтэйгээ хамт байхын тулд хичээхгүй юм бол хожим нэг өдөр харамсах болно шүү дээ.

Бүгдээрээ хайртай хүмүүстэйгээ хамтдаа байж, өгөөжтэй цагийг тэдэнтэй өнгөрөөж, үнэт дурсамжуудыг бий болгох арга олцгооё.

## Өөрийн чадвараа бүрэн дайчлах маань ч яав даа

Хүмүүс бас хүсэж байсан шигээ эсвэл болох ёстой байсан шигээ хүн болж чадаагүйдээ харамсдаг байна. Тэд амьдралаа эргэн харахад өөрсдийн чадвараа бүрэн дайчлаагүй, хийж болох байсан олон зүйлийг хийгээгүй байснаа ухаардаг.

Өөрсдийнхөө мэргэжилд амжилт гаргах талаар би энд яриагүй байна. Энэ амжилт нь хичнээн агуу байсан ч биднийг хүлээж буй тэрхүү агуу мөнхийн аянд ганцхан алхам төдий л юм.

Харин би Бурханы хүсэж байгаа шиг тийм хүн болох талаар ярьж байна.

Нэгэн яруу найрагч бид энэ дэлхийд өмнөх амьдралаа “алдар суун үүлийг мөшгөн”<sup>4</sup> ирсэн хэмээн хэлсэн.

Тэнгэрлэг Эцэг маань бидний жинхэнэ чадавхийг мэднэ. Тэр бидний өөрсдийнхөө тухай мэдэхгүй тэр зүйлүүдийг мэддэг. Тэр биднийг энд амьдрах хугацаандаа бүтээгдсэн зорилгоо биелүүлж, сайн сайхан амьдралаар амьдарсаар, Түүний дэргэд эргэж очихыг сануулж байдаг.

Тэгтэл бид яагаад агшин зуурын, чухал биш, өнгөцхөн зүйлст хамаг цаг зав, хүч чадлаа үрээд байдаг юм бэ? Ач холбогдолгүй, түр зуурын зүйлсийн араас хөөцөлдөхөө яагаад болихгүй байна вэ?

“Тэнгэрт эд баялгийг [өөрсөддөө] хураа. Учир нь тэнд хивэн хорхой болоод зэв идэж сүйтгэдэггүй, хулгайч ч эвдэж ордоггүй, хулгайлдаггүй”<sup>5</sup> гэдэг үгсийг дагах нь дээр биш гэж үү?

Үүнийг бид яаж хийх вэ? Аврагчийн жишээг дагаж, Түүний заасан зүйлсийг амьдралдаа хэрэгжүүлж, Бурхан мөн бусдыг чин сэтгэлээсээ хайрлаж байж үүнийг хийж чадна.

Бурханы шавь болох замдаа хөлөө зөөж ядан, байн байн цаг руугаа хяламхийн, алхам тутамдаа гомдоллосноор үүнийг лав хийж чадахгүй.

Сургаалаар амьдрахдаа бид усанд хөлийнхөө хурууг дүрчихээд сэлээд ирлээ гэж хэлдэг хөвгүүн мэт байж болохгүй. Бид Бурханы охид хөвгүүд учир илүү их зүйлийг хийх чадвартай. Гэхдээ хийхийг хүслээ гээд л энэ бүгд биелэхгүй. Бид ямар нэгэн зүйл хийх ёстой. Бид бүр Тэнгэрлэг Эцэгийн хүсэж байгаа шиг тийм хүмүүс болох ёстой.

Сургаалын талаарх гэрчлэлээ тунхаглах нь сайн хэрэг гэхдээ амьдрал маань дахин сэргээгдсэн сургаалын жишиг болж байвал бүүр ч сайн. Өөрсдийнхөө хийсэн гэрээнд үнэнч байхыг хүсэх нь сайн хэрэг. Гэхдээ, ариун гэрээндээ үнэнч байж, зөв зохистой амьдралаар амьдарч, аравны нэгээ төлж, бусад өргөлөө өргөж, Мэргэн Ухааны үгсийг сахьж, хэрэгцээтэй гэдэнд үйлчилж байвал бүүр сайн. Гэр бүлийн залбирал, судраас суралцах, гэр бүлээрээ эрүүл таатай үйлд оролцоход илүү их цаг гаргана хэмээн зарлах нь сайн хэрэг гэхдээ эдгээрийг тууштайгаар хийсэн цагт л бидний амьдралд тэнгэрлэг адислалууд ирнэ.

Бурханы шавь байна гэдэг нь аз жаргал, ариун зүйлсийг эрмэлзэхийг хэлдэг. Энэ нь биднийг хамгийн сайн, аз жаргалтай болгох зам юм.

Бүгдээрээ Аврагчийг дагаж, анхнаасаа ямар болохоор төлөвлөгдсөн байсан яг тийм хүн болохын төлөө хамгаа зориулах шийдвэрийг гаргацгаая. Бүгдээрээ Ариун Сүнсний өдөөлтийг сонсож, дуулгавартай дагацгаая. Ингэх юм бол бидэнд байгаа гэж зүүдлээ ч үгүй тэдгээр зан чанаруудыг Тэнгэрлэг Эцэг маань бидэнд нээж өгнө. Тэрээр бидний өмнөх замыг гэрэлтүүлж, нууцлаг, бидэнд байгаа ч гэж таамаглахгүй байгаа тэдгээр авьяас чадваруудыг олж харах нүд өгөх болно.

Аз жаргал, ариун зүйлсийг олж авахын төлөө бид өөрсдийгөө хэдий чинээ дайчлана төдий чинээ хожим харамсах шалтгаан маань багасна. Аврагчийн ивээлд хэдий чинээ найдна төдий чинээ Тэнгэр дэх Эцэгийн хүсэж буй тэрхүү зам дээр байгаагаа бид мэдрэх болно.

### **Илүү аз жаргалтай байх минь яав даа**

Удахгүй үхнэ гэдгээ мэдэж буй хүмүүсийн харамсдаг өөр нэгэн зүйлийг хэлэхэд та бүхэн гайхах байх. Тэд өөрсдийгөө илүү их аз жаргалтай байлгасан ч болоосой гэж хүсдэг юм.

Гэр бүлийн сайн сайхан байдал, хангалттай орлого, асуудлын маань төгсгөл нэг үгээр хэлэхэд биднийг аз жаргалтай болгох бүхэн энүүхэнд, булан тойроод л байгаа юм шиг санасаар хамаг амьдралаа өнгөрүүлдэг.

Гэвч нас ахих тусам өнгөрсөн үеэ эргэн харж, гаднах нөхцөл байдлууд тийм ч чухал бус, бидний жаргах, эсэхэд огт нөлөөлдөггүй юм байна гэдгийг ухаардаг.

Харинбид нарбол чухал. Бид өөрсдөө л жаргах үгүйгээ шийдэцгээнэ.

Эцсийн эцэст бид нар л өөрсдийнхөө аз жаргалын эзэд шүү дээ.

Миний эхнэр Хэрриет бид хоёр дугуй унах их дуртай. Байгалийн гоо сайхныг бишрэн гадуур явах сайхан байдаг. Бидэнд дагах дуртай зам байдаг ч бид хэр их хол явж байгаагаа эсвэл бусдаас хэр их хурдалж байгаагаа нэг их анзаараад байдаггүй.

Гэсэн ч бид илүү өрсөлдөөнч байх ёстой юм шиг санагдах үе надад гардаг. Өөрсдийгөө жаахан л дайчилчихвал бид арай хурдан болж нэгэн шинэ өндөрлөгт хүрчих юм шиг санагддаг гэж би боддог. Заримдаа би энэ санаагаа эхнэртэйгээ хуваалцаж том алдаа гарганаа.

Иймэрхүү маягийн санал гаргахад эхнэр маань ихэвчлэн эелдэг, тодорхой, шулуун шударга хариу өгдөг. Тэр инээгээд, “Диетер, энэ чинь уралдаан биш аялал шүү дээ. Үүнээсээ таашаал ав л даа” гэж хэлдэг.

100 хувь түүний зөв. Түүний хичнээн зөв болохыг би энд дурдаад ч яахав!

Заримдаа бид бариан дээрээ хамаг анхаарлаа хандуулчихаад аялалаасаа таашаал авахаа мартчихдаг. Аялалаа дуусгахын төлөө би эхнэртэйгээ дугуй унахаар явдаггүй. Түүнтэй хамт байхад маш амттай мөн гайхалтай байдаг учраас би түүнтэйгээ явдаг юм.

Таатай, баяр баясгалантай мөчүүдийг анзаарахгүй зөвхөн дуусахыг нь хүлээсээр байгаа нь мунхаг хэрэг бус уу?

Сүүлийн эгшиг замхарч алга болсны дараа л сайхан хөгжмөөс таашаал авахаар чих тавин сонсож эхэлдэггүй биз дээ? Үгүй. Бид хөгжмийн зохиолын ая эгшиг, айзам хэмнэл, хөг нот бүрийг нь алдалгүй сонсож байж таашаал авдаг.

Бид нар зөвхөн “амен” гэж хэлэхийн тулд эсвэл дуусгахын тулд залбирдаггүй биз дээ? Мэдээж үгүй. Бид Тэнгэрлэг Эцэгтэй ойрхон байж, Түүний Сүнсийг хүлээн авч, Түүний хайрыг мэдрэхийн тулд залбирдаг.

Бид аз жаргал маань үргэлж хажууханд байсныг үл анзааран ирээдүйд хаа нэгтэй байгаа аз жаргалаа хүлээн амьдрах ёсгүй юм шүү. Өнгөрсөн амьдарлынхаа л сайн

сайханд баясаг гэж бидэнд амьдрал заяагаагүй. “Энэ бол Эзэний бүтээсэн өдөр . . . ,” үүнд хөгжилдөн баясцаа”<sup>6</sup> хэмээн Дуулалд бичигдсэн байдаг.

Ах эгч нараа, бид ямар ч нөхцөл, ямар ч зовлон зүдгүүр эсвэл сорилтод байсан хамаагүй өдөр болгон ямар нэгэн гайхалтай, нандин зүйлс бидэнтэй тохиолддог юм шүү. Харж, талархалтай хүлээн авч чадах л юм бол биднийг баярлуулах зүйлс өдөр болгон болж байдаг юм.

Магадгүй бид нүдээрээ биш зүрх сэтгэлээрээ хайж эхлэх ёстой юм болов уу. Би нэгэн эшлэлд маш дуртай. “Зөвхөн зүрх сэтгэлээрээ л бид хамгийн тод томруун хардаг. Нүдэнд харагддаг чухал зүйл гэж нэгээхэн ч үгүй.”<sup>7</sup>

Бидэнд “бүхий л зүйлд талархах”<sup>8</sup> хэрэгтэй хэмээн тушаасан билээ. Тиймээс амьдралын болж бүтэхгүй байгаа зүйлийг томруулан харж байснаас мэлмий мөн зүрх сэтгэлээрээ талархахуйц жижиг зүйлсийг бид *олж харах нь* дээр биш гэж үү?

Их Эзэн, “Мөн бүх зүйлийг талархалтайгаар хүлээн авдаг тэрээр алдар суут болгогдох болно; мөн энэ дэлхийн зүйлүүд, бүр зуу дахин, түүнд нэмэгдэх болно”<sup>9</sup> гэж амласан байдаг.

Ах эгч нараа, Тэнгэрлэг Эцэгийн маань өгөөмөр адислалууд, Түүний энэрэлт авралын төлөвлөгөө, сэргээгдсэн сургаалын мөнхийн үнэнүүд болон энэ мөнх бус амьдралын аялал дахь олон гайхамшгийг хараад, “бидэнд баясах шалтгаан байхгүй гэж үү?”<sup>10</sup>

Тиймээс өөрсдийн байгаа байдлаасаа үл хамааран бүгдээрээ аз жаргалтай байхаар шийдэцгээе.

### **Шийдвэрүүдийн талаар**

Нэг өдөр бид зайлшгүй алхамыг хийж, энэ мөнх бус амьдралаас дараагийн оршихуйд орно. Нэг өдөр бид амьдралаа эргэн харж, илүү оновчтой шийдвэр гаргаж, илүү сайхан амьдралтай байж, цаг заваа илүү ухаалгаар өнгөрөөх боломж бидэнд байсан болов уу гэж бодох болно.

Хожим хойно маш ихээр харамсахгүйн тулд одоо хэдэн шийдвэр гаргасан нь дээр байхаа. Тиймээс бүгдээрээ,

- Хайртай хүмүүстэйгээ илүү их цагийг хамтдаа өнгөрөөцгөөе.

- Бурханы хүсэж байгаа шиг тийм хүн болохыг чин сэтгэлээсээ хичээцгээе.
- Нөхцөл байдлаасаа үл шалтгаалан аз жаргалыг олцгооё.

Бид өнөөдөр Аврагчийг дагавал маргааш аливаа зүйлд харамсахгүй байж чадна гэдгийг би гэрчилж байна. Хэрэв бид алдаа гаргаж гэм нүгэл үйлдсэн бол – хэрэв бид хийсэн сонголтондоо харамсаж байвал - бидэнд уучлагдаж болох Христийн Цагаатгалын ариун нандин бэлэг байгаа билээ. Бид цаг хугацаагаар аялан өнгөрсөнд очиж, өнгөрсөнийг өөрчилж чадахгүй ч бид гэм нүгэлээ наминчилж чадна. Аврагч бидний харууслын нулимсыг арчиж,<sup>11</sup> бидний гэм нүглийн ачааг авч хаях болно<sup>12</sup>. Түүний Цагаатгал бидэнд өнгөрсөнөө орхин, цэвэр гартай, ариун зүрхтэйгээр урагшилж<sup>13</sup> илүү сайн сайхныг хийж, мөн илүү сайн хүн болох зориг өгдөг.

Тиймээ, энэ амьдрал нүд ирмэх зуур л өнгөрөн одож байна. Бидний өдөр хоногууд маш хурднаар богиносож байна. Хэдий тийм боловч, бидний сүнс үхэхгүй, нэг өдөр бидний дахин амилсан махбодтой нэгдэж мөнхийн алдар сууг хүлээн авах болно. Нигүүлсэнгүй Христээр бид бүгдээрээ мөнхөд дахин амьдрах болно. Бидэнд Аврагч, Гэтэлгэгч байдаг учир бид хэзээ нэгэн өдөр “үхлийн гашуун нь Христээр залгигдсан юм”<sup>14</sup> хэмээх үгсийг ойлгож мөн баясах юм.

Бурханы охид хөвгүүд болох тэнгэрлэг үүргээ биелүүлэх зам маань мөнхийн юм. Ах эгч, хүндэт найз нараа, бид энэ мөнхийн замаар *өнөөдөр* алхаж эхлэх хэрэгтэй. Нэг ч өдрийг бид алдаж болохгүй. Амьдрал гэж юу байдгийг амьдралынхаа эцсийн өдөр биш яг одоо мэдээсэй гэж би залбирч байна. Есүс Христийн нэрээр, амен.

#### Тэмдэглэл

1. Алма 40:11.
2. Сузи Стайнэрийн “Үхлийн хамгийн том таван гэмшил,” *Хамгаалагч*, 2, 1, 2012, [www.guardian.co.uk/lifeandstyle/2012/feb/01/top-five-regrets-of-the-dying](http://www.guardian.co.uk/lifeandstyle/2012/feb/01/top-five-regrets-of-the-dying).
3. Броны Уэр, Стайнэрт, “Үхлийн хамгийн том таван Гэмшилүүд.”
4. “Магтаал: Хүүхэд Насны дурсамжаас мөнх бусын сануулга,” *Вэллиэм Вордсвортын шүлгийн бүтэн боть* (1924), 359.
5. Матай 6:20.
6. Дуулал 118:24.
7. Антони де Гэгээнтэн-Экспери, *Жижигхэн хан Хүү*, орчуулсан. Ричард Ховард (2000), 63.

8. Мозая 26:39; мөн Сургаал ба Гэрээ 59:7 үзнэ үү.
9. Сургаал ба Гэрээ 78:19.
10. Алма 26:35.
11. Илчлэлт 7:17.
12. Матай 11:38–30-г үзнэ үү.
13. Дуулал 24:4-г үзнэ үү.
14. Мозая 16:8 ;мөн 1 Коринт 15:54-г үзнэ үү.

# Сүмийн албан тушаалтнуудыг дэмжүүлэн баталсан нь

**Ерөнхийлөгч Хенри Б.Айринг танилцуулав**

*Тэргүүн Зөвлөлийн Нэгдүгээр зөвлөх*

Томас Спенсер Монсоныг Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн бошиглогч, үзмэрч, илчлэгч болон Ерөнхийлөгчөөр; Хенри Беннион Айрингийг Тэргүүн Зөвлөлийн Нэгдүгээр зөвлөхөөр; Диетер Фриедрих Угдорфыг Тэргүүн Зөвлөлийн Хоёрдугаар зөвлөхөөр тус тус дэмжүүлэн батлах санал оруулж байна.

Дэмжиж байгаа хүмүүс гараа өргөнө үү.

Татгалзаж байгаа хүн байвал гараа өргөж болно.

Бойд Кеннет Пакерыг Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ерөнхийлөгчөөр, дараах гишүүдийг тус чуулгын гишүүдээр дэмжүүлэн батлах санал оруулж байна. Үүнд: Бойд К.Пакер, Л. Том Перри, Рассел М.Нелсон, Даллин Х.Өүкс, М. Рассел Баллард, Ричард Г.Скотт, Роберт Д.Хейлс, Жеффри Р.Холланд, Давид А.Беднар, Квинтин Л. Кук, Д. Тодд Кристофферсон, Нейл Л.Андерсен.

Дэмжиж байгаа хүмүүс гараа өргөнө үү.

Татгалзаж байгаа хүн байвал гараа өргөж болно.

Тэргүүн Зөвлөлийн зөвлөхүүд болон Арванхоёр Төлөөлөгчийг бошиглогч, үзмэрч, илчлэгчдээр дэмжүүлэн батлах саналыг оруулж байна.

Дэмжиж байгаа хүмүүс гараа өргөнө үү.

Татгалзаж байгаа хүн байвал гараа өргөж болно.

Ахлагч Жей Э.Женсенийг Далын Чуулгуудын Ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүнээс чөлөөлж байна.



Түүний үзүүлсэн үйлчлэлд талархаж байгаа хүмүүс гараа өргөнө үү.

Ахлагч Крейг К.Крисченсенийг Далын Чуулгуудын Ерөнхийлөгчийн Зөвлөлийн гишүүнээр дэмжүүлэн батлах санал оруулж байна.

Дэмжиж байгаа хүмүүс гараа өргөнө үү.

Татгалзаж байгаа хүн байвал гараа өргөж болно.

Ахлагч Марлин К.Женсенийг Сүмийн түүхч бөгөөд цэдэг хөтлөгчөөр онцгой сайн үйлчилснийх нь төлөө түүнд талархал илэрхийлж, үүрэгт ажлаас нь чөлөөлөх санал оруулж байна.

Дэмжиж байгаа хүмүүс гараа өргөнө үү.

Ахлагч Стивен Э.Снөүт Сүмийн түүхч бөгөөд цэдэг хөтлөгчөөр дэмжүүлэн батлах санал оруулж байна.

Дэмжиж байгаа хүмүүс гараа өргөнө үү.

Татгалзаж байгаа хүн байвал гараа өргөж болно.

Ахлагч Кейт К.Хилбиг, Жей Э.Женсен, Марлин К.Женсен, Оставиано Тенорио нарыг Далын Нэгдүгээр Чуулгын гишүүнээс чөлөөлж, тэднийг чөлөөнд гарсан Ерөнхий Эрх Мэдэлтэн гишүүдээр томилохыг бид санал болгож байна.

Ахлагч Кейт Р.Эдвардс, Ларри В.Гиббонс нарыг Далын Хоёрдугаар Чуулгын гишүүнээс чөлөөлөх санал оруулж байна.

Эдгээр ах нарт онцгой үйлчлэлийнх нь төлөө талархал илэрхийлэхэд бидэнтэй санал нэг байгаа хүмүүс гараа өргөнө үү.

Бусад Ерөнхий эрх мэдэлтнүүд, Бүсийн Далууд, түүнчлэн туслах бүлгүүдийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөлүүдийг одоогийн дуудлагуудад нь дэмжин баталж байна.

Дэмжиж байгаа хүмүүс гараа өргөнө үү.

Татгалзаж байгаа хүн байвал гараа өргөж болно.

Ах эгч нар аа, та нарын дэмжин баталсан санал, итгэл бишрэл, чин үнэнч байдал, залбиралд тань талархалаа илэрхийлье.

# Сайн эцэг эх болох нь

**Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын**

*Ахлагч Л. Том Перри*

---

*Сайн эцэг эхчүүдэд Есүс Христийн сайн мэдээг хүүхдүүддээ заахын тулд хэрэгтэй тусламж, дэмжлэгээ авч болох олон арга замууд байдаг.*

---

Энэ зун миний амьдралд онцгой үйл явдал тохиож, би 90 насныхаа ойг тэмдэглэв. Бид амьдральнхаа тодорхой үе шатанд хүрсэн үед, өнгөрсөн үеийн үйл явдлууд, туршлагаа эргэн санах нь, сургамжтай бас ашиг тустай юм. Залуу хүмүүс та нарт 90 нас хүрсэн хүний амьдралын тухай сонсох нь, тийм ч сонин биш санагдаж болох юм. Харин намайг төрөх үед, урт наслахыг маш том амжилт гэж үздэг байсан гэдэг. Намайг урт удаан амьдралаар адисалсан, Тэнгэрлэг Эцэгтээ би өдөр бүр баярлан талархаж явдаг билээ.

Амьдралын минь туршид олон зүйлс өөрчлөгдөж байсан. Би аж үйлвэрийн өрнүүн хөгжлийн болон мэдээллийн эрин зууны гэрч боллоо. Автомашин, телефон, нисэх онгоцыг үй олноор үйлдвэрлэдэг болсон олон шинэ зохион бүтээлтийн үед, миний идэр залуу нас өнгөрсөн юм. Өнөө үед бидний олж, ашиглан, бусадтай хуваалцдаг мэдээлэл бараг өдөр бүр өөрчлөгдөж байна. Бид бүхний амьдардаг дэлхий, ийм түргэн хурдацтайгаар өөрчлөгдөж байгаад, би үнэхээр гайхдаг. Өнөөгийн өөрчлөлтүүдээс олон нь, бидний амьдралыг сайжруулах боломжтой мэт өнгө аясаараа сэтгэл татна.

Бидний эргэн тойронд болж байгаа түргэн өөрчлөлтүүдийн дунд, Есүс Христийн сайн мэдээний үнэ цэнэ хэзээ ч алдагдахгүй байхын төлөө, бид чин сэтгэлээсээ залбирч, шаргуу ажиллахыг хичээдэг билээ. Эдгээр үнэ цэнэтэй зүйлсээс зарим нь алга болох аюул, аль хэдийнээ нүүрлээд байна. Дайсны тэргүүн зэргийн зорилго болох

гэрлэлтийн ариун байдлыг устгаж, гэр бүлүүдийг сүйрүүлэх явдал нь, аюул нүүрлээд байгаа үнэт зүйлсийн жагсаалтыг тэргүүлж байна. Эдгээр үнэт зүйлс нь, Тэнгэрлэг Эцэгийн хайртай хүүхэд бүрт, сайн нөлөөгөөр өсч хүмүүжих боломжийг олгож, мөнхийн үнэ цэнэтэй бусад зүйлсийг олж авдаг тэрхүү, гэр орныг аюулгүй болгодог билээ.

Манай гэр бүл миний 90 насны ойг тэмдэглэхээр бэлтгэж байсан нь, урт удаан амьдралынхаа туршлагыг эргэн санаж, үнэлэлт дүгнэлт өгөхөд надад тусалсан юм. Жишээ нь, 70 шахам жилийн тэртээ, Дэлхийн II Дайны үед Номхон далайн Сейпан арал дээрх, Тэнгисийн цэргийн баазаас эцэг эхдээ бичсэн миний нэлээд хэдэн захидлыг, ач охин минь цуглуулж, надтай хуваалцсан юм.

Тэдгээр захидлуудаас нэг нь миний анхаарлыг онцгой татсан юм. Энэ бол 1945 оны, Ээж нарын баярын өдрөөр ээждээ бичсэн, миний захидал байлаа. Хайр энэрлээр дүүрэн аав, ээж хоёр минь, гэр орондоо надад заадаг байсан хичээлүүдээс, сурч мэдсэн зүйлийнхээ төлөө би, тэдэнд, үүрд баярлан талархаж явдгийг минь, та бүхэн ойлгох болов уу гэж найдан, захидлын зарим хэсгийг хуваалцахыг хүсч байна. Аав ээж хоёр маань, гэрлэлт болон үр хүүхдээ зөв өсгөн хүмүүжүүлэх үйлстээ, тэргүүн зэргийн ач холбогдол өгсөн нь надад, сайн эцэг эхийн үлгэр дууриалал болсон юм.

1945 оны Ээж нарын баярын өдрөөр, ээждээ бичсэн миний захидал ингэж эхэлжээ:

“Хайрт ээжээ,

“Сүүлийн дөрвөн жил би, Ээж нарын баярын өдрийг танаасаа хол өнгөрүүлсэн нь, яасан азгүй хэрэг вэ? Би жил бүр тантай хамт байж, танд хэчнээн их хайртайгаа, таныг хэчнээн их бодлогоо танд хэлэхийг хүсдэг ч, дахиад л энэ нь боломжгүй болсон учраас, бодол санаагаа шуудангаар дамжуулан илгээх нь л, миний хийж чадах хамгийн сайн зүйл болоод байна.

“Гайхалтай ээж таны, миний төлөө хийсэн бүхнийг би, бусад жилүүдээс ч илүү энэ жил, ихээр дурсан санаж байна. Хамгийн түрүүнд, миний төлөө таны хийдэг байсан жижиг сажиг зүйлсийг би үгүйлэн санах юм. Би өглөө орноос босохдоо, цэвэрхэн цамц оймс бэлэн байгаа бил үү? гэж огт

санаа зовдоггүй байсан. Зөвхөн шургуулга татаж, онгойлгох нь л, миний хийдэг ажил байж. Хоолны цаг болоход, миний дуртай хоолыг хамгийн сайхнаар хийсэн байгаа гэдэгт би, үргэлж итгэлтэй байдаг байлаа. Би шөнө унтахдаа, орны даавуу цэвэрхэн байгаа гэдгийг, мөн надад дээд зэргийн ая тухыг бүрдүүлж өгдөг, бусад зүйлс бүгд зохих ёсоороо байгаа гэдгийг мэддэг байсан. Ийм сайхан гэр оронд амьдарна гэдэг, үнэхээр аз жаргал байлаа.”

Би захидлын эхний хоёр догол мөрийг уншаад, эдгээр үгс үнэхээр сэтгэл уярам сонсогдсоноос, эхэндээ мэл гайхсан шүү. Магадгүй энэ нь, шумуулнаас хамгаалах тороор битүү бүрсэн аяны орон дээр унтаж, майханд амьдарч байсан хүнд, гэр орных нь ая тух үгүйлэгдэж байсных биз ээ.

Ээждээ бичсэн миний захидал цааш ийн үргэлжилсэн аж:

“Гэвч ээж таныгаа хайрлах хайрын мэдрэмжүүд, таны надад үзүүлдэг байсан үлгэр жишээнээс тань ирдэг байсан юм шүү. Бид бага балчир наснаасаа эхлэн, гэр орондоо мэдэрдэг байсан тэрхүү баяр баясгалан нь, таны үлгэр жишээг дагаснаар, бидний амьдралд улам сайхан болсон юм. Биднийг хадан хавцал руу дагуулж явах цагийг, та үргэлж бидэнд гаргадаг байсан. Бид ууланд явган аялахаас эхлээд, бидэнтэй бөмбөг тоглох хүртлэх ямар ч зүйлд, таньд л найддаг байсан. Аав та хоёр амралтанд хэзээ ч хоёулхнаа явдаггүй байлаа. Үргэлж гэр бүлээ авч явдаг байсан. Одоо би гэр орноосоо хол байгаа болохоор, гэр бүлийнхээ амьдралын талаар ярихыг үргэлж хүсдэг. Учир нь гэвэл, бидний гэр орны амьдрал дэндүү сайхан байсан. Миний үйлдэл бүхэн ээж таны зан төлөвийн тусгал байдаг учраас, таны надад зааж сургасан зүйлсээс би ухарч чадахгүй. Нора Сонн Перригийн хүү хэмээн нэрлэгдэхээр зохистой байхын тулд, амьдрал надад хүндхэн сорилтыг бий болгож байна. Би энэ нэрээрээ маш их бахархдаг бөгөөд, энэ нэрээ үргэлж эрхэмлэн дээдэлж явах болно гэдэгт итгэлтэй байна.

“Ирэх жил Ээж нарын баярын өдрөөр би тантай хамт байж, өнгөрсөн дөрвөн жил төлөвлөж байсан зүйлсээ, ээж тандаа үзүүлэх болно гэдэгт би итгэлтэй байна.

“Зовлон бэрхшээлээр дүүрсэн энэ дэлхий дээр, таны хийсэн гайхамшигтай зүйлсийн төлөө Их Эзэн таныг адислах болтугай.

“Хайртай шүү Ээж Тандаа, Том”<sup>1</sup>

Би захидлаа дахин уншихдаа, гэр бүлийнхээ болон тойрог, гадас, өөрийн төрж өссөн нийгмийн соёл, зан заншлыг тунгаан бодлоо.

Соёл гэдэг бол хүмүүсийн амьдралын хэв маяг юм. Сайн мэдээний өвөрмөц соёл буюу, Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн, бүх гишүүдийн эрхэмлэн баримталдаг цогц үнэт зүйлс, итгэл найдварын соёл бий. Сайн мэдээний энэхүү соёл буюу амьдралын хэв маяг нь, авралын төлөвлөгөө, Бурханы зарлигууд болон амьд бошиглогчдын сургаалуудаас эх ундаргатай юм. Энэхүү соёл нь, бид амьдралаа хэрхэн авч яваа болон, гэр бүлээ хэрхэн өсгөн төлөвшүүлж байгаагаар илэрдэг.

Мөнх бус амьдралд ямар үүрэг хариуцлага хүлээх талаар, Адамд өгсөн анхны заавар Эхлэл номын 2:24-т байдаг: “Ийм учраас эр хүн, эцэг эхээ орхиод, эхнэртэйгээ нийлэн, тэр хоёр нэгэн бие болох ажгуу.”

Ийнхүү эрэгтэй, эмэгтэй хоёр хүн хууль ёсоор хуримлах нь, дэлхийг өвлөн эзэмших ирээдүйн үеийнхний бэлтгэл төдийгүй, энэ нь мөнх бус амьдралд агуу баяр баясгалан, сэтгэл ханамжийг авчирч чадна. Гэрлэлтийг, санваарын хүчээр энэ амьдралд болон үүрд мөнхөд тунхагласан үед, энэ нь бүр ч үнэн юм. Ийм гэрлэлтэнд төрсөн хүүхдүүд, өөр хаана ч байдаггүй тийм аюулгүй байдалд амьдардаг.

Сайн эцэг эхчүүдийн гэр орондоо заадаг хичээлүүд нь, дайсны нөлөө үлэмж өргөжин газар авч байгаа өнөөгийн дэлхийд улам чухал болж байна. Сатан манай нийгмийн үндэс суурь болсон гэр бүлийг бусниулан, мөхөлд хүргэх гэж оролдож байгааг бид мэднэ. Тэрээр маш зальжин хийгээд, өнгөлөн далдалсан олон аргаар дэлхий даяар гэр бүлийн амьдралыг түүнчлэн, итгэлтэй Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн соёл болон гэрээнүүдийг дайрч давшилж байна. Гэр оронд үр хүүхдэдээ заах нь хамгийн ариун, хамгийн чухал үүрэг хариуцлага гэдгийг эцэг эхчүүд ухамсарлах ёстой. Сүм, сургууль зэрэг бусад байгууллагууд нь

эцэг эхчүүдэд туслан, “явах ёстой замаар нь замнуулахын тулд хүүхдийг сургадаг ч”(Сургаалт Үгс 22:6) энэхүү үүрэг хариуцлагын хүндийг гагцхүү эцэг эхчүүд үүрэх ёстой. Аз жаргалын агуу төлөвлөгөөгөөр, Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүдийг халамжлан, өсгөн хүмүүжүүлэх үүргийг сайн эцэг эхчүүдэд итгэмжлэн даатгасан юм.

Эцэг эхчүүд бидэнд, үүргээ биелүүлэх олон арга зам байдаг бөгөөд, хүүхдүүддээ Есүс Христийн сайн мэдээг заахад хэрэгтэй тусламж, дэмжлэг авах боломж бий. Гэр бүлийн бат бөх соёлыг бий болгохын тулд, эцэг эхчүүдийн хийж болох таван зүйлийг би зөвлөмж болгоё:

Нэгдүгээрт, Эцэг эхчүүд Тэнгэрлэг Эцэгт хандан, Түүний илгээсэн хүүхдүүдийг хайрлаж, ойлгон, удирдахад туслахыг чин сэтгэлээсээ гуйж залбирдаг байх хэрэгтэй.

Хоёрдугаарт, Тэд гэр бүлийн залбирал, судар судлах болон гэр бүлийн үдшийг тогтмол хийж, аль болохоор хамт хооллож, энэ үеэр хоорондоо ярилцаж, үнэт зүйлсийг заадаг тогтсон цагтай байх хэрэгтэй.

Гуравдугаарт, Эцэг эхчүүд Сүмийн дэмжлэг хэсэг болсон, хүүхдүүдийн Хүүхдийн Хэсгийн багш нар, залуучуудын удирдагчид, ангиудын болон чуулгуудын ерөнхийлөгчийн зөвлөлүүдтэй холбоотой байхыг, чухалчлан анхаарах ёстой. Хүүхдүүдтэй нь ажиллахаар дуудагдаж, адислагдсан хүмүүстэй харилцаатай байснаар, эцэг эхчүүд хүүхдүүдийнхээ өвөрмөц хэрэгцээг ойлгон, шийдвэрлэж чадна.

Дөрөвдүгээрт, Эцэг эхчүүд хүүхдүүдтэйгээ гэрчлэлээ байнга хуваалцаж, Бурханы зарлигуудыг сахих болон, Тэнгэрлэг Эцэгээс Өөрийн итгэлтэй хүүхдүүдэд амласан адислалуудыг олж авахад нь, тэдэнд тууштай дэмжлэг үзүүлдэг байх хэрэгтэй.

Тавдугаарт, Бид энгийн хийгээд тодорхой дүрмүүд ба зорилгууд, гэр бүлийн эрүүл саруул уламжлал болон ёс заншил дээр, гэр бүлээ зохион байгуулж мөн хүүхдүүд нь гэр орондоо тодорхой ажил үүрэг хүлээхийн хамт үүнээсээ зохих орлогыг авч, өөрсдийнхөө олсон мөнгийг төсөвлөх, хуримтлал бий болгох болон аравны нэгээ төлж сурдаг “эдийн засагч гэр бүл” байж болно.

Бат бөх гэр бүлийн соёлыг бий болгох эдгээр зөвлөмжүүд, Сүмийн соёлтой хосолсон үед л амжилт олж чадна. Манай гэр бүлүүдийн бат бөх соёл нь, бидний хүүхдүүдийг, “дайсны галт сумнаас”(1 Нифай 15:24), тэрчлэн хүүхдийн нүдний өмнө байнга ил байдаг, үе тэнгийнхний соёл, зугаа цэнгэл ба оддын соёл, нэр хүнд ба үнэлэмжийн соёл, интернет ба мэдээллийн соёл зэрэгээс хамгаалах болно. Энэ нь манай хүүхдүүдэд “дэлхийнх биш” байж, харин “дэлхийд амьдрахад” нь туслах болно.( Иохан 15:19-ийг үзнэ үү).

Ерөнхийлөгч Жозеф Филдэнг Смит ингэж сургасан юм: “Хүүхдүүд нь яагаад баптисм хүртэх ёстойг ойлгож, баптисмынхаа дараа, Бурханы зарлигуудыг үргэлж биелүүлэх хүслийг зүрх сэтгэлдээ төлөвшүүлэхийн тулд, мөн Түүний дэргэд буцаж очин амьдрахын тулд, Есүс Христийн сайн мэдээний авралын зарчмуудыг хүүхдүүдээ заах нь, эцэг эхчүүдийн үүрэг мөн. Хайрт ах, эгч нар минь ээ, гэр бүл чинь, хүүхдүүд чинь, бас та өөрөө эцэг эхтэйгээ лацдан холбуулахыг хүсдэг үү. . . ? Хэрэв үүнийг хүсдэг бол, үр хүүхдэдээ бүр багаас нь эхэлж заах ёстой. Та үйл хэргээрээ бас үлгэр жишээгээрээ тэдэнд заах хэрэгтэй.”<sup>2</sup>

Гэр бүлийн тунхагт ийн өгүүлсэн байдаг:

“Нөхөр, эхнэр хоёр нь бие биенээ болон үр хүүхдээ хайрлан халамжлах ариун үүрэг хүлээнэ. ‘Үр хүүхэд бол Эзэнээс ирдэг бэлэг мөн’ (Дуулал 127:3). Эцэг эхчүүд хүүхдүүдээ хайраар болон зөв шударга байдлаар өсгөн хүмүүжүүлж, бие бялдар болон оюун санааных нь хэрэгцээг хангаж, бие биенээ хайрлан үйлчилж, Бурхны зарлигуудыг дагаж, хаана ч амьдарсан хуулийг дээдлэн сахидаг иргэд байхыг, зааж сургах ариун үүрэгтэй юм. . . .

“ . . . Тэнгэрийн загвараар эцэг нь, өрх гэрээ хайр болон зөв шударга ёсоор тэргүүлэн удирдаж, амьдралын хэрэгцээт зүйлсээр хангаж, гэр бүлээ хамгаалах үүрэгтэй. Эхийн үндсэн үүрэг бол, хүүхдүүдээ хайраар өсгөн хүмүүжүүлэх явдал мөн. Энэхүү ариун үүргээ биелүүлэхэд, эцэг эхчүүд харилцан бие биедээ адил тэгшээр туслах ёстой.”<sup>3</sup>

Хойч үеэ өсгөн хүмүүжүүлж, тэдэнд заах эхийн үүргийг товойлгон тавьсан нь, тэнгэрийн загвар гэдэгт би итгэлтэй байдаг. Гэвч хүүхдүүд болон ач зээ нартаа сайн нөлөө үзүүлж,

тэдэнтэй харилцахдаа нөхөр, эхнэр хоёр эрх тэгш түншүүдийн ёсоор хамтран ажиллаж байгааг харахад үнэхээр гайхамшигтай байдаг.

Бусармаг нүгэл хилэнц манай хүүхдүүдийн эсрэг урьд өмнө үзэгдээгүйгээр илэрхий, улаан цайм, ичгүүр сонжуургүй, улангассан мэт дайран давшилж байна. Гэр бүлийн бат бөх соёлыг төлөвшүүлэх нь манай хүүхдүүдийг дэлхийн муу нөлөөнөөс тусгаарлах бас нэг хамгаалалт байх болно.

Сион дахь сайн аав, ээж та нарыг Бурхан адислах болтугай. Тэрбээр, Өөрийн мөнхийн хүүхдүүдийг халамжлах ажлыг та нарт итгэл хүлээлгэн даатгасан юм. Эцэг эхчүүд бид, Түүний ажил болон алдар сууг, Түүний хүүхдүүдийн дунд тохиолгон авчрах үйлсэд, Бурханы түншүүд, түүгээр ч зогсохгүй Түүнтэй нэгдэн нийлэгчид билээ. Энэхүү эрхэм үйлсэд чадах бүхнээ хийх нь, бидний ариун үүрэг юм. Энэ тухай би Есүс Христийн нэрээр гэрчилэлээ, амен.

#### Эшлэл

1. Л. Том Перригээс Ээж нарын баярын өдрөөр ээждээ бичсэн захидлаас, 1945 оны 5-р сарын 3-нд Сейпанаас илгээжээ.
2. Жозеф Фиелдинг Смит, Conference Report, 1948 оны 10-р сар, 153.
3. “Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг,” *Лиахона*, 2010 оны 11-р сар, 129.



---

# Санаа сэтгэлээ бүрэн зориулсан байх нь

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын

Ахлагч М. Рассел Баллард

---

*“Сайн зарчимд санаа сэтгэлээ бүрэн зориулсан” олон ажилчдын хичээл зүтгэлээр ачаа нь хөнгөрч, агуу зүйлүүд хийгдсэн юм.*

---

Ахлагч Перри, та манай Сүмийн хамгийн залуу 90-н настай хүн гэж би бодож байна. Та нар түүнийг сандлаасаа ямар хурдан үсэрч боссоныг анзаарсан байх.

Хайрт ах эгч нараа, би шууд модноос нь гүйцэд боловсорсон шинэхэн улаан лооль эсвэл шүүслэг тоор жимс авч идэх болгондоо 60 жилийн өмнөх Юта мужийн Холлэдэй дахь аавын маань жижигхэн тоор жимсний цэцэрлэг бодол санаанд минь буудаг юм. Тэр тэнд яваандаа маш том, амттай тоор жимс болон ургадаг тоорын цэцэгсийн үр тогтоох зөгийн үүрнүүдтэй байсан.

Аав маань ажилч зөгийнүүддээ хайртай байсан бөгөөд мянга мянгаараа хамтран ажиллаж байгаа тэднийг хараад гайхан биширдэг байлаа. Тэд хамтран ажиллаж, тоорын цэцгээс цуглуулсан цэцгийн балыг байгалийн хамгийн ач тустай хүнс тэжээлийн нэг болох амтлаг, алтан шаргал зөгийн бал болгон хувиргадаг байв. Хоол тэжээлийн мэргэжилтнүүд зөгийн бал нь амьдралд хэрэгтэй фермент, витамин, эрдэс болон ус гэсэн бүхий л бодисуудыг өөртөө багтаадаг хүнс тэжээлийн нэг нь гэж хэлдэг.

Аав маань намайг байнга өөрийн зөгий үржвэрийн ажилд оролцуулахыг хичээдэг байсан ч харин би түүнийг өөрөө л зөгийнүүддээ харж халамжилж байгаад маш их баярладаг байсан. Гэвч тэр өдрүүдээс хойш би ойролцоогоор жаран

мянган зөгийтэй хамгийн дээд зэргээр зохион байгуулагдсан зөгийний үүрний талаар сурч мэдсэн билээ.

Ажилч зөгийнүүд нь үр тогтоох, бал цуглуулах мөн өтгөрүүлсэн балыг зөгийн бал болгох ажилдаа чин сэтгэлээсээ зүтгэдэг. Энэ нь Бүтээгчийн тэдний гарал зүйд суулгасан байгалиас заяасан зөн билэг, тэдний гайхамшигтай бодит хүсэл нь юм. Зөвхөн 450 грамм зөгийн бал гаргахын тулд дунджаар зөгий үржвэрийн 20.000- 60,000 зөгий хамтдаа сая гаруй цэцгэн дээр сууж, дэлхийг хоёр удаа тойрсонтой тэнцэхүйц газар аялах хэрэгтэй гэдэг нь тогтоогдсон байдаг. Дөнгөж хэдхэн долоо хоногоос дөрвөн сар амьдрах энэ богино хугацаандаа нэг ажилч зөгий үүрэндээ ердөө л цайны халбаганы арванхоёрны нэгтэй буюу 42 миллиграммтай тэнцэх бал хандивладаг.

Нийт дүнтэй нь харьцуулахад шалихгүй өчүүхэн мэт санагдавч цайны халбаганы арванхоёрны нэгтэй тэнцэх бал бүр зөгийн үүрний амьдралд амин чухал зүйл юм. Тэд нэг нэгэндээ итгэдэг. Хэдхэн зөгийний хувьд дэндүү дааж давшгүй байж болох ажил нь бүх зөгий өөрсдийн хийх ёстой зүйлийг итгэлтэйгээр хийснээр амархан болдог.

Манай Сүмийн түүхэнд зөгийн үүр нь үргэлж чухал бэлэг тэмдэг болсоор ирсэн. Мормоны номноос бид мянга мянган жилийн өмнө Жаредчууд Америк руу аялах замдаа ажилч зөгийнүүдийг авч явсныг мэдэж авдаг (Иферийн 2:3-ийг үз). Агуу Солт Лейкийн эргэн тойрны юу ч үгүй эзгүй хоосон цөл газрыг ургац сайтай өнөөгийн хөндий болгон өөрчлөхийн тулд Брингам Янг зөгийн үүрийг анхдагч нарийн дунд уриалан дэмжих мөн хамтран ажиллах хүчийг илчлэх бэлэг тэмдэг болгон сонгосон. Бид тэдний хамтын хичээнгүй хөдөлмөрийн ашиг тусыг хүлээн авагчид билээ.

Манай олон Ариун Сүмийн гадна болон дотор заслаас зөгийн үүрийн бэлэг тэмдгийг харж болно. Миний зогсож буй энэ индэр нь Ерөнхийлөгч Гордон Б.Хинклигийн байшингийн арын цэцэрлэгт байсан хуш модоор хийгдсэн бөгөөд үүн дээр зөгийн үүрийг чимэглэн сийлбэрлэсэн байдаг.

Энэ бүх бэлэг тэмдэг нь “сайн зарчимд санаа сэтгэлээ бүрэн зориулсан” (С ба Г 58:27).олон ажилчдын хичээл зүтгэлээр ачаа нь хөнгөрч, агуу зүйлүүд хийгдэснийг гэрчлэх

нэгэн бодит баримт юм. Бид яг ажилч зөгийн адил Их Эзэн Есүс Христийн сургаалуудад өгсөн амлалтандаа гол анхаарлаа хандуулан, төвлөрөх юм бол дэлхий дээрх хэдэн сая Хожмын Үеийн Гэгээнтнүүд ямар их зүйлийг гүйцэлдүүлж болохыг төсөөлөөд үз дээ.

Эхний бөгөөд хамгийн агуу тушаал нь:

“Чи бүх зүрх, бүх сэтгэл, бүх оюун ухаанаараа өөрийн Бурхан Эзэнээ хайрла. . .

Удаах нь “Чи хөршөө өөрийн адил хайрла”.

“Энэ хоёр тушаал дээр бүх Хууль болоод Эш үзүүлэгчид тулгуурладаг юм” (Матай 22:37, 39–40). хэмээн Аврагч заасан.

Аврагчийн үгс нь энгийн ч тэдгээрийн утга агуулга нь төгс төгөлдөр мөн гүнзгий ач холбогдолтой билээ. Бид өөрсдийгөө хайрладгийн адил Бурханыг мөн өөрсдийн хөршүүдээ хайрлан, тэдэнд анхаарал халамж тавих ёстой. Бид бүгд Христийн дагалдагчдын хувьд хамтдаа нэгдэн бусдын хэрэгцээнд санаа тавьж, эргэн тойронд маань байгаа гэр бүлийнхэн, найз нөхөд, хөрш болон бусад хүмүүс, нийгэмдээ үйлчлэх юм бол бид дэлхийд ямар их сайн зүйлийг хийж чадахыг төсөөлөөд үз дээ.

Иаковын илгээсэн бичигт үйлчлэл нь цэвэр ариун бөгөөд бузартаагүй жинхэнэ шүтлэгийг тодорхойлдог гэсэн байдаг (Иаков 1:27-г үз).

Бид дэлхий даяар Сүмийн гишүүдийн өгч байгаа үйлчлэлийн талаар ялангуяа гал түймэр, үер, хар шуурга, хуй салхи гэх мэт хүнд хэцүү хямралын үед өгсөн Хүмүүнлэгийн үйлчлэлийн талаар уншдаг. Гэнэтийн аюулын үед өгөх эдгээр хамгийн хэрэгтэй, хамгийн талархалтай хариу үйлдлүүд нь нэг нэгнийхээ ачааг хөнгөн байлгах замаар зайлшгүй үргэлжлэх ёстой. Гэвч бидний өдөр тутмын амьдрал яах вэ? Бусдыг гэсэн Христийн чин сэтгэлийн хайраараа дамжуулан өдөр бүр бидний хийдэг хэдэн сая жижиг нигүүлсэнгүй үйлдлийн нэгдсэн хүчин чармайлт яах вэ? Цаг хугацаа өнгөрөх тусам Түүний хайрын тусгалаар, Тэнгэрлэг Эцэгийн хүүхэд бүрт биднээр дамжуулан тэдэнд хүрэх хүчин чармайлт өөрчлөгдөх болно. Бидний зовлон түгшүүртэй дэлхийд Христийн энэхүү хайр нь өнөөдөр урьд өмнө нь хэзээ

ч байгаагүйгээр илүү их хэрэгтэй байгаа бөгөөд ирэх жилүүдэд улам их хэрэгтэй байх болно.

Эдгээр энгийн, өдөр тутмын үйлчлэлийн үйлдлүүд нь ганц нэгээрээ тийм их зүйл биш мэт санагдаж болох ч харин нэгтгэн хамтад нь харахад яг л ганц зөгийн үүрэндээ хандивласан цайны халбаганы арванхоёрны нэгтэй тэнцэх балтай адилхан болдог. Бурхан ба Түүний хүүхдүүдийг хайрлах хайрын хүч бидэнд бий. Энэ хайр нь Христтэй адил сайхан сэтгэлийн олон сая үйлдлүүдэд мэдэгдэхүйцээр тунхаглагдах үед амьдралыг тэтгэгч итгэл, найдвар мөн энэрлийн балаар дэлхийг тэжээн, сайжруулах болно.

Өөрт байгаа бүхнээ зориулсан тэрхүү ажилч зөгийн адил бүхнээ зориулах байдлыг зан төлвийнхөө нэг хэсэг болгохын тулд бид юу хийх хэрэгтэй вэ? Бидний олонхи нь Сүмийн цуглаануудад хичээнгүйгээр оролцож, ялангуяа Ням гарагт дуудлагууддаа шаргуу ажилладаг. Мэдээж энэ нь магтууштай зүйл. Гэхдээ бидний оюун санаа, зүрх сэтгэл долоо хоногийн бусад өдрүүдэд сайн зүйлст бүрэн зориулагдаж байна уу? Бид зүгээр л өөрсдийн үүргээ гүйцэтгээд явна уу эсвэл бид Есүс Христийн сайн мэдээнд үнэнээр хөрвөгдсөн байна уу? Оюун бодолдоо ургуулсан итгэлийн үрийг бодгалийнхаа шим тэжээлтэй хөрсөнд гүн суулган, ургуулж чадаж байна уу? Бидний мөнхийн аз жаргал, энх амгалан байдалд зайлшгүй чухал шаардлагатай Алмагийн хэлсэн тэрхүү зүрх сэтгэлийн хүчит өөрчлөлтийг бид хэрхэн хийх вэ? (Алма 5:12–21-г үз).

Зөгийн бал нь зөвхөн мөнх бус амьдралыг тэтгэх бүхий л хэрэгцээт бодисуудыг агуулдаг гэдгийг санацгаа. Харин Христийн сайн мэдээ ба сургаал нь мөнхийн амьдралыг олж авах цорын ганц зам мөн. Зөвхөн бидний гэрчлэл маань оюун бодол, зүрх сэтгэлд маань гүн суусан үед л бидний бусдыг хайрлах, бусдадаа үйлчлэх хүсэл тэмүүлэл Аврагчийнхтай адил болох болно. Тийм ээ зөвхөн тэгж байж л бид Сүнсний эрх мэдлээр ойр дотныхоо хүмүүсийн зүрх сэтгэлд хүрсэн гүн хөрвөгдсөн Христийн шавь нар болох билээ.

Бидний зүрх сэтгэл энэ дэлхийн зүйлүүд дээр тавигдаагүй үед л бид хүмүүсийн хүндэтгэл хүлээхийг эрмэлзэхгүй, бардамналыг өөгшүүлэхийг эрэлхийлэхгүй (С ба Г 121:35–37).

байх болно. Түүний оронд бид Христтэй адил чанаруудыг өөртөө хүлээн авах ёстойг Есүс заасан:

- Бид эелдэг зөөлөн хийгээд номхон дөлгөөнөөр, мөн тэсвэр тэвчээртэй (С ба Г 121:41-г үз).
- Бид нинжин сэтгэл, мөн цэвэр мэдлэгээр энэ нь зусардалтгүйгээр мөн заль мэхгүй (С ба Г 121:42-г үз).
- Бид бүх хүмүүсийн төлөө энэрлийг мэдэрдэг (С ба Г 121:45-г үз).
- Бидний бодол санаа үргэлж ариун журамтай байдаг (С ба Г 121:45-г үз).
- Бид хилэнцийг хийх хүсэлгүй болсон (Мозая 5:2-г үз).
- Ариун Сүнс нь бидний байнгын хамтрагч ба санваарын номлол тэнгэрээс буух шүүдэр лугаа адил чиний сүнсэн дээр намуухан буух болно (С ба Г 121:45–46-г үз).

Ах эгч нараа, тэгэхээр одоо би шашныг хэт хөөрөн дуурайх эсвэл улайран бишрэх явдлыг урамшуулан дэмжиж байгаа юм биш шүү. Ерөөсөө ч тийм биш! Би ердөө л бид итгэж байгаа зүйлдээ байнга тууштай, шударгаар үйлдэж, амьдрахын тулд сургаалуудыг зүрх сэтгэл болоод бодгальдаа гүн уусган шингээснээр Христийн сайн мэдээнд хөрвөхөд маань зайлшгүй хэрэгтэй дараах алхмыг хийхийг санал болгож байна.

Энэхүү шударга байдал нь бидний амьдралыг хялбарчилж, Сүнс болон бусдын хэрэгцээг мэдрэх чадварыг маань өсгөн нэмэгдүүлдэг. Энэ нь бид нүглээ наманчилж, Түүний тушаалуудыг сахиж, Аврагчийг дагах үед ирдэгтэй адил тийм л баяр баясгаланг амьдралд, тийм л амар амгаланг бодгальд маань авчирдаг.

Энэ өөрчлөлтийг бид хэрхэн хийх вэ? Христийн энэ хайрыг зүрх сэтгэлдээ хэрхэн шингээх вэ? Сүмийн гишүүн нэг бүрийн хувьд үүний дотор хөвгүүд ба охид, залуу эрэгтэйчүүд ба залуу эмэгтэйчүүд, ганц бие насанд хүрэгчид ба эцэг эхчүүд та нарын амьдралд өөрчлөлт оруулах нэгэн энгийн өдөр тутмын зуршил болгох зүйл байдаг.

Энэхүү энгийн зуршил бол: өглөө бүр залбирахдаа, Тэнгэрлэг Эцэгээс Түүний хайртай хүүхдүүдийн нэгэнд үйлчлэх боломжийг таньж мэдэхэд удирдахыг залбиран гуй. Тэгээд өдрийн турш хайр болон итгэлээр дүүрэн зүрх сэтгэлтэйгээр тусламж хэрэгтэй хэн нэгийг олохоор яв. Яг л ажилч зөгийнүүд аль цэцэгнээс бал цуглуулах вэ гэдэгт анхаарлаа төвлөрүүлдэг шиг анхаарлаа төвлөрүүл. Хэрэв та нар үүнийг хийх юм бол сүнслэг мэдрэмжүүд тань тэлэн нэмэгдэж, урьд нь хэзээ ч боломжгүй мэт байсан үйлчлэх боломжуудыг та нар олж нээх болно.

Ихэнх тохиолдолд Тэнгэрлэг Эцэг өөр нэгэн хүний залбирлыг биднээр, та нараар бас надаар, бидний эелдэг зөөлөн үгсээр мөн үйлээр, бидний үйлчлэлийн болон хайрын энгийн үйлдлээр дамжуулан өгдөг хэмээн Ерөнхийлөгч Томас С. Монсон бидэнд заасан.

Мөн Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл: “Бурхан биднийг ажиглаж мөн Тэр биднийг харж хамгаалдаг. Гэхдээ ер нь Тэр бидний хэрэгцээг өөр хэн нэгнээр дамжуулан өгдөг. Тийм учраас бие биендээ үйлчлэх нь амин чухал зүйл юм” хэмээн хэлсэн. (*Сүмийн Ерөнхийлөгчдийн захиас*: Спенсер В. Кимбалл [2006], 82).

Хэрэв та нар үйлчлэлийг өдөр бүр гэр орондоо, сургууль дээрээ, ажил дээрээ, мөн Сүм дээр хийх юм бол Сүнс та нарыг хөтлөн, зөвхөн та нарын өгч чадах тодорхой үйлчлэл хэрэгтэй хүмүүсийг ялгаж мэдэхэд тань туслах болно. Та нар Ариун Сүнсээр өдөөгдөж, дэлхийд Христийн цэвэр хайр болон Түүний сайн мэдээний нөлөөг үзүүлэхээр гайхалтайгаар зоригжих болно.

Жижигхэн ажилч зөгий цайны халбаганы арванхоёрны нэгтэй тэнцэх бальг үүрэндээ хандивладаг шиг Христтэй адил үйлчлэлээр дамжуулан Бурханы хайрыг Түүний хүүхдүүдтэй хуваалцах хүчин чармайлтаа арван мянга дахин бүр хэдэн сая дахин залбиралтайгаар нэмэх юм бол энэ илүү харанхуй, нүгэлтэй болж байгаа дэлхийд Христийн Гэрлийг авчирах сайны нөлөө түргэн өсөх болно. Нэгдмэл байснаар бид гэр бүлдээ, ганцаардмал нэгэнд, ядууст, сүнслэг болон сэтгэл санааны хувьд гэмтэж бэртсэн нэгэнд мөн үнэн ба амар

амгаланг хайж байгаа Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүдэд хайр ба энэрлийг авчирах болно.

Ах эгч нараа, өдөр бүр ямар нэгэн утга учиртай үйлчлэлийг, үүний дотор сайн мэдээний үнэн мөн өөрсдийн гэрчлэлээ хуваалцах үйлчлэлийг өгөх хэн нэгнийг олох сүнслэг өдөөлтийн төлөө залбирцгаая. Өдөр бүрийн эцэст, “Өнөөдөр би энэ дэлхийд ямар нэгэн сайн үйлийг хийсэн үү? Тусламж хэрэгтэй хэн нэгэнд тусалсан уу?” (*Hymns*, 223) гэсэн асуултанд “тийм” хэмээх хариултыг хэлэх боломжтой байцгаая хэмээн би даруухнаар залбирч байна.

Энэ бол Бурханы ажил. Бүхнээ зориулсан тэдгээр жижигхэн ажилч зөгийнүүд шиг өөрсдийн ажлыг итгэлтэйгээр хийцгээе хэмээн даруухнаар Есүс Христийн нэрээр залбирч байна, амен.

# Надад ирэгтүн, Ай Израилын угсаа Та нар!

Далын

*Ахлагч Ларри Эко Хок*

---

*Бид бүгд Аврагч Есүс Христ дээр ирж, зүрх сэтгэлээ цэвэршүүлэх үед Мормоны Номонд өгөгдсөн хүчит амлалтуудыг биелүүлэх зэмсэг болцгоох юм.*

---

Вьетнамын дайны үед би Америкийн Нэгдсэн Улсын Явган Цэргийн албанд сайн дураар элссэн. Тэгээд цэргийн бэлтгэл хийхээр Виржиниа мужийн Куантикод ирсэн даруйдаа 54 шинэ цэргийн хамт хуарандаа орныхоо өмнө номхон тушаалтай зогсож байлаа. Жагсаалын дарга маань олон тулаанд орж хатуужсан ахмад дайчин байсан бөгөөд анх удаа бидэнтэй танилцахдаа хуарангийн хаалгыг зад өшиглөн, хараалын үгс хашгичсаар орж ирж билээ.

Өөрийгөө ийм ширүүн байдлаар танилцуулсныхаа дараа тэрээр цэрэг болгоноос асуулт асууж эхэлсэн юм. Тэр шинэ цэрэг болгоныг гоочлох зүйл олж, бүдүүлгээр шоолон тохуурхаж байв. Жагсаалын дундуур асуултаа асууж явахад нь түүний тушааснаар цэрэг болгон асуултанд нь “Тийм” эсвэл “Үгүй, Сургагч Түрүүчээ” хэмээн чанга дуугаар хариулж байлаа. Номхон тушаал авч эгц урагшаа харан зогссон байсан учраас түүний юу хийж байгааг харах боломж надад байсангүй. Миний ээлж болоход, тэр миний цүнхийг аван, доторх зүйлсийг нь орон дээр асгахыг би мэдсэн. Эд зүйлсийг минь онгичиж байснаа, миний өмнө ирж зогсоход нь түүний дайралтанд бэлтгэн хамаг биеэ чангалж билээ. Тэр миний Мормоны Номыг барьсан байв. Хашгичиж эхлэхийг нь



хүлээж байтал тэр над руу ойртоод, “Чи Мормон уу?” хэмээн асуув.

Тушаасных нь дагуу би, “Тийм ээ, Сургагч Түрүүчээ” гэж байдаг чангаараа хашгиран хариулав.

За одоо л болохоо болино доо гэж бодож байтал тэрээр хэсэг чимээгүй байснаа, Мормоны Ном барьсан гараа өргөн, маш намуухнаар “Чи энэ номонд итгэдэг үү?” гэж асуулаа.

Би дахиад л хамаг чадлаараа “Тийм ээ, Сургагч Түрүүчээ” хэмээн хариулав.

Яг тэр мөчид би түүнийг мормончууд болон Мормоны Номыг доромжлон хашгирч эхэлнэ гэдэгт огт эргэлзээгүй юм. Гэвч тэр юу ч хэлсэнгүй. Хэдэн хормын дараа тэр ор луу минь очиж Мормоны Номыг маань болгоомжтойгоор буцаан тавьж билээ. Тэгээд тэр намайг алгасан үлдсэн шинэ цэргүүдийг бүдүүлэг үгсээр доромжилсоор цааш одсон.

Яагаад тэр айхтар Явган Цэрэг намайг доромжлолгүй зүгээр орхисон юм бол хэмээн би олон удаа гайхширан бодож байлаа. Гэхдээ би ямар ч эргэлзээгүйгээр “Тийм ээ, би Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүн”, “Тийм ээ, би Мормоны Номыг үнэн гэдгийг мэднэ” гэж хэлж чадсандаа баяртай байдаг. Энэ гэрчлэл нь Ариун Сүнсээр дамжин, хоёр номлогч мөн пристүүдийн чуулгын зөвлөхийн тусламжтайгаар надад ирсэн үнэт бэлэг юм.

Намайг 14 настай байхад Лий Пийрсэн, Боид Кэмпхаисэн гэдэг хоёр номлогч манай гэр бүлийнхэнд Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээг зааж, би баптисм хүртсэн. Хоёр жилийн дараа, пристүүдийн чуулгын зөвлөх Ричард Борен надаас Мормоны Номыг уншихыг хүссэн юм. Би тэр урилгыг хүлээн авч, орой болгон доод тал нь арван хуудсыг уншсаар дуусгасан.

Эхний хуудсан дээр нь, “Израилын угсааны үлдэгдэл болох Леменчүүдэд мөн түүнчлэн Иудей болон харийнханд бичигдсэн болой” гэж бичсэнийг би уншсан. Мормоны Ном: Есүс Христийн бас Нэгэн Гэрээ номын удиртгал хэсэгт леменчүүдийг “Америкийн индианчуудын өвөг дээдэс” гэж бичсэн байдаг. Мормоны Номыг унших зуур энэ номонд миний Америкийн индиан өвөг дээдсийн тухай бичигдсэн мэт надад санагдсан. Үүнд, МЭӨ 600 орчим онд “амлалтын

нутагт” (1 Нифай 2:20) очихоор Иерусалимаас гарсан хүмүүсийн түүхийг, тэдний нэг хэсгийг хожим нь Леменчүүд хэмээн нэрлэсэн тухай өгүүлдэг. Мормоны Ном бол Америк тивийн хаа нэгэнтээ амьдарч байсан эдгээр хүмүүстэй Бурхан хэрхэн харьцаж байсан талаарх цэдэг юм. Мөн Есүс Христ Амилуулалтынхаа дараа тэдний дунд номлосон талаарх цэдэг байдаг. Цаг хугацааны явцад тэдгээр хүмүүс Америк тив даяар болон ойр орчмын арлууд дээр тархсан болохыг Мормоны Номонд өгүүлсэн байдаг (Алма 63:9–10 үзнэ үү). Ирээдүйд харийнхан олноороо энэхүү амлалтын нутагт ирж, Бурханы уур хилэн Леменчүүд дээр бууж, тэд тархаж, мөн цохигдон бараг устгагдах болно хэмээн Мормоны Номын бошиглогчид зөгнөн хэлж байсан (1 Нифай 13:10–14 үзнэ үү).

Миний элэнц эцэг Эко Хок нь Пони овгийн Индиан хүн бөгөөд 1850-иад оны орчимд одоогийн Небраскад төржээ. Түүнийг 19 настай байхад, Пони овгийн хүмүүсээс 23 сая акр (9.3 сая га) газрыг нь Америк тивд цагаачлан ирсэн хүмүүс булаан авсан юм. 1874 онд Пони овгийн хүмүүс хэдэн зуун км газар алхсаар Оклахомагийн Индианчуудын Бүс буюу индианчуудад зориулсан тусгай газар нутагт иржээ. Оклахомад ирэхэд 12 мянган Пони хүмүүсээс 700 ч хүрэхгүй үлдсэн байж. Бусад овгуудын нэгэн адилаар Пони овгийнхон ч мөн тараагдаж, цохигдон бараг устгагдсан.

Мормоны Номонд Израилын угсааны үлдэгдэл болох леменчүүдийн үр удамд өгөгдсөн онцгой захиас байдаг. Эдгээр хожмын өдрүүдийн талаар аавынхаа үзэгдлийг орчуулж байхдаа Нифай дараах захиасыг хэлдэг: “Мөн тэр өдөр бидний үр удмын үлдэгдэл, тэд бол Израилын угсааных гэдгээ, мөн тэд Их Эзэнтэй гэрээт хүмүүс гэдгээ мэдэх болно; мөн тэгээд тэд өвөг дээдсийнхээ мэдлэгт мөн түүнчлэн эцэг өвгөд нь түүгээр тохинуулагдсан өөрсдийн Гэтэлгэгчийн сайн мэдээний тухай мэдлэгт ирж мөн мэдэх болно; иймийн тул тэд өөрсдийн Гэтэлгэгч мөн түүний сургаалын мөн чанарын мэдлэгт орох болно; тэд түүнд хэрхэн ирж бас аврагдахыг мэдэж болохын тулд буюу” (1 Нифай 15:14).

Мормоны Ном бол ариун судар юм. Энэ нь мөнхийн сайн мэдээг бүрэн дүүрэн агуулдаг. Бошиглогч Иосеф Смит “Мормоны Ном бол дэлхий дээрх хамгийн зөв ном юм, мөн

энэ нь манай шашны тулгуур чулуу бөгөөд хүмүүн нь үүний хуулиудыг дагах юм бол, өөр ямар ч номыг дагаснаас илүүгээр Бурханд ойртох юм” гэж хэлсэн (*Teachings of Presidents of the Church, 4:461*).: *Joseph Smith* [2007], 64). Тийн энэ судар нь дэлхийн бүх л хүмүүст зориулсан захиасыг агуулдаг.

Мормоны Номыг анх удаа 17 настай байхдаа уншиж байсны хувьд би Моронайн: “Мөн та нар эдгээр зүйлийг хүлээн аваад, та нар Бурхан, Мөнхийн Эцэгээс, Христийн нэрээр, эдгээр зүйлүүд үнэн эсэхийг асуухыг та нарт ухуулья би; мөн хэрэв та нар Христэд итгэлтэй байж, чин сэтгэлтэйгээр, үнэн хүсэлтэйгээр асуух аваас, тэрбээр үүний үнэнийг Ариун Сүнсний хүчээр та нарт мэдүүлэх болно” (Моронай 10:4) гэх амлалтанд анхаарлаа төвлөрүүлж байж билээ.

Би өвдөг сөгдөн залбираад Мормоны Ном бол үнэн гэсэн хүчтэй сүнслэг гэрчлэлийг хүлээн авсан. Тэр гэрчлэл маань амьдралынхаа туршид зам мөрөө олоход надад тусалдаг.

Бүх хүмүүсийг Мормоны ном: Есүс Христийн бас Нэгэн Гэрээг уншихыг би уриалж байна.

Ялангуяа би Израилын угсааны үлдэгдэл Мормоны Номонд гардаг хүмүүсийн үр удам болох тэдгээр хүмүүсийг дэлхийн хаана ч байлаа гэсэн Мормоны Номыг ахин дахин уншихыг хүсч байна. Мормоны Номонд агуулагдсан амлалтуудын талаар судлаарай. Есүс Христийн үлгэр жишээ, сургаалыг дагаарай. Их Эзэнтэй гэрээ хийж, тэдгээрийг сахиарай. Ариун Сүнсний удирдамжийг эрэлхийлж мөн үүнийг дагаарай.

Мормоны Номын өөр нэгэн бошиглогч болох Амаликайн хэлсэн үгсээр би яриагаа төгсгөө: “Мөн эдүгээ, хайрт ах дүүс минь, та нарыг Израилын Ариун Нэгэн болох Христэд ирж, мөн түүний авралаас мөн түүний гэтэлгэлийн хүчнээс хүртээсэй хэмээнэ би. Тийм ээ, Түүнд ирэгтүн, мөн өөрийн бүхэл бодгалийг түүнд өргөл болгон өгөгтүн, мөн мацаг барьж бас залбирахаа үргэлжлүүл, мөн эцсийг хүртэл тэвчигтүн; мөн Их Эзэн амьдардгийн адил та нар аврагдах болно (Омнай 1:26).

Бид Аврагч Есүс Христ дээр ирж, зүрх сэтгэлээ цэвэршүүлэх үед Мормоны Номонд өгөгдсөн хүчит

амлалтуудыг биелүүлэх зэмсэг болж чадна. Үүнийг би Есүс Христийн ариун нэр дээр гэрчилж байна, амен.

# Амиа сольж авахын тулд хүн юугаа өгөх юм бэ?

Далын

Ахлагч Роберт С.Гей

*Эцэгийн мөнхийн амьдралын шагналыг авахын тулд жижиг ч бай том ч бай бүх нүглээ орхино.*

Аврагч Өөрийн шавь нараас “Амиа сольж авахын тулд хүн юугаа өгөх юм бэ?”<sup>1</sup> хэмээн асуусан байдаг.

Энэ асуултыг аав маань олон жилийн өмнө надад анхааралтайгаар тунгаан бодохыг заасан юм. Намайг бага байхад аав ээж маань надад гэрийн ажлыг даалгаж, хариуд нь надад багахан хэмжээний мөнгө өгдөг байлаа. Би долоо хоногт 50 центээс арай илүү их мөнгө авдаг байсан бөгөөд тэрхүү мөнгөөрөө ихэнхдээ кино театрт кино үздэг байсан юм. Тэр үед 11 настай хүүхдийн тасалбар 25 цент байсан болохоор надад 25 цент үлддэг байлаа. Би үлдсэн мөнгөөрөө нэг ширхэг нь 5 центийн үнэтэй чихрийн цуглуулгаас авдаг байсан. Таван чихрийн цуглуулгатай кино! Би үүнээс илүү сайхан байж чадна гэж үү.

Намайг 12 нас хүртэл бүх зүйл ийм сайхан хэвээрээ байлаа. Би киноны тасалбар авахаар зогсож байхдаа 12 настай хүүхдийн тасалбар 35 цент байхыг анзаарлаа. Энэ нь хоёр чихрийн цуглуулгын мөнгийг хасна гэсэн үг. Би энэхүү золиослолыг хийхэд бэлэн биш байсан учраас өөртөө “Чи долоо хонгийн өмнөх шигээ л харагдана шүү дээ” гэж өөртөө шалтаг олсон юм. Би урагшилж, 25 центийн тасалбар өгөхийг хүслээ. Кассчин анзаарсангүй, би ч урьдын адил гурвын оронд таван чихрийн цуглуулга худалдан авлаа.

Өөрийнхөө хийсэн зүйлд баяртай байсан болохоор би аавдаа өөрийнхөө том амжилтыг хэлэхээр гэр рүүгээ яарч

билээ. Намайг бүх зүйлийн талаар нэг бүрчлэн хэлэхэд аав маань юу ч хэлээгүй юм. Намайг ярьж дууссаны дараа тэр над руу хараад “Хүү минь, чи өөрийнхөө амийг таван центийн зоосоор солих байсан уу?” гэж асуусан юм. Түүний үгс миний зүрх сэтгэлд дэндүү хүчтэй нөлөөлж, энэ нь хэзээ ч мартахгүй хичээл болсон юм.

Олон жилийн дараа би идэвх султай Мелкизедек санваартан ахаас уг асуултыг асуусан. Тэрээр гэр бүлийнхэндээ хайртай гайхамшигтай ах байлаа. Гэсэн хэдий ч тэрээр сүмд олон жилийн турш яваагүй байсан. Түүнд тэмцээнээс тэмцээний хооронд явдаг мэргэжлийн спортын багт тоглодог гайхалтай авьяастай хүүтэй байлаа. Түүний баг Ням гарагт дасгал хийж, тэмцээнд оролцдог байсан бөгөөд хэд хэдэн том тэмцээнд түрүүлсэн. Би түүнтэй уулзахдаа түүнд санваартны хувьд тэрээр тангараг хийгээд гэрээгээ эрхэмлэн биелүүлвэл “Эцэгт байгаа бүхэнг.”<sup>2</sup> хүлээн авна гэсэн амлалт байгааг сануулсан юм. Дараа нь би түүнээс “Улсын аваргын төлөө тэмцээн Эцэгт байгаа бүхнээс илүү чухал уу?” гэж асуусан юм. Тэрээр эелдгээр “Би таны хэлэх гээд байгаа зүйлийг ойлголоо” гэж хэлээд бишоптойгоо уулзах цаг товлосон юм.

Өнөөдөр бидний сайн зорилгыг үл харгалзан дэлхийн сайн гэж хэлэх зүйлст хэт их автагдах нь амархан болсон байна. Дэлхий биднийг “алсуур хайхыг.”<sup>3</sup> ятгаж байна. Саяхан нэг хүн надаас “Ганцхан хундага архи тогтоочих нь тийм сүртэй зүйл үү?” гэж асуусан юм. Энэ нь дайсны үг болохыг та мэдэхгүй байна гэж үү? Кайн “Миний мэдэх ёстой тэр Их Эзэн чинь хэн бэ?”<sup>4</sup> гэж асуугаад амиа алдсан байдаг. Бид бяцхан нүглийн төлөө өөрсдийгөө зөвтгөх үед Сатан ялалтын бүрээ үлээж байдаг. Нэг лонх сүү,<sup>5</sup> буруу үсэглэсэн нэр,<sup>6</sup> аяга шөлөөр,<sup>7</sup> хүүгийн эрх, өв худалдагдаж байлаа.

Бид аяга шөл эсвэл аваргын төлөөх тэмцээнээр амиа солихоор уруу татагдах үедээ Каин шиг өөрсдийнхөө үйлдлийг зөвтгөж болно эсвэл Бурханы тааллыг дагахыг эрэлхийлж болно. Бид үргэлж л тийм байсан болохоор бид өөрсдөөсөө засвар, залруулга хэрэгтэй ямар нэгэн зүйлийг бид хийж байна уу гэхээсээ илүүтэйгээр бид Эцэгийн хүслийг

гүйцэтгэх үү эсвэл эргэн буцах уу? гэдгээ өөрсдөөсөө асуух ёстой.<sup>8</sup>

Их Эзэн бидний зөв шударга байдалд хайртай боловч биднийг үргэлжлүүлэн наманчилж, дуулгавартай байхыг хүсдэг. Бид Библиэс нэгэн тушаалуудыг сахихдаг баян залуу Аврагчийн өмнө сөгдөөд “мөнх амийг өвлөн авахын тулд би юу хийх хэрэгтэй вэ?” гэж асуудаг тухай уншдаг. Аврагч түүнд “Чамд нэг л юм дутаж байна. Явж, өөрийн бүх өмчөө зарж ядууст өг.”<sup>9</sup> гэж хэлэхэд тэр гунигтайгаар буцаад явсан юм.

Баян дэлхийн зүйлст хэт автсан Леменчүүдийн хаан, Лемонайн эцэг бас мөнхийн амьдралын талаар үүнтэй адил асуултыг асуусан: “Энэ ёс бусын сүнснийг цээжнээсээ үндсээр нь сугалуулан, мөн Бурханаар төрж болохын тулд, мөн түүний Сүнснийг хүлээн авч болохын тулд би юу хийх билээ? . . . Би энэхүү агуу баяслыг хүлээн авч болохын тулд би хаант улсаа орхих болно.”<sup>10</sup>

Их Эзэн Өөрийн үйлчлэгч Ааронаар дамжуулан түүнд ямар хариулт өгснийг санаж байна уу? “Хэрэв та бүх нүглүүдээ наманчилбал, мөн Бурханы өмнө доош бөхийвөл, та хүлээн авах болно гэдэгтээ найдсаар, мөн итгэлтэйгээр түүний нэрийг дуудвал, тэгвэл та хүссэн тэрхүү найдварыг хүлээн авах болно.”<sup>11</sup>

Хаан хийх ёстой тэдгээр золиослолуудыг ойлгоод өөрийгөө даруусгаж, газар дээр сунан хэвтэж, “Ай Бурхан, . . . би таныг мэдэхийн тулд бүх нүглүүдээ орхих болно.” хэмээн залбирдаг.<sup>12</sup>

Эцэгийн мөнхийн амьдралын шагналыг авахын тулд жижиг ч бай том ч бай бүх нүглээ орхих нь Аврагчийн биднээс хариуд нь авахыг хүсдэг зүйл юм. Бид өөрсдийгөө зөвтгөсөн явдал, шалтаг, ухаалаг тайлбар, биеэ өмөөрөх, хойш тавих зан, гадаад төрх, хувийн бардамнал, шүүмжилсэн бодол санаа болон юмсыг өөрийнхөөрөө хийх зангаа мартаж ёстой. Бид өөрсдийгөө бүх дэлхийн зүйлсээс салгаж, Бурханы дүр төрхийг царай төрхөндөө хүлээж авах хэрэгтэй.<sup>13</sup>

Ах эгч нараа, энэ шаардлага нь зөвхөн муу зүйлс хийхгүй байхаас илүүт шаардана гэдгийг санаарай. Бидний дайсан үргэлж идэвхтэй тэмцдэг учраас бид ч бас үйлдэл хийх ёстой

ба “дүйнгэ, бодлогогүйгээр.”<sup>14</sup> суух ёсгүй. Бурханы дүр төрхийг царай төрхөндөө хүлээж авна гэдэг нь бие биендээ үйлчлэхийг хэлж байгаа юм. Бидний хийдэг зүйлс нүгэл байхад хийх ёстой зүйлсээ хийдэггүй нүгэл мөн байдаг бөгөөд бид энэ хоёроос хоёулангаас нь зайлсхийх ёстой.

Африкт номлолын ерөнхийлөгчөөр үйлчилж байх үедээ хуралд явах замдаа энэ агуу үнэнийг мөнхөд заасан нэгэн бяцхан хүү ганцаараа замын хажууд мэгшин уйлж байгааг харснаа би мартдаггүй юм. Миний дотор нэгэн дуу хоолой “Зогсоод тэр хүүд тусал” гэж хэллээ. Тэр дуу хоолойг бараг сонссон даруйдаа би өөртөө тайлбар гарган “Чи зогсож болохгүй. Чи хоцорно шүү дээ. Чи бол тэргүүлэх албан тушаалтан, тиймээс хоцорч болохгүй” гэж хэллээ.

Намайг хурал болох цуглааны байранд ирэх үед нөгөөх хоолой дахин “Яваад тэр хүүд тусал” гэж дахин хэллээ. Би машиныхаа түлхүүрийг Афаси гэдэг Сүмийн гишүүнд өгөөд тэр хүүг над дээр авчрахыг гуйсан юм. 20 минутын дараа миний мөрийг хэн нэгэн цохисон бөгөөд хүү гадаа ирсэн байсан юм.

Тэр ойролцоогоор 10 настай байсан бөгөөд түүний аав нь нас барж, ээж нь шоронд орсныг бид олж мэдлээ. Тэр Акрагийн ядуусын хороололд өөрт нь хоол хийж өгч, унтах газар олж өгдөг асрагчтай амьдардаг байжээ. Тэрээр амьдрах газрынхаа мөнгийг олохын тулд гудамжинд хатаасан загас зардаг байжээ. Тэр өдөр хүү өдөржингөө хамаг байдгаараа хашгиран загас зарсныхаа дараа халаасандаа гараа хийхдээ цоорхой байсныг олж мэджээ. Тэр бүх орлогоо алдсан байлаа. Хэрэв тэр мөнгөгүй гэртээ харивал худалч нэртэй болж, зодуулан, гудамжинд хөөгдөж гарах байсныг би харсан даруйдаа ухаарсан билээ. Бид түүний айдсыг дараад, түүнд алдсан мөнгийг нь өгөн, гэр болон асрагчид нь хүргэж өгсөн.

Тэр өдөр би гэр рүүгээ харих замдаа хоёр агуу үнэнийг ухаарсан юм. Нэгдүгээрт, би урьд нь хэзээ ч мэдэж байгаагүйгээр Бурхан хүн нэг бүрийг халамжилдаг бөгөөд хэзээ ч биднийг орхихгүй. Хоёрдугаарт, бид өөрсдөдөө байгаа Сүнсний дуу хоолойг байнга сонсож байх ёстойг би мэдэх бөгөөд өөрсдийн айдас болон тавгүй байдлаас үл хамааран



биднийг хааш нь аваачна, тийшээ “шууд”<sup>15</sup> явах ёстой гэдгийг сурсан юм.

Нэгэн өдөр шавь нар нь Аврагчаас тэнгэрийн хаанчлалд хэн нь хамгийн агуу болохыг асуудаг. Тэр хөрвөгдөж, даруу байж, хүүхэд адил дуулгавартай байх нэгэн нь тийм байх юм хэмээн тэдэнд хэлээд үргэлжлүүлэн “Учир нь Хүний Хүү алдагдсаныг аврахаар ирсэн юм.”<sup>16</sup> гэжээ. Тэр энэ ганц өгүүлбэрээр бидний номлолыг тодорхойлсон юм. Бид алдагдсан, хамгийн сүүлд байдаг, хамгийн үнэ цэнэгүй гэж өөрсдийгөө боддог хүмүүсийг аврах ёстой. Зөвхөн нүглээс зугтах нь хангалтгүй бөгөөд бид “түүний загалмайг үүрэлцэж”<sup>17</sup> мөн бусдыг итгэлээ өөрчлөхөд нь туслахад “санаа сэтгэлээ бүрэн зориулж,”<sup>18</sup> байх ёстой. Энэрэл хайраар бид үрэлгэн хүүг тэврэн авч,<sup>19</sup> мэгшин уйлах өнчин хүүхдүүдийн уйлж, гуниглах цагт нь хамт байж, харанхуй болон гуниг зовлонд автсан хүмүүсийн гуйлт,<sup>20</sup> хийгээд гачигдсан гэр бүлийн зовлон зүдгүүрийг сонсохыг биднээс уриалдаг. “Сатан хүн бүрийг Каин эсвэл Иудас шиг болгох шаардлагагүй. Түүнд зөвхөн хүмүүсийг төвийг сахисан болгох л хангалттай”<sup>21</sup> хэмээн Ахлагч Нийл А.Максвелл хэлсэн юм.

Саяхан нэгэн гадасны чуулганы дараахан нэгэн өсвөр насны хүүхэд надад дөхөж ирээд “Бурхан надад хайртай юу?” гэж асуусан юм. Бурхан хэнийг ч ганцаар нь орхидоггүй гэдгийг бидний үйлчлэлээр дүүрэн амьдрал батлан харуулаасай.

“Амиа сольж авахын тулд хүн юугаа өгөх юм бэ?” хэмээх асуултын хувьд Сатан биднээс чихрийн цуглуулга, дэлхийн аваргын төлөөх тэмцээнээр амиа солихыг хүсдэг юм. Харин Аврагч бидэнд ямар ч дэлхийн шагнал амлалгүйгээр нүглүүдээ Түүнд өгч, Түүний царай төрхийг өөрсдөдөө шингээж, мөн тэр бүгдийг бусдын зүрхэнд суулгахыг хүсдэг юм. Ингэснээр бид дэлхийн бүх баялгаас ч агуу Бурханд байгаа бүхнийг хүлээн авах болтугай.<sup>22</sup> Танд төсөөлөгдөж байна уу?

Никарагуа дахь саяхны аяллынхаа үеэр би бидний зочилсон нэгэн энгийн амьдралтай гэр бүлийн гэрт “Миний гэрчлэл миний хамгийн үнэ цэнэтэй баялаг” гэх тэмдгийг олж харсан юм. Надад ч мөн адил. Миний гэрчлэл бол миний

бодгалын баялаг бөгөөд зүрх сэтгэлийнхээ гүнээс би энэ сүм бол Бурханы үнэн Сүм, Аврагч түүний удирдагч бөгөөд Өөрийн сонгосон бошиглогчоороо дамжуулан Сүмийг удирддаг гэдгийг гэрчилж байна. Есүс Христийн нэрээр, амен.

### Эшлэлүүд

1. Матай 16:26.
2. Сургаал ба Гэрээ 84:38.
3. Иаков 4:14.
4. Мосе 5:16.
5. Лонхтой сүү, түүний цөцгий нь Томас Б.Марш болон Харрис эгч нарын маргалдааны гол сэдэв байлаа. Тэд өөрсдийнхөө эх сурвалжуудыг нийлүүлж, бяслаг хийхээр тохирчээ. Марш эгч сүүндээ цөцгийнөөс хийлгүй өөртөө авч үлдэж байна гэдгийг Харрис эгч олж мэдсэнээр тэд хоорондоо муудалшжээ. Томас Марш асуудлыг бишопт хэлсэн боловч бишоп Харрисыг зөвтгөжээ. Энэ асуудал нь бишопоос Дээд Зөвлөл, Дээд Зөвлөлөөс Тэргүүн Зөвлөлд хүрч, тэнд байсад бүтд Марш эгч буруутай гэж үзжээ. Энэ нь Томас Марш болон Ах нарын дунд том ангал бий болгожээ. Удалгүй Томас Марш Миссуригийн хотын даргын өмнө Мормончууд Миссури мужид эелдэг бус хандаж байна гэж мэдүүлжээ (Жорж А.Смит. "Discourse." *Deseret News*, 1856 оны 4-р сарын. 16, 44-г үзнэ үү.).
6. Бошиглогч Иосеф Смит Саймонд Райдрьг номлолд үйлчлэхийг дуудах үед Райдр түүний нэрийг хэвлэгдэж гарсан илчлэлтэнд "Райдер" хэмээн буруу үсэглэсэн байсныг харжээ. Тэрээр гомдож, эцэстээ урвагч болж, бошиглогчийг өд, давирхайгаар

- цацахад оролцжээ. Иосеф Смит илчлэлтээ өөрийн бичээчид хэлдэг байсан бөгөөд нэрийг үсэглэх явцад оролцдоггүй байсныг Райдр мэдээгүй юм. (Milton V. Backman Jr., *The Heavens Resound: A History of the Latter-day Saints in Ohio, 1830–1838* [1983], 93–94; Donald Q. Cannon and Lyndon W. Cook, eds., *Far West Record: Minutes of The Church of Jesus Christ of Latter-day Saints, 1830–1844* [1983], 286-г үзнэ үү.)
7. Эхлэл 25-д Есав ууган хүү байх эрхээ Иаковт "талх болон аяга шөлний" төлөө худалдсан тухай бид сурдаг (шүлэг 34).
  8. Сургаал ба Гэрээ 19:18–19-г үзнэ үү.
  9. Марк 10:21–22-г үзнэ үү.
  10. Алма 22:15.
  11. Алма 22:16.
  12. Алма 22:18.
  13. Алма 5:14–19-г үзнэ үү.
  14. Алма 60:7.
  15. Марк 1:18.
  16. Матай 18:11.
  17. Иаков 1:8.
  18. Сургаал ба Гэрээ 58:27.
  19. Лук 15:11–32-г үзнэ үү.
  20. Иосеф Смит—Түүх 1:15–16-г үзнэ үү.
  21. Нийл А. Maxwell, *Deposition of a Disciple* (1976), 88.
  22. Сургаал ба Гэрээ 19:38-г үзнэ үү.

---

# Ариун сүмийн стандарт

Далын Ахлагч

Скотт Д.Вайтинг

---

*Энэ Сүм ариун сүмийн барилгад өндөр стандартуудыг баримталдаг нь бид хувийн амьдралаа хэрхэн авч явах ёстойн загвар бөгөөд бэлгэдэл юм гэдгийг би мэдсэн билээ.*

---

Би саяхан Ютагийн Бригам хотын үзэсгэлэнт ариун сүмд очихдоо Хавайн түүхэт Леи Ариун сүмийн нээлтийн үйл ажиллагаа, дахин онцгойлон адислалт болон соёлын төвийн үйл ажиллагааны зохицуулагчаар үйлчилж байсан үеэ дурсан саналаа.

Өргөн хүрээтэй шинэчлэлийн ажил дуусахаас хэдхэн сарын өмнө намайг Ариун Сүмийн Хэлтсийн Гүйцэтгэх захирал Ахлагч Виллям Р.Уокер болон түүний хэлтсийн ажилтнуудтай хамт ариун сүмийг шинэчлэн засварлах ажлын явцтай танилцана уу гэж урьсан юм. Биднээс гадна ерөнхий гүйцэтгэгч компаний олон ажилтан тэнд очсон байлаа. Бидний аяллын зорилгын нэг хэсэг нь ариун сүмийн шинэчлэлтийн явц, хийгдсэн ажлын чанарт шалгалт хийх явдал байв. Биднийг тэнд очих үед нийт ажлын 85 хувийг хийчихсэн байлаа.

Би ариун сүм дотор явж байхдаа Ахлагч Уокер болон түүний ажилтнууд ажлын чанарыг хэрхэн шалгахыг харж, ерөнхий гүйцэтгэгчтэй ярилцахыг нь сонсож явлаа. Биднийг нэг өрөөнөөс нөгөөг дамжин явах үед нэг хүн үе үе хананд гараа хүргээд байх нь ажиглагдав. Тэр хүн хананд хүрсэн гарын хуруунуудаа үрж үзсэнээ, барилгын ерөнхий гүйцэтгэгч рүү очин, “Энэ хана өөтэй байна. Ийм өө ариун сүмийн стандартад тохирохгүй. Та энэ өөг арилгаж, ханыг

тэгшхэн болгох хэрэгтэй” гэхэд гүйцэтгэгч түүний үг бүрийг хариуцлагатайгаар тэмдэглэн авч байлаа.

Хожим зөвхөн хэдхэн хүн л ашиглах Ариун сүмийн хэсэгт хүрч ирэхэд нөгөөх хүн биднийг зогсоож, шинээр угсарсан, гоёмсог, тугалга гүйлгэн хийсэн шилэн цонхонд бидний анхаарлыг хандуулав. Энэ цонхны хэмжээ нь 0,6 м өргөн, 1,8 м өндөр бөгөөд цонхыг геометрийн жижиг дүрсүүд бүхий өнгөт шилээр хийсэн ажээ. Тэрээр 5 см хэмжээтэй өнгөт шилэн тэгш өнцөгт рүү зааж, “энэ тэгш өнцөгт далий байна” гэлээ. Тэгш өнцөгтийг энгийн нүдээр харахад тэгшхэн юм шиг л байлаа. Гэвч би нарийн багаж бариад хэмжиж үзвэл нөгөөх жижигхэн тэгш өнцөгт үнэхээр 3 миллиметр далий байлаа. Энэ цонх ариун сүмийн стандартыг хангахгүй байгаа учраас үүнийг солих хэрэгтэй гэсэн зааврыг гүйцэтгэгч компанид өглөө.

Бараг ажиглагдамгүй ийм өчүүхэн өө сэвээс болоод бүх цонхыг солино гэдэг гайхмаар юм шиг надад санагдаж билээ. Учир нь ариун сүмийн энэ цонх хэний ч нүдэнд тусахааргүй, хэн ч мэдэхээргүй газарт байрлана шүү дээ.

Тэр өдөр би ариун сүмээс гэр рүүгээ явж байхдаа энэ туршлагаас сурсан зүйлээ тунгаан бодлоо. Өөрөөр хэлбэл би эндээс сурч мэдсэн зүйлээ эргэцүүлэн бодож билээ. Ариун сүмийн барилгын ажлын явцтай танилцахаар намайг тэнд очсоноос хойш хэдэн долоо хоног өнгөрч, засвар шинэчлэлтийн ажил дууссаны дараа би энэ тухай илүү зүйлийг ойлгосон юм.

Би бүрэн шинэчлэгдэж дууссан хойно нь Хавайн Леи Ариун сүмд ороод үзэсгэлэнтэй сайхныг нь гайхан биширч билээ. “Өөтэй хана,” “далий цонх” үзсэн тухайгаа эргэн санах нь надад сонин байсныг та бүхэн ойлгож байгаа биз ээ. Гүйцэтгэгч хананы өөтэй хэсгийг янзалсан болов уу? Цонхыг үнэхээр сольсон болов уу? Нөгөөх өөтэй хана руу хүрч очтол их л гоё ханын цаас наасан байлаа. “Барилгын гүйцэтгэгч ханын өөг яаж засаа бол гэж сонирхон хараад, өөг цаас нааж өнгөлөн далдалжээ” гэж би эхлээд бодов. Гэвч ариун сүмийн ханануудад анхнаасаа ханын цаас наахаар төлөвлөсөн байсныг би мэдлээ. Хэрэв ханын цаас наах л байсан юм бол бараг ажиглагдамгүй өчүүхэн жижиг өө сэвийг асуудал болгохын хэрэг юу байсан юм бол? гэж гайхлаа. Дараа нь би далий цонх

байсан газар руу яаран очтол цонхны өмнө шалнаас тааз шүргэсэн өндөр ургамлыг саванд хийж байрлуулсныг хараад ихэд гайхав. “Барилгын гүйцэтгэгч нөгөөх жижигхэн далий тэгш өнцөгтийг бас л өнгөлөн далдлаа шив дээ” гэж бодсоноо цонхонд тулж очоод, ургамлын навчийг хажуу тийш болгон харвал цонхыг үнэхээр сольсон байлаа. Би үүнийг хараад инээмсэглэв. Нөгөөх жижигхэн далий тэгш өнцөгт одоо тэгшхэн, гоё харагдаж байлаа. Энэ цонхны өмнө ургамал байрлуулах нь анхнаасаа ариун сүмийн дотоод засал чимэглэлийн нэг хэсэг байсныг би мэдлээ.

Өчүүхэн жижиг овон товонтой хана, бараг ажиглагдамгүй далий өнцөгтэй цонхыг засахад нэмэлт ажил хийх нь бас хүмүүс бараг ажиглахааргүй газарт байрлах цонхыг солих нь юунд хэрэгтэй юм бол? Барилгын гүйцэтгэгч яагаад ийм өндөр стандартыг баримтлах шаардлагатай байсан юм бол?

Би ариун сүмээс гараад дээшээ харж, шинэчилж дууссан барилгын гадна талын үзэсгэлэнтэй сайхныг болон “Их Эзэн Танд болон Таны Өргөөнд ариунаас ариуныг” гэсэн үгсийг хараад гүнзгий бодолд автаж билээ.

Энэ Сүмийн ариун сүмүүд нь дээрх үгсийн утгыг бүрэн илэрхийлж чаддаг. Эдгээр ариун барилгуудыг бид ашиглахын тулд барьдаг бөгөөд дотор нь авралын ариун нандин ёслолуудыг гүйцэтгэдэг билээ. Гэвч ариун сүм үнэхээр хэний өргөө болох тухайд аливаа эргэлзээ байх ёсгүй. Бид хамгийн жижиг сажиг зүйлүүдэд ч гэсэн барилгын стандартуудыг чанд баримталснаар зөвхөн Их Эзэн Есүс Христийг хайрлаж, Түүнийг дээдлэн хүндэлдгээ төдийгүй, ариун сүм бол Түүний өргөө учраас эдгээр ариун барилгуудад хүндэтгэлтэй ханддагаа бүх хүмүүст харуулдаг юм.

Их Эзэн Навугийн Ариун сүмийг барих тухай Бошиглогч Иосеф Смитэд өгсөн илчлэлтэд ийн зааварлажээ:

“Ирцгээ та нар, өөрсдийн бүх алттайгаар, мөн өөрсдийн мөнгөтэйгөөр, мөн өөрсдийн бүх эртний эдлэлүүдтэйгээр, мөн эртний эдлэлүүдийн талаар мэдлэгтэй ирэх хэн боловч, . . . дэлхийн бүх үнэт моднуудыг . . . авчраг;

“. . . Мөн миний нэрээр өргөө баригтун, учир нь үүн дотор Бүхнээс Дээд нь орших буюу.”<sup>1</sup>

Бид ариун сүмийг Их Эзэнд зориулан барихдаа Хуучин Гэрээнд Соломон хааны үндэслэн бий болгосон загварыг баримтлан хамгийн сайн материал, хамгийн дээд ур чадварыг<sup>2</sup> ашигладаг. Өнөөдөр бид энэхүү загварт бага зэрэг зохих өөрчлөлтүүдийг хийн Их Эзэний ариун сүмүүдийг барихад ашигласан хэвээрээ л байна.

Өө сэвийг энгийн нүдээр харж, хүмүүний гараар барьж үзээд мэдэх буюу мэдрэх аргагүй ч бид хир зэрэг хүч чармайлт гаргасан мөн өөрсдөдөө байгаа боломжоо дээд зэргээр дайчилсан уу, үгүй юү гэдгийг Их Эзэн мэддэг. Үүнтэй адил бид Ариун Сүмд орохуйц зохистой амьдрахын төлөө чадах бүхнээ хийж байна уу, үгүй юү гэдгийг тэр бас мэднэ. Их Эзэн ийн зөвлөсөн билээ:

“Мөн Их Эзэний нэрээр надад өргөө барьж, мөн энэ нь бузарлагдахгүй байхын тулд ариун биш зүйлийг үүн дотор орохыг хүлцэхгүй байхын хэрээр миний алдар суу үүн дээр орших болно;

“Тийм ээ, мөн миний оршихуй тэнд байх болно, учир нь би үүнд ирэх болно, зүрх сэтгэлээрээ ариун, үүнд ирэх тэд бүгд Бурханыг харах болно.

“Гэвч хэрэв энэ нь бузарлагдах аваас би үүнд орж ирэхгүй, мөн миний алдар суу тэнд байх нь үгүй, учир нь цэвэр ариун биш ариун сүмүүдэд бибээр орохгүй байх болно.”<sup>3</sup>

Дээрх барилгын гүйцэтгэгчийн адил, амьдралд маань Их Эзэний сургаалуудтай үл нийцэх ямар нэг зүйл байгааг мэдсэн үед, хүч чармайлтаа бүрэн дайчилж ажиллаагүйгээ мэдсэн үедээ нүглээ Их Эзэнээс нууж чадахгүй гэдгээ ойлгон, буруу зүйлийг тэр дор нь залруулах ёстой. “Бид нүглээ далдлахыг оролдоход . . . , болгоогтун, тэнгэр өөрийгөө татан авдаг; [мөн] Их Эзэний Сүнс гашууддаг”<sup>4</sup> гэдгийг санагтун.

Энэ Сүм ариун сүмийн барилгад өндөр стандартуудыг баримталдаг нь бид хувийн амьдралаа хэрхэн авч явах ёстойн загвар бөгөөд бэлгэдэл юм гэдгийг би мэдсэн билээ. Эрт үеийн Сүмд Төлөөлөгч Паулын өгсөн дараах сургаалыг бид амьдралдаа хэрэгжүүлж чадна:

“Та нар өөрсдөө Бурханы сүм мөн бөгөөд Бурханы Сүнс та нарын дотор оршдогийг мэддэггүй юм уу?

“Хэрэв хэн нэг нь Бурханы сүмийг устгавал Бурхан тэр хүнийг устгана. Учир нь Бурханы сүм бол ариун бөгөөд энэ нь та нар юм.”<sup>5</sup>

Бид бүгд хамгийн сайн материалаар хийгдсэн бөгөөд бурханлаг уран чадварын гайхамшигтай бүтээл юм. Гэвч бид хариуцлагын насанд хүрч, нүгэл, уруу таталттай нүүр учран тулсан үед бидний ариун сүмд шинэчлэл, засвар хэрэгтэй болдог. Бидний доторх ханануудад овон товон гарч, сэтгэл зүрхний цонхнууд далий болж мэднэ. Иймд бид ариун газруудад зогсож чадахын тулд зүрх сэтгэлээ шинэчлэн өөрчлөх хэрэгтэй. Биднээс биелүүлэхийг хүсдэг ариун сүмийн жишиг нь төгс төгөлдөр болохыг шаарддаггүй ч, үүнийг биелүүлэхээр хичээн чармайж, зарлигуудыг сахин, Есүс Христийн шавь байхаар амьдрахын тулд чадах бүхнээ хамгийн сайнаар хийхийг биднээс хүсэн хүлээдэг билээ. Бурханы Сүнс бидний дотор үргэлж оршихын төлөө бид дутагдал доголдол, төгс бус байдлаа засч залруулахын тулд чадах бүхнээ хамгийн сайнаар хийж, ариун сүмийн адислалуудад тэнцэхээр зохистой амьдрахын төлөө би залбирч байна. Есүс Христийн нэрээр, амен.

#### *Эшлэл*

1. Сургаал ба Гэрээ 124:26–27.
2. Хаадын Дээд 6–7-г үзнэ үү.
3. Сургаал ба Гэрээ 97:15–17-г үзнэ үү.
4. Сургаал ба Гэрээ 121:37.
5. 1 Коринт 3:16–17; мөн шүлэг 19-г үзнэ үү.

# Итгэлийн тань сорилт

**Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын**

*Ахлагч Нийл Л.Андерсен*

---

*Төмрийг ган болгон хувиргадаг цоргим халуун гал  
лугаа адил бидний итгэл хүндээр соригдох үед  
сүнсний ариусал бидэнд ирж, бидний сүнсний хүч  
чадал өсөн нэмэгдэх болно*

---

Арван жилийн өмнө намайг эхнэр Катигийнхаа хамт Бразил Улсын Сан Паулод амьдарч байхад, Ерөнхийлөгч Давид Мариотт Бразил Улсын Сан Пауло Интерлагос Номлолыг тэргүүлж байв. Тэрээр эхнэр Нийл болон Вилл, Вэсли, Трейс гэгч гурван хөвгүүнийхээ хамт манай ойролцоо амьдардаг байв. Тэд гэр орон, ажил төрөл, бас гэр бүлийнхээ олон гишүүнийг орхиод номлолд үйлчлэх бошиглогчийн дуудлагын дагуу тэнд очсон юм.

Нэг удаа Ерөнхийлөгч Мариотт намайг дуудав. Индиана мужийн Их Сургуулийн хийлийн ангийн төгсөх курсийн оюутан, тэдний 21 настай, зөв шударга, хайрт охин Жоржияг Сүмийн цуглааны дараа дугуйгаар гэр рүүгээ явж байхад нь ачааны машин шүргэчихсэн ажээ. Энэ тухай анх мэдэгдэхэд Жоржиягийн бие гайгүй байсан ч, хэдэн цагийн дараа бие нь гэнэт муудсан гэнэ.

Жоржияд туслахын тулд гэр бүл, найз нөхөд нь мацаг барьж, залбирч эхэлсэн байлаа. Ээж нь тэр шөнөдөө Бразилаас нисч очжээ. Түүнийг Индианад ирэхэд хоёр том хүүхэд нь тосч, Жоржияг нас барахад нь түүний дэргэд байсан тухай ярьжээ.

Би Мариоттын гэр бүлд тохиолдсон энэхүү эмгэнэлт явдлын үеэр түүнчлэн дараагийн хэдэн сар, хэдэн жилд тэднийхнийг ажиглан харж байлаа. Тэд уйлж унжин, залбирч, Жоржиягаа дурсан ярьж, уй гашууд автан, сэтгэл санаагаар



унасан ч, итгэл нь хэзээ ч алдраагүй юм. Энэ өглөөний хуралдаан дээр бид үүнтэй төстэй итгэлийн тухай Бовен болон Вилбергэрийн гэр бүлийн гайхалтай түүхийг сонслоо.<sup>1</sup>

Итгэлийн бэлэг бол сүнсний үнэлж баршгүй бэлэг юм. “Цорын ганц үнэн Бурхан Таныг болон Таны илгээсэн Есүс Христийг мэдэх нь мөнхийн амь мөн”<sup>2</sup> хэмээн Есүс нэгэнтээ залбирсан байдаг.

Бидний итгэл Бурхан Эцэг болон бидний Аврагч бөгөөд Гэтэлгэгч Түүний Хүү Есүс Христ дээр төвлөрдөг. Энэхүү итгэлийг сайн мэдээний бүрэн байдал дэлхий дээр сэргээгдсэн, Мормоны Ном бол Бурханы үг мөн бошиглогчид, төлөөлөгчид өнөөдөр санваарын түлхүүрүүдийг атгадаг тухай мэдлэг дэмждэг. Бид итгэлээ эрхэмлэн дээдэлж, итгэлээ бэхжүүлэхийн төлөө хөдөлмөрлөн, итгэлээ улам нэмэгдүүлэхийн төлөө залбирч, итгэлээ хамгаалахын төлөө чадах бүхнээ хийдэг билээ.

Төлөөлөгч Петр “та нарын итгэлийн баталгаа”<sup>3</sup> гэсэн нэг зүйлийг нэрлэсэн байдаг. Тэр энэ зүйлийг биеэрээ үзсэн юм. Есүсийн дараах үгсийг санагтун:

“Симон оо, . . . чамайг улаан буудай мэт шигшихийн тул Сатан зөвшөөрөл гуйсан.

“Гэсэн ч итгэл чинь сульдахгүй тулд Би чиний төлөө залбирсан.”<sup>4</sup>

Төлөөлөгч Петр хожим нь, “Та нарыг сорихын тулд дунд чинь ирдэг галт сорилтод ямар нэгэн хачирхалтай юм та нарт тохиолдсон мэт бүү гайх”<sup>5</sup> хэмээн хэлж биднийг урамшуулан дэмжсэн юм.

Эдгээр хүнд сорилт та нарыг улам хүчирхэгжүүлэх учиртай ч Бурхан, Түүний Хүүд итгэх итгэлийг тань бууруулах буюу тэр ч бүү хэл бүр устгаж, Түүнд өгсөн амлалтуудаа тууштай биелүүлэх хүслийг тань сулруулж бас болно.

Итгэлийн тань сорилтын үед та нар хэрхэн “хөдөлшгүй бөгөөд гуйвшгүй”<sup>6</sup> байж чадах вэ? Хэрэв та итгэлийнхээ Христэд итгэх итгэлээ ашиглан, залбирч, судруудыг тунгаан бодож, наманчлан, зарлигуудыг сахиж, бусдад үйлчилснээр та итгэлийнхээ үндэс суурийг бий болгоход туслах зүйлсийг хийхэд өөрийгөө дайчлан ажилладаг билээ.

Итгэлийг тань сорьсон юу ч танд тохиолдлоо гэсэн Сүмээс бүү холд! Итгэлд тань сорилт тулгарсан үед Бурханы хаант улсаас өөрийгөө хөндийрүүлэх нь далайн хар салхи нүдэнд харагдахаар ойртсон үед хоргодох байраа орхин явахтай адил юм.

Төлөөлөгч Паул, “Та нар цаашид харь хүмүүс болон гаднын хүмүүс биш, харин ариун хүмүүсийн адил нутгийн иргэд бөгөөд Бурханы гэр бүлийнх юм”<sup>7</sup> гэж хэлсэн билээ. Бид Сүмд явснаар итгэлээ хамгаалдаг. Бид итгэлтэй хүмүүстэй цуглан залбирч мөн залбиралдаа хариу авдаг. Мөн бид дуу хөгжмөөр дамжуулан Бурханыг шүтэн биширч, Аврагчийн тухай гэрчлэлээ хуваалцан, бие биедээ үйлчилж, Их Эзэний Сүнснийг мэдэрдэг. Бид ариун ёслолоос хүртэж, санваарын адислалууд, авч, ариун сүмд ордог. “Ёслолуудад . . . , бурханлаг байдлын хүч илэрхийлэгддэг”<sup>8</sup> хэмээн Их Эзэн тунхагласан билээ. Та нар итгэлийн сорилттой тулгарсан үед Бурханы гэр бүлийн дотор аюулгүй үлдэгтүн. Бурханы гэр бүлд таны байр ямагт бэлэн байдаг. Бид хамтдаа даван туулж чадахгүй тийм давагдашгүй хүнд сорилт гэж байдаггүй.<sup>9</sup>

Ерөнхийлөгч Томас С.Монсон ингэж хэлсэн юм:

“Нийгмийн ёс суртахууны луужин буюу чиг хандлага [түргэн өөрчлөгдөж байна]. Нэгэн цагт . . . зохисгүй гэгддэг байсан зан авирыг эдүгээ олон хүмүүс . . . байж болох зүйл . . . хэмээн үздэг болжээ.”<sup>10</sup>

Залуу насаа үдэж буй ганц бие насанд хүрэгчид Сүмд олноороо байна. Амьдрал нь тэдний хүсэн хүлээж байснаас өөрөөр эргэсэн ч тэд ариун явдлын хуулийг сахьдаг.<sup>11</sup> Энэ бол тэдний итгэлийн сорилт юм. Христийн шавь нар болох эдгээр залуу эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийг би гүнээ хүндэлж, тэднээр бахархдаг.

“Нөхөн үржихүйн ариун хүч нь . . . зөвхөн хууль ёсоор гэрлэсэн эхнэр нөхөр болох эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хооронд байх ёстой”<sup>12</sup> хэмээн Бурхан зарлиг болгосон билээ. Шинэ Гэрээнд Аврагч “Эмэгтэй хүнийг тачаадан харах хүн бүр зүрхэндээ түүнтэй хэдийнээ завхайрсан хэрэг юм”<sup>13</sup> хэмээн мэдэгдэж, дагалдагчдынхаа чанд баримтлах ёстой ёс суртахууны жишгийг тунхагласан юм. Тэрээр бидэнд бусдыг

шүүмжлэхгүй байхыг заасан боловч, Тэр “Яв, дахин бүү нүгэл үйлд”<sup>14</sup> хэмээн шулуухан хэлдэг байлаа.

Манай гэр бүлийн нэг найз байдаг. Та нар түүнтэй адилхан хэн нэгнийг таньдаг магадгүй та өөрөө ч түүнтэй адилхан байж болно. Тэр эмэгтэй үргэлж итгэлтэй байж, Сүмд үнэнчээр үйлчилдэг. Мэргэжилдээ гаргуун сайн түүгээр гэрийнхэн нь бахархдаг. Найз маань гэрлэж, үрийн зулай үнэрлэхийг хүсэн хүлээдэг ч, ганц бие хэвээрээ л байна. “Би . . . итгэл найдвараа Есүс Христэд тавихаар шийдсэн. Хэрэв гэрээнүүддээ, түүний дотор ариун явдлын хуулийг үнэнч итгэлтэйгээр сахьвал . . . адислалыг надаас буцаан татахгүй . . . гэдэгт би итгэлтэй . . . байдаг”<sup>15</sup> гэж тэр ярьсан.

Бидний өөр нэг найз номлолд үнэнчээр үйлчилж, дараа нь өндөр шалгууртай академид дадлага хийж байгаа. Тэр гэр бүлтэй болохыг хүсдэг. Түүнд тулгарч байгаа итгэлийн сорилт бол ижил хүйстэндээ сэтгэл татагддаг явдал юм. “Нэгэн өдөр намайг гэр бүлтэй болно хэмээн миний патриархын адислалд амласан. Гэхдээ . . . энэ амьдралд уу эсвэл дараагийн амьдралд уу гэдгийг би мэдэхгүй. . . . Гэвч Бурханы амласан адислалуудыг үгүй болгох ямар нэг зүйлийг хийхийг би хүсдэггүй. . . . Ариун явдлын хуулиар амьдрах нь сорилт хэдий ч, бид тулгарсан сорилтуудыг даван туулж, хайр, хүндэтгэлээ Бурханд харуулж, Түүний зарлигуудыг сахихын тулд дэлхийд ирсэн биз дээ? Би сайн мэдээгээр, сайн эрүүл мэндээр, хайр энэрлээр дүүрэн гэр бүлээр, үнэнч анд найз нараар адислагдсан хүн. Ийм олон адислалынхаа төлөө би баярлаж явдаг”<sup>16</sup> гэж тэр саяхан надад бичжээ.

“Та яахлаараа их зүйлийг хүсдэг билээ?” хэмээн дэлхийг эсэргүүцэхэд Их Эзэн,

“Миний бодол санаанууд бол та нарын бодол санаа биш. Миний зам нь та нарын замаас өөр. . . .

“Тэнгэр нь газраас өндөр байдаг шиг Миний зам та нарын замаас, Миний бодол та нарын бодлоос өндөр билээ”<sup>17</sup> гэж хариулсан юм.

Христийн энэ хоёр дагалдагч, бас тэдэнтэй адил хэдэн арван мянган хүмүүс: “Би Өөрийн амар амгалангаа та нарт өгнө. Ертөнцийн өгдгөөс өөр юмыг Би та нарт өгч байна. Та

нар зүрхээ бүү зовоо. Бүү ай”<sup>18</sup> гэсэн Аврагчийн адислалыг мэдэрдэг, мэддэг билээ.

Өнөө үед нийтлэг тохиолддог өөр нэг сорилт бий. Сүмийг гутааж, итгэлийг устгахыг хүсдэг цөөн хүмүүс ямагт байсаар ирсэн, одоо ч байна. Өнөөдөр тэд интернетийг ашиглаж байна.

Манай сүмийн тухай тараадаг зарим мэдээлэл бодит мэт санагдавч үнэн бус байдаг. 1985 онд хамт ажилдаг нэг хүн “Мормоны шашин үндэслэгдсэн түүх үнэн үү?” гэсэн нэртэй өгүүлэл нийтлэгдсэн *Time* сэтгүүлийн дугаарыг гартаа барьсаар орж ирснийг би санаж байна. Уг өгүүлэлд Мартин Харрис бичсэн гэх, саяхан олдсон нэг захидлын тухай өгүүлжээ. Энэ өгүүлэл Мормоны Номын ялтсуудыг олсон тухай Иосеф Смитийн шастиртай зөрчилдсөн байлаа.<sup>19</sup>

Энэ шинэ мэдээлэл Мормоны Сүмийг устгах юм биш үү? гэж миний хамтран ажиллагч надаас асуув. Энэхүү баримт бичгийн улмаас Сүмээс гарна гэж хэлсэн нэг хүний тухай энд дурдсан байв. Хожим нь өөр хүмүүс Сүмээс гарсан тухай мэдээлсэн юм.<sup>20</sup> Энэ бол тэдний итгэлийн сорилт байсан гэдэгт би итгэдэг.

Хэдэн сарын дараа шинжээчид уг захидал хуурамч болохыг илчилсэн (захидлыг хуурамчаар үйлдэгч нь бас гэм буруугаа хүлээсэн юм). Энэхүү мэхлэлтийн улмаас Сүмийг орхисон хүмүүс Сүмд эргэж ирнэ гэдэгт би итгэлтэй байснаа санаж байна.

Хэдэн арван жилийн өмнө Сүмийн нэг удирдагчийн хэлсэн үг манай Сүмийн сургаалтай нийцэхгүй байгаа юм шиг санагдсан үед цөөн хүмүүс өөрсдийн итгэлд эргэлзсэн явдал бий. Сүмийн сургаалд удирдлага болгодог нэг чухал зарчим байдаг. Аль нэг сургаалыг Тэргүүн Зөвлөл болон Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын 15 гишүүн бүгдээрээ адилхан заадаг. Бидний сургаал хэн нэгний хэлсэн тодорхой бус үгсээр халхлагдсан байдаггүй. Үнэн зарчмуудыг олон удаа, олон хүн заадаг. Манай Сүмийн сургаалыг олж үзэх нь төвөггүй юм.

Сүмийн удирдагчид чин шударга боловч төгс биш хүмүүс. Моронайн дараах үгсийг санагтун: “Миний төгс бусын улмаас намайг, бас түүний төгс бусын улмаас эцгийг минь ч, бас түүний өмнө бичсэн тэднийг ч бүү буруушаа; харин та нар

бидний байснаас илүү ухаалаг байхад сурч болохын тулд, бидний төгс бусыг та нарт илчилсэнд нь Бурханд талархлаа мэдүүл.”<sup>21</sup>

Иосеф Смит ингэж хэлсэн юм, “Би бол төгс хүн гэж та нарт хэзээ ч хэлэхгүй. Гэвч илчлэлтүүдэд буруу зүйл байхгүй.”<sup>22</sup> Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн түүх болон хувь тавилан дахь Бурханы мутрын гайхамшгийг зөвхөн сүнсний гэрлээр дамжуулан ойлгож болно. “Хүн бүр эцсийн бүлэгт итгэлдээ тулгуурлаж, байр сууриа. . . илэрхийлэх ёстой”<sup>23</sup> хэмээн Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон хэлсэн юм. Энэ нь та нарт тохиолдвол бүү гайх!

Үндсэндээ сорилтууд нь хүнд байдаг. Тэдгээр нь сэтгэл эмзэглүүлэм, шаналгаа зовлонтой байж, олон шөнө нойргүй хонож, дэрээ нэвтэртэл уйлахад хүргэж болно. Гэвч бидэнд тулгардаг сорилтууд сүнслэг байдлын хувьд биднийг сүйрэлд хүргэх ёсгүй. Сорилтууд биднийг гэрээнүүдээ сахихгүй байхад, Бурханы гэр бүлээс холдон хөндийрөхөд хүргэх ёсгүй.

“ . . . Бурханы Хүү, Христ болох, бидний Гэтэлгэгчийн хадан дээр та нар сууриа тавих ёстойг санагтун; чөтгөр хүчит салхиа, . . . хуй салхин дахь дайралтаа илгээхэд, түүний бүхий л мөндөр мөн хүчит шуурга та нар дээр нүдэхэд . . . энэ нь та нарыг зовлонгийн хийгээд төгсгөлгүй халаглалын ангал тийш доош чирж дийлэх хүчгүй байх болно. . . .”<sup>24</sup>

Төмрийг ган болгон хувиргадаг цоргим халуун гал лугаа адил *бидний* итгэл хүндээр соригдох үед сүнсний ариусал бидэнд ирж, бидний сүнсний хүч чадал өсөн нэмэгдэх болно.

Ахлагч Тодд Кристофферсон өөртөө тохиолдсон сорилтоос сурсан зүйлийнхээ тухай: “Би тэр үед хэдийгээр зовсон ч одоо эргээд харахад, миний асуудал түргэн шийдэгдээгүйд би баяртай байдаг. . . . Би Аврагчаа бас Тэнгэрлэг Эцэгээ өөрөөр мэдэх аргагүй тийм арга замаар мөн тийм хэмжээгээр мэдсэн юм. . . . Би Их Эзэнд бүх зүрх сэтгэлээрээ итгэж сурсан юм.”<sup>25</sup>

Петр энэ туршлагыг “алтнаас ч . . . илүү үнэтэй”<sup>26</sup> гэж дүрсэлсэн бол Моронай “итгэлийн тань сорилтын”<sup>27</sup> дараа гэрчлэл ирдэг хэмээн нэмж хэлсэн юм.

Би Мариоттын гэр бүлийн тухай түүхээр үгээ эхэлсэн билээ. Өнгөрсөн долоо хоногт Кати бид хоёр тэдэнтэй хамт

Жоржиягийн шарил дээр очлоо. Арван жил улиран оджээ. Гэр бүл болон найз нөхөд нь Жоржияг хайрладаг байсан хайрынхаа тухай дурсан ярьж байлаа. Түүний амьдралыг дурсан тэмдэглэхийн тулд цагаан бортгон савтай гели авчирсан байлаа. Жоржиягийн ээж итгэл, ойлголт нь хэрхэн өсөн нэмэгдсэн тухайгаа сэтгэл нь уяран уйлсаар ярьсан бол, аав нь түүнд ирсэн амлагдсан гэрчлэлийн тухай чимээгүйхэн надад ярьж билээ.

Итгэлтэй болсон үед итгэлийн сорилт ирдэг бөгөөд үүний үр дүнд итгэл өсөн нэмэгддэг юм. Итгэл тань соригдсон үед та, итгэлийнхээ сорилттой тулгараад байсан үед нь Бошиглогч Иосеф Смитэд Их Эзэний өгсөн тайтгаруулагч амлалтыг санагтун. Энэ амлалт итгэл тань соригдсон үед танд бас өгөгдсөн юм : “Зам дээрээ зогсогтун . . . , бүү эмээ . . . , учир нь Бурхан чамтай үүрд хамт байх болно.”<sup>28</sup> Үүнийг би Есүс Христийн нэрээр ариунаар гэрчилж байна, амен.

#### Эшлэл

1. Шайн М.Бовен “Because I Live, Ye Shall Live Also,” ба Анн М.Дибб “Би үүнийг мэднэ. Би үүний дагуу амьдардаг. Би үүнд хайртай.” 2012 оны 10-р сарын Ерөнхий Чуулганы бямба гарагийн өглөөний хуралдаан.
2. Иохан 17:3.
3. 1 Петр 1:7.
4. Лук 22:31–32.
5. 1 Петр 4:12; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн.
6. Алма 1:25.
7. Ефес 2:19.
8. Сургаал ба Гэрээ 84:20.
9. Мозая 18:8–10-г үзнэ үү.
10. Томас С.Монсон, “Stand in Holy Places,” *Лиахона*, 2011 оны 11-р сар, 82.
11. Эзра Тафт Бенсон, “The Law of Chastity,” *New Era*, 1988 оны 1-р сар, 4–7; “The Law of Chastity” *Бригам Янг Их Сургууль 1987–88 Speeches* (1988), 1–5, [speeches.byu.edu](http://speeches.byu.edu); мөн *Сайн мэдээний зарчмууд* (2009), 224–32-ыг үзнэ үү.
12. “Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг,” *Лиахона*, 2010 оны 11-р сар, 129.
13. Матай 5:28.
14. Иохан 8:11.
15. Personal correspondence, 2012.
15. Personal correspondence, 2012.
16. Исаиа 55:8–9.
17. Иохан 14:27.
19. Ричард Н.Остлинг, “Challenging Mormonism’s Roots,” *Time*, 1985 оны 5-р сарын 20, 44.
20. Гордон Б.Хинкли, “Lord, Increase Our Faith,” *Ensign*, 1987 оны 11-р сар, 52.
21. Мормон 9:31.
22. *Сүмийн Ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит* (2007), 522.
23. Эзра Тафт Бенсон, “The Book of Mormon Is the Word of God,” *Tambuli*, 1988 оны 5-р сар, 6.
24. Хиламан 5:12.
25. Д.Тодд Кристофферсон, “Give Us This Day Our Daily Bread” (Сүмийн Боловсролын системийн галын дэргэдэх ярилцлага, 2011

- оны 1-р сарын 9), lds.org/  
broadcasts.
26. 1 Петр 1:7; мөн 1 Петр 4:13-ыг үзнэ үү .
27. Ифер 12:6.
28. Сургаал ба Гэрээ 122:9;  
Ерөнхийлөгч Жорж К.Каннон ийн хэлжээ: “Хүнд сорилт хэчнээн ч хэцүү, уй гашуу хэчнээн ч гүнзгий, гай зовлон хэчнээн их байлаа гэсэн Бурхан биднийг хэзээ ч орхихгүй. Тэр биднийг хэзээ ч орхиогүй өдий хүрсэн юм. Тэр ингэж чадахгүй. Энэ бол түүний зан чанар биш. Тэр өөрчлөгдөн хувирдаггүй; Тэр өчигдөр ямар байсан өнөөдөр хэвээрээ байгаа, ирэх мөнхийн эрин зуунуудад тэр хэвээрээ байх болно. Бид ийм Бурхантай хүмүүс. Бид Түүний зөвлөгөөг дагаснаар Түүнийг анд найзаа

болгосон юм. Иймээс Тэр биднийг түшин дэмжих болно. Бид галт зуухан дотуур өнгөрч, гүнзгий усыг туулж болно. Гэвч бид живэхгүй, тэвдэж сандрахгүй. Хэрэв бид Бурханд итгэж, Түүний зарлигуудыг сахих юм бол бүх хүнд сорилтууд, хүндрэл бэрхшээлээс улам сайжран, ариусан гарч ирэх болно” (“Freedom of the Saints,” эмхтгэсэн Брайн Х.Стаи, *Collected Discourses, Ерөнхийлөгч Вилфорд Вудраф, Түүний Хоёр Зөвлөхүүд, Арванхоёр Төлөөлөгчид, болон Бусад Хүмүүсээр хүргэгдэв* 5 боть [1987–92], 2:185); мөн Жеффри Р.Холланд, “Come unto Me,” *Ensign*, 1998 оны 4-р сар, 16–23-ыг үзнэ үү.

# Хүүхдүүдээ хамгаал

**Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын**

*Ахлагч Даллин Х.Өүкс*

---

*Хүүхдүүдийнхээ – өсөж буй үеийнхнийхээ сайн сайхан мөн тэдний ирээдүйн төлөө илүү ихээр санаа тавин нэгдье гэсэн миний уриалгыг харин үгүйсгэх ёсгүй юм шүү.*

---

Хүүхэд уйлан тусламж эрэн бидэн дээр ирэхэд ямар байдгийг бид бүгд мэднэ. Биднийг хайрладаг Тэнгэрлэг Эцэг маань өөрийн хүүхдүүдээ халамжлуулахын тулд тэдгээр мэдрэмжийг бидэнд өгдөг юм. Хүүхдүүдээ хамгаалж, тэдний сайн сайхны төлөө байх үүргийн талаар ярихад минь тэр мэдрэмжүүдээ дурсан санаарай.

Хүүхдүүдээ хамгаалах талаар Есүс Христийн сайн мэдээ, Түүний авралын төлөвлөгөө юу гэж заасан байдаг талаар би ярих болно. Энэ бол миний дуудлага. Орон нутгийн удирдагч нар тойрог, гадас гэсэн ганцхан нэгжийг хариуцдаг бол, Төлөөлөгч хүн дэлхий дахинаа гэрчлэх үүрэгтэй байдаг билээ. Үндэстэн, ястан, шашин болгонд байдаг хүүхдүүд бол Бурханых юм.

Улс төр, нийгмийн дэг журам хүүхдүүдийн сайн сайхны талаар ямар байр суурьтай байдаг талаар би ярихыг хүсэхгүй ч, бусад сүмийн удирдагч нарын адил иргэн, албан хаагч болон хувийн хэвшлийн байгууллагуудын ажилчдын сонголт ямар үр дагавар авчирдаг талаар дурдахгүй байж чадахгүй нь. Аврагчийн зарлигласны дагуу бид бүгд бие биенээ, ялангуяа сул дорой, өөрийгөө хамгаалж чадахгүй тэдгээрийг хайрлан хамгаалах үүрэг хүлээдэг.

Хүүхдүүд маань маш эмзэг шүү. Тэдэнд өөрийгөө хамгаалах, өөрсдийгөө хэрэгтэй зүйлээрээ хангах эсвэл өөрсдийн сайн сайхан байх байдалд нөлөөлөх чадвар маш бага



байдаг. Тэдний эрх ашгийг хамгаалж, насанд хүрэгчдийн хувиа хичээх сэтгэлээсээ илүүтэй тэдний сайн сайхан байдлыг чухалд үзэн шийдвэр гаргах чадвартай хэн нэгэн хүүхдүүдэд хэрэгтэй.

## I.

Насанд хүрэгчдийн хорон санаат гэмт хэрэг, хувиа хичээсэн байдлаас болж хохирч байгаа сая сая хүүхэд энэ дэлхий дээр байгаа нь биднийг сэрдхийлгэдэг.

Дайн дажин болж байгаа улс орнуудад дайтаж байгаа талууд хүүхдүүдийг хүчээр өөрсдийн эгнээндээ элсүүлж байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллагаас гаргасан тайлангаас харахад нэг жилд хоёр сая гаруй хүүхэд хүчирхийлэл болон садар самууны хохирогч болдог байна.<sup>1</sup>

Авралын төлөвлөгөөний дагуу хүүхдийн хүчирхийлэлийн хамгийн ноцтой хэлбэр нь тэдний энэ дэлхийд төрөх эрхийг хязгаарлах явдал юм. Энэ явдал дэлхий нийтэд жишиг болоод байна. Америкийн Нэгдсэн Улсын үндэсний хэмжээнд энэ жилийн төрөлт нь сүүлийн 25 жилтэй харьцуулахад хамгийн бага байж,<sup>2</sup> ихэнх Европ болон Азийн орнуудад нилээн хэдэн жилийн турш төрөлт нь хүн амаа нөхөх түвшинд хүрэхээ больжээ. Энэ нь зөвхөн шашинтай холбоотой асуудал биш. Төрөх хүүхдүүдийн маань тоо цөөрөх тусам соёл иргэншил, тэр бүү хэл бүхэл бүтэн үндэстэн хүртэл сул дорой болж улмаар сөнөж үгүй болох аюултай.

Төрөлт багасаж байгаа шалтгаануудын нэг нь үр хөндүүлэх явдал юм. Дэлхий дахинаа жилд 40 сая гаруй үр хөндөлт хийгдэж байна гэсэн тоо баримт байна.<sup>3</sup> Олон хууль тогтоомж үр хөндөлтийг зөвшөөрч, тэр ч байтугай өөгшүүлж байдаг. Харин бидний хувьд энэ нь жигшүүрт хэрэг юм. Жирэмслэлтийн үед гардаг хүүхдийн хүчирхийлэлийн бас нэг хэлбэр нь эх хүн тэжээллэг хоол хүнс дутагдсанаас эсвэл хар тамхи хэрэглэснээс болж хүүхдэд илрэх төрөлтийн гажиг юм.

Олон мянган хүүхдийг төрүүлэхгүй алж, эсвэл гажигтай болгож байхад, маш олон хос хүүхэдтэй болохыг хүссэн хэдий ч чадахгүй, хүүхэд үрчилж авахыг хүсэж байгаа нь эмгэнэлт бодит байдал билээ.

Төрснийх нь дараа хүүхдийг хүчирхийлэх эсвэл үл тоомсорлох явдал нь олон нийтэд ил харагддаг. Дэлхий дахинаа бараг найман сая хүүхэд таван нас хүрэлгүй нас барж байна. Ихэнх нь эмчилж эсвэл урьдчилан сэргийлж болох өвчнөөр нас бардаг юм.<sup>4</sup> Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын мэдээлснээр хүнсний гэжээлийн дутагдлаас болж дэлхийд дөрвөн хүүхдийн нэг нь оюун санаа болон биеийн доройтолд ордог байна.<sup>5</sup> Сүмийн удирдагч болсон бид дэлхийн олон улс оронд амьдарч, аялахдаа иймэрхүү байдлыг зөндөө хардаг билээ. Хүүхдийн ерөнхий Ерөнхийлөгчийн зөвлөл “төсөөлөхийн аргагүй” орчинд амьдарч байгаа хүүхдүүдийн талаар мэдээлдэг. Филиппин Улсад амьдардаг нэгэн ээж: “Заримдаа мөнгө маань хоол авахад хүрэлцдэггүй, гэхдээ зүгээрээ, яагаад гэвэл энэ нь надад хүүхдүүддээ итгэлийн талаар заах боломжийг олгодог юм. Асуудлыг маань шийдэж өгөөч гэж бид хамтдаа залбирдаг, тэгээд хүүхдүүд маань Их Эзэн биднийг адислахыг хардаг юм.”<sup>6</sup> гэж хэлж билээ. Өмнөд Африкт, Хүүхдийн хэсгийн ажилтан ганцаардаж, гунихарсан бяцхан охинтой уулзжээ. Хайраар асуусан хэдэн асуултанд тэр бяцхан охин аав, ээж, эмээ байхгүй, зөвхөн өвөө нь түүнийг халамжилдаг гэж сулхан хоолойгоор хариулжээ.<sup>7</sup> ДОХ-оос болж олон асран хамгаалагчид нь нас бардаг тив дээр иймэрхүү эмгэнэлт түүх нь элбэг тохиолддог.

Гэхдээ баян чинээлэг үндэстнүүдэд ч гэсэн хангалттай халамж, хамгаалалт авч чадахгүйгээсээ болж хохирч буй хүүхэд, залуус байдаг. Ядуу орчинд өсөж буй хүүхдүүдэд эрүүл мэндийн үйлчилгээ авах мөн боловсрол олж авах боломж дутмаг байна. Тэдний амьдарч буй орчин мөн эцэг эхийн хараа хяналт муу учраас тэдгээр хүүхдүүдэд байнга аюул заналхийлж байдаг. Ахлагч Жеффри Р.Холланд Хожмын Үеийн Гэгээнтэн цагдаагийн ажилтны туршлагаас саяхан хуваалцсан билээ. Хэрэг шалгах явцдаа тэрээр нэг муу оромжинд ор дэвсгэргүй, халтар шалан дээр бие биенээ гэврэн хэвтэж, унтахыг оролдож буй таван хүүхдийг олжээ. Хажууханд нь ээж нь бусадтай нийлэн архи ууж байсан байна. Хүүхдүүдийг хооллочихоор зүйл тэр гэрт огт байсангүй. Ор шиг юм хийн хүүхдүүдийг хэвтүүлээд тэр

ажилтан өвдөг сөхрөн тэднийг хамгаалахыг хүсэн залбирчээ. Тэгээд хаалга руу чиглэн явж байхад нь, тэдгээр хүүхдийн нэг нь болох зургаа орчим насны охин гүйн ирж түүний гараас шүүрэн “Та намайг үрчилж аваач дээ?” гэж гуйсан байна.<sup>8</sup>

Нэгэн бяцхан хүүхэд авчран дагалдагчдийнхаа өмнө зогсоогоод Аврагчийнхаа хэлсэн үгсийг санаж байгаа байх:

“Миний нэрээр ийм хүүхдийг хүлээн авсан хэн боловч Намайг хүлээн авсан хэрэг.

“Харин хэн Надад итгэгч эдгээр багачуудаас нэгийг нь бүдрүүлнэ, түүний хувьд хүзүүндээ тээрмийн хүнд чулуу зүүгээд тэнгисийн гүнд живсэн нь дээр” (Матай 18:5–6).

Хамгаалалт шаардлагатай хүүхдүүдэд маань заналхийлж буй бас нэг аюул нь сэтгэл санааны хүчирхийлэл юм. Хүүхэд, залуусыг доош нь хийж, дээрэлхэж эсвэл ичээдэг эцэг эх, асран хамгаалагч, багш эсвэл үеийнхэн нь тэдэнд биеийн гажигаас илүү хор хөнөөл учруулдаг. Хүүхэд, залуусыг үнэ цэнэгүй, хайрлашгүй, хэнд ч хэрэггүй хэмээн итгүүлэхэд энэ нь тэдний сэтгэл санааны хөгжил, сайн сайхан байдалд нь хэзээ ч эдгэхгүй, гүн сорви болон үлддэг байна.<sup>9</sup> Өвөрмөц асуудалтай, үүн дотор ижил хүйстэндээ татагддаг, залуу хүмүүс нэн эмзэг байдаг бөгөөд тэднийг загнан гадуурхахгүй, харин хайрлан ойлгох нь их чухал юм.<sup>10</sup>

Их Эзэний тусламжтайгаар бид наманчилж мөн өөрчлөгдөж, улмаар өөрийн болон бусдын хүүхдүүдийг илүү ихээр хайрлаж мөн тэдэнд тусалж чадах юм.

## II.

Эцэг эх, асран хүмүүжүүлэгч нарын харьцаанаас үүдэлтэй хүчирхийлэлтэй эн чацуу биеийн болон сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдийн хэд хэдэн жишээ байна. Ерөнхийлөгч Монсон эцэг эх нь хүүхдүүдийнхээ бие болон сэтгэл санааг бэртээж, гэмтээсэн хүчирхийлэл, түүний нэрлэснээр “олиггүй үйлдэлүүд”-ийн талаар ярьж байсан.<sup>11</sup> Би Ютагийн Дээд Шүүхэд ажиллаж байхдаа иймэрхүү хэргүүдийн сэтгэл сэрдхийлгэм баримтуудыг судлан их хямардаг байж билээ.

Эцэг эх нь гэрлэсэн эсэх, гэрлэлт нь хир амжилттай байгаа, гэрлээд удаж байгаа эсэх, бүр өргөнөөр нь аваад үзвэл гэрлэлтийн байдал, хүүхдүүддээ тавьдаг анхаарал халамж

зэрэг нь хүүхдүүдийн сайн сайхан байдалд ихээр нөлөөлдөг. Гэр бүлийн судлаач хоёр эрдэмтэн ингэж хэлсэн байна: “урьд нь гэрлэлт бол юуны түрүүнд нөхөн үржих мөн хүүхдүүдээ өсгөх орчин болж байсан юм. Гэрлэлт нь хүүхдүүдийн эхийг эцэгт нь ойр байлгаснаар, эцэг хүүхдийн хоорондох холбоог бий болгох орчинг бүрдүүлдэг байжээ. Харамсалтай нь өнөө үед, хүүхдүүд голлох байр сууриа алдсаар байна.”<sup>12</sup>

Харвардын их сургуулийн хуулийн профессор орчин үед гаргасан гэрлэлт, салалтын тухай хууль тогтоомж, гэрлэлтэд хандах хандлагыг: “Хууль болон олон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн хэвлэлд өнөө үеийн Америк гэр бүлийн байдлыг нэг иймэрхүү байдлаар тодорхойлдог: гэрлэлт нь үндсэндээ эхнэр нөхөр хоёрын хэрэгцээг хангах харьцаа юм. Энэ шаардлага хангагдахаа болих нь хэн нэгний буруу биш, тиймээс ч эхнэр нөхөр аль аль нь хүссэн үедээ энэхүү харьцааг цуцлуулж болно. Хүүхдүүд энд огт хамаагүй. Хүүхдүүдийн тухай ярилаа гэхэд тэдгээр нь үл мэдэгдэм, анзаарагдахгүй байр суурийг эзэлдэг”<sup>13</sup> гэж тодорхойлжээ.

Гэрлэлтийг зөвхөн “хүссэн үедээ хийж . . . анхны асуудал үүсэхэд л цуцалж болдог гэрээ төдий” хэмээн тооцож, ялангуяа ингэснээрээ хүүхдүүдийг зовоож байвал, энэ нь “хатуу зэмлэл хүртэх бусармаг үйлдэл юм” хэмээн Сүмийн удирдагч нар хэлсэн байдаг.<sup>14</sup> Салалт нь хүүхдүүдэд гүн нөлөөлдөг. Сүүлийн хэдэн жилд салсан гэр бүлүүдийн хагас нь бага насны хүүхдүүдтэй байсан байна.<sup>15</sup>

Хэрэв эцэг эх нь гэр бүлийн тунхагт өгөгдсөн “Нөхөр, эхнэр хоёр нь бие биенээ болон үр хүүхдээ хайрлан, халамжлах албан ёсны хариуцлага хүлээнэ . . . Эцэг эхчүүд хүүхдүүдээ хайраар болон зөв шударга байдлаар өсгөн хүмүүжүүлж бие бялдар болон оюун санааных нь хэрэгцээг хангаж, бие биенээ хайрлан, үйлчилж, . . . байхыг зааж сургах нандин үүрэгтэй юм”<sup>16</sup> гэсэн зааварчилгааг дагасан бол тэд хамтран хүүхдүүдээ өсгөн, тэдэндээ адислал болох байсан юм. Хүүхдүүдэд сургах хамгийн найдвартай арга нь эцэг эхийнх нь үлгэр жишээ байдаг. Салж буй эцэг эхчүүд хүүхдүүддээ хүссэн хүсээгүй буруу үлгэр дууриал үзүүлж байдаг юм.

Хүүхдүүдээ сайн сайхан байлгахын тулд зайлшгүй салах шаардлагатай үе бас байдаг байх. Гэхдээ тэр нь ховор.<sup>17</sup> Гэр

бүлд асуудал гарахад эцэг эхчүүд нэн түрүүнд хүүхдүүдийнхээ ашиг сонирхолыг чухалчлан үздэг байх хэрэгтэй. Их Эзэний тусламжтайгаар тэд үүнийг хийж чадна. Хүүхдүүдэд сэтгэл санаа болон хувийн хүч чадал хэрэгтэй. Эдгээрийг гэрлэлт, зорилго нэгтэй байж олж авдаг юм. Ээж минь бэлэвсэрсэн учир ганцаараа биднийг өсгөсөн. Тиймээс эцэг эх нь хоёулаа байж хүүхдүүдээ өсгөхгүй тохиолдол гарна гэдгийг би ойлгодог. Гэвч болж өгвөл эцэг эх та нар хамтдаа үлдэхийг сонгож байгаа чээ.

“Хэний ч буруугаас болоогүй” хэмээн нэрлэгддэг “салалтыг” зөвшөөрдөг хууль тогтоомжоос болж хамгийн түрүүнд хохирдог нь хүүхдүүд юм. Гэрлэлтээ цуцлуулах маш амархан гэж хүүхдүүд үздэг байна. Олон арван жил хийгдсэн нийгмийн шинжлэх ухааны судалгааны үр дүнг нэгтгэн “хүүхдүүдэд хамгийн ээлтэй бүтэц нь төрсөн эцэг эх нь хамтдаа үлддэг гэр бүлийн бүтэц юм”<sup>18</sup> гэж нэгэн эрдэмтэн хэлжээ. *Нью-Йорк таймсын* сэтгүүлч “Америкийн Нэгдсэн Улсад уламжлалт гэр бүлийн ач холбогдол багасахын сацуу хүүхдүүдийн сайн сайханд гэрлэлт нь чухал ач холбогдолтой болохыг харуулсан гуйвшгүй нотлох баримтууд гарч ирсэн нь гайхалтай юм”<sup>19</sup> гэж хэлсэн байна. Энэхүү бодит байдал нь хүүхэдтэй эсвэл хүүхэдтэй болохыг завдаж байгаа хүмүүст гэрлэлт мөн салах тал дээр шийдвэр гаргахад нь чухал зөвлөмж болох ёстой. Өөрсдийн хувиа хичээх сонирхол эсвэл насанд хүрэгчдийн эрх ашгийг хамгаалан тэмцдэг бус харин хүүхдийн эрх ашгийг хамгаалахад анхаарлаа хандуулдаг улс төрч, журам батлагч мөн албан хаагчид бидэнд хэрэгтэй билээ.

Гэрлэхгүй байснаар хүүхдүүдээ бас хохироодог байна. Америкийн Нэгдсэн Улсад хүүхэд төрүүлсэн эхчүүдийн 41 хувь нь гэрлээгүй байдаг бөгөөд энэ нь бидний өсч буй үеийнхний сайн сайхан байдалд нөлөөлж байгаа нь их ноцтой юм.<sup>20</sup> Гэрлээгүй эхчүүдэд маш их асуудал тулгардаг бөгөөд тэдний хүүхдүүд гэрлэсэн эцэг эхтэй хүүхдүүдтэй харьцуулахад илүү их асуудалтай тулгардаг нь тодорхой.<sup>21</sup>

Гэрлээгүй эхээс төрсөн хүүхдүүдийн ихэнх нь – буюу 58% нь хамтран амьдардаг хосуудын хүүхдүүд байна.<sup>22</sup> Эдгээр хосуудын талаар бид юу ч гэж бодох нь хамаагүй тэдний

хүүхдүүд нь илүү их бэрхшээлтэй тулгардаг юм.<sup>23</sup> Тэгэхээр тогтвортой гэр бүл нь хүүхдүүдийн хувьд их чухал байдаг байх нь.

Ижил хүйстэнтэйгээ суусан хосуудын хүүхдүүд мөн ялгаагүй адил асуудалтай байдаг. Ийм нөхцөл байдал хүүхдэд хэрхэн нөлөөлөх талаар хийсэн нийгмийн шинжлэх ухааны ажил болон үр дүн нь маргаантай юм. Учир нь *Нью-Йорк таймс-ын* сэтгүүлчийн ажигласнаар “ижил хүйстэнтэй гэрлэх нь үндсэндээ нийгмийн доторх туршилт бөгөөд үр дагаврыг нь мэдэхийн тулд нилээн урт хугацаа шаардагддаг” юм байна.<sup>24</sup>

### Ш.

Би хүүхдүүдийн төлөө, бүх хүүхдүүдийн төлөө эдгээр үгсийг хэллээ. Зарим хүмүүс зарим нэг жишээг маань үгүйсгэх байх, гэсэн хэдий ч хүүхдүүдийнхээ – өсөж буй үеийнхнийхээ сайн сайхан мөн тэдний ирээдүйн төлөө илүү ихээр санаа тавин нэгдье гэсэн миний уриалгыг харин үгүйсгэх ёсгүй юм шүү.

Бид Бурханы хүүхдүүдийн талаар ярьж байна. Түүний хүчтэй тусламжийн ачаар хүүхдүүдэд туслахын тулд бид илүү ихийг хийж чадна. Энэ уриалгыг би зөвхөн Хожмын Үеийн Гэгээнтнүүдэд тавьсангүй харин бусдын эрх ашгийг өөрсдийнхөөсөө дээгүүр тавьдаг бусад шашныхан болон хувь хүмүүст хандан бас хүргэж байгаа юм шүү. Ийм хүмүүс л хүүхдүүдийн сайн сайхны төлөө юм хийж чаддаг.<sup>25</sup>

Шинэ Гэрээнд Аврагчийн зааснаар ариун бяцхан хүүхдүүд л бидэнд номхон, хүлцэнгүй байдлын үлгэр жишээ болдгийг шашинтай хүмүүс бас мэддэг.

“Үнэнээр Би та нарт хэлье. Та нар өөрчлөгдөж, хүүхдүүдтэй адил болохгүй бол, тэнгэрийн хаанчлалд орохгүй.

“Иймээс хэн өөрийгөө энэ хүүхэд адил даруу болгоно, тэр нь тэнгэрийн хаанчлалд хамгийн агуу нь болно.” (Матай 18:3–4).

Амилсан Их Эзэн Нифайчуудад хандан наманчилж мөн баптисм хүртэж, “мөн бяцхан хүүхэд лугаа адил болох ёстой, эс бөгөөс Бурханы хаант улсыг ямар ч аргаар өвлөж чадахгүй”

гэж хэлснийг бид Мормоны номноос уншдаг. (3 Нифай 11:38; мөн Моронай 8:10-г үзнэ үү).

Бид бяцхан хүүхдүүд шиг даруу болж, бяцхан хүүхдүүдэд хүрч туслахын төлөө байгаасай гэж би залбирч байна. Учир нь тэд бол бидний, Сүмийн мөн үндэстний ирээдүй юм шүү. Есүс Христийн нэрээр, амен.

### Эшлэл

1. UNICEF, *The State of the World's Children 2005: Childhood under Threat* (2004), 26-г үзнэ үү.
2. Хаяа Ел Нассер "National Birthrate Lowest in 25 Years," *USA Today*, 2012 оны 7-сарын 26, А1-г үзнэ үү.
3. Гилда Сет ба бусад "Induced Abortion: Incidence and Trends Worldwide from 1995 to 2008," *The Lancet*, vol 379, no 9816 (2012 оны 2-р сарын 18):625–32-г үзнэ үү.
4. UNICEF, "Young Child Survival and Development," <http://www.unicef.org/childsurvival/index.html>-г үзнэ үү.
5. Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага, *World Health Statistics 2012* (2012), 109, 118-г үзнэ үү.
6. 2012 оны 9-р сарын 13-ны Хүүхдийн Ерөнхий Ерөнхийлөгчийн Зөвлөлийн тайлан-г үзнэ үү.
7. Хүүхдийн Ерөнхий Ерөнхийлөгчийн Зөвлөлийн тайлан.
8. Жеффри А.Холланд "Israel, Israel, God Is Calling," СБС-ийн залуу насанд хүрэгчдэд зориулсан галын дэргэдэх ярилцлага, 2012 оны 9-р сар ; мөн Р. . Скотт Лойд, "Zion Not Only Where, but How We Live," *Deseret News*, 2012 оны 9-р сарын 10 үзнэ үү.
9. Ким Пайнтер, "Parents Can Inflict Deep Emotional Harm," *USA Today*, 2012 оны 7-р сарын 30, B8; Рачел Лоури, "Mental Abuse as Injurious as Other Forms of Child Abuse, Study Shows," *Deseret News*, 2012 оны 8-р сарын 5, А3-г үзнэ үү.
10. "End the Abuses," *Deseret News*, 2012 оны 6-р сарын 12, А10-г үзнэ үү.
11. Томас С.Монсон, "Нандин хүүхдүүд, Бурханы бэлэг," 2000 оны 6 сарын *Лиахона*, 2; "A Little Child Shall Lead Them," үзнэ үү.
12. В. Брэдфорд Вилкокс ба Елизабет Маркүарт, *The State of Our Unions: Marriage in America* (2011), 82-г үзнэ үү.
13. Мэри Энн Глендон *Abortion and Divorce in Western Law: American Failures, European Challenges* (1987), 108-г үзнэ үү.
14. Дэвид. О.МкКей, "Structure of the Home Threatened by Irresponsibility and Divorce," *Improvement Era*, 1969 оны 6-р сар, 5-г үзнэ үү.
15. Диана В.Эллиот ба Тавиа Симмонс, "Marital Events of Americans: 2009," *American Community Survey Reports*, 2011 оны 8-р сарыг үзнэ үү.
16. "Тэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг" 2010 оны 11 сарын *Лиахона*-г үзнэ үү.
17. Далин Х.Өүкс, "Салалт" 2007 оны 5 сарын *Лиахона*-г үзнэ үү.
18. Чарльз Муррэй, *Coming Apart: The State of White America, 1960–2010* (2012), 158.
19. Росс Дойхат, "Gay Parents and the Marriage Debate," *New York Times*, 2012 оны 6-р сарын 11, <http://douthat.blogs.nytimes.com/>

- 2012/06/11/gay-parents-and-the-marriage-debate/.
20. Жоусе А. Мартин, ба бусад “Births: Final Data for 2009,” *National Vital Statistics Reports*, 60:1 (2012 оны 8-р сар)-г үзнэ үү.
  21. Виллиам Ж. Дорти, болон бусад, *Why Marriage Matters: Twenty-One Conclusions from the Social Sciences* (2002); ба В. Бадфорд Вилкокс болон бусад *Why Marriage Matters: Thirty Conclusions from the Social Sciences*, гуравдахь хэвлэл (2011)-г үзнэ үү.
  22. Мартин болон бусад “Births: Final Data 2010 он 10–11-г үзнэ үү.”
  23. Вилкокс *Why Marriage Matters*-г үзнэ үү.
  24. Росс Дохат “Gay Parents and the Marriage Debate.” (Марк Регнерус “How Different Are the Adult Children of Parents Who Have Same-Sex Relationships? Findings from the New Family Structures Study,” *Social Science Research*, vol.41 [2012]: 752–70).
  25. Хожмын Үеийн Гэгээнтнүүд эцэг эх байх үүрэг хариуцлагыг амьдралынхаа хамгийн чухал зорилго болгодог (Pew Research Center’s Forum on Religious and Public Life, *Mormons in America: Certain in Their Beliefs, Uncertain of Their Place in Society*, 2012 оны 1-р сарын 12, 10, 16, 51)-г үзнэ үү.



# Ах нар аа, бидэнд хийх ажил байна

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулганы

Ахлагч Д. Тод Кристофферсон

---

*Санваар атгагчийн хувьд бидэнд нийгэм, гэр орон, Сүмдээ гүйцэтгэх чухал үүргүүд байна.*

---

Ах нар аа, эрчүүд болон хөвгүүдэд тулгардаг асуудлуудын талаар сүүлийн үед нэлээн их ярьж мөн бичдэг болж. Зарим хэвлэгдсэн номны нэрийг дурдвал: *Why There Are No Good Men Left* (Сайн эрчүүд хаачсан бэ), *The Demise of Guys* (Эрчүүдийн мөхөл), *The End of Men* (Эрчүүдийн төгсгөл), *Why Boys Fail* (Хөвгүүд яагаад амжилтанд хүрдэггүй вэ), мөн *Manning Up* (Эр хүн болох нь).. Гайхалтай нь эдгээр номын ихэнхийг эмэгтэйчүүд бичсэн байх юм. Өнөө үед, аль ч нийгэмд эрчүүд маань тэдний үүрэг хариуцлага, нийгэмд эзлэх байр суурийнхаа талаар эрс тэс, өөр өөр мэдээлэл авч байна гэдэг санаа энэ номнуудад давтагдаж байна. *Manning Up* (Эр хүн болох нь) номны зохиолч энэ явдлыг ийнхүү тодорхойлжээ:

*Manning Up* номны зохиолч үүнийг дүрслэн: “Эмэгтэй хүн болохын тулд охид насанд хүрэх л хэрэгтэй, харин хөвгүүд эр хүн болохын тулд шалгуур давах ёстой гэдэг дүрэм бараг л бүх нийгэмд байжээ. Хөвгүүд зориг, хүч чадал эсвэл өөр нэгэн шаардлагатай чадварыг харуулах ёстой байж. Энэ шалгуурыг давснаар эмэгтэйчүүд болон хүүхдүүдээ хамгаалж чадна гэдгээ харуулдаг байсан бөгөөд энэ нь тэдний нийгэм дэх үндсэн үүрэг нь байлаа. Харин өнөө үед, хөгжиж буй зах зээлд эмэгтэйчүүд давамгайлж эхлэхэд, гэр бүлийнхээ хэрэгцээг хангадаг нөхөр, эцгүүд тийм ч хэрэгтэй биш болж, тэдний үндсэн үүргээ биелүүлэхэд шаардлагатай байсан сэтгэлийн

тэнхээ, гуйвшгүй байдал, зориг, үнэнч байх зэрэг зан чанарууд огт хэрэггүй эсвэл бүр эдгээрийг дурдах нь ч бага зэрэг ичгүүртэй болоод байна.” хэмээн бичжээ.<sup>1</sup>

Эмэгтэйчүүдэд илүү их боломж гаргаж өгөх тэмүүллийг бид сайшаадаг. Гэхдээ энэ тэмцэлдээ эр хүн болон тэдний үүргийг гутаадаг нэгэн ч байх л юм. Тэд амьдралыг эрэгтэй, эмэгтэй хоёр хүний тэмцэлдээн мэтээр харж, аль нэг нь заавал нөгөөгөө захирч байх ёстой, мөн энэ цаг үед эмэгтэйчүүдийн ээлж ирсэн мэтээр бодож итгэдэг бололтой. Зарим нэг нь ажилдаа л амжилт гаргах нь хамгийн чухал, гэрлэлт болон үр хүүхэдтэй болох нь тийм ч чухал бус гэж үзнэ. Тиймээс эр хүн ямар хэрэгтэй юм бэ?<sup>2</sup> Хэтэрхий олон Холливудын кино, зурагтын нэвтрүүлэг, бүр зарим нэг рекламанд хүртэл эр хүнийг чадваргүй, боловсроогүй, хувиа хичээснээр дүрслэх нь олонтоо. Эрчүүдийг ингэж сул дорой болгох нь муу үр дүн авчирч байна. Жишээлбэл, Америкийн Нэгдсэн Улсад дараах байдал анзаарагдсан байна:

“Бага ангиас магистрт суралцах хүртлээ охид нь хөвгүүдээсээ бүх талаараа илүү байна. Жишээлэхэд, наймдугаар ангид ороход хөвгүүдийн дөнгөж 20 хувь нь л хангалттай бичиг үсэгт тайлагдаж, 24 хувь нь хангалттай уншиж чаддаг болсон байна. Залуу эрэгтэйчүүдийн их сургуульд орохдоо өгөх шалгалтын дүн сүүлийн 40 жилтэй харьцуулахад 2011 онд хамгийн муу байсан байна. Хөвгүүд дунд болон их сургуулиа орхих магадлал нь охидынхоос 30 хувиар илүү байна. . . . 2016 он гэхэд бакалавр зэргийн 60, магистрын 63, докторын 54 хувийг эмэгтэйчүүд авна гэсэн урьдчилсан таамаглал байна. Сурлагаараа хоцорч, тусгай боловсролын хөтөлбөрт хамрагдсан оюутнуудын гуравны хоёр нь эрэгтэйчүүд байна.”<sup>3</sup>

Зарим эрчүүд болон хөвгүүд энэ сөрөг дохиог хариуцлагаас мултрах арга болгож, жинхэнэ утгаараа эр хүн болон төлөвшдөггүй байна. Нэгэн их сургуулийн профессор бодит байдлыг харуулсан ч байж магадгүй ажиглалтынхаа талаар: “Эрэгтэйчүүд малгайгаа арагш нь харуулж өмсөөд, миний компьютер гэрийн даалгаврыг минь залгичихлаа гэсэн хөөрхийлөлттэй тайлбар тавин ангидаа орж ирдэг. Харин эмэгтэйчүүд өдрийн хувиараа шалган, хуулийн сургуульд

хэрхэн орох талаар асуун орж ирж байна.”<sup>4</sup> гэж хэлжээ Кино шүүмжлэгч нэгэн эмэгтэй өөрийн саналаа дараах эвгүй үгсээр “бид эрчүүдээс юуг хүсэж болох вэ. . . бид аз болж хамтрагчтай болохоор шийдлээ гэхэд эрчүүдээс зөвхөн хамтрагч байхыг л хүснэ. Бидний орон зай руу орохгүй, харин өөрийнхөө орон зайндаа л байх нэгэн хэрэгтэй.”<sup>5</sup> гэж илэрхийлжээ.

Ах нар аа, бид ийм байж болохгүй. Санваар атгагчийн хувьд бидэнд нийгэм, гэр орон, Сүмдээ гүйцэтгэх чухал үүргүүд байна. Бид эмэгтэйчүүд, хүүхдүүд мөн Бурханы итгэл хүлээхүйц хүмүүс байх хэрэгтэй. Энэ хожмын өдрүүдэд Сүм болон Бурханы Хаант улсад ямар ч санаачлагагүй хөвгүүд болон эрчүүд хэрэггүй. Хувийн сахилга батгүй, зугаа цэнгэл л хөөн амьдрах залуусаар бид яах юм бэ. Амьдралын ямар ч зорилгогүй, гэр бүлтэй болохыг үл хүсэх, энэ дэлхийд өөрийн хувь нэмрээ оруулахгүй байгаа залуу эрчүүдээр бид яах юм бэ. Гэр орондоо сүнслэг удирдамж өгч чадахгүй байгаа нөхөр болон эцгүүдээр бид яах юм бэ. Бурханы Хүүгийн жаягийн дагуу Ариун санваарыг атгадаг атлаа хамаг хүчээ садар самууныг үзэхэд зориулж, хамаг цагаа интернэтэд өнгөрөөдөг эрчүүдээр бид яах юм бэ (хачирхалтай нь тэд нар *дэлхийнх* мөртлөө *дэлхийд* байдаггүй тэд нар билээ).

Ах нар аа, бидэнд хийх ажил байна.

Хөвгүүд минь, та нар сайн суралцаж байгаад арван жилээ төгсөөд боловсролоо үргэлжлүүлэх хэрэгтэй байна. Та нарын нэг хэсэг нь бизнес, хөдөө аж ахуй, улс төр эсвэл бусад нарийн мэргэжлийг олж авахын тулд их дээд сургуулиудад орохыг зорьж байгаа байх. Зарим нь дүрслэх урлаг, хөгжим болон тайзны урлагт амжилт гаргана. Өөр нэг хэсэг нь наймаанд суралцахыг хүснэ. Өнгөрсөн он жилүүдэд манай гэрийг засаж, шинэчлэх ажилд нэлээд хэдэн чадварлаг ажилчид оролцож байсан юм. Мужаан, цахилгаанчин, сантехникч, будагчин, ханын хавтан болон хивс наагч, дээвэрлэгч тэдгээр хүмүүсийн ур чадвар, хүнд хэцүү ажил хийх чадвар бүхий байгааг нь үзэн биширч байсан юмдаг. Ямар ч мэргэжил сонгосон байсан ч түүнээ сайн эзэмшиж, гэр бүлийнхээ хэрэгцээг ханган, нийгэм болон эх орондоо хувь нэмрээ оруулж чадахуйц нэгэн болох нь чухал юм шүү.

Саяхан би 14 настай Энэтхэг хөвгүүний нэг өдрийн амьдралыг харуулсан кино үзлээ. Тэр эртлэн босч хичээлээсээ өмнө долоо хоногийн 6 өдөр хагаст нь хоёр өөр газарт удаан хугацаагаар ажилладаг байна. Түүний олсон орлогоос гэр бүлийнх нь сайн сайхан байдал хамаардаг ажээ. Харанхуй болсон хойно тэр хоёр дахь ажлаа тараад хуучин дугуйгаа унасаар яаран гэртээ харина. Тэрбээр гэртээ орж ирээд хэдэн цаг гэрийн даалгавраа хийсний дараа л, 10:30- 11:00 цагийн орчим шалан дээр унтаж буй дүү нарынхаа хажуугаар орон унтахаар хэвтэнэ. Би түүнийг танихгүй хэдий ч, түүний тууштай мөн зоримог зан чанараар нь бахархаж байна. Өөрт байгаа хязгаарлагдмал нөхцөл байдлын дунд, боломжоороо чадах бүхнээ хийж байгаа сайхь хөвгүүн гэр бүлдээ үнэхээр адислал авчирч байгаа юм. Тэрбээр эрийн цээнд хүрээд, сайн сайхан бүхнийг бүтээгч болно гэдэгт би лав эргэлзэхгүй байна.

Эцэг, удирдагч, гэрийн багш болох насанд хүрсэн эрчүүд та нар зохистой үлгэр дууриал үзүүлэн, өсөж буй хөвгүүддээ жинхэнэ эр хүн болоход нь туслах хэрэгтэй байна. Нийгмийн дунд биеэ хэрхэн авч явах болон бусад чадваруудыг тэдэнд заахтун. Тэдэнд ярианд хэрхэн оролцох, яаж хүмүүстэй танилцаж мөн харьцах, эмэгтэйчүүд болон охидтой харьцахдаа хэрхэн биеэ авч явах, яаж үйлчлэх, идэвхтэй амьдарлаар хэрхэн амьдрах, донтолгүйгээр сонирхлоо хэрхэн хөгжүүлэх, алдаагаа яаж засах болон зөв сонголт хэрхэн хийх талаар заахтун.

Тиймээс, хаана ч байсан хамаагүй, намайг сонсож буй бүхэнд хандан, Иошуад Жехова хэлсэнчлэн, би та нарт, “Тууштай бөгөөд зоригтой бай” (Иошуа 1:6) гэж хэлмээр байна. Нөхцөл байдал тань ямар ч байлаа гэсэн зориг гарган чадлынхаа хэрээр бэлтгэ. Сайн нөхөр, сайн эцэг болоход бэлтгэ; сайн хийгээд бүтээмж ихтэй иргэн байхад бэлтгэ; санваарыг нь атгадаг Их Эзэндээ үйлчилдэг байхад бэлтгэ. Таньг хаана ч байлаа гэсэн Тэнгэрлэг Эцэг таньг мэдэх болно. Та ганцаараа биш; танд санваар болон Ариун Сүнсний бэлэг байгаа тул хэрэв та шантрахгүй байдлаар ажиллаж мөн Түүний тушаалуудыг дагавал ирээдүйд олон боломж олдох болно.

Маш олон газарт та нар хэрэгтэй байна. Тэдгээрийн дундаас та нарын тусламж хамгийн их хэрэгцээтэй газар бол та нарын санваарын чуулганууд юм шүү. Ням гарагийн хичээлийн төдий бус чуулганууд бидэнд хэрэгтэй байна. Мөн бидэнд Их Эзэний ажлыг хийхийг хүсдэг, чуулганы болон гэр бүлийн гишүүдээ дэмжиж, уулзсан хүн болгоны амьдралд эерэгээр нөлөөлж чадахуйц тийм чуулганы удирдагч нар хэрэгтэй байна.

Номлолын ажлыг аваад үз л дээ. Хөвгүүд минь, цагаа дэмий бүү үрэгтүн. Аль болох сайн мөн шаргуу бэлтгэлээ базаа. 17, 18 настай болж байж л ухаан сууна гэж бүү хүлээ. Аароны Санваарын чуулганууд гишүүддээ санваарын амлалт мөн гэрээнүүдийг ойлгож, ахлагчаар томилогдоход нь туслах хэрэгтэй; мөн тэдэнд Ариун Сүмийн ёслолуудыг хүлээн авч, номлолд амжилттай үйлчлэхэд нь бэлтгэхэд туслах хэрэгтэй байна. Мелкизедек санваарын чуулганууд номлолын ажилд бүхнээ зориулах номлогч нарыг бэлтгэхэд эцэг эхчүүдэд тусалж чадна. Мөн тойрог, салбар болгонд эдгээр чуулганууд одоо үйлчилж буй номлогч нартайгаа илүү ойр хамтран ажиллах ажлыг удирдан зохион байгуулж чадна.

Үүний нэг адил, санваартнуудын хариуцах ёстой бас нэгэн ажил нь Ерөнхийлөгч Томас С.Монсоны давтан хэлсэн Аврагчаас минь ирсэн дуудлага билээ. Энэ нь Сүмээс ямар нэгэн шалтгаанаар холдож, өөрийгөө тусгаарласан тэднийг аврах дуудлага юм. Бид энэхүү дуудлагадаа нэлээд амжилт гаргаад байна. Залуу эрэгтэйчүүд маань энэ ажилд амжилттай оролцож ирсэн билээ. Шинэ Мексикийн Альберкёркийн Рио Гранд Испани тойргийн Аароны санваарын чуулган хэнийг буцаан авчирч болох талаар ярилцаад, хамтдаа тэр хөвгүүдийнхээр орохоор гарцгаажээ. Нэгэн хөвгүүн, “Намайг ийм олон хүн тэдэнтэй хамт Сүмд явахыг хүсэж байсныг би мэдээгүй. Иймээс би одоо Сүмд явах хүсэлтэй байна.” – гэж ярьжээ. Чуулганы гишүүд өөр нэгэн залуу эрэгтэйг урих гэж очоод түүнээс дараагийн хөвгүүнийд очиход тэдэнтэй хамт явахыг хүсжээ. Тэр хөвгүүн зөвшөөрсөн байна. Чуулганы залуус тэр хөвгүүнийг зөвхөн Сүмдээ эргэж ирэхэд нь урьсан төдийгүй, тэр даруй чуулганыхаа нэгэн хэсэг болгосон байна.

Санваартнуудын өөр нэгэн бэрхшээлтэй хэдий ч сэтгэл өөгшөөх ажил бол гэр бүлийн түүх болон ариун сүмийн ажил юм. Бидний хийх ёстой ажлын чухал хэсгийн талаар шинэчлэгдсэн дуудлага болон илүү эрхэм зорилгыг бий болгох захиа Тэргүүн Зөвлөлөөс удахгүй та нарт ирэх болно. Идэвх султай эсвэл бидний мэдэхгүй байгаа өөр олон эрчүүд мөн хөвгүүд санваар авахын тулд бэлтгэгдэх ёстой юм.

Бидний чуулганууд бие биенээ дэмжих ахан дүүсийн барилдлагаа бий болгодог. “Ах нар аа, санваарын чуулган нь харьяалагддаг эр хүн болгондоо хүч чадлын эх сурвалж нь болж, чуулганы ах болгон, ‘Би Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн санваарын чуулганы гишүүн. Ах нар маань бүх л талаар надад туслахад бэлэн байдаг шиг, би ч бас тэдэнд туслахад бэлэн зогсоно. Бид хамтдаа байж, Бурханы гэрээт хөвгүүдийн хувьд сүнслэгээр өсөн хөгжих болно. Бид хамтдаа байж, эдийн засаг, нийгэм, эсвэл сүнслэг байдалд ямар ч дайралт ирэхэд юунаас ч ичиж зоволгүй, юунаас ч айхгүй эсэргүүцэн зогсож чадна’ гэж хэлэх тэр өдөр Их Эзэний зорилго биелсэн агуу өдөр болох юм.”<sup>6</sup> бгэж Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли хэлж байсан юм.”<sup>6</sup>

Эдийн засгийн хямралын үед тулгарч болох нэгэн асуудал нь ажлаа алдах явдал юм. Нэлээн дээр гаргасан Сүмийн халамжийн нэг товхимол дээр, “ажлаа алдсан хүнийг Сүмд онцгойлон авч үзэх хэрэгтэй, учир нь тэрээр орлого олох боломжгүй болж, Иов шиг түүний шударга байдал нь соригддог юм. Соригдох өдрүүд нь сар болж, сарууд нь он жил болон хувирахад тэр хүний зовлон нь улам нэмэгддэг. . . . Долоо хоногийн турш сүнс сүлдний доройтолд орсон хүнийг зөвхөн Ням гарагт Сүм дээр авчирснаар аврах боломжгүй.”<sup>7</sup> гэж заасан байдаг.

2009 оны 4 сард, Тэргүүлэх Бишопын Зөвлөлийн зөвлөх асан Ричард С.Ежли ажлаа алдсан гишүүндээ туслахын тулд нэгдэж чадсан үлгэр жишээч нэгэн чуулганы талаар ярьсан билээ:

“Ютагийн Сентервилл-ын Phil’s Auto буюу (Филийн Авто) гэх машин засвар үйлчилгээний газар нь санваартан удирдагч, чуулган юу хийж чадахын тод үлгэр жишээ болсон билээ. Фил ахлагчдын чуулганы гишүүн бөгөөд нэгэн машин засварын

газар механикчаар ажилдаг байжээ. Азгүй явдал болж тэр засварын газар эдийн засгийн хямралаас болж Филийг ажлаас нь халсан байна. Энэ нь Филд маш хүнд цохилт болжээ.

“Энэ талаар сонсоод Филийн бишоп Леон Олсон ахлагчдын чуулганы ерөнхийлөгчтэйгөө нийлэн Филд туслах арга замуудыг залбиран хайж эхэлсэн байна. Эцсийн эцэст Фил бол тэдний чуулганы гишүүн, ах нарынх нь нэг байсан бөгөөд түүнд тусламж хэрэгтэй болоод байв. Тэгээд ер нь Фил өөрийн гэсэн бизнесээ эхлүүлж болох юм гэсэн дүгнэлтэнд тэр хоёр хүржээ. Чуулганы нэг гишүүн засварын газар ажиллуулах боломжтой том амбараа өгч болох боломж байв. Чуулганы бусад гишүүд засварын газарт хэрэгтэй бүхий л багаж, тоног төхөөрөмж цуглуулахад тусалж болно. Ядаж л тэр амбаарыг цэвэрлэхэд хүн болгон хүчин зүтгэж болох байлаа.

“Тэгээд тэд саналаа Филд хэлж, дараа нь чуулгандаа танилцуулав. Амбаарыг цэвэрлэж, хэрэгтэй багаж, тоног төхөөрөмж цуглуулж, ажил эхлүүлэхэд бүгдийг бэлэн болгоцгоов. Phil’s Auto (Фтлийн авто засварын газар) ажлаа амжилттай эхэлж, улмаар тэрээр илүү ашигтай удаан хугацаагаар байх газар руу бизнесээ нүүлгэсэн байна. Яг хэрэгтэй үед чуулганы ах нар туслахад бэлэн зогсож байсан учир энэ бүгд боломжтой болсон юм.”<sup>8</sup>

Гэхдээ мэдээжийн хэрэг “Та нарын хийж болох Их Эзэний хамгийн чухал ажил танай гэр орны дөрвөн ханан дунд хийгдэнэ.”<sup>9</sup> гэж манай бошиглогч нар удаа дараа хэлсэн байдаг. Гэрлэлтийн ач холбогдлыг гутааж, зорилгыг нь үгүйсгэж байгаа өнөөгийн нийгэмд бид гэрлэлтээ бат бөх болгохын төлөө ихийг хийх хэрэгтэй болоод байна. Хүүхдүүдээ “залбирч, Их Эзэний өмнө цэх шулуун алхахыг” (СбаГ 68:28) заахын тулд бид ихийг хийх ёстой. Бидний үүрэг бол яв цав Мормоны номонд тод томруунаар тодорхойлсончлон хүүхдүүдээ зүрх сэтгэлийн агуу өөрчлөлтийг мэдрэх буюу Их Эзэнд хөрвөхөд нь туслах явдал юм. (Мозая 5:1–12Алма26-г үз). Нийгмийн Халамжийн бүлэгтэй нийлэн санваарын чуулганууд хүүхдүүдээ хэрхэн хөрвүүлэхийг эцэг эхчүүдэд заах ёстой юм. Мөн ганц бие эцэг, эхчүүдэд санваарын адислалуудыг хүргэж болох юм.

Ах нар аа, Бидэнд хийх ажил байна. Та нарын хийдэг золиослол болон сайн сайхан зүйлүүдийн төлөө талархлаа илэрхийлье. Үүнийгээ үргэлжлүүлшгээе тэгвэл Их Эзэн танд тусална. Юу хийж, юу гэж хэлэхээ мэдэхгүй байж болох ч, та зөвхөн хийгээд л эхэл. Хийж эхлэх цагт “үр дүнтэй хаалга тэдний төлөө нээгдэх болно” (С ба Г 118:3) гэж Их Эзэн хэлсэн. Ярьж эхлэхэд “. . . та нар хүмүүсийн өмнө мэдэгдэх нь үгүй. Учир нь, та нар юу хэлэх ёстой нь яг тухайн цагт та нарт өгөгдөх болно” (С ба Г 100:5–6) гэж Их Эзэн амлаж байна. Бид эгэл болоод төгс бус нь үнэн хэдий ч, бидэнд төгс Цагаатгалыг боломжтой болгосон төгс Багш байгаа бөгөөд бид түүний нигүүлсэл болон санваарт дуудагдсан билээ. Бид наманчилж өөрсдийгөө ариусгах юм бол миний хэлсний адилаар зааж болохын тулд та нарт тэнгэрийн хүчээр хишиг хүртээгдэх болно, (С ба Г 43:16-г үзнэ үү). гэж тэр амласан билээ.

Өөрсдийн чадвар мөн авьяасаа хөгжүүлж, зөв шударгын төлөө зогсож, золиос хийхээсээ айдаггүй, ажиллах хүсэлтэй, бусдад аз жаргал болон авралыг авчрах эр хүн, жинхэнэ эр хүн бидэнд хэрэгтэй байна гэж Сүм тань, эх дэлхий тань, эмэгтэйчүүд тань хэлж байна. “Rise up, O men of God!”<sup>10</sup> (Бурханы эрчүүд босоцгоо) хэмээн тэд дуудаж байна. Бидэнд босоход минь туслаач Бурхан минь. Есүс Христийн нэрээр. Амен.

### Notes

1 Кэй С. Химовиц, *Manning Up: How the Rise of Women Has Turned Men into Boys* (2011), 16.

2 “Залуу эрэгтэйчүүдээс насанд хүрэхийн тулд яах ёстой вэ гэж асуухад бараг нэг нь ч гэрлэх хэрэгтэй гэж хэлдэггүй байна. Амжилтанд хүрнэ гэдгийг тэд боловсрол эзэмших, эдийн засгийн хувьд бие даах, бүрэн цагийн ажилтай болох гэх мэтчилэн дандаа ажилтай холбодог байна. Ажил, амжилт, бие даасан байдал нь хүмүүсийг тодорхойлдог болжээ.” (Химовиц, *Manning Up*, 45). Энэхүү гэрлэлтийн эсрэг байр суурийг эмэгтэйчүүдээр хүлээн

зөвшөөрүүлэх ажил их идэвхтэй өрнөж байна. Лондоны *Times* сэтгүүлд нэгэн эмэгтэй: “Гэр бүл, багш нарын нэг нь ч надад ‘Нээрээ чи гэрлэж, хүүхэд гаргах хэрэгтэй шүү’ гэж хэлж байгаагүй. Биднийг шинэ, эрх тэгш, орчин үеийн амьдарлаар амьдраг гэсэндээ тэд олон зуун үеийн эмэгтэйчүүдийн хүсэл байсан гэрлэж, үр хүүхэдтэй болох гэдэг санааг бидний ирээдүйгээс нэг мөсөн арчихаар шийджээ” гэж бичсэн байна (Елеанор Миллз, “Learning to Be Left on the Shelf,” *Sunday Times*, Apr. 18, 2010, [www.thetimes.co.uk](http://www.thetimes.co.uk); in Hymowitz, *Manning Up*, 72).



Дөч гарч яваа нэгэн эмэгтэй гэрлэж амжаагүй талаараа харамсаж бичсэн өгүүллэгийнх нь хариуд: “Эр хүнтэй байх хэрэгцээгээ ийм өндөрт тавьсанд чинь гайхаж байна,” “Өөртөө итгэж сураач ээ!” “Хүнээс шалтгаална гэдгээ ингэж хүлээн зөвшөөрөх гэж,” мөн “Охин маань таны адил гэрлэхийг тэгэж их хүсвэл, би түүнийгээ буруу өсгөж дээ гэж бодох байлаа” гэсэн үгстэй захидлууд иржээ (Лори Готтлиб, *Marry Him: The Case for Settling for Mr. Good Enough* [2010], 55).

Энэ бүгдээс авууштай нэг зүйл нь юу вэ гэвэл ихэнх хүмүүс, тэдний дунд залуу насанд хүрэгчид, энэхүү гэрлэлт болон гэр бүлийн эсрэг явуулганд үл автаж байгаа явдал юм. “Пенсильваны Их Сургуулийн эдийн засагчийн хийсэн судалгаагаар Америкийн нэгдсэн Улсад 2008 онд их дээд сургууль дүүргэсэн цагаан арьстан эмэгтэйчүүдийн 86 хувь нь дөч шүүргээд гэрлэсэн байхад, дүүргээгүй хүмүүсийн 88 хувь нь гэрэлсэн байж. Дээд боловсрол эзэмшсэн цагаан арьст гэрлэсэн эрэгтэйчүүдийн хувь мөн үүнтэй ойролцоо 84 хувьтай байж. Судалгаан дээр үндэслээгүй, нийтлэг мэргэн ухаанаар бол гэрлэх гэдэг нь эмэгтэйчүүдийн хувьд тэнэг асуудал болдог байна. Харин боловсролтой, цагаан арьст эмэгтэйчүүд үүнтэй санал

нийлэхгүй байгаа юм. Тэд бусад аль ч нийгмийн давхаргын хүмүүсээс илүүтэйгээр ‘гэрлэсэн хүмүүс гэрлээгүй хүмүүсээс хамаагүй илүү аз жаргалтай байдаг’ гэдэгт итгэнэ. . . . Их сургуульд дөнгөж орсон хүмүүсийн олонх буюу бараг 70 хувь нь гэрлэж, хүүхэдтэй болох нь ирээдүйд маш хэрэгтэй гэж үздэг байна.” (Химовиц, *Manning Up*, 173–74).

- 3 Филип Г.Зимбардо, Никита Дункан, *The Demise of Guys: Why Boys Are Struggling and What We Can Do about It* (2012), e-book; “Behind the Headlines.” бүлгийг үзнэ үү.
- 4 Барбара Дафо Вайтхэд, *Why There Are No Good Men Left: The Romantic Plight of the New Single Woman* (2003), 67.
- 5 Аманда Диксон, “‘Hunger Games’ Main Character a Heroine for Our Day,” *Deseret News*, 2012 оны 4-р сар, 2, [www.deseretnews.com](http://www.deseretnews.com).
- 6 Гордон Б.Хинкли, “Welfare Responsibilities of the Priesthood Quorums,” *Ensign*, 1977 оны 11 сар, 86.
- 7 *Helping Others to Help Themselves: The Story of the Mormon Church Welfare Program* (1945), 4.
- 8 Ричард Г.Ежли, “This Is Your Phone Call,” *Liahona*, 2009 оны 5 сар, 54.
- 9 *Teachings of Presidents of the Church: Harold B. Lee* (2000), 134.
- 10 “Rise Up, O Men of God,” *Hymns*, no. 323.

# Зориг, хүч чадал хийгээд эрч хүчээрээ үлэмж баатарлаг бай

Тэргүүлэх Бишоп

*Бишоп Гари И. Стивенсон*

---

*2000 залуу дайчны адил, зохистой  
санваартнуудын хувьд зоригтой баатарлаг байж,  
өөрсдийгөө бэлэн байлгаарай.*

---

Энэ үдэш би залуу эрэгтэйчүүдэд, энэхүү санваартны хуралдаанд оролцохоор дэлхий даяар цугларсан Аароны санваартнуудад хандан бишопын хувьд ярьж байгаадаа их адислалыг онцгойлон мэдэрч байна. Мормоны Номноос, Хиламан болон түүний 2000 залуу дайчны талаар өгүүлсэн түүхийг би та нартай хуваалцъя. Энэхүү судар нь, эртний эдгээр залуу эрэгтэйчүүдийн зан чанарыг ойлгоход тусалдгаас гадна өнөө үеийн залуу эрэгтэйчүүд та нарт урам зориг өгдөг билээ. Би дуртай судраасаа эш татъя: “Мөн тэд бүгд залуу эрс мөн тэд зориг мөн түүнчлэн хүч чадал хийгээд эрч хүчээрээ үлэмж баатарлаг байв; гэвч болгоогтун, энэ нь бүгд бус—тэд . . . цаг ямагт үнэнч эрс байлаа.”<sup>1</sup> Зориг, хүч чадал, эрч хүч ба үнэн –эдгээр нь ямар хүсүүштэй шинж чанарууд билээ!

Би тэрхүү залуу дайчдыг дүрсэлсэн эхний шинж чанар болох “зоригор баатарлаг” гэдэг үгэн дээр анхаарал төвлөрүүлэхийг хүсч байна. Миний хувьд эдгээр үгс сайхь залуу эрэгтэйчүүд зөв зүйлийг зоригтойгоор хийснийг, өөрөөр хэлбэл Алмагийн хэлснээр “ямар ч цагт мөн . . . хаана ч гэсэн Бурханы гэрчлэгч болж зогсох”<sup>2</sup> тууштай байдлыг харуулсан юм. 2000 залуу дайчдад эрэлхэг зоригоо харуулах тоо томшгүй олон мөч тохиосон юм. Та бүгдэд ч гэсэн

зоригтой байхыг шаардсан чухал мөчүүд амьдралд тань тохиолдох болно. Миний найз Жон амьдралынхаа тийм мөчүүдийн нэгийг надтай хуваалцсан юм.

Хэдэн жилийн өмнө Жон, Япон улсын нэр хүндтэй нэгэн их сургуулиас элсүүлснийг нь гэрчилсэн мэдээ хүлээн авчээ. Тэрбээр дэлхийн өнцөг булан бүрээс ирсэн бусад олон шилдэг оюутнуудтай хамт олон улсын оюутны хөтөлбөрт оролцохоор болоод байв. Зарим нь хэл соёлын талаарх мэдлэгээ гүнзгийрүүлэхийг зорилго болгон ирсэн байхад, зарим нь үүнийг яваандаа Японд мэргэжил эзэмшин үлдэхэд анхны алхам болно хэмээн үзэж байв. Гэхдээ бүгдээрээ харийн нутагт суралцахаар ар гэрээ орхин ирцгээсэн ажээ.

Жоныг тэнд очсоных нь дараахан, нэг айлын хувийн байрны дээвэр дээр үдэшлэг болох гэж байгаа тухай мэдээ гадаад оюутнуудын дунд тархсан байлаа. Тэр орой, Жон хоёр найзынхаа хамт зарлагдсан хаягаар нь хүрч очсон байна.

Жон найзуудынхаа хамт байрны дээд давхар хүртэл цахилгаан шатаар яваад, тэндээсээ нарийхан шатаар өгсөн дээвэр дээр гарч, бусад зочидтой яриа хөөрөө өрнүүлжээ. Гэвч шөнө орой цаг өнгөрөх тусам уур амьсгал өөрчлөгдөж, чимээ шуугиан, чанга дуу хөгжим, архи дарс нэмэгдсэн ба Жоны санаа зовох байдал бас нэмэгджээ.. Марихуана хар тамхийг нийтээрээ хэрэглэх гэж хэн нэгэн нь оюутнуудыг том тойрог болгон зогсоож эхэлсэн гэнэ. Жон ярвайн, хоёр найздаа явах цаг боллоо гэж хэлжээ. Тэдний нэг нь бараг шоолох шахуу, “Жон, энэ чинь амархан шүү дээ – цөмөөрөө зүгээр тойрогт нь ороод зогсчихъё, тэгээд бидний татах ээлж болоход, бид таталгүйгээр дараагийнхаа хүнд дамжуулчихна. Бусдын нүдэн дээр эндээс явж, өөрсдийгөө эвгүй байдалд оруулаад яах вэ!” гэжээ. Энэ нь Жонд амархан сонсогдсон ч, зөв сонсогдоогүй. Жон бодлоо эрсхэн хэлээд, тэндээс даруйхан явах ёстойгоо мэдэж байлаа. Хэдэн хормын дотор, тэр зориг гарган, бусад нь хүссэнээрээ үйлдэж болно, гэхдээ би явлаа гэж хэлэхэд нэг найз нь үлдэхээр шийдээд, тойрогт оржээ; нөгөө найз нь Жоныг дурамжханаар даган цахилгаан шатанд суухаар шатаар уруудан буусан байна. Цахилгаан шатны хаалга онгойход, Япон цагдаагийн офицерууд цувран гарч, дээвэр дээр гарах шатаар өгсөн гүйлдэхэд тэд ихэд

гайхсан гэнэ. Жон, найзтайгаа хамт цахилгаан шат руу орж, доошоо буужээ.

Цагдаа нар шатаар гарч ирэхэд, уг оюутнууд хууль бус хар тамхиа, баригдахгүйн тулд тэр даруйд дээврээс шидсэн гэнэ. Гэсэн ч, цагдаа нар шат руу гарах гарцыг хаагаад, бүх оюутнуудыг зэрэгцүүлэн зогсоож, нэг бүрийг нь хоёр гараа дэлгэн харуулахыг шаардлаа. Тэгээд эгнээний дагуу явж, оюутан бүрийн эрхий болон долоовор хурууг анхааралтайгаар үнэрлэсэн гэнэ. Татсан байсан эсэх нь хамаагүй, марихуана хар тамхийг барьсан хүн болгон бүгдээрээ буруутгагдаж, хатуу шийтгэл амссан. Дээвэр дээр үлдсэн оюутнууд бараг бүгдээрээ элссэн их сургуулиасаа хасагдсан байна. Гэмт хэрэгтэйгээр буруутгагдсан хүмүүс, Японоос хөөгдсөн байх. Боловсролын мөрөөдөл, олон жилийн бэлтгэл, Японд ирээдүйд ажил олж болох боломж бүгд л ганцхан хормын дотор замхран алга болсон байна.

Би одоо тэр гурван найзад юу тохиолдсоныг хэлье. Дээвэр дээр үлдсэн найз нь, элсэхийн тулд маш их хичээж, шаргуу хөдөлмөрлөн байж орсон Японы тэр их сургуулиасаа хөөгдөж, гэр рүүгээ буцахаас аргагүй болсон гэнэ. Тэр шөнө Жонтой хамт уг үдэшлэгийг орхин гарсан найз нь Японд сургуулиа төгсөөд Америкийн Нэгдсэн улсын хамгийн шилдэг хоёр сургуульд үргэлжлүүлэн суралцаж, мэргэжил эзэмшжээ. Мэргэжил нь түүнийг Ази руу буцааж аваачсан бөгөөд тэр тэнд мэргэжлээрээ гарамгай амжилт гаргасан ажээ. Тэр өнөө хүртэл Жонд, тэр нэгэн шөнө үлгэр дууриал болохуйц зориг гаргасанд баярлан, талархаж явдаг ажээ. Жоны хувьд, түүний амьдрал дахь үр дагавар нь хэмжээлшгүй байсан. Тэр, уг жилийг Японд өнгөрөөснөөр аз жаргалтайгаар гэрлэж, мөн хоёр хүүтэй болсон. Тэрбээр гарамгай бизнесмен болсон төдийгүй саяхан Японы нэгэн их сургуульд профессороор ажиллах болжээ. Тэр чухал орой, Японд уг үдэшлэгийг орхин явах зориг гаргаагүй бол түүний амьдрал хэрхэн өөрчлөгдөх байсныг төсөөлөөд үз дээ .

Залуу эрэгтэйчүүд ээ, Жоны адил, үе тэнгийнхнийхээ дунд, тэдний нүдэн дээр зориг гарган, зөв сонголт хийх хэрэг та нарт гарч магадгүй. Ийнхүү зориг гаргасны тань төлөө та нарыг шоолж, дорд үзэн доромжилж болох л юм. Үүнээс

гадна, өнөө үед та нарын муу мухайтай тэмцэх тэмцэл дэлгэцийн өмнө, ганцаархнаа байхад тань явагдах болно. Бидэнд ач тусгаа өгч байгаа технологи та нарын өмнөх үеийнхэнд байгаагүй асуудлуудыг бас дагуулж байна. Үндэсний явуулсан судалгаагаар, өнөөгийн өсвөр насныхан зөвхөн сургууль дээрээ төдийгүй бас интернет дээр түгшүүр төрүүлэм их хэмжээгээр уруу татагдаж байдгийг тогтоожээ. Архи, хар тамхи хэрэглэж байгааг олон нийтийн интернет сүлжээнээс байнга харж байдаг өсвөр насныхан бусадтай харьцуулахад архи, тамхинд орох магадлал нь гурваас дөрөв дахин өндөр байдаг байна гэж уг судалгаа харуулсан байна. “Бидэнд нүүрэлдэг дарамт шахалтууд дээр нэгэн цоо шинэ–технологийн дарамт шахалт–нэмэгдсэнийг энэ жилийн судалгаа харууллаа. Технологийн дарамт шахалт хүүхдүүдийг найз нөхөд, мэддэг хүмүүсээс нь илүү ихээр дарамталж байна. Энэхүү дарамт нь гэр орон, хүүхдийн тань өрөөнд интернетээр дамжин орж ирдэг юм.”<sup>4</sup> гэж уг судалгааны талаар Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газрын нэгэн нарийн бичгийн дарга хэлсэн байна. Товчлуурыг дарах уу болих уу гэдэг дээр л шударга зоригт байдлаа үзүүлэх хэрэг гарна. *Миний Сайн Мэдээг Номло* номонд: “Ганцаараа байхдаа, хэн ч хараагүй гэж бодож байгаа үедээ юуны талаар бодож мөн юуг хийх тань та нарын ариун журмын хэмжүүр юм”<sup>5</sup> гэж номлогч нарт заадаг. Зоригтой бай! Хүчтэй бай! “Та нар ариун газруудад зогс мөн бүү хөдөл”<sup>6</sup>.

Залуу эрэгтэйчүүд ээ, Их Эзэн та нарт хүчийг өгөх болно гэж би амлаж байна. “Бурхан бидэнд айдсын сүнсийг бус, харин хүчний . . . сүнсийг өгсөн.”<sup>7</sup> Тэр зоригт байдал мөн шударга зан чанарын тань төлөө, та нарыг аз жаргал болон баяр баясгалангаар шагнах болно. Тийм зоригт байдал нь Есүс Христ болон Түүний Цагаатгалд итгэх та нарын итгэл, та нарын залбирал болон зарлигуудад дуулгавартай байсны тань үр дүн болон ирэх болно.

Ерөнхийлөгч Н. Эддон Таннер: “Сургуулийн тоглоомын талбай дээр ганц залуу хөвгүүн л сайны агуу нөлөөг үзүүлж чадна. Сайн мэдээний дагуу амьдарч, санваараа хадгалж, зөв зүйлийн төлөө зогсож байгаа нэгэн залуу эрэгтэй, хөл бөмбөгийн баг, сургууль, эсвэл хамт ажиллагсдынхаа дунд

тоолшгүй олон сайн зүйлийг үйлдэж чадна. Заримдаа та нар, өөрсдийн тань адил итгэлтэй тэднээс хүртэл, та нарын зөвийг үйлдэж байгааг нь хүндэлж байгаа тэднээс ч, доромжлол шүүмжлэлийг авах болно. Аврагч бат бөх итгэлээсээ ухарч няцахгүй байсан болохоор л түүнийг тамлаж, шоолон доромжлон, нулимж, мөн эцэст нь цовдолсон гэдгийг санаарай. Хэрвээ тэр бууж өгөн, “Өө, хэнд хэрэгтэй юм бэ дээ?” гээд зорилгоосоо ухарч няцсан бол юу тохиох байсан талаар та нар ер нь бодож үзэж байсан уу? Бид нар бууж өгөгч байхыг хүсч байна уу, эсвэл дэлхий дээрх бүх л хилэнц, сөрөг хүчнээс үл хамааран зоригтой үйлчлэгч байхыг бид хүсч байна уу? Зөв зүйлийн төлөө зогсох зоригтой байж мөн Христийн чин үнэнч, итгэлт дагагчдын тоонд орцгооё”<sup>8</sup> гэж хэлсэн байдаг.

2000 залуу дайчны адил, зохистой санваартнуудын хувьд зоригтой баатарлаг байж, өөрсдийгөө бэлэн байлгахад би та нарыг урьж байна. Юу хийж, хаашаа явж, юуг үзэж харж байгаа тань хэн болохыг тань тодорхойлох болно гэдгийг санаарай. Чи хэн болохыг хүсч байна вэ? Зохистой дикон, зохистой багш, зохистой прист болоорой. Зохих насандаа дараагийнхаа ёслолыг хүлээн авахад мөн яваандаа Мелкизедек Санваарыг хүлээн авахдаа зохистой байна гэсэн зорилгыг, мөн ариун сүмд орох зохиистой байна гэсэн зорилгыг өөртөө тавиарай. Энэ нь тэнгэрлэг тусламжийг урих зөв шударга байдлын зам юм шүү. Их Эзэн, “Үүний ёслолуудад бурханлаг чанарын хүч илэрхийлэгддэг” хэмээн хэлдэг.

*Бурханы өмнө хүлээх үүрэг болон Залуучуудын бат бөх байдлын төлөө* гарын авлагуудад байх бошиглолын заалтууд болон эцэг эхчүүд, санваартны удирдагчид тань чамайг зөв зам дээр удирдан дагуулах болно.

Ерөнхийлөгч Томас С.Монсон саяхан:

“Ухаалаг [шийдвэрийг] гаргахад, зориг, үгүй гэж хэлэх зориг, тийм гэж хэлэх зориг шаардагдана . . .

“Тэнгэр дэх Эцэгтэйгээ үүрд мөнхөд амьдрах тэр зорилгод тань хүргэх тэр замаасаа хазайхгүй байх шийдвэрийг яг одоо гаргаач хэмээн би та нараас гуйж байна”<sup>10</sup> гэж зөвлөсөн билээ.

2000 дайчид, удирдагч Хиламаныхаа байдлааны дуудлагыг сонсон, зоригт баатарлаг байдлаа харуулсан шиг, та нар ч

гэсэн, бошиглогч удирдагч, Ерөнхийлөгч Томас С. Монсоныг дагаснаар зоригт баатарлаг байдлаа харуулж бас чадна.

Аароны санваартан залуучууд аа, би Бурхан Эцэг болон Есүс Христийн талаарх гэрчлэлээ өргөж, Иосеф Смитийн “Ах дүүс минь, ийм агуу учир шалтгааны төлөө бид урагш явахгүй гэж үү? Арагшаа биш, харин урагшаа явагтун. Зориглогтун, ах дүүс минь тэгээд ялалт өөд улам бүр ахь!”<sup>11</sup> гэж хэлснээр яриагаа өндөрлөе. Есүс Христийн нэр дээр, Амен.

#### Эшлэл

1. Алма 53:20.
2. Мозая 18:9.
3. Үг хэлэгчид ярьсан хувь хүний түүх
4. Иосеф А. Калифано, Жюнер, CASA Columbia байгууллагыг үүсгэн байгуулагч мөн дарга байсан, уг судалгааг CASA хэвлэлд шилжүүлсэн, [www.casacolumbia.org](http://www.casacolumbia.org).
5. *Миний Сайн Мэдээг Номло: Номлогчийн Үйлчлэлийн талаарх удирдамж* (2004), 118.
6. Сургаал ба Гэрээ 87:8.
7. 2 Тимот 1:7.
8. Н. Элдон Таннер, “For They Loved the Praise of Men More Than the Praise of God,” *Ensign*, 1975 оны 11 сар, 74–75.
9. Сургаал ба Гэрээ 84:20.
10. Томас С. Монсон, “The Three Rs of Choice,” *Лиахона*, 2010 оны 11 сар, 67–70.
11. Сургаал ба Гэрээ 128:22.

# Өөрсдийн талаар болгоомжтой бай

Далын

*Ахлагч Антони Д.Перкинс*

---

Хөрвөлтөө гүнзгийрүүлж, гэр бүлээ хүчирхэгжүүлэн санваарын зам дээрээ үлдээрэй. . . . Замын дагуу байрлуулсан Бурхан мөн Бошиглогчдын “Болгоомжтой бай” хэмээх сүнслэг тэмдгүүдийг дагаж, эмгэнэлт байдлаас зайлсхий.

---

Намайг залуу хөвгүүн байхад гэр бүлийнхэн маань өвөө эмээгийн айлчлахаар Америкийн Роки уулсыг (Хадат уулсыг) даван, машинаар аялдаг байж билээ. Аяны зам маань шарилжит талаас эхээ авч, нарс модоор хучигдсан налууг даган дээш өгсөж, яваандаа дээшлэн улиас мододтой төглөөр явж, эргэн тойрон алган дээр минь байгаа мэт харагдах уулын оройн нугад ирдэг байлаа.

Гэхдээ энэ байгалийн үзэсгэлэнт газраар аялах зам тийм ч аюулгүй байсангүй. Хурдны замын ихэнх нь эгц уулын бэл дээр баригдсан байв. Аялагчдыг хамгаалахын тулд зам баригчид хашаа барьж мөн “Болгоомжил: Чулуу нурна” гэсэн тэмдгүүдийг тавьсан байсан. Бид эдгээр сэрэмжлүүлгийг тавьсны олон учир шалтгааныг олж харсан. Замаас тэртээ доогуур голын эргээр хад, чулууд нуран хөглөрсөн байв. Үе үе, бид ангалын ёроолд эвдэрч хэмхэрсэн машинууд байхыг олж харж байсан ба энэ нь сэрэмжтэй байгаагүйгээс жолооч нарт тохиосон эмгэнэлт явдал байлаа.



## Санваарын Тангараг болон Гэрээ

Ах нар аа, та нар бүгдээрээ орсон эсвэл зарим нь удахгүй Мелкизедек Санваарын гэрээ хийгээд тангарагт орох болно.<sup>1</sup> Тэрхүү гэрээнд доод болон дээд санваарын аль алиныг нь хүлээн авснаар өөрсдийн дуудлагыг эрхэмлэн биелүүлэхээр дамжуулан өсөн хөгжиж, бид “Эцэгт байгаа бүхнийг”<sup>2</sup> хүлээн авах хүртэл Бурханы хамгийн агуу адислалууд өөд байнга авирах тийм гайхамшигт аян эхэлдэг билээ.

Тэрхүү селестииел замыг бүтээгч мэргэн загварчин маань бидний аянд зориулан анхааруулгын тэмдгүүдийг тавьсан байдаг. Санваарын гэрээ хийгээд тангараг нь: “Мөн өөрсдөдөө санаа тавихдаа болгоомжтой байх зарлигийг бибээр эдүгээ та нарт өгч байна”<sup>3</sup> хэмээх бодгальд нэвт шингэсэн сэрэмжлүүлгийг агуулсан байдаг.

Бурхан яагаад бидэнд болгоомжтой байх зарлигийг өгөх вэ? Сатан бидний бодгалийг үүрдийн зовлон зүдгүүрт унагах ангал руу чирэхийг эрэлхийлдэг бодит нэгэн<sup>4</sup> болохыг Тэр мэддэг. Бас түүнчлэн санваар атгагчдын дотор “эгэл хүн”<sup>6</sup> хийгээд “төөрөлдөхдөө амархан”<sup>7</sup> нэгэн оршиж байдгийг Бурхан мэддэг. Тиймээс бошиглогчид биднийг итгэл, наманчлал, аврах ёслолуудаар дамжуулан мөн өдөр бүр сайн мэдээний дагуу амьдарснаар “хуучин хүнээ тайлж”<sup>8</sup> “Христийг өмсөхийг”<sup>9</sup> урьдаг.

## Эмгэнэлт явдлаас зайлсхийх нь

Санваарын замаар дээшлэх зуураа, ямар ч хөвгүүн эсвэл эр хүн болгоомжтой байхаа болих юм бол доош чирэгдэж болно. Шилдэг сайн залуу эрэгтэй, дөнгөж буцаж ирсэн номлогч, бусдын хүндэтгэлийг хүлээсэн санваартны удирдагч эсвэл гэр бүлийн тань хайртай гишүүн, санаандгүй байхад чинь унан төөрөхийг хараад та нар гайхширч мөн сэтгэл шимширч байсан уу?

Хуучин Гэрээний Давидын түүх нь, санваарын хүчээ дэмий үрсний эмгэнэлт жишээ юм. Тэр залуухан байхдаа Голиатыг ялан дийлж мөн хэдэн арван жилийн турш зөв шударгаар амьдарсан хэдий ч<sup>10</sup>, энэ бошиглогч-хаан сүнслэг байдлын хувьд эмзэг байсан. Угаал үйлдэж байгаа үзэсгэлэнт Батшебаг дээвэр дээрээсээ харсан тэр ноцтой мөчид ёс

суртахууны харуул “Болгоомжтой бай, Давид, чи тэнэглэж байна! хэмээн хашгираад хажууд нь зогсож байсангүй. Өөрийн талаар болгоомжтой байж чадаагүйгээс болж<sup>11</sup> мөн Сүнсний өдөөлтийн дагуу үйлдээгүйгээс болж<sup>12</sup>, тэр мөнхийн гэр бүлээ алдахад хүрсэн.<sup>13</sup>

Ах нар аа, бүр хүчит Давид хүртэл өргөмжлөлд хүргэх зам дээрээс шүүрэгдэж чадаж байгаа бол бид тиймэрхүү хувь тавилангаас яаж зайлсхийх вэ?

Хувь хүний гүн гүнзгий хөрвөлт болон гэр бүлийн бат бөх харьцаа хэмээх ихэр хоёр хамгаалалтын зарчим тэнгэр рүү хөтлөх сүнслэг зам дээрээ байхад маань тусалдаг.

Сатан үүнийг мэддэг болохоор, санваарын замыг хөндөлсөх, хөрвөлтийг бяцлах, гэр бүлд ан цав гаргах хад чулуудыг шидэлж байдаг. Аз болоход, Есүс Христ болон Түүний бошиглогчид замын дагуу “Болгоомжтой бай” гэсэн тэмдгүүдийг тавьсан. Тэдгээр тэмдгүүд нь уур хилэн, шунал, тачаал гэх мэт хөрвөлтийг бяцлах<sup>14</sup>, гэр бүлд ан цав гаргах нүглүүдээс биднийг байнга сэрэмжлүүлж байдаг билээ.

Удаан хугацааны өмнө, Мосе “Их Эзэнийг мартуузай”<sup>15</sup> гэж зөвлөсөн. Өнөөгийн яарч давчидсан мөн зугаа цэнгэлээр дүүрэн дэлхийд, хүмүүн нь “Их Эзэн Бурханаа . . . мартдагийг, . . . алдсыг үйлдэхэд, мөн хилэнцэт нэгнээр удирдагдахдаа”<sup>16</sup> хичнээн хурдан нь хэвээр байсаар байна.

### **Хөрвөлтөө гүнзгийрүүлж, гэр бүлээ хүчирхэгжүүлэх нь**

Сүнслэг байдалд саад тотгор болох уруу таталтын чулуудын бартаан дунд санваарын зам дээрээ аюулгүй үлдэхийн тулд, хөрвөлтийг гүнзгийрүүлж, гэр бүлийг хүчирхэгжүүлэх үндсэн зургаан зарчмыг би сануулмаар байна.

Нэгдүгээрт, Залбирах нь “Сатаныг ялан дийлэх”<sup>17</sup> тэнгэрлэг тусламжийн үүдийг байнга нээдэг. Есүс санваар атгагчдад “болгоомжтой бай, учир нь Сатан чамайг салхинд хийсгэхээр эрэлхийлж байна” хэмээн анхааруулах болгондоо Тэр залбирал нь уруу таталтыг сөрөн зогсох үйлдэл<sup>18</sup> гэж зөвлөдөг. Ерөнхийлөгч Томас С.Монсон заахдаа: “Бидний хэн нэг нь дандаа залбирч бай гэсэн зөвлөгөөг сонсохдоо удаан

байсан бол одооноос өөр эхлэх сайн цаг байхгүй шүү. . . Хүн өвдөг сөхрөн суугаа үедээ л хамгийн өндөр байдаг”<sup>19</sup> гэсэн.

Хоёрдугаарт, Эртний болон орчин үеийн судруудаас суралцах нь биднийг Бурхантай холбодог. Их Эзэн Сүмийн гишүүдэд “тэдгээр [бошиглогч нар] нь хөнгөмсөг зүйл хэмээн тооцогдож, мөн үүний улмаас буруушаалт дор авчрагдан, . . . бүдэрч мөн унахгүйн тулд . . . болгоомжтой байг”<sup>20</sup> гэж сануулсан. Энэхүү чухал зэмлэлээс зайлсхийхийн тулд бидэнд “[Их Эзэний] сонгогдсон бошиглогчдоос хувийн, биечилсэн зөвлөгөө авах боломжийг”<sup>21</sup> олгодог судрууд, Сүмийн сэтгүүлүүд болон вэб хуудаснуудаас хичээнгүйлэн унших хэрэгтэй.

Гуравдугаарт, Зохистойгоор ёслолуудад оролцох нь “Ариун Сүнснийг зам заагчаа”<sup>22</sup> болгоход биднийг бэлтгэдэг. Аврагч, “Мэхлэгдэхгүйн тулд болгоомжтой байхыг” сэрэмжлүүлэхдээ хэрэв бид “Сүнсний хамгийн шилдэг бэлгүүдийг хичээнгүйлэн эрэлхийлэх”<sup>23</sup> юм бол мэхлэгдэхгүй байх болно гэж Тэр амласан. Долоо хоног бүр ариун ёслолоос зохистойгоор хүртэх нь гишүүдэд “түүний Сүнснийг өөрсөдтэйгээ үргэлж хамт байлгах”<sup>24</sup> боломжийг өгдөг. Ариун сүмд шүтэн биширснээр бид “Ариун Сүнсний бүрэн байдлыг хүлээн авч”<sup>25</sup> болдог.

Дөрөвдүгээрт, чин сэтгэлийн хайрыг үзүүлэх нь хувийн хөрвөлт болон гэр бүлийн харьцааны гол цөм мөн. Хаан Бенжамин “та нарын дунд зөрчлүүд байхаас . . . айж болгоомжил”<sup>26</sup> гэж зөвлөсөн. Сатан нь “зөрчилдөөний эцэг”<sup>27</sup> бөгөөд гэр бүлийн гишүүд “байлдан мөн тэмцэж”<sup>28</sup> байхыг л тэр эрэлхийлдэг гэдгийг хэзээ ч бүү март. Ах нар аа, хэрвээ бид гэр бүлийнхээ хэн нэг гишүүнд сэтгэлийн, үг хэлээр эсвэл биеийн хүчирхийлэл үзүүлэх юм бол, эсвэл хэн нэгнийг дээрэлхэх юм бол, тэгвэл бид санваарын хүчээ алддаг.<sup>29</sup> Уур хилэнгээ хянаж байгаарай. Гэр бүлийн гишүүд маань бидний амнаас хараал зүхлийг биш, харин адислалыг сонсож байх ёстой. Бид сэнхрүүлгээр, тэсвэр тэвчээрээр, эелдэг зөөлөн хийгээд номхон дөлгөөнөөр, чин сэтгэлийн хайр, нинжин сэтгэлээр мөн энэрлээр л бусдад нөлөө үзүүлэх ёстой.<sup>30</sup>

Тавдугаарт, Аравны нэгийн хуулинд дуулгавартай байх нь итгэл болон гэр бүлийн нэгдмэл байдлын чухал хэсэг мөн.

Сатан гэр бүлүүдийг селестиел замаас нь арчиж хаяхын тулд шуналтайгаар, хөрөнгө мөнгөний араас хөөцөлдүүлэх аргыг ашигладаг тул Есүс, “Шуналаас болгоомжил”<sup>31</sup> гэж зөвлөсөн. Бид орлогоо төлөвлөж, шударга аравны нэг болон өгөөмөр мацаг барилтын өргөлийг төлж, шаардлагатай зардлаа тооцоолж, шаардлагагүй өрөнд орохоос зайлсхийж, ирээдүйн хэрэгцээнд зориулан хадгалж мөн түр зуурын бие даасан байдалтай болох үед шунал нь дарагдах болно. “Харин та нар эхлээд Бурханы хаант улсыг мөн түүний зөв шударгыг эрэлхийл, мөн эдгээр бүх зүйл та нарт нэмэгдэн өгөгдөх болно”<sup>32</sup> гэдэг нь Бурханы бидэнд өгсөн амлалт билээ.

Зургадугаарт, Ариун явдлын хуулийг бүрэн дүүрнээр сахин амьдрах нь Ариун Сүнснийг “байнгын хамтрагчаа”<sup>33</sup> байлган “Бурханы оршихуйд” өөртөө итгэлтэй зогсох боломжийг олгодог. Сатан нь ариун журам болон гэрлэлт рүү хэмжээлшгүй бузар явдлаар дайрч байна. Их Эзэн садар самууныг үйлдэгчдэд “болгоомжилж мөн үтэр түргэн наманчлахыг” сэрэмжлүүлсэн ба Түүний тодорхойлолт бие махбодийн садар самуунаас гадна энэ садар самуун явдлын өмнөх тачаангуй бодлыг хүртэл багтаасан юм.<sup>34</sup> Орчин үеийн бошиглогчид болон төлөөлөгчид, порнографийн тахлын талаар олон удаа тодорхой ярьж байсан. Ерөнхийлөгч Гордон Б. Хинкли: “Порнографи бол нэгэнтээ үзэсгэлэнтэй сайхан байсан зүйлийг бүрмөсөн үгүй болгож, мөн гэр бүл болон хувь хүмүүсийг устгах хүчит шуурга адил юм. . . Үүнийг үзэж хэрэглэдэг хэн байлаа ч, өөрсдийгөө намагт шавраас татаж гаргах цаг болчихоод байна”<sup>35</sup> гэж заасан билээ. Хэрвээ та нар, ямар нэгэн байдлаар ариун явдлын хуулийг зөрчихөөр уруу татагдах юм бол, Египетийн Иосефийн, “гадагш зугтан гарсан”<sup>36</sup> үлгэр жишээг дагаарай.

Эдгээр зургаан үндсэн зарчим нь санваарыг атгагч нарт сүнслэг хамгаалалт болох хувийн хөрвөлт болон гэр бүлийн харилцааны хооронд аюулгүй явснаар тэнгэрт хүрэх зам дээрээ өгссөөр байхад нь тусална. Залуу эрэгтэйчүүд ээ, эдгээр зарчмыг дуулгавартай дагах нь ариун сүмийн гэрээнүүд, бүрэн цагийн номлолын үйлчлэл болон мөнхийн гэрлэлтийг хүлээн авахад та нарыг бэлтгэх болно. Нөхрүүд болон аав нар аа, эдгээр зарчмын дагуу амьдрах нь гэр орноо

зөв шударга байдалд тэргүүлж, гэр бүлийнхээ сүнслэг удирдагчаар үйлчлэх, эхнэртэйгээ адил тэгш хамтрагч байхад та нарыг мэргэшүүлэн боловсруулах болно.<sup>37</sup> Санваартны зам нь баяр баясгалангаар дүүрэн аян зам юм шүү.

### Санваарын Зам дээр үлдэх нь

Залуу хөвгүүн байсан дурсамжаасаа эргэн ярихад бид Роки Уулсыг давсан нэг тохиолдлыг би санадаг. “Болгоомжтой бай: Чулуу нурна” гэсэн тэмдгийг өнгөрсний дараа аав маань жижиг хайрга чулууд бидний өмнө зам дээр унаж байгааг ажигласан. Тэр хурдаа сааруулж, машинаа бараг зогстол удаашруулсаны дараахан нь сагсан бөмбөгний хэмжээтэй чулуу бидний хажуугаар өнхрөн бууж ирсэн. Аав маань чулууны нуралт зогсохыг хүлээж байгаад аянаа үргэлжлүүлж билээ. Аавын маань байнгын анхаарал болгоомжтой байдал, шуурхай түргэн үйлдэл гэр бүл маань зорьсон газартаа аюулгүй хүрэх боломжийг олгосон юм.

Ах нар аа, Сатан “хүмүүний сүнсийг устгахыг”<sup>38</sup> эрэлхийлдэг. Хэрэв та нарын бодгаль сүнслэг аюулын ангалын ирмэгт аажмаар дөхөж байгаа бол унахаасаа өмнө одоо зогс, буцаад зам руугаа зал.<sup>39</sup> Хэрэв та нар “Болгоомжтой бай” гэсэн тэмдгийг үл тоомсорлон, нүгэл үйлдсэн учир та нарын бодгаль санваарын зам дээр өндөрт байхын оронд ангалын ёроолд осолдон хэвтэж байгаа мэт санагдаж байгаа бол чин сэтгэлийн наманчлал болон Есүс Христийн цагаатгах золиослолын хүчээр та нар өргөгдөж мөн Бурханы тэнгэрт очих зам дээр дахин гарч чадна гэдгийг би гэрчилж байна.<sup>40</sup>

Есүс, “Хоёр нүүртнүүдээс . . . та нар болгоомжил”<sup>41</sup> гэж заасан. Хэрэв та нар санваарыг атгахаар зохистой биш бол, та нарт наманчлахад тань туслах бишоптойгоо уулзаарай. “Нүглээс татгалзаж. . . мөн болгоомжлогтун”<sup>42</sup> гэж Аврагч маань хэлдэг ч, Тэр бас түүнчлэн, “Их Эзэн, би та нарыг өршөөж байна . . . Замаараа явж мөн дахин нүгэл бүү үйлд”<sup>43</sup> гэж амладаг юм.

Би хөвгүүн болоод эрэгтэй хүн бүрийг хөрвөлтөө гүнзгийрүүлж, гэр бүлээ хүчирхэгжүүлэн санваарын зам дээрээ үлд хэмээн урьж байна. Залбирал, судар ба ёслолууд хөрвөлтийг гүнзгийрүүлдэг. Хайр, аравны нэг болон ариун явдал нь гэр бүлийг бэхжүүлэн хүчирхэгжүүлдэг. Замын дагуу

байрлуулсан Бурхан мөн Бошиглогчдын “Болгоомжтой бай” хэмээх сүнслэг тэмдгүүдийг дагаж, эмгэнэлт байдлаас зайлсхий. “Уруу таталт байсан хэдий ч тэдгээрт анхаарал тавиагүй”<sup>44</sup> Есүс Христийн төгс жишээг дагахыг хичээ.

Хэрэв эрэгтэйчүүд “өөрсдийн талаар болгоомжтой бай”<sup>45</sup> гэсэн санваарын гэрээг сахих юм бол бид болоод гэр бүлийнхэн маань зорьж буй селестиел хаант улс дахь өргөмжлөгдсөн газартаа аюулгүй мөн баяр хөөртэйгээр хүрнэ гэдэгт итгэлтэй байж болно хэмээн би амлаж байна. Есүс Христийн ариун нэр дээр би ийн гэрчилж байна, амен.

### Эшлэл

- 1 Сургаал ба Гэрээ 84:33–44 -г үзнэ үү.
- 3 Сургаал ба Гэрээ 84:38.
- 3 Сургаал ба Гэрээ 84:43.
- 4 Иосеф Смит—Түүх 1:16; мөн Мосе 1:12–22 -г үзнэ үү.
- 5 Хиламан 5:12; мөн 2 Нифай 1:13; Хиламан 7:16 -г үзнэ үү.
- 6 Мозая 3:19; мөн 1 Коринт 2:14 -г үзнэ үү .
- 7 “Come, Thou Fount of Every Blessing,” *Сүмийн дуулал* (1948), хуудас 70.
- 8 Колоссай 3:8–10; мөн Ефес 4:22–24 -г үзнэ үү.
- 9 Галат 3:27; мөн Ром 13:14 -г үзнэ үү.
- 10 1 Самуел 13:14; 17:45–47 -г үз.
- 11 2 Самуел 11:1–17 -г үзнэ үү.
- 12 “Та нар юуны түрүүнд Сүнсний өдөөлтөөр сэрэмжлүүлэгдэхгүйгээр ноцтой алдаа гаргалгүй байж чадахгүй” (Бойд К.Пакер, “Залуучуудад зөвлөх нь”, *Лиахона*, 2011 оны 11 сар, 18).
- 13 Сургаал ба Гэрээ 132:39 үзнэ үү; мөн Судрын удирдамж хэсгээс, “Давид”-г үзнэ үү.
14. Сургаал ба Гэрээ 23:1; 25:14; 38:39 үзнэ үү; мөн түүнчлэн Эзра Тафт Бенсон, “Beware of Pride,” үзнэ үү, *Ensign*, 1989 оны 5 сар, 4–7.
15. Дэд Хууль 6:12; мөн Дэд Хууль 8:11–19 -г үзнэ үү.
16. Алма 46:8.
17. Сургаал ба Гэрээ 10:5.
18. Сургаал ба Гэрээ 52:12–15; мөн Лук 22:31–32; Алма 37:15–17; 3 Нифай 18:18–19 -г үзнэ үү.
19. Томас С.Монсон, “Come unto Him in Prayer and Faith,” *Лиахона*, 2009 оны 3-р сар , 4.
20. Сургаал ба Гэрээ 90:5; мөн Сургаал ба Гэрээ 41:1, 12 -г үз.
21. Гордон Б.Хинкли, “Faith: The Essence of True Religion,” *Ensign*, 1981 оны 11 сар, 5.
22. Сургаал ба Гэрээ 45:57.
23. Сургаал ба Гэрээ 46:8; мөн Ефес 4:14; Сургаал ба Гэрээ 52:14–16; Колоссай 2:8-г үзнэ үү.
24. Моронай 4:3; Сургаал ба Гэрээ 20:77; мөн 3 Нифай 18:1–11 -г үзнэ үү.
25. Сургаал ба Гэрээ 109:15.
26. Мозая 2:32.
27. 3 Нифай 11:29–30 үзнэ үү.
28. Мозая 4:14.
- 29 Сургаал ба Гэрээ 121:36–37 үзнэ үү ; мөн Сургаал ба Гэрээ 63:61–63 -г үзнэ үү.
- 30 Сургаал ба Гэрээ 121:41–45 -г үзнэ үү.
- 31 Лук 12:15; мөн Сургаал ба Гэрээ 38:39 -г үзнэ үү.
- 32 Матай 6:33; мөн түүнчлэн 3 Нифай 13:33 -г үзнэ үү.

- 33 Сургаал ба Гэрээ 121:45–46; мөн Сургаал ба Гэрээ 67:11; Мосе 1:11 - г үзнэ үү.
- 34 Сургаал ба Гэрээ 63:14–16 үзнэ үү; мөн Матай 5:27–28; 3 Нифай 12:27–30 -г үзнэ үү.
- 35 Гордон Б.Хинкли, “A Tragic Evil among Us,” *Liahona*, 2004 оны 11 сар, 59–62; мөн түүнчлэн Даллин Х.Өүкс, “Порнографи” *Liahona*, 2005 оны 5 сар, 87–90; Жеффри Р.Холланд, “Place No More for the Enemy of My Soul,” үзнэ үү, *Liahona*, 2010 оны 5 сар, 44–46.
- 36 Эхлэл 39:12.
- 37 *Гарын авлага 2: Сүмийг удирдах нь* (2010), 2.3-г үзнэ үү.
38. Сургаал ба Гэрээ 10:27; мөн 1 Петр 5:8 -г үзнэ үү.
39. Сургаал ба Гэрээ 3:9–10; 1 Коринт 10:12–13; 2 Петр 3:17 -г үзнэ үү.
40. Алма 13:27–29; Сургаал ба Гэрээ 109:21 -г үзнэ үү.
41. Лук 12:1; мөн Сургаал ба Гэрээ 50:6–9 -г үзнэ үү.
42. Сургаал ба Гэрээ 82:2.
43. Сургаал ба Гэрээ 82:1, 7..
44. Сургаал ба Гэрээ 20:22; мөн Еврей 2:17–18; 4:14–16 -г үзнэ үү.
45. Сургаал ба Гэрээ 84:43; мөн Дэд Хууль 4:9; Мозая 4:29–30 -г үзнэ үү.

# Санваартан хүний баяр баясгалан

Тэргүүн Зөвлөлийн Хоёрдугаар Зөвлөх

Ерөнхийлөгч Диетер Ф.Угдорф

---

*Бүгдээрээ санваарын гайхамшиг хийгээд давуу эрхийг ойлгож мөн хүлээн авцгаая. Биднээс хийхийг хүссэн үүрэг хариуцлагаа хүлээн авч мөн хайрлацгаая.*

---

## Нисэхийн баяр баясгалан

Олон жилийн өмнө би ахмад цолтой хоёр нисгэгчтэй хамтран хүүхэд насны мөрөөдлөө биелүүлж хуучны онгоцыг сэргээн засварлахаар шийдсэн билээ. Бид хуучирч муудсан 1938 оны Пайпер Каб онгоц худалдан авч, үүнийгээ хуучин хэвэнд нь оруулахаар ажиллаж эхэлсэн. Бид энэ ажлыг зүрх сэтгэлээсээ хийж байлаа. Энэ онгоцыг сэргээн засварлах нь миний хувьд маш онцгой утга учиртай юм. Учир нь би залуу байхдаа үүнтэй маш төстэй онгоцоор анх нисч сурсан.

Ах дүү Врайт алдартай анхны нислэгээ хийснээс ердөө 35 жилийн дараа л энэ онгоцыг үйлдвэрлэсэн байв. Энэ тухай бодохоор л би өөрийгөө ямар настай хүн бэ гэдгээ мэдрэх юм даа.

Энэ онгоцны хөдөлгүүр нь цахилгаан үүсгүүргүй учраас бүхээг доторх хүн хөдөлгүүрээ асаах үед өөр хэн нэгэн нь гадна талд зогсоод хөдөлгүүрийг нь асч эхэлтэл онгоцны сэнсийг хамаг чадлаараа эргүүлдэг байв. Хөдөлгүүр асах бүрт энэ нь сэтгэл хөдлөл ба эр зоригийн бэлэгдэл болдогсон.

Агаарт гарсны дараа Пайпер Каб нь хурдан нисэхэд зориулагдаагүй нь ойлгогдох болно. Заримдаа бүр өөдөөс хүчтэй салхилах үед онгоц огт нисэхгүй байгаа мэт санагддаг



гээч. Германд байхдаа машины хурдны зам дээгүүр өсвөр насны хүүтэйгээ хамт нисч байснаа би санадаг. Тэр үед доогуур явж байсан машинууд манай онгоцыг хөнгөхөөн гүйцээд явж байж билээ!

Гэвч би энэ жижигхэн онгоцонд хичнээн их хайртай гээч! Түүгээр нисэхэд нисэх гэдэг нь ямар гайхалтай сайхан болохыг мэдэрдэг юм. Та сонсож, мэдэрч, үнэртэж ер нь нисэх гэдэг нь ямар байдгийг бүрэн утгаар нь мэдрэх болно. Ах дүү Вraith энэ талаар дүрслэхдээ: “Агуу цагаан далавчнуудын тусламжтайгаар агаарт хөөрөхдөө нисгэгч нарын эдэлдэг баяр хөөрийг юутай ч зүйрлэшгүй юм”<sup>1</sup> гэж хэлсэн байдаг.

Үүний эсрэгээр, энэ жилийн эхээр надад АНУ-ын Тэнгисийн Цэргийн флотын дэлхийд алдартай “Хөх Тэнгэр Элч нар” нислэгийн багийнхантай Ф-18 онгоцоор нисэх завшаан тохиосон юм. Энэ үйл явдлаас яг 50 жилийн өмнө би цэргийн нисэх хүчний байлдааны нисгэгч болох бэлтгэлээ дуусч байсан учраас ийн нисэх нь надад тэр үеийг минь санагдуулж билээ.

Мэдээж хэрэг орчин үеийн Ф-18 онгоцоор нисэх нь Пайпер Каб онгоцоор нисэхээс тэс өөр байлаа. Энэ нь надад нисэхийн илүү эрч хүчтэй талыг мэдрүүлж байсан. Энэ нь аэродинамикийн хуулийг төгс ашиглах мэт байлаа. Хэдий тийм ч “Хөх Тэнгэр Элч нартай” дуунаас хурдан онгоцоор нисэх нь залуу хүний хийх ажил юм байна гэдгийг бас сануулсан. Ах дүү Вraithын хэлсэн үгсээс дахин иш татахад: “Нисэх мэдрэхүй нь бусад бүх зүйлээс илүүтэйгээр оюун ухааныг эцэст нь хүртэл тэлэх сэтгэлийн хөөрөл ба төгс амар амгаланг нэгтгэсэн мэдрэмж юм.”<sup>2</sup> Үүн дээр нэмж хэлэхэд “Хөх Тэнгэр элч нартай” нисэх нь эргэн тойрон дахь тэс өөр “тэнгэр элч нарын” тэврэлтийг мэдрүүлж байлаа.<sup>14</sup> (хошин шог байдлаар хэлж байна)

Энэ хоёр нислэгийн аль нь надад их таалагдсан бэ гэж надаас асуувал алийг нь гэж хэлэхээ би сайн мэдэхгүй. Энэ хоёр нислэгийн зарим нь хамгийн ил тод байдлаараа тэс өөр байсан ч зарим талаараа маш адилхан байсан.

Пайпер каб ба Ф-18 хоёроор нисэхэд хоёуланд нь миний сэтгэл хөдөлж мөн нисэх нь ямар сайхан болохыг нь мэдэрсэн. Энэ хоёроор нисэх нь надад яруу найрагчийн “Дэлхийн татах

хүчнээс гарч, дэлгэсэн далавчин дээр тэнгэрт дүүлэх сайхан”<sup>3</sup> гэдэг үгсийг санагдуулж байв.

### Хаа ч ижил байдаг санваар

Одоо та бүхэн надаас энэ хоорондоо тэс өөр хоёр нислэг өнөөдрийн энэ цуглаан буюу бидний атгадаг санваарын эрх мэдэл эсвэл бидний хийх дуртай санваарын үйлчлэлтэй ямар холбоотой юм бэ хэмээн асуух байх аа.

Ах нараа, хувь хүн бүрийн хийдэг санваарын үйлчлэлийн туршлага маш өөр өөр байдаг нь үнэн биш гэж үү? Бид үүнийг та нарын зарим нь Ф-18 дуунаас хурдан онгоцоор нисч байхад харин зарим нь Пайпер каб онгоцоор нисч байна гэж хэлж болох юм. Та нарын зарим нь туслахаас дээд пристийн бүлгийн удирдагч, диконы чуулгын нарийн бичиг зэрэг дуудлагууд нь бүгд идэвхтэй санваартанд өгөгдсөн, санваартнуудын үйл ажиллагаа идэвхтэй явагддаг тойрог ба гадсанд амьдардаг. Бүх дуудлагыг өгч болох хангалттай их санваартантай тойрогт байдаг нь та нарын давуу тал юм.

Харин нөгөө хэсэг нь маш цөөхөн Сүмийн гишүүд ба санваартнуудтай дэлхийн бүст амьдардаг. Та ганцаардаж, хийх ёстой зүйлсийг бүгдийг нь хийх гэсэн ачаандаа та түүртэж ядарч байж магадгүй. Санваарын үйлчлэлийн хөдөлгүүрийг асаахын тулд таны хувийн оролцоо маш их хэрэгтэй байж болох юм. Заримдаа танай салбар эсвэл тойрог өсч хөгжихгүй байгаа мэт танд санагдаж ч байж болох юм.

Хэдий тийм ч таны үүрэг хариуцлага эсвэл нөхцөл байдлаас үл хамааран чин сэтгэлийн санваарын үйлчлэлээс баяр хөөр ирдэг гэдгийг та бид мэддэг.

Би Пайпер каб, Ф-18 эсвэл өөр ямар ч онгоц байсан хамаагүй үргэлж нисэх дуртай байсан. Би Пайпер каб онгоцоор нисэж байхдаа ямар удаан юм бэ гэж гомдоллож байсангүй. Ф-18-аар нисэхдээ олон үйлдэл хийдэг маневр нь миний хөгширч байгаа бие махбодыг надад сануулсанд нь би гомдолоогүй.

Тиймээ, ямар ч нөхцөл байдалд төгс бус зүйл үргэлж тохиолддог. Аливаа зүйлээс гомдоллох шалтгаан олоход маш амархан байдаг.

Гэвч ах нараа, бид Бурханы Хүүгийн жаягийн нэрээр Ариун санваарыг атгагчид билээ! Бид бүгдээрээ тэргүүн

дээрээ гар тавиулж, Бурханы санваарыг хүлээн авсан хүмүүс. Бид энэ дэлхий дээрх Түүний үйлчлэгчдийн хувьд Түүний нэрийн өмнөөс үйлдэх үүрэг хариуцлага ба эрх мэдлийг хүлээн авсан. Том тойрог эсвэл жижиг салбарт байна уу ялгаагүй бид үйлчилж, адисалж мөн бүх хүмүүст бас бидэнд итгэн даалгасан тэдгээр зүйлсийг үргэлж хийхээр дуудагдсан. Үүнээс илүү сэтгэл хөдөлгөм зүйл байдаг гэж үү?

Санваарын үйлчлэлээс ирэх баяр хөөрийг мэдэрч, ойлгож мөн үүнд талархалтай байцгаая.

### **Санваараас ирэх баяр баясгалан**

Нисэх дур хүсэл маань бүхэл амьдралынхаа зүг чигийг олоход минь ихээхэн нөлөөлсөн. Гэвч нисгэгч байсан туршлагауд маань хичнээн жаргалтай, сайхан байсан хэдий ч Сүмийн гишүүний туршлагауд маань илүү гүн гүнзгий, илүү баяр хөөртэй, илүү утга учиртай байсан билээ. Би Сүмийн үйлчлэлд өөрийгөө бүрэн зориулах үед Бурханы бүхнийг чадагч хүч чадал мөн Түүний өршөөл энэрлийг мэдэрдэг.

Би нисгэгч байхдаа тэнгэрт хүрсэн бол Сүмийн гишүүн байснаараа тэнгэрээс ирэх хайр энэрлийг мэдэрсэн юм.

Заримдаа би нисгэгчийн бүхээгт суудаг байснаа санадаг ч Сүмийн ах эгч нартайгаа мөр зэрэгцэн үйлчлэх нь үүнийг маань орлодог. Энэ агуу үйлсийн нэгэн жижигхэн хэсэг байснаар өсөн нэмэгддэг сүнслэг амар амгалан ба баяр хөөрийг мэдрэх боломжоо би энэ дэлхийн өөр юугаар ч сольшгүй билээ.

Өнөөдөр бид санваар атгагчдын нэгэн том бүлгийн гишүүдийн хувьд цугларцгаасан байна. Бусдыг дэмжин тэтгэж мөн Бурханы хаант улсыг байгуулахын тулд өөрсдийн чадах бүхнээ хийж, Их Эзэнд мөн ахан дүүстээ үйлчлэх нь бидний ариун нандин баяр хөөр ба агуу боломж юм.

Санваар бол Бурханы мөнхийн хүч бөгөөд эрх мэдэл гэдгийг бид ойлгодог бас мэддэг билээ. Бид энэ санваарын тодорхойлтыг цээжээрээ шууд хэлж чаддаг. Хэдий тийм ч бид хэлж байгаа зүйлийнхээ утга учрыг үнэхээр ойлгодог бил үү? Би давтан хэлье: *санваар бол Бурханы мөнхийн хүч бөгөөд эрх мэдэл юм.*

Бурхан санваараар дамжуулан тэнгэр ба дэлхийг бүтээж мөн захирдаг гэдгийг тунгаан бодоод үз дээ.

Энэ хүчээр дамжуулан Тэрээр “үхэшгүй байдал хийгээд мөнх амьдралыг хүмүүнд”<sup>4</sup> тохиолгон авчирч, гэтэлгэж мөн өргөмжилдөг юм.

Бошиглогч Иосеф Смитийн тайлбарласнаар санваар гэдэг бол: “Дэлхийн бүтээлтийн эхэнд Бүхнийг Чадагч Өөрийн алдар сууг үүгээр дамжуулан илчилж эхэлсэн мөн эдүгээг хүртэл хүмүүний үрст Өөрийгөө илчилсээр байгаа бас цагийн төгсгөлийг хүртэл Тэрбээр Өөрийн зорилгыг мэдүүлсээр байх суваг юм.”<sup>5</sup>

Бүхнээс хүчтэй Тэнгэр дэх Эцэг маань сул дорой, төгс бус хэмээн тодорхойлогддог мөнх бус хүмүүн бидэнд санваарын эрх мэдлийг найдан өгсөн билээ. Түүний хүүхдүүдийн авралын төлөө Түүний нэрийн өмнөөс үйлдэх эрх мэдлийг Тэр бидэнд олгосон. Энэхүү эрх мэдлээр бид сайн мэдээг номлож, авралын ёслолуудыг гүйцэтгэж, дэлхий дээр Бурханы хаант улсыг байгуулахад тусалж мөн гэр бүлийнхэн ба ахан дүүстээ үйлчилж, адисладаг.

### **Бүх хүнд боломжтой**

Энэ бол бидний атгадаг ариун санваар юм.

Санваар болон үүн дэх аливаа үүрэг хариуцлагыг худалдан авч эсвэл тушаалаар өгдөггүй. Санваарын хүч чадлыг эрх мэдэл ба эд баялагаар нөлөөлж, урвуулж, хүчилж ашиглаж чадахгүй. Энэ бол тэнгэрлэг хуулиар зохицуулагддаг сүнслэг хүч юм. Үүнийг бидний агуу Тэнгэрлэг Эцэг маань үүсгэн байгуулсан. Санваарын хүч нь зөвхөн шударга ёсны зарчмуудаар хянагдаж мөн захирагддаг.<sup>6</sup>

Христ бол дэлхий дээрх бүх үнэн санваарын эрх мэдэл хийгээд хүчийн эх сурвалж мөн.<sup>7</sup> Энэ бол Түүний ажил бөгөөд Түүнд туслах боломж бидэнд өгөгдсөн. “Мөн өөрийнх нь анхаарал халамжинд итгэж даалгасан бүх зүйлд даруу төлөв хийгээд хайраар дүүрэн, итгэл, найдвар, мөн энэрэлтэй, биеэ барьдаг байхаас бусдаар өөр хэн ч энэ ажилд тусалж эс чадна.”<sup>8</sup>

Бид өөрсдийн ашиг тусын тулд биш харин бусдад үйлчилж, бусдыг өргөн дэмжихийг эрэлхийлэх ёстой. Бид хүчлэх биш харин “сэнхрүүлээр, . . . тэсвэр тэвчээрээр, . . . эелдэг зөөлөн хийгээд номхон дөлгөөнөөр, хайраар тэтгэгдэж”<sup>9</sup> хийх ёстой.

Бүхнийг Чадагч Бурханы санваар нь зохистой эрэгтэйчүүдэд хаана ч байсан, эцэг өвгөд нь ямар ч хүмүүс байсан, нөхцөл байдал нь хичнээн энгийн байсан ч, бөмбөрцгийн хол ойр хаана ч байсан хамаагүй өгөгддөг. Үүнийг ямар ч мөнгөгүйгээр, үнэгүйгээр авах боломжтой. Эртний бошиглогч Исаиа: “Цангасан хүн бүр ус уруу ирэгтүн. Мөнгөгүй хүн бүр ирж, идэгтүн!”<sup>10</sup> хэмээн бичиж үлдээжээ.

Аврагч Есүс Христийн эгэл хүний ойлгох аргагүй, мөнхийн Цагаатгалын ачаар бид урьд нь зохистой бус эсвэл алдаа хийдэг байсан ч Бурханы санваар бидэнд өгөгдөх боломжтой болсон. Наманчлалын сүнслэгээр цэвэршүүлэх, цэвэрлэх үйл явцаар дамжуулан та нар “босч мөн урагш гэрэлтүүлж”<sup>11</sup> чадна. Аврагч ба Гэтэлгэгчийн хязгааргүй мөн өршөөнгүй хайрын ачаар та нар мэлмийгээ өргөн, цэвэр ариун, зохистой болж, Бүхнийг Чадагч Бурханы хамгийн ариун санваарын зохистой атгагч, Бурханы үнэнч хийгээд сурвалжит хөвгүүд нь байж чадна.

### **Санваарын гайхамшиг хийгээд давуу эрх**

Санваарын гайхамшиг хийгээд давуу эрхийг ойлгож, хүндэлдэггүй хүмүүсийг харахад надад гунигтай байдаг. Тэдгээр хүмүүс бол онгоцонд суугаад үүлсийн дээгүүр, агаарыг зүсч яваагаа анзаарахгүй онгоцонд тараадаг самар нь ямар жижигхэн ууттай юм бэ хэмээн гомдоллон суугаа зорчигчидтой адил юм! Эртний хаад ингэж ердөө л ганц удаа нисч үзэхийн төлөө бүх эд хөрөнгөө өгөхөд ч бэлэн байх байсан бизээ.

Ах нараа, бид бол агуу санваарын эрх мэдэл, хүч чадлын даруухан үйлчлэгчид байхаар адислагдсан хүмүүс юм. Бүгдээрээ мэлмийгээ өргөн энэхүү боломж нь үнэн чанартаа юу болохыг харж, ухаарч мөн хүлээн авцгаая.

Зөв шударга, хайраар дүүрэн, мөн чин сэтгэлийн санваарын үйлчлэлээрээ дамжуулан бид: “Би та нарын нүүрний өмнө явах болно. Би та нарын баруун гар талд мөн та нарын зүүнтээ байх болно, мөн миний Сүнс та нарын зүрх сэтгэлд, мөн миний тэнгэр элчүүд та нарыг дэмжихийн тулд та нарын эргэн тойронд байх болно”<sup>12</sup> хэмээх илчлэлтийн үнэн утга учрыг мэдрэх боломжтой байх болно.

Бүгдээрээ санваарын гайхамшиг хийгээд давуу эрхийг ойлгож мөн хүлээн авцгаая. Гэр бүл болон Сүмийн нэгжүүд маань том эсвэл жижиг байхаас үл хамааран биднээс хийхийг хүссэн энэхүү үүрэг хариуцлагаа хүлээн авч мөн хайрлацгаая. Зөв шударга, тууштай байдал болон санваарынхаа үйлчлэлд үргэлж өсөн хөгжицгөөе. Санваарын үйлчлэлээсээ баяр хөөрийг мэдэрцгээе!

Мэдлэг, дуулгавартай байдал ба итгэлийн зарчмуудыг амьдралдаа хэрэгжүүлсэнээр бид үүнийг илүү сайн хийж чадна.

Энэ нь нэгдүгээрт бид Бурханы илчилсэн үгсэд байдаг санваарын сургаалуудыг мэдэж, мөн үүнийг амьдралдаа хэрэгжүүлдэг байх хэрэгтэй гэсэн үг юм. Санваарын үйл ажиллагааг явуулдаг гэрээ болон зарлигуудыг ойлгох нь маш чухал байдаг.<sup>13</sup>

Хоёрдугаарт, ухаалаг байж мөн олж авсан энэхүү мэдлэгийнхээ дагуу тууштай мөн шударгаар үйлдэцгээе. Бид Бурханы хуулиудыг сахиж, оюун ухаан, бие махбодоо сахилга баттай байлгаж мөн бошиглогчдын заасан зөв шударгын загварын дагуу үйлдэх аваас санваарын үйлчлэлийн баяр баясгаланг мэдрэх болно.

Эцэст нь Их Эзэн, Есүс Христэд итгэх итгэлээ улам бат бэх болгоцгооё. Өөрсөд дээрээ Түүний нэрийг хүлээн авч, дагалдагч байх зам дээр өдөр бүр алхах болно хэмээн амлацгаая. Бидний үйлс бидний итгэлийг төгс болгох болтугай.<sup>14</sup> Дагалдагч байснаараа бид гэр бүлийнхэн, бусад хүмүүс болон Бурханд үйлчлэх явцдаа шат шатаар төгөлдөржих болтугай.

Бид бүх зүрх сэтгэл, хүчин чадал, оюун хийгээд хүчээрээ санваарын үйлчлэлд үйлчлэх үед бидэнд агуу мэдлэг, амар амгалан болон сүнслэг бэлгийн амлалтууд өгөгддөг. Бид ариун санваарыг хүндлэн дээдлэх аваас Бурхан биднийг хүндэлж мөн “эцсийн өдөр бид [Түүний] өмнө буруугүй зогсох болно.”<sup>15</sup>

Бид үргэлж өөрсдийн агуу хийгээд бүхнийг чадагч Бурханы санваарын гайхамшиг хийгээд баяр баясгаланг харах нүд, бишрэх зүрх сэтгэлтэй байх болтугай хэмээн би залбирч байна, Есүс Христийн нэрээр, амен.

*Эшлэл*

1. Вилбур Врайт, Жеймс Тобинд, *To Conquer the Air: The Wright Brothers and the Great Race for Flight* (2003), 238.
2. Тобин дах Врайтын ах нар, *To Conquer the Air*, 397.
3. Жонн Жиллеспи Маги Бага., “High Flight,” Дианн Равич., *The American Reader: Words That Moved a Nation* (1990), 486.
4. Моце 1:39.
5. Сүмийн Ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит (2007), 108–9.
6. Сургаал ба Гэрээ 121:36.-г үзнэ үү.
7. Еврей 5:4–10; Сургаал ба Гэрээ 107:3-г үзнэ үү.
8. Сургаал ба Гэрээ 12:8.
9. Сургаал ба Гэрээ 121:41.
10. Исаиа 55:1-ийг үзнэ үү.
11. Сургаал ба Гэрээ 115:5.
12. Сургаал ба Гэрээ 84:88.
13. Сургаал ба Гэрээ 84:33–44; 121:34–46-г үзнэ үү.
14. Иаков 2:22-ыг үзнэ үү.
15. Сургаал ба Гэрээ 4:2.

# Өндөр зорилго тавихад нь хүүхдүүддээ тусал

Тэргүүн Зөвлөлийн Нэгдүгээр зөвлөх

*Ерөнхийлөгч Хенри Б.Айринг*

---

*Таны удирддаг хүмүүс таны удирдамж,  
чиглүүлээр Бурханы хаант улсад үйлчлэхийн  
тулд бүрэн хүч чадлаа дайчлан ажиллах  
боломжтойгоо ойлгож, үүндээ итгэн, үйлчлэх  
хүсэл нь нэмэгдэх болно.*

---

Энэхүү санваартны чуулганд оролцож, ийм гайхалтай заавар, гэрчлэлүүдийг сонсох боломжтой байгаадаа би маш их талархалтай байна. Энэ нь миний амьдралын туршлагыг надад бодогдууллаа. Надад байсан, гэхдээ би өөрөө харж чадахгүй байсан зүйлсийг намайг мэддэг хүмүүс харсны учир санваартны хувьд гүйцэтгэх боломжтой зүйлс маань бараг бүгд гүйцэлдсэн юм.

Би залуу эцэг байхдаа хүүхдүүд маань Их Эзэний хаант улсад ямар хувь нэмэр оруулж чадахыг мэдэхийн тулд залбирдаг байлаа. Хөвгүүдийн хувьд тэд санваарын боломжуудыг ашиглаж болохыг би мэдсэн. Харин охидын хувьд тэд Их Эзэнийг төлөөлөн үйлчлэл үзүүлж болно гэдгийг мэдэж авсан. Хүүхдүүд бүгдээрээ Түүний ажлыг хийж чадна. Хүүхэд бүр тусдаа хувь хүн учраас Их Эзэн тус бүрд нь Түүнд үйлчлэхэд хэрэг болох өвөрмөц бэлэг өгсөн байгааг би мэдэж байлаа.

Эдүгээ би эцэг бүр, залуучуудын удирдагч болгон юу хийвэл зохихыг тодорхойгоор, нэгд нэгэнгүй хэлж чадахгүй. Гэвч та нар төрөлхийн заяасан сүнсний бэлгүүдээ танихад нь залуучуудад тусалснаар тэднийг адисалж чадна гэдгийг би та



нарт амлаж байна. Хүн бүр өөр, мөн өөр өөр хувь нэмэр оруулж чадна. Бурханы хаант улсад хувь нэмрээ оруулж чадахгүй нэг ч хүн байхгүй. Санваараар удирддаг тэдгээр хүмүүст тань, ялангуяа залуучуудад Бурханы соёрхсон бэлгүүдийг олж харахын тулд та бүхэн илчлэлтийг эрэлхийлвээс тэдний хийж чадах үйлчлэлд залуучуудыг удирдахаар адислагдах болно. Таны удирддаг хүмүүс таны удирдамж, чиглүүлээр Бурханы хаант улсад үйлчлэхийн тулд бүрэн хүч чадлаа дайчлан ажиллах боломжтойгоо ойлгож, үүндээ итгэн, үйлчлэх хүсэл нь нэмэгдэх болно.

Би хүүхэд нэг бүрээ Бурханд үйлчлэх өвөрмөц боломжуудад бэлтгэхэд хэрхэн тусалж болохыг мэдэхийн тулд хүүхдүүдтэйгээ хамт залбирдаг байлаа. Тэгээд дараа нь ирээдүйгээ төсөөлөн, ирээдүйдээ итгэн найдаж, үүнийхээ төлөө зүтгэхэд нь тэдэнд туслахыг би хичээдэг байв. Би хөвгүүддээ зориулан тус бүрт нь түүний онцгой бэлгүүдийг дүрсэлсэн судрын эшлэл болон нэг бэлгийнх нь дүрс бүхий жижигхэн модон самбар зорж хийсэн. Зураг болон бичээсийн доод талд хөвгүүн бүрийнхээ баптисм хийлгэсэн болон санваарын албан тушаалууд томилогдсон он сар өдрийг эдгээр үйл явдлын үеэрх нурууны өндрийг тэмдэглэн сийлсэн юм.

Хөвгүүн бүрдээ зориулж сийлсэн самбар нь сүнсний бэлгүүдээ таньж, Их Эзэний ажилд ямар хувь нэмэр оруулж чадахаа харахад түүнд туслахын тулд сийлбэртэй самбар хийснээ би дүрслэн ярья. Та бүхэн өөрийн хайрладаг мөн удирддаг залуу хүн бүрийн онцгой бэлэг болон боломжуудыг танин мэдэхэд над шиг сүнслэгээр нөлөөлөгдөж болох юм.

Ууган хүү маань дикон, Ийгл Скаут болох үед түүний болон түүний ирээдүйн тухай бодоход бүргэдийн зураг миний санаанд орж билээ. Бид Айдаход Өмнөд Тетон уулын бэлд амьдарч байхдаа ууланд явган явж, бүргэдүүд тэнгэрт элин халин нисэхийг хардаг байлаа. Энэ зураг Исаиагийн дараах үгсийг надад санагдуулж билээ:

“Тэр ядарсанд тэнхээ өгч, чадал дутагдсанд нь хүч нэмдэг.

“Залуу хүн ч ядарч сульданд идэр хөвгүүд ч бүдэрдэг:

“Харин Эзэнд найдагчдын хүч нь шинэчлэгдэнэ. Тэд бүргэд мэт жигүүр дээрээ элин халина. Тэд гүйхдээ үл ядран, алхахдаа үл цуцна.”<sup>1</sup>

Хүү минь ядарч цуцсанаас бид Өмнөд Тетон уулын оргилын доошно талд явган аяллаа өндөрлөсөн юм. Тэрээр зогсохыг хүссэн бөгөөд “Бид уулын оргил дээр гарч чадаагүйнхээ төлөө би үргэлж харамсах болж байна уу? Аав аа, та дээшээ яв. Би таны урмыг хугалахыг хүсэхгүй байна” гэж хэлэхэд нь,

“Би хэзээ ч урам хугарахгүй, чамд ч харамсах юм огт байхгүй. Бид уулын оргилд хамт гарснаа үргэлж дурсан санах болно” гэж би хариулж билээ. Тэгээд би хүүгийнхээ өндрийн хэмжээг заасан самбарын дээд талд бүргэд сийлж, “Бүргэдийн далавчин дээр” гэсэн бичээс үйлдэж билээ.

Хэдэн жилийн дараа, номлогчийн хувьд хүү минь миний хамгийн их найдаж, төсөөлж байснаас илүү өндөрт элин халин ниссэн юм. Номлолын талбарт тохиолдсон зарим сорилт бэрхшээлийг даван туулах нь түүнд ахадсан мэт санагдаж байсан. Таны тусалж дэмждэг залуу хүнд миний хүүд тохиолдсонтой адил зүйл тохиолдож болно. Миний бодлоор огт боломжгүй мэт санагдаж байсан хэцүү гадаад хэлээр сайн мэдээг номлоход Их Эзэн хүүг минь өндөрт өргөн дэмжсэн юм. Хэрэв та хэн нэгэн хөвгүүнд санваарын боломжуудыг нь мэдрүүлэхийг хичээх юм бол Их Эзэн хэрэгтэй зүйлийг чинь хэлж өгөх болно гэдгийг би танд амлаж байна. Их Эзэн танд илчилсэн зүйлээс тэр хөвгүүн илүү чадавхитай байж болно. Өндөр зорилго тавьж түүндээ хүрэхэд нь түүнд тусал.

Таны дэмжиж тусалдаг хөвгүүн бат бөх итгэлтэй санваартан үйлчлэгч болоход хэтэрхий бүрэг юм шиг санагдаж магадгүй. Манай хөвгүүдийн бас нэг нь бага байхдаа дэлгүүрт ороод худалдагчтай хэд гурван үг сольж чаддаггүй ичимхий бүрэг хүүхэд байсан. Тэр хэтэрхий аймхай, бүрэг байсан болохоор би түүний ирээдүйн санваартны амьдралынх нь талаар санаа зовж, залбирдаг байлаа. Түүнийг номлолын талбарт байгаагаар бодож үзэв, тийм ч найдвар төрөм санагдаагүй. “Хэн ч мөрдөж мөшгөөгүй байхад хар санаатан

зугтдаг бол зөв шударга хүн арслан мэт зоригтой”<sup>2</sup> гэсэн Сургаалт Үгс дэх судар руу би хөтлөгдсөн юм.

Би түүний самбар дээр архирч байгаа арслангийн толгойн дүрсний доод талд “Арслан мэт зоригтой” гэдэг үгийг сийлсэн юм. Тэр хүү минь номлолд үйлчилсэн үедээ бас дараагийн жилүүдэд нь энэхүү сийлбэрээр илэрхийлсэн миний найдварыг биелүүлсэн юм. Нэгэнтээ бүрэг ичимхий байсан миний хүү агуу итгэл үнэмшилтэйгээр сайн мэдээг зааж, аюул ослыг зоригоор даван туулсан юм. Их Эзэнийг төлөөлөх үүрэг хариуцлагаа тэр нэр төртэй биелүүлсэн билээ.

Таны удирддаг залуу эрэгтэйд ийм зүйл тохиолдож болно. Хэрэв та түүнд итгэлийг нь төлөвшүүлбэл одоо таны харж байгаа бүрэг хөвгүүнийг Их Эзэн зоригтой үйлчлэгч болгон өөрчлөх болно.

Их Эзэн Өөрийн үйлчлэгчдийг зоригжуулдгийг бид мэднэ. Бурхан Эцэг, Түүний Хүү Есүс Христ хоёрыг ойн цоорхойд харсан залуу хөвгүүн Иосеф сүнслэг байдлын хувьд агуу нэгэн болон өөрчлөгдсөн шүү дээ. Бошиглогч Иосеф Смит шоронгийн бүдүүлэг харгалзагчдыг хэрхэн зэмлэн дуугүй болгосныг Парли П.Пратт харсан юм. Ахлагч Пратт ийн бичжээ:

“Тэр гэнэт босч ирээд, аянгын нүргэлээн мэт дуугаар эсвээс хүрхрэх арслан лугаа адил ойролцоогоор миний санаж байгаагаар дараах үгсийг хэлэв:

*“ЧИМЭЭГҮЙ БАЙЦГАА, тамын шулмасууд аа. Би та нарыг Есүс Христийн нэрээр зэмлэн, дуугүй болохыг зарлиглаж байна; Та нарын заваан үг яриаг би дахиад ганц ч минут сонсож тэсэхгүй нь. Заваан яриагаа орхи, үгүй бол та нар эсвэл би НҮД ИРМЭХИЙН ЗУУР үхнэ шүү!”*

Ахлагч Пратт энэ явдлын тухай, “Хэний ч үл мэдэх Миссурийн нэгэн тосгон дахь гянданд шөнө дунд энэхүү сүрдэн биширмээр агуу үйл явдлыг зөвхөн би л харсан юм”<sup>3</sup> хэмээн бичжээ.

Их Эзэн Өөрийнх нь зөв шударга үйлчлэгчид Түүний нэрээр ярьж, Түүний санваараар гэрчилсэн үед тэдэнд арслан мэт зоригтой байх боломжийг олгох болно.

Өөр нэгэн хүү маань бүр хөвгүүн байхдаа маш олон найзтай болсон байлаа. Найз нар нь түүнтэй хамт байхыг

байнга хичээнэ. Тэр хүмүүстэй тун амархан найз нөхөд болдог байлаа. Тэр хүү минь Бурханы хаант улсад ямар хувь нэмэр оруулж чадахыг мэдэх гэж залбирч мөн хичээсний үр дүнд хүмүүсийг хайр, эв нэгдлээр холбон нэгтгэх чадвар түүнд байгааг би мэдэрсэн.

Энэ нь намайг Миссурид Сионыг байгуулах санваартнуудын хүч чармайлтыг дүрсэлсэн Сургаал ба Гэрээн дэх нэг түүх рүү хөтөлсөн бөгөөд уг түүхэнд тэдний хичээл зүтгэл, хувь нэмрийг тэнгэр элчүүд харж, магтсан тухай өгүүлдэг билээ. Энэ нь агуу золиослолыг шаардсан билээ. Сургаал ба Гэрээн дэх илчлэлтэд “Гэсэн хэдий ч, адислагдсан болой та нар, учир нь та нарын гэрчилсэн гэрчлэл тэнгэр элчүүд харж байхын тулд тэнгэрт цэдэглэгддэг болой, мөн тэд та нарт баясдаг бөлгөө, мөн нүглүүд тань өршөөгдсөн болой та нарт”<sup>4</sup> хэмээн өгүүлсэн байдаг.

Хүүгийнхээ нурууны өндрийг тэмдэглэсэн самбар дээр “Тэнгэр элчүүд чамд баярлана” гэсэн үгсийг би сийлэв.

Энэ хүүгийн минь хүмүүсийг цуглуулж, тэдэнд нөлөөлөх чадвар нь сургуулиа төгссөний дараа үргэлжилсэн юм. Тэр санваартан нөхдийнхөө хамт өөрийн бүс дэх залуучуудад хүнд нөхцөл байдлыг тэвчээрээр даван туулж, ялалт байгуулах итгэлийг өгсөн гадасны үйл ажиллагаануудыг зохион байгуулсан билээ. Тэрээр эдгээр залуу эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдэд итгэлийг төлөвшүүлснээрээ Америкийн алслагдсан хөдөө нутгуудад Сионыг байгуулахад тусалсан юм. Хүүгийнхээ самбар дахь сийлбэрт бүрээ үлээж байгаа тэнгэр элчүүдийг сийлсэн нь хэрэг дээрээ тэд бүрээгээ хэрхэн үлээдгийг яг дуурайлгаж чадаагүй байх, үнэндээ бүрээг сийлсэн нь үлээхээс амархан байсан.

Дэлхий даяарх санваартны удирдагчид өөрсдийн тойрог, гадас, номлолуудад Сионыг байгуулж байгааг тэнгэр элчүүд хараад баярлана. Мөн амьдарч байгаа газартаа, ямар ч нөхцөл байдлыг үл харгалзан Сионыг байгуулахад таны тусалж байгаа залуу эрэгтэйчүүд, залуу эмэгтэйчүүдэд тэнгэр элчүүд баярлах болно. Сион бол гэрээ ба хайраар холбогдсон хүмүүс юм. Сионд нэгдэхэд нь залуучууддаа туслахыг би та бүхнээс урьж байна.

Хөвгүүдийнхээ нэгэнд нь зориулж би самбарт нь огторгуй дахь нар болон бусдын төлөө хийсэн Аврагчийн залбирлаас авсан: “Энэ бол мөнх амьдрал” гэсэн үгсийг сийлсэн. Аврагч мөнх бус үйлчлэлийнх нь төгсгөл ойртсон үед Эцэгтээ хандаж ийн залбирсан билээ:

“Цорын ганц үнэн Бурхан Таныг болон Таны илгээсэн Есүс Христийг мэдэх нь мөнхийн амь мөн.

“Хий гэж надад өгсөн ажлыг тань гүйцэтгэн Би Таныг газар дээр алдаршуулав.”<sup>5</sup>

Миний хүү санваарын үйлчлэлийг гурван тивд хийсэн ч хамгийн чухал нь гэртээ, гэр бүлийнхээ дотор хийсэн түүний үйлчлэл юм. Тэр амьдралаа гэрийнхнийхээ дунд өнгөрүүлдэг. Гэртээ ойрхон ажил хийдэг. Эхнэр хүүхдүүдтэйгээ хамт хооллохоор үдийн цайны цагаар гэртээ ирдэг. Хүү минь гэр бүлийнхээ хамт Айринг өгч бид хоёртой маш ойрхон амьдардаг. Тэд манай цэцэрлэгийг арчилдаг. Уг нь энэ цэцэрлэг тэднийх юм л даа. Манай энэ хүү зөвхөн мөнх амьдралд тэнцэхээр амьдардаг төдийгүй, өөрийг нь хүрээлэн буй гэр бүлийнхээ гишүүдийн хайр талархлаар мөнхөд хүрээлүүлсэн хүн юм.

Мөнх амьдрал бол гэр бүлтэйгээ, Эцэг, Хүү, Ариун Сүнс гуравтай үүрд нэгдэн нийлж амьдрах явдал мөн. Мөнх амьдрал нь Бошиглогч Иосеф Смитээр дамжин сэргээгдсэн Бурханы санваарын түлхүүрүүдийг ашигласнаар боломжтой болдог. Удирддаг залуусаа мөнх амьдралын зорилготой байж, уг зорилгоо биелүүлэхийн төлөө хичээн чармайдаг байхыг урамшуулан дэмжих нь тэдэнд таны өгч чадах нэг агуу бэлэг юм. Та гэр бүлдээ үзүүлдэг үлгэр жишээгээрээ энэхүү бэлгийг үндсэндээ өгч чадна. Таны удирддаг хүмүүс Сүмд гэр бүлгүй байж болно. Гэвч хөшигний хоёр талд гэр бүлийн хайрыг мэдрэхэд мөн тэр хайрыг хүсэх хүсэлтэй байхад нь тэдэнд туслах үүргийг би та нарт өгч байна.

Миний дүрсэлсэн өндрийн самбар нь залуучуудад Бурханы соёрхсон агуу чадавхийг болон тэдэнд болон тэдний ирээдүйд зориулан Түүний бэлтгэсэн үйлчлэлийн боломжуудыг олж харахад тэдэнд туслах арга замуудын зөвхөн нэг нь юм. Үүнийг хүүхдүүдээ болон таны удирддаг бусад залууст зориулж хэрхэн хийхийг мэдэхэд чинь Бурхан

танд туслах болно. Гэвч та өөрөө залбирч энэхүү ирээдүйн тухай ойлголттой болж, үүнийгээ залуу хүн тус бүр дээр ганцаарчлан хэрэгжүүлбэл, Бурхан Өөрийн хүүхэд нэг бүрийг хайрлаж, тэдний хүн бүрээс агуу бэлгүүдийг олж хардгийг та мэдэх болно.

Би эцэг хүний хувьд хөвгүүдийн нэгэн адил охид маань ч Бурханы хаант улсад агуу ирээдүйтэй болохыг олж харахаар адислагдсан юм. Би удирдамж эрэлхийлж залбирснаар охид маань Бурханы хаант улсыг байгуулахад тусалж чадах үйлчлэгчдэд байх ёстой итгэл тэдэнд байгааг харж, Бурхан итгэх итгэлийг нь хүчтэй болгоход туслах арга замыг олж харсан билээ.

Би охидоо бага байхад олон үеийнхнээсээ нас барсан хүмүүсийг хайрлах хайрыг мэдрэхэд нь бид бусдад тусалж чадна гэдгийг ойлгосон. Энэхүү хайр нь үйлчлэлээс ирдэг бөгөөд мөнх амьдралын найдварт сүнслэгээр нөлөөлдгийг би мэдсэн юм.

Тиймээс бид талхны сав сийлж, гэртээ барьсан бүтэн талхыг савандаа хийж, бэлэвсэн эмэгтэй, эрэгтэйчүүд гэр бүлүүдэд өгөхөөр хамт гардаг байлаа. Талхны саван дээрээ, “Ж’эйме ет Ж’еспере” гэж бичсэн нь францаар “Би хайртай бас би итгэж найддаг” гэсэн утгатай юм. Охидын маань хосгүй өвөрмөц сүнсний бэлэг зөвхөн миний сийлбэрлэсэн талхны саваар илэрдэг байсан төдийгүй бид тусламж хэрэгтэй хүмүүс, зовж зүдрэгсдэд барьсан талхаа хүргэж өгдөг байсан нь Аврагчийн хайр болон Түүний Цагаатгал хүмүүст найдварын төгс гэрлийг бий болгодгийн нотолгоо болдог байлаа. Энэ бол миний охидын хувьд бас бид бүгдийн хувьд мөнх амьдрал юм.

Одоо та нар, “Айринг ах аа, та намайг модоор хэрхэн сийлбэр хийхийг сурах ёстой гэж байгаа юм уу?” гэж бодож байж магадгүй. Тэгвэл үгүй шүү. Би тэр үед эелдэг уриалгахан, авьяаслаг багш байсан Ахлагч Боид К.Пакерын тусламжтайгаар модоор сийлбэр хийж сурсан юм. Түүний сийлбэрчийн агуу бэлэг, багшийн тэвчээртэй, шаргуу чанартай харьцуулахад миний ур чадвар өчүүхэн юм. Зөвхөн тэнгэр л Ерөнхийлөгч Пакер шиг багшаар хангаж чадна. Гэвч хүүхдүүддээ зориулж модоор сийлбэр хийхгүйгээр тэдний зүрх сэтгэлд нөлөөлөх олон арга зам танд бий.

Жишээ нь, бие биенээсээ хэдэн зуун километрээр алслагдсан бидэнд холбоо мэдээллийн шинэ технологи итгэл найдварын захиасыг бага зардлаар эсвэл үнэгүйгээр байнга хуваалцах боломжийг олгож байна. Ийнхүү захиас хуваалцахад эхнэр минь надад тусалдаг. Бид утсаар ярихаас эхэлдэг бөгөөд холбогдох боломжтой байгаа ач, зээ нар эсвэл хүүхдүүдтэйгээ холбогдож, ажил, хичээл сургуульдаа ямар амжилт олж байгаа ямар үйлчлэл хийсэн талаар нь асууж ярилцдаг. Бас тэднээс тэдгээр үйл явдлуудын гэрэл зургийг бидэн рүү явуулахыг хүсдэг. Тэдгээр гэрэл зургуудад хэдэн догол мөр тайлбар хийж, Мормоны Номын нэг юмуу хоёр шүлэг нэмдэг. “Гэр бүлийн тэмдэглэл: Бага ялтсууд” хэмээн бидний нэрлэсэн тэмдэглэлийн сүнслэг чанар болон бидний хязгаарлагдмал хүч чармайлтад Нифай, Мормон хоёр тийм ч сэтгэл хангалуун байхгүй байж болох юм. Гэвч Айринг эгч бид хоёр энэхүү хүч чармайлтаараа адислагдсан юм. Бид сонгож авсан судрын хэсгүүд болон бичсэн товчхон гэрчлэлийн захиаснаасаа сүнслэг нөлөөг мэдэрдэг. Бид мөн тэднийхээ амьдралаас тэдний зүрх сэтгэл бидэн рүү болон Аврагч руу мөн дээш эргэж байгаагийн нотолгоог олж хардаг.

Бусдад нөлөөлөх өөр олон арга зам бий. Тэдгээрээс заримыг нь та нар аль хэдийнээс ашиглаж байгаа. Гэр бүлийн залбирал хийж, судар судалж хэвших нь ой тойнд хоногшин үлдэх дурсамжуудыг бий болгож, зүрх сэтгэлийн агуу өөрчлөлтөд хүргэх болно. Спортын уралдаан тэмцээн, кино үзэх зэрэг гадна талаас нь харахад дэлхийн шинжтэй үйл ажиллагаанууд ч гэсэн хүүхдийн зүрх сэтгэлд нөлөөлнө. Үйл ажиллагаа ямар байх нь чухал биш харин түүнээс ирдэг

мэдрэмж чухал юм. Нэг залуугийн амьдралд агуу өөрчлөлт гаргаж чадах үйл ажиллагаануудыг тодорхойлох нэгэн сайн сорилгыг би нээж олсон юм. Хүний сонирхолд тулгуурласан үйл ажиллагааны үр дүн нь Бурханы бэлэг болж ирдэг хэмээн хүмүүс зөвлөдөг. Энэ нь үнэн байж болохыг би хувийн туршлагаасаа мэднэ.

Би 12-тойдоо дикон болохдоо Нью-Йорк хотоос 80 км хол орших Нью Жерсид амьдарч байв. Бейсболлын мундаг тоглогч болохыг мөрөөддөг байлаа. Аав маань Бронкс дахь түүхэт хуучин Яанкий Цэнгэлдэх Хүрээлэнд болдог тоглолтыг үзэхээр намайг дагуулж явлаа. Жөү ДиМаггио цохиураа далайн цохьтол бөмбөг аав бид хоёрын сууж байсан талбайн төвийг чиглэн талбайн гадна гарсан нь одоо ч миний нүдэнд харагдах шиг болдог. Аав бид хоёр Нэгдсэн Улсын топ лигийн бейсболлын тоглолтыг ердөө ганцхан удаа хамт үзсэн нь тэр байлаа.

Гэтэл дараа нь нэг өдөр би аавтай хамт өөрийн амьдралыг эгнэгт өөрчилсөн юм. Аав намайг НьюЖерсигээс Солт Лейк хот дахь нэгэн томилогдсон патриархын гэрт дагуулан очлоо. Би тэр хүнийг өмнө нь огт харж байгаагүй. Аав намайг үүдний довжоон дээр орхичихоод яваад өглөө. Патриарх намайг сандал дээр суулгаад, гараа толгой дээр минь тавьж, миний зүрх сэтгэл дэх агуу хүслийн илэрхийллийг багтаасан, Бурханаас ирсэн бэлэг болох адислалыг өгсөн юм.

“Энхийг тогтоогчид адислагдсан болой”<sup>6</sup> хэмээх үгсийг хэлүүлдэг тэдгээр хүмүүсийн нэг нь би мөн гэдгийг патриарх хэлж билээ. Огт танихгүй хүн миний зүрх сэтгэлийг яаж мэддэг юм бол доо гэж би гайхаад нүдээ нээж, ийм гайхамшиг тохиосон өрөөг тойруулан харлаа. Надад тохиох боломжуудын тухай энэхүү адислал миний амьдрал, гэрлэлт, санваарын үйлчлэлд нөлөөлсөн юм.

Би энэ туршлагаасаа болон түүний дараа тохиолдсон зүйлсээс үндэслэн, “Учир нь хүн бүрд бэлэг бүхэн өгөгддөггүй; учир нь олон бэлэг байдаг, мөн хүн болгонд Бурханы Сүнсээр бэлэг өгөгддөгийг”<sup>7</sup> гэрчилж чадна.

Их Эзэний надад илчилсэн бэлгээр би хайрлаж, үйлчилдэг хүмүүсээ адислах боломжуудыг эрж олон, бэлтгэж чадсан юм.



Бурхан бидний бэлгүүдийг мэддэг. Бидэнд өгөгдсөн бэлгүүдийг мэдэхийн тулд, эдгээр бэлгүүдийг хэрхэн хөгжүүлэхийг мэдэхийн тулд, Бурханаас бидэнд олгосон бусдад үйлчлэх боломжуудыг танин мэдэхийн тулд залбирч байхыг би на нарт болон өөртөө даалгаж байна. Гэвч юуны өмнө, Бурханы өгсөн үйлчлэх онцгой бэлгүүдээ танихад нь бусдад туслахын тулд та бүхэн сүнслэгээр нөлөөлөгддөг байхын төлөө би залбирч байна.

Хэрэв та нар залбирч гуйвал өөрийн удирддаг бөгөөд хайрладаг хүмүүсийг үйлчлэх бүрэн хүч чадалд нь хүртэл тусалж, өргөн дэмжих чадвараар адислагдах болно. Бурхан амьд, Есүс бол Христ, бид Бурханы санваарыг атгадаг бөгөөд бидний зүрхэн дэх найдвараас гадна Түүнд үйлчлэх онцгой бэлгүүдийг Бурхан бидэнд бэлтгэсэн байгаа гэдгийг би та бүхэнд гэрчилж байна. Есүс Христийн нэрээр, амен.

#### Эшлэл

- |   |                            |
|---|----------------------------|
| 1. Исаиа 40:29–31.  | 4. Сургаал ба Гэрээ 62:3.  |
| 2. Сургаалт Үгс 28:1.   | 5. Иохан 17:3–4.           |
| 3. Парли П.Праттын намтар, хянан тохиолдуулсан Бага Парли П.Пратт, (1938), 211. | 6. Матай 5:9               |
|   | 7. Сургаал ба Гэрээ 46:11. |

# Бусдыг ирээдүйд ямар хүмүүс болсон байхаар нь харж сур

Ерөнхийлөгч Томас С.Монсон

---

*Бид хүмүүсийг одоо ямар байгаагаар нь биш харин ямар хүн болж чадахаар харж сурах хэрэгтэй.*

---

Хайрт ах нар аа, Чуулганы энэхүү үзэсгэлэнт төвд сүнслэг нөлөө бүхий захиасуудыг сонсохоор Бурханы санваартнууд жилд хоёр удаа цугладаг билээ. Сүмийн санваартнуудын ерөнхий хуралдаан үргэлж гайхалтай уур амьсгалд болж өнгөрдөг бөгөөд энэхүү сүнслэг мэдрэмж Чуулганы Төвөөс Бурханы хөвгүүд цугласан газар бүрд тархан хүрдэг билээ. Өнөө орой ч бидэнтэй ийм сүнс хамт байлаа.

Чуулганы энэхүү үзэсгэлэнт төв баригдахаас олон жилийн өмнө Солт Лейк хот дахь Ариун Сүмийн Талбайг үзсэн нэг зочин Табернеклд болсон ерөнхий чуулганы хуралдаанд оролцож, Ах нарын захиасыг сонсчээ. Тэр залбирлуудыг болон Табернеклын Найрал дууны гайхамшигтай дуу хөгжмийг их анхааралтай сонссон гэнэ. Тэр хүн бас Табернеклын гайхамшигт бадралт баг бишгүүр хөгжмийг бахархан биширсэн ажээ. Хуралдаан дууссаны дараа түүнийг “Хэрэв өнөөдрийн үг хэлэгчдийн ярьсан зүйл үнэн гэдгийг би мэдэх юм бол эзэмшиж байгаа бүхнээ өгөхөд бэлэн байна” гэж хэлэхийг нь өөр нэг хүн сонсжээ. Чухамдаа бол тэрээр “Би сайн мэдээний тухай гэрчлэлтэй болохыг хүсч байна” гэсэн ажээ.

Үнэний тухай гэрчлэлээс өөр юу ч энэ дэлхийд тайтгарал, аз жаргалыг бий болгож чадахгүй. Өнөө орой энд цуглаад

байгаа хүн бүр хэдийгээр бат бөх байдлаараа өөр өөр ч гэсэн, гэрчлэлтэй байгаа гэдэгт би итгэж байна. Хэрэв өөрийн чинь хүсдэг шиг чинь тийм хүчтэй гэрчлэл өөрт чинь хараахан байхгүй гэж боддог бол, ийм гэрчлэлтэй болохын төлөө ажилла хэмээн би та нарт зөвлөж байна. Итгэл тань хүчтэй бат бөх бол үүнийгээ хадгалахын тулд ажиллагтун. Үнэний мэдлэг бидэнд байгаа болохоор бид агуу ихээр адислагдсан хүмүүс юм.

Ах нар аа, эдүгээ багаахан итгэлтэй эсвээс огт итгэлгүй үй түмэн хүмүүс байна. Хэрэв бид тэдэнтэй гэрчлэлээ хуваалцаж, өөрчлөгдөхөд нь тэдэнд туслах талаар хүч чармайлт гаргавал тэд бат бөх гэрчлэлтэй болж чадна гэдгийг би өнөө орой та нарт хандаж хэлэх гэсэн юм. Энэ бол миний захиас. Зарим тохиолдолд *бид* хүмүүсийн зүрх сэтгэлийг өөрчлөхөд урам дэм өгч чадна. Би сайн мэдээнд бүрэн дүүрэн итгэлтэй болж хараахан амжаагүй байгаа гишүүдийн талаар эхлээд ярья.

Олон жилийн өмнө Финляндын Хельсинкэд болсон бүсийн чуулганы ээж нар болон охидуудын хуралдаан дээр би нэгэн гайхалтай, сэтгэлд хоногшин үлдсэн, сүнслэг үгийг сонсож билээ. Түүнээс хойш бараг 40 жил өнгөрсөн ч би тэр захиасыг огт мартдаггүй. Үг хэлэгч тэр эмэгтэй олон үнэний тухай ярьсан. Тэрээр бас бусад хүмүүс эмэгтэй хүнд хандаж өөрт нь тэр бол сайхан, нүдэнд дулаахан эмэгтэй, нийгэмд үнэ цэнэтэй хүн гэж хэлж байх хэрэгтэй гэж хэлж билээ.

Ах нар аа, эрчүүд энэ талаараа эмэгтэйчүүдтэй их адилхан гэдгийг би мэднэ. Эрэгтэйчүүд ч бас нийгэмд үнэ цэнэтэй, чадварлаг, чухал хүмүүс хэмээн хэлүүлэх хэрэгтэй байдаг. Эрэгтэйчүүд бидэнд үйлчлэх боломж олгох хэрэгтэй. Идэвхгүй болоод дахин идэвхтэй болох талаараа эргэлзэж байгаа гишүүдэд туслах арга замыг бид залбирч эрэлхийлэх ёстой. Боломжтой үйлчлэл хийхийг тэднээс хүсэх нь дахин идэвхтэй болоход нь тэдэнд хэрэгтэй хөшүүрэг байж болно. Гэвч энэ талаар тусалж чадах удирдагчид заримдаа ийнхүү туслахад дурамжхан байдаг. Хүмүүс өөрчлөгдөж чадна гэдгийг бид байнга санаж явах хэрэгтэй. Тэд гэм нүглээ наманчилж чадна. Тэд санваараа зохистойгоор авч явж, Их Эзэнд хичээнгүйлэн үйлчилж чадна. Би хэдэн жишээ дурдъя.

Би анх Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн болоод Ерөнхийлөгч Давид О,МкКейн зөвлөх, Ерөнхийлөгч Н. Элдон Таннерыг Канадын Альбертад болсон нэг гадасны чуулганд дагалдан явсан юм. Хуралдааны үеэр гадасны ерөнхийлөгч ахлагчаар томилогдох шаардлага хангасан дөрвөн ахын нэрийг уншлаа. Эдгээр эрчүүд Ерөнхийлөгч Таннерын таньдаг хүмүүс байв. Учир нь тэр энэ нутагт нэг хэсэг амьдарч байсан ажээ. Гэвч Ерөнхийлөгч Таннер тэднийг урьд нь ямар байсныг санаж байсан ч, харин тэдний амьдрал өөрчлөгдөж, ахлагч болох шаардлагыг бүрэн хангасан гэдгийг нь мэдээгүй байжээ.

Гадасны ерөнхийлөгч эхний хүний нэрийг хэлээд түүнийг босно уу гэв. Ерөнхийлөгч Таннер “Түүнийг хар л даа. Би түүнийг ингэж өөрчлөгдөнө гэж хэзээ ч бодоогүй” гэж надад шивнэн хэллээ. Гадасны ерөнхийлөгч хоёр дахь хүний нэрийг дуудахад тэр хүн бослоо. Ерөнхийлөгч Таннер намайг аяархан ёворч, мөн л гайхсанаа илэрхийлэв. Энэ нь дөрвөн ах дээр бүгд дээр давтагдлаа.

Хуралдааны дараа эдгээр дөрвөн ахад баяр хүргэх завшаан Ерөнхийлөгч Таннер бид хоёрт олдсон билээ. Хүмүүс өөрчлөгдөж чадна гэдгийг тэд үнэхээр харуулсан юм.

1940, 50-иад оны үед Америкийн шоронгийн харгалзагч Клинтон Даффи шоронгийнхоо хоригдлуудыг ердийн амьдралд дасгах хүч чармайлгаараа нэрд гарч байлаа. Түүний санаачлагыг шүүмжлэгч нэгэн, “Ирвэс толбоо арилгаж чаддаггүй гэдгийг та мэддэг байлгүй дээ” гэхэд

харгалзагч Даффи, “Би ирвэснүүдтэй ажилладаггүй. Би хүмүүстэй ажилладаг, хүмүүс өдөр бүр өөрчлөгддөг гэдгийг та мэдвэл зохино”<sup>1</sup> гэж хариулсан гэдэг.

Олон жилийн тэртээ Канадын Номлолд үйлчлэх завшаан надад тохиосон юм. Тэнд бид цөөхөн санваартантай нэг салбар байлаа. Уг салбарыг үргэлж номлогч нар удирддаг байв. Тэр үед надад гишүүд салбарыг тэргүүлэх ёстой гэсэн хүчтэй сэтгэгдэл төрсөн юм.

Манай салбарт насанд хүрсэн Аароны санваарын дикон байсан бөгөөд тэр санваараар шат ахихад тэнцэхээр биш, өөрөөр хэлбэл сүмд идэвхтэй биш байлаа. Би түүнийг салбарын ерөнхийлөгчөөр дуудахаар сүнсээр өдөөгдөв. Би

түүнтэй ярилцлага хийсэн өдрөө үргэлж санаж явах болно. Түүнийг салбарын ерөнхийлөгчөөр дууд гэж Их Эзэн надад сүнслэг удирдамж өглөө гэж би түүнд хэлэв. Тэр өөрөө их эсэргүүцсэн ч, эхнэр нь түүнийг ихэд урамшуулан дэмжсэн учир тэр салбарын ерөнхийлөгчөөр үйлчлэхээр болов. Би түүнийг пристээр томилов.

Тэр өдөр түүний хувьд шинэ амьдралынх нь эхлэл байлаа. Түүний амьдрал түргэн цэгцэрч, зарлигуудыг хэрхэн сахиж амьдрах ёстой тийм л байдлаар амьдрах болно хэмээн тэрээр надад ам өгөв. Тэр хэдхэн сарын дараа ахлагчаар томилогдсон. Тэр сүүлдээ эхнэр болон гэр бүлийнхээ хамт ариун сүмд явж, лацдан холбуулсан. Хожим нь тэдний хүүхдүүд номлолд үйлчилж, Их Эзэний өргөөнд гэрлэцгээсэн.

Зарим үед ах нарт тэд бол үнэ цэнэтэй, чухал хүмүүс гэдгийг ойлгуулах нь өөрийгөө өөрчилж, бүрэн идэвхтэй болоход нь тэдэнд тусалдаг. Энэ нь ямар ч насны санваартнуудын хувьд адил юм. Амьдралаа өнгөтэй өөдтэй авч явахад нь тэдэнд туслах нь бидний үүрэг юм. Бид дутагдлаа засахад нь тэдэнд тусалж чадна. Бид хүмүүсийг одоо ямар байгаагаар нь биш харин Христийн сайн мэдээний тухай гэрчлэлтэй болсны дараа ямар болсон байхаар нь харах чадварыг өөртөө хөгжүүлэх ёстой.

Нэг удаа би Колорадогийн Ледвиллд цуглаанд оролцож байлаа. Ледвилл бол далайн түвшнээс дээш 3,000 метрт оршдог газар. Би тэрхүү онцгой цуглааныг далайн түвшнээс дээш их өндөрт болсон учраас бус харин тэр орой болсон нэг зүйлийн улмаас санаж явдаг юм. Цуглаанд хэдхэн санваартан байлаа. Канадын Номлолын нөгөөх салбар шиг энэ салбарыг мөн л үргэлж номлогч нар удирддаг байжээ.

Тэр оройн цуглаан сайхан болсон ч биднийг хаалтын дуу дуулж байхад салбарыг орон нутгийн ерөнхийлөгч тэргүүлэх ёстой гэсэн сүнсний өдөөлт надад ирэв. Тэгээд би номлолын ерөнхийлөгчид хандаж, “Салбарыг тэргүүлж чадах нутгийн хүн байхгүй юү?” гэж асуулаа.

“Тийм хүнийг би мэдэхгүй” гэж тэр хариулав.

Хаалтын дуу дуулж байх үеэр эхний гурван эгнээнд сууж байсан эрэгтэйчүүдийг сайн ажиглахад миний анхаарал

тэдгээр ах нарын нэгэн дээр нь тогтов. “Тэр хүн салбарын ерөнхийлөгчөөр үйлчилж чадах юм биш үү?”

“Би мэдэхгүй байна. Магадгүй л юм” гэж номлолын ерөнхийлөгч хариулав.

“Ерөнхийлөгч өө, би өөр өрөөнд орж түүнтэй ярилцъя. Биднийг эргэж иртэл та ярьж бай” гэж би хэллээ.

Бид хоёрыг өрөөнд эргэж ирэхэд номлолын ерөнхийлөгч гэрчлэлээ хэлж дуусч байлаа. Би тэр ахын нэрийг салбарын шинэ ерөнхийлөгч хэмээн танилцууллаа. Тэр өдрөөс хойш Колорадогийн Ледвилл салбарыг нутгийн гишүүн тэргүүлэх болсон юм.

Ах нар аа, бид энэ зарчмыг хараахан гишүүн болоогүй хүмүүст ч хэрэглэж болно. Бид хүмүүсийг одоо ямар байгаагаар нь биш, харин тэднийг Сүмийн гишүүн болж, Христийн сайн мэдээний тухай гэрчлэлтэй болсны дараа тэдний амьдрал сайн мэдээний сургаалуудад нийцсэн байхаар нь харах чадварыг өөртөө хөгжүүлэх ёстой.

Тэртээ 1961 онд номлолын ерөнхийлөгч нарын дэлхий дахины чуулган болоход Сүмийн бүх номлолын ерөнхийлөгчдийг Солт Лейк хотод ирүүлсэн юм. Би Канадын Торонто дахь номлолоосоо Солт Лейк хотод ирэв.

Тэр үед Арванхоёрын Чуулгын туслахуудын нэг байсан Н.Элдон Таннер ах Их Британи болон баруун Европ дахь номлолуудыг тэргүүлж, туршлагатай болсныхоо дараа дөнгөж ирээд байсан юм. Тэрээр хамгийн шилдэг нэг номлогчийн тухай ярьсан юм. Тэр нөгөөх номлогчтой ярилцаж байгаад, “Баптисм хүртээж Сүмд авчирсан бүх хүмүүсийг танд гишүүд зааж өгсөн гэж би бодож байна” гэхэд,

залуу номлогч, “Үгүй, бид тэднийг бүгдийг нь Сүмийн материалууд тарааж айлуудаар явж байгаад олсон юм” хэмээн хариулсан гэдэг.

Бусад номлогчдын олж чадаагүй тийм гарамгай амжилтыг олсны шалтгаан юунд байв? гэдгийг мөн түүний арга барил бусдынхаас ямар ялгаатай болохыг Таннер ах түүнээс асуусан ажээ. Залуу номлогч өөрийнхөө танилцсан болгонд баптисм хүртээхийг хичээдэг гэж хэлжээ. Номлогч залуу хаалга тогшоод тамхи татаж байгаа, хуучин хувцастай, тэр тусмаа шүтлэг бишрэлийг сонирхдоггүй гэмээр хүнийг харах юм бол,

тэр хүн өөр нөхцөл байдалд ямархуу байдалтай харагдах бол гэдгийг оюун санаандаа зураглан төсөөлөхийг хичээдэг хэмээн ярьжээ. Тэрээр нөгөөх хүнийг сахлаа хуссан, цэвэрхэн цагаан цамц, цагаан өмд өмссөнийг харин өөрөө түүнийг баптисмын ус руу дагуулан орж байгаагаар дотроо төсөөлөн бодог гэнэ. “Би хүнийг тийм байдлаар төсөөлөн харсан үедээ түүний зүрх сэтгэлд нөлөөлөх арга замаар гэрчлэлээ хуваалцах чадвартай болдог” гэж тэр номлогч ярьжээ.

Бид найз нөхөд, хамт ажилладаг хүмүүс, хөршүүдээ ийм байдлаар харах үүрэгтэй юм. Дахин хэлэхэд, бид хүмүүсийг одоо ямар байгаагаар нь биш, харин ямар болсон байхаар нь харах үүрэг хариуцлагатай юм. Бусдын тухай ийм байдлаар бодож байхыг би та нараас эрхэмлэн хүсч байна.

Ах нар аа, Их Эзэн та бидний эзэмшдэг санваар хэчнээн чухал болохыг бидэнд хандан удаа дараа ярьсан. Бид энэхүү санваарыг санваарын тангараг ба гэрээгээр хүлээн авдгийг Тэр бидэнд хэлсэн юм. Бид хүлээн авсан бүх зүйлдээ итгэлтэй байж, энэхүү гэрээгээ эцсийг хүртэл сахих үүрэгтэй гэдэг зааврыг Тэрбээр бидэнд өгсөн билээ. Тэгвэл Эцэгт байгаа бүхэн бидэнд өгөгдөх болно.<sup>2</sup>

Зориг--уруу таталтыг эсэргүүцэх зориг, уулзсан хүн бүхэн тань сайн мэдээний захиасыг сонсох боломжтой байх ёстой гэдгийг санан, бид тэдэнд гэрчлэлээ хэлэх зориг бол зүрхтэй байх ёстой. Бидний олонхид нь энэ тийм ч амар санагддаггүй. Гэвч бид Тимотод хэлсэн Паулын дараах үгсэд итгэж болно:

“Учир нь Бурхан бидэнд айдсын сүнсийг бус, харин хүч, хайр ба биеэ захирахын сүнсийг өгсөн.

“Тиймээс бидний Эзэний гэрчлэлээс бүү ич.”<sup>3</sup>

1974 оны 5-р сард би Жон Х.Гроберг ахтай хамт Тонгагийн арлууд руу очсон юм. Бид Тонгагийн хаантай уулзахаар цаг товлосон бөгөөд бидний уулзалт албан ёсны байдалд болж өнгөрсөн билээ. Бид харилцан найрсаг үг солилцсон. Гэвч биднийг уулзалтаас гарч явахын өмнө Жон Гроберг тогтсон журмаас гадуур нэг зүйл хэлж билээ. “Эрхэм Дээдэс Та болон таны харьяатууд жинхэнэ Мормончууд болох ёстой. Тэгвэл Таны асуудлууд бас танай харьяатуудын асуудлууд ихээхэн хэмжээгээр шийдвэрлэгдэх болно” хэмээн тэр хэлсэн юм.

Хаан яралзтал инээмсэглэн, “Жон Гроберг, таны зөв шүү” гэж хариулсан.

Агрыйп хааны өмнө Төлөөлөгч Паул ямар байдалтай байсныг бас Агрыйп Паулын гэрчлэлд: “Чи чинь намайг Христийнх болгох нээ”<sup>4</sup> хэмээн хариулсныг би тэр үед санаж билээ. Гроберг ах, хаанд гэрчлэлээ хэлэх зоригтой байсан юм.

Өнөө орой Түүний бүрэн цагийн номлогчид болон Их Эзэнд үйлчилж байгаа олон мянган санваартнууд цуглараад байна. Тэд номлолын дуудлагынхаа дагуу гэр орон, гэр бүл, найз нөхөд, сургуулиа орхиод үйлчлэхээр явцгааж байна. Үүнийг ойлгодоггүй хүмүүс: “Тэд яагаад энэ ажилд өдий төдий золиослол хийж, тийм дуртай явдаг юм бэ?” хэмээн асууж магадгүй юм.

Манай номлогчид эрт үеийн гарамгай номлогч Паулын адил: “Учир нь хэрэв би сайн мэдээг тунхаглавал, үүнд сайрхах юм надад юу ч алга. Учир нь би шахалтанд байдаг. Хэрэв би сайн мэдээг тунхаглахгүй бол, энэ нь надад зовлон болдог!”<sup>5</sup> хэмээн хариулах болно.

Амилсан Их Эзэн Галилд арваннэгэн Төлөөлөгч дээр хүрч ирэхдээ өгсөн хамгийн чухал сургаалууд, хамгийн чухал үүрэг хариуцлага, хамгийн шууд шулуун зарлигуудыг ариун судрууд агуулдаг билээ. Тэрбээр ингэж хэлсэн юм:

“Тэнгэр газар дээрх бүх эрх мэдлийг надад өгсөн.

“Иймээс явж, бүх үндэстнийг дагалдагч болгогтун. Эцэг, Хүү, Ариун Сүнсний нэрээр тэдэнд баптисм хүртээж,

“Миний та нарт тушаасан бүгдийг сахин биелүүлэхийг тэдэнд заа. Харагтун, дэлхийн төгсгөл хүртэл Би та нартай үргэлж хамт байх болно.”<sup>6</sup>

Энэхүү бурханлаг зарлиг агуу амлалттай нэгдэн өнөө үе буюу цагийн голчид бидний үйл ажиллагааны удирдамж болж байна. Номлолын ажил бол Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн ялгарах онцлог юм. Энэ нь үргэлж ийм байсан мөн үргэлж ийм байх болно. “Эцсийн эцэст бидний хамгийн агуу, хамгийн чухал үүрэг бол Сайн мэдээг номлох юм”<sup>7</sup> хэмээн Бошиглогч Иосеф Смит тунхагласан билээ.

Бурханы энэхүү агуу армид эдүгээ үйлчилж байгаа бүрэн цагийн бүх номлогчид хоёрхон жилийн хугацаанд бүрэн



цагийн хөдөлмөрөө дуусган, гэр орондоо, хайртай хүмүүстээ эргэж ирнэ. Тэдний халааг авах хүмүүс бол өнөө орой цугласан Сүмийн Аароны санваартнууд юм. Залуу эрэгтэйчүүд ээ, та нар номлолын дуудлагад хариулахад бэлэн байна уу? Та нар номлолын талбарт хөдөлмөрлөх хүсэлтэй байна уу? Та нар үйлчлэхэд бэлтгэгдсэн үү?

Ерөнхийлөгч Жон Тейлор номлолын ажилд тавигдах шаардлагуудыг дүгнэж хэлэхдээ: “Сайн мэдээний энэхүү захиасыг бусдад хүргэх хүмүүс Бурханд итгэх итгэлтэй, сүсэг бишрэлдээ чин үнэнч, санваартаа хүндэтгэлтэй ханддаг; . . . Ариун Сүнс болон Бурханы хүчээр дүүрэн[:]. . . шударга, зарчимч, ариун журамтай, цэвэр ариун ёс суртахуунтай байх ёстой”<sup>8</sup> гэжээ.

Ах нар аа, Христийн сайн мэдээг хуваалцах зарлигийг бидэнд өгсөн билээ. Бидний амьдрал Бурханы жишигтэй нийцэж байгаа үед бидний нөлөөнд байгаа хүмүүс: “Ургац хураалт дуусч, зун өнгөрлөө, бид аврагдаагүй байна”<sup>9</sup> хэмээн хэзээ ч гашуудахгүй.

Бодгалиудын төгс Хоньчин, бүх хүн төрөлхтнийг аварсан агуу номлогч Тэрбээр бидэнд дараах бурханлаг баталгааг өгсөн юм:

“Хэрэв та нар энэ хүмүүст наманчлалыг тунхаглахад өөрсдийн бүхий л өдрүүдэд хөдөлмөрлөж мөн зөвхөн нэг бодгалийг надад авчрах аваас, миний Эцэгийн хаант улсад түүнтэй хамт та нарын баяр баясгалан хэчнээн агуу байх билээ!

Мөн эдүгээ, хэрэв миний Эцэгийн хаант улсад надад авчирсан нэг бодгальтай хамт та нар агуу баяр баясгалантай байх аваас, хэрэв та нар олон бодгалийг надад авчрах юм бол та нарын баяр баясгалан хэчнээн агуу байх билээ!”<sup>10</sup>

Эдгээр үгсийг хэлсэн хүн бол Бурханы Хүү, бидний Гэтэлгэгч, бидний Аврагч гэдэг хувийн гэрчлэлээ тунхаглаж байна.

Нөхөрлөлийн гараа бусдад шаргуу бөгөөд тэвчээртэйгээр дахин дахин сунгах зориг бидэнд байхын төлөө, сайн мэдээг хуваалцах зарлигийг биелүүлэхийн тулд бид Тэнгэрлэг Эцэгээс даруухнаар удирдамж хүсдэг байхын төлөө би

залбирч байна. Ах нараа, энэ бол бидний үүрэг билээ. Есүс Христийн нэрээр, амен.

*Эшлэл*

1. Билл Сандс *The Seventh Step* (1967), 9.
2. Сургаал ба Гэрээ 84:33–39-г үзнэ үү.
3. 2 Тимот 1:7–8.
4. Үйлс 26:28.
5. 1 Коринт 9:16.
6. Матай 28:18–20.
7. Сүмийн Ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит (2007), 330.
8. Сүмийн Ерөнхийлөгчдийн сургаалаас: John Taylor (2001), 73.
9. Иеремиа 8:20.
10. Сургаал ба Гэрээ 18:15–16.

# Асар хаана байна вэ?

**Ерөнхийлөгч Хенри Б.Айринг**

*Тэргүүн Зөвлөлийн Нэгдүгээр зөвлөх*

---

*Тэнгэрлэг тусламжийг хааж байгаа мэт санагдах тэрхүү асар Бурханыг бүрхэн далдалдаггүй, харин энэ нь заримдаа биднийг бүрхэн далдалдаг. Бурхан хэзээ ч нуугддаггүй, харин бид заримдаа нуугддаг.*

---

Бошиглогч Иосеф Смит Либерти шоронд зовон шаналж байхдаа: “Ай Бурхан минь Та хаана байна вэ? Мөн Таны байгаа газрыг бүрхэгч тэрхүү асар хаана байна вэ?”<sup>1</sup> хэмээн чанга хашгирчээ. Биднээс олон нь хувийн зовлон зүдгүүр тохиолдсон үед Бурхан биднээс даан ч хол байна даа гэж боддог. Тэнгэрлэг тусламжийг хааж байгаа мэт санагдах тэрхүү асар Бурханыг бүрхэн далдалдаггүй, харин энэ нь заримдаа биднийг бүрхэн далдалдаг. Бурхан хэзээ ч нуугддаггүй, гэтэл бид заримдаа Бурханаас биднийг холдуулах учир шалтгаануудын асраар өөрсдийгөө бүрхэснээр, Түүнийг хол хүршгүй гэж боддог. “Таны хүсэл биелэгдэх болно”<sup>2</sup> гэсэн бодол биш, харин бидний хүсэл мөрөөдлөөс үүссэн асар Бурханыг халхалдаг. Бурхан биднийг харж байдаг бөгөөд бидэнтэй харилцахад үргэлж бэлэн байдаг. Харин бид заримдаа Түүнийг сонсож, Түүний хүсэл болон Түүний цагт захирагдах хүсэлгүй байдаг.

Бид Түүний өмнө хүүхэд шиг хүлцэнгүй болсон үед Бурханаас хол хөндий байгаа мэт санагдах нь багасах болно. Өөр хүмүүсийн бодол санал бидний сонголтод ихээр нөлөөлж байгаа дэлхийд энэ нь амаргүй юм. Гэвч энэ нь Бурхан бидэнд ойр байдаг, биднийг мэддэг бөгөөд Тэр хэзээ ч итгэлтэй

хүүхдүүдээсээ нуугддаггүй хэмээх энэ үнэнийг мэдэхэд бидэнд туслах болно.

Миний гурван настай зээ охин гэм зэмгүй, даруу байдлын хүч биднийг Бурхантай хэрхэн холбодгийг харуулсан юм. Зээ охин маань Юта дахь Бригам хотын ариун сүмийн нээлтийн үйл ажиллагаанд гэр бүлтэйгээ хамт явсан юм. Тэрхүү үзэсгэлэнт байшингийн нэг өрөөнд тэр зогсож байхдаа эргэн тойрноо харснаа, “Ээж ээ, Есүс хаана байгаа юм бэ?” гэж асуужээ. Ээж нь охиндоо ариун сүмд Есүсийг харах боломжгүй харин Түүний нөлөөг зүрх сэтгэлдээ мэдэрч чадна гэж хариулсан аж. Элиза ээжийнхээ хариултыг анхааралтай бодож үзээд сэтгэл хангалуун болжээ. “Есүс хэн нэгэнд туслахаар явчихсан юм байна” гэж охин дүгнэн хэлсэн.

Элизагийн ойлголтыг асар халхлаагүй эсвээс үнэн байдлыг харахад нь түүнд саад болоогүй юм. Бурхан түүнд ойрхон байсан бөгөөд охин ч Түүнд ойрхон байгаагаа мэдэрчээ. Тэрээр ариун сүм бол Их Эзэний өргөө гэдгийг мэдэж байлаа. Харин амилж, алдар сууг олсон Есүс Христ бие махбодтой бөгөөд нэг удаа нэг л газарт байж чадна гэж ойлгосон ажээ.<sup>3</sup> Есүс өргөөндөө байхгүй байгаа болохоор өөр хаа нэгтээ байх ёстой гэж Элиза ойлгосон байлаа. Мөн Аврагч хаа нэгтээ өөр газар Эцэгийнхээ хүүхдүүдийн төлөө сайныг үйлдэж яваа гэсэн ойлголт Аврагчийн тухай түүний мэдлэгээс үүдэлтэй байлаа. Элиза, Есүсийн бодит оршихуйн гайхамшгийг батлах гэсэндээ биш, харин Түүнд хайртай учраас л Түүнийг харна гэж найдаж байсан нь илт байлаа.

Бид бүгдэд хэрэгтэй байдаг, бас үүнийг бид бүгд хүсдэг тайтгарлыг Сүнс түүний балчирхан оюун ухаан, зүрх сэтгэлд илчилж чадсан юм. Есүс Христ амьд, биднийг мэддэг бөгөөд биднийг дээрээс харж, бидний төлөө санаа тавьж байдаг билээ. Сэтгэл эмзэглэн, ганцаардсан буюу төөрөлдөж будилсан үед Тэрбээр бидний байдлыг нэгд нэгэнгүй мэддэгийг, Түүний зорилго бол биднийг адислах явдал гэдгийг ойлгохын тулд Есүс Христийг заавал харах хэрэг бидэнд байхгүй.

Элизагийн туршлага, хүүхэд ахуй насаа үдээд олон жил болж байгаа бидэнд ч бас тохиолдож болно гэдгийг би өөрийнхөө амьдралаас мэдэж байна. Би ажил мэргэжлийнхээ

эхний жилүүдэд, Станфордын их сургуульд багшийн ажлыг тэтгэвэрт гартлаа баталгаатай хийхийн тулд шаргуу ажилласан юм. Өөртөө болон гэр бүлдээ сайхан амьдралыг бий болгож өглөө гэж би бодож байсан. Бид хадмууддаа ойрхон, нэн тохилог орчинд амьдардаг байв. Дэлхийн жишгээр бол би амжилт олсон байлаа. Гэвч Калифорнийг орхиж, Айдахогийн Рексбург дахь Рикс Коллежид шилжин очих боломжийг надад Сүмээс өгсөн юм. Амьдрал дахь мэргэжилйн зорилго маань, ирээдүйнхээ талаар миний мэддэгээс илүү сайн мэддэг Тэнгэр дэх Эцэгээс минь намайг холдуулах асар байж магадгүй байсан юм. Гэвч тэр цагийг хүртэл ажил мэргэжилдээ болон гэр бүлийн амьдралдаа гаргасан амжилт маань Бурханаас ирсэн бэлэг гэдгийг мэдсэнээрээ би адислагдсан билээ. Ингээд би бяцхан хүүхэд шиг өвдөг сөгдөн залбирч яах ёстойгоо асуулаа. Тэгээд би оюун ухаанд минь намуухан дуу хоолой “Энэ бол миний сургууль” хэмээн шивнэхийг сонссон юм. Энд намайг Бурханаас халхлан далдлах асар байсангүй. Ингээд би итгэл ба даруу байдлаар өөрийн хүслээ Түүний хүсэлд захируулж, Их Эзэнд ойр байгаагаа, бас миний төлөө Тэрбээр анхаарал халамж тавьдгийг мэдэрсэн юм.

Би Рикс коллежид ажиллах хугацаандаа Бурханы хүслийг эрэлхийлж, түүнийг биелүүлэхийн төлөө хичээж, амьдралд минь гүйцэтгэх Бурханы идэвхтэй үүргээс намайг салгах буюу Түүнийг халхлан хаах асраас хол байж чадсан. Түүний ажлыг хийхээр хичээсэн үед би Түүнд ойр байгаагаа, бас Тэр миний байдлыг сайн мэдэж, миний аз жаргалын төлөө үлэмж санаа тавьж байгааг нь мэдэрдэг байлаа. Гэтэл Станфордод байхад маань надад тохиолдсон шиг, дэлхийн хүсэлт, саналууд надад ирж эхэлсэн. Намайг Рикс коллежийн ерөнхийлөгч болсноос хойш тав дахь жилийн сүүлчээр надад нэг онцгой сайхан ажлын санал ирлээ. Би энэ саналын талаар тал талаас нь бодож, залбирч үзсэнээ, бүр Тэргүүн Зөвлөлтэй зөвшилцлөө. Тэд надад элэгсэг дотно хандаж, бяцхан хошигнол хэлсэн ч, тэг ингэ гэж шууд чиглэл өгсөнгүй. Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл намайг, нэг том корпорациас надад олгохыг хүсч байгаа ажлын тухай тайлбарлахыг маань анхааралтай сонссоноо, “За Хал аа, маш сайхан боломж шиг

сонсогдож байна! Хэрэв та бидэнд хэрэгтэй болбол, бид таныг хаанаас олохоо мэднэ шүү дээ” гэв. Тэд намайг хаанаас олохыг мэддэг юм аа гэхэд мэргэжлийн ажлаараа амжилт олох гэсэн миний хүсэл Бурханыг олоход саад болж, бас Түүний урилгыг сонсож дагахад саад тээг учруулах асар болж мэдэхээр байв.

Эхнэр минь үүнийг мэдэрч Рикс коллежоос явах хэрэг бидэнд байхгүй гэсэн хүчтэй сэтгэгдэл түүнд төрсөн юм. Би тэгэхэд нь “Тэгвэл тэр чинь миний хувьд хангалттай хариулт” гэж хэлсэн. Гэвч тэр намайг хувийн илчлэлт авах хэрэгтэй гэж шаргуу хүссэн нь ухаалаг зөвлөгөө байлаа. Тиймээс би дахин залбирав. Энэ удаа би удирдамж хүлээн авлаа. Оюун ухаанд минь нэгэн дуу хоолой сонсогдож, “Би таныг Рикс коллежид дахиад багахан хугацаагаар байхыг зөвшөөрч байна” хэмээн хэлж билээ. Миний хувийн хүсэл эрмэлзэл үнэнийг мэдэхэд саад тээг болж, илчлэлт хүлээн авахыг хүндрүүлсэн байж болох юм.

Нөгөөх ажлын саналаас татгалзаж, Рикс коллеждоо үлдэх сүнсээр нөлөөлөгдсөн шийдвэрээр адислагдсанаас хойш нэг сарын дараа ойрхон байдаг Тетоны далан эвдэрсэн юм. Тэр далан эвдэрч, зуу зуун хүмүүст тусламж хэрэгтэй болно гэдгийг Бурхан мэдэж байжээ. Зөвлөгөө хүсч, Рикс коллежид үлдэх Түүний зөвшөөрлийг авах боломжийг Тэр надад олгосон. Рексбургийн коллеж дахь миний ажил үнэ цэнэтэй хэвээр байхын учир шалтгааныг Бурхан мэдэж байсан юм. Өмч хөрөнгө болон амьдрал нь эвдэрч сүйдсэн хүмүүст туслах Түүний хүссэн зүйлсийг хийхийн тулд Тэнгэрлэг Эцэгт хандан үе үе залбирахаар би тэнд байж байсан. Би бусад хүмүүстэй хамт олон цагийг гэр байшин дотроос шавар ус зөөн өнгөрөөсөн билээ. Түүний тааллыг мэдэж мөн биелүүлэх хүсэл маань надад өөрийн дотоод сэтгэлээ тэлэх боломжийг олгосон юм.

Энэ явдал, Бид Бурханы хүслийг мэдэх буюу биднийг хайрладаг Түүний хайрыг мэдрэхэд саад тотгор болж болох өөр нэгэн арга замыг харуулж байна; энэ нь юу вэ гэвэл, Их Эзэн өөрийн цаг хугацаатай байтал бид өөрсдийн цагийн хуваариар болгохыг шавдуулж болдоггүй. Рексбургт хангалттай удаан хугацаагаар үйлчиллээ гэж бодоод, өөр зүйлсийг цаашид хийхээр би шавдаж байсан. Зарим үед бид

өөрсдийн цагийн хуваарийн дагуу үйлдэхээр зөрөх нь Түүний хүслийг олж харахад маань садаа болдог.

Бошиглогч Иосеф Либерти шоронд байхдаа Миссури дэх Сүмийн гишүүдийг мөшгөн хавчигчдыг шийтгэж өгөхийг Их Эзэнээс гуйсан юм. Тэр тэднийг хурднаар баттайгаар цээрлүүлэхийн төлөө залбирсан. Гэвч Их Эзэн “үүнээс хойш олон биш жил өнгөрөхөд”<sup>4</sup> Сүмийн дайснуудын учрыг олох болно хэмээн хариулсан ажээ. Сургаал ба Гэрээний 121-р хэсгийн 24 болон 25-р шүлэгт Тэрбээр:

“Болгоогтун, миний мэлмий бүх ажлыг хардаг мөн мэддэг авай, мөн үүний зохих цагт, тэд бүгдэд зориулсан шуурхай шүүлт надад нөөцөд буй;;

“Учир нь ажлуудынх нь дагуу хүн болгонд цаг нь өгөгдсөн болой”<sup>5</sup> гэжээ.

Бид “Таны цагт” мөн “Таны хүсэл биелэгдэх болно” хэмээн бодож, залбирсан үед халхлагч асрыг зайлуулж чадна. Их Эзэн зөвхөн хамгийн сайн зүйлсийг хүсдэгийг бид мэддэг учраас, Түүний цаг хугацаагаар болох нь бидэнд хангалттай байх ёстой.

Манай бэрүүдийн нэг нь Бурхан түүний дээр халхлагч асар байрлуулсан хэмээн олон жил бодож явсан юм. Тэр гурван хүүхэдтэй залуу эх байсан ч илүү олон хүүхэдтэй болохыг мөрөөддөг байсан. Хоёр удаа үр зулбасны дараа тэр шаналан залбиран гуйж эхэлсэн. Хүүхэд гаргалгүй олон жил өнгөрөх тусам уурлах уруу таталтанд автагдаж байгаагаар бэр маань мэдэрсэн юм. Отгон хүүхэд нь сургуульд ороход эзгүй үлдсэн гэр орон нь ээж болох хүслийг нь шоолж байгаа мэт санагдаж байсан. Бас танилуудынх нь төлөвлөөгүй, хүсээгүй жирэмслэлтүүд ч тэгж санагдаж байлаа. Тэрээр ерөөгдсөн Мариатай өөрийгөө зүйрлэн бодож, “Эзэний шивэгчнийг харагтун”<sup>6</sup> хэмээн түүний хэлсэн үгийг зүрх сэтгэлдээ хэлсэн ч хариуд нь юу ч сонссонгүй.

Нөхөр нь түүний санаа сэтгэлийг өргөхийг хүсэн Калифорни руу ажлаар явахдаа дагуулж явжээ. Нөхрөө хуралд сууж байх үеэр тэр нэг ч хүнгүй үзэсгэлэнт далайн эргээр алхалж явахдаа зүрх нь түг түг дэлсэн, сэтгэл нь догдлоход чангаар залбирчээ. Тэрбээр анх удаа дахиад хүүхэдтэй болохыг биш, харин бурханлаг зорилготой

үйлчлэлийг гуйн залбирсан байна. “Тэнгэрлэг Эцэг минь ээ, би Танд өөрийнхөө бүх цаг завьг зориулах болно. Үүнийг яаж дүүргэхийг надад харуулна уу?” хэмээн чанга дуугаар хэлж, хаашаа ч явах шаардлагатай болсон гэр бүлээ авч тийшээ явахад бэлэн байгаагаа илэрхийлжээ. Энэ залбирал нь амар амгалангийн ер бусын мэдрэмжийг түүнд төрүүлжээ. Энэ нь түүний зүрх сэтгэлийн тодорхой хүслийг биелүүлээгүй ч анх удаа зүрх сэтгэлдээ тайтгарлыг олсон ажээ.

Тэр залбирал халхлагч асрыг зайлуулж, тэнгэрийн цонхыг түүнд нээж өгсөн юм. Хоёр долоо хоногийн дараа тэр хөл хүндтэй болсноо мэджээ. Хүү, бэр хоёрт номлолын дуудлага ирэхэд шинээр төрсөн хүүхэд нь яг ойдоо хүрсэн байлаа. Хаашаа ч хамаагүй явж, даалгасан ямар ч ажлыг хийх амлалт өгсөн учраас бэр маань айдсаа хойш тавьж, гадаадад хүүхдүүдээ авч явсан юм. Номлолын талбарт байхдаа, номлогчдыг шилжүүлдэг өдөр тэр дахиад нэг хүүхэд төрүүлсэн.

Энэ залуу эх шиг тэнгэрийн хүсэлд бүрэн захирагдах нь заримдаа бидний толгой дээрээ бий болгодог сүнсний халхлагч асрыг зайлуулахад туйлын чухал юм. Гэвч энэ нь бидний залбиралд тэр дороо хариу ирэхийг баталгаатай болгодоггүй.

Сара хөл хүндтэй болж, Исаакийг хэвлийдээ олохоос өмнө, мөн тэд амлагдсан нутгаа хүлээн авахаас бүр өмнө Абрахамын зүрх сэтгэл зөв шударга байсан юм. Хамгийн түрүүнд биелүүлэх ёстой өөр зорилгууд тэнгэрт байсан юм. Тэдгээр зорилгуудад зөвхөн Абрахам, Сара хоёрын итгэлийг төлөвшүүлэх төдийгүй, тэдэнд бэлтгэсэн нутагт хүрэх урт удаан, тойруу аян замд бусадтай хуваалцах мөнхийн үнэнүүдийг тэдэнд заах нь орж байсан юм. Их Эзэн хариугаа урт удаан хугацаагаар, заримдаа бүр хэн нэгний бүх амьдралын төгсгөл хүртэл хойшлуулах нь олонтоо тохиолддог. Гэвч ийнхүү алгуурлах нь үргэлж адислалыг дагуулдаг бөгөөд хэзээ ч ганцаардмал, уй гашуудалтай, тэвчээргүй байх хэрэггүй.

Түүний цаг хугацаа үргэлж биднийх биш байдаг ч, Их Эзэн амлалтандаа хүрэх болно гэдэгт бид итгэлтэй байж болно. Бурханд хүрэх нь дэндүү хэцүү гэж боддог та нарын



дундах хүмүүст, Түүнийг нүүр нүүрээрээ тулан харах өдөр бид бүгдэд ирэх болно гэдгийг би гэрчилж байна. Одоо биднийг харахад нь Түүнд юу ч саад болдоггүй шиг, Түүнийг харахад нь бидэнд юу ч саад болохгүй байх болно. Бид бүгд Түүний өмнө өөрийн биеэр хүрч очин зогсох болно. Бид бүгд миний зээ охин шиг Есүс Христийг яг одоо харахыг хүсдэг ч, Тэр биднийг мэддэг шиг бид өөрсдөө Түүнийг мэдэхэд хүргэх зүйлсийг эхлээд хийвэл Түүний шүүлтийн тавцангийн өмнө бид дахин уулзах нь илүү баяртай үйл явдал байх болно. Бид түүнд үйлчилснээр Түүнтэй адилхан болж, бидний нүдийг юу ч халхлахгүй тэр өдөр ойртох үед бид Түүнд ойрхон байгаагаа мэдрэх болно.

Бурхан өөд чиглэсэн уг хөдөлгөөн урт удаан үргэлжилж болно. “Миний Эцэгээр ерөөгдөгсөд өө, та нар нааш ир. Ертөнцийн сууриас та нарт бэлтгэсэн хаанчлалыг өвлөн авсугай”<sup>7</sup> хэмээн Аврагч заасан билээ. Тэгээд Тэрбээр хэрхэн гэдгийг бидэнд ийн хэлсэн юм:

“Учир нь Намайг өлсөж байхад та нар Надад идэх юм өгсөн. Намайг цангаж байхад уух юм өгсөн. Намайг харь хүн байтал урьж оруулсан.

“нүцгэн байхад минь Намайг хувцасласан, өвчтэй байхад минь Намайг эргэж байсан, шоронд байхад минь Над уруу ирсэн билээ” гэхэд,

“зөвт хүмүүс Түүнд “Эзэн, бид хэзээ Таныг өлсөж байхыг тань хараад хооллож, цангаж байхыг тань хараад уух юм өгсөн бэ?”

“Хэзээ бид Таныг харь газрынх байхыг тань хараад урьж оруулан, нүцгэн байхыг тань хараад хувцасласан юм бэ?”

“Хэзээ бид Таныг өвчтэй байхыг тань хараад эргэж, шоронд байхыг тань хараад очсон юм бэ?” гэх болно.

“Тэгэхэд Хаан тэдэнд, “Үнэнээр би та нарт хэлье. Та нар эдгээр ах дүүсийн маань нэгэнд нь, тэр байтугай хамгийн дордод ньгийнхүү хандсан бол, Надад хийсэн хэрэг”<sup>8</sup> гэж хэлжээ.

Тэрбээр Эцэгийнхээ хүүхдүүдийн төлөө биднээр хийлгэхийг хүсч байгаа зүйлийг бид хийвэл Их Эзэн үүнийг Өөртөө хандсан нинжин сэтгэл хэмээн үзэх бөгөөд бид Түүний хайр, сайшаал магтаалыг мэдрэснээр Түүнд улам ойр

байгаагаа мэдэх болно. Тодорхой цаг хугацаа өнгөрөхөд бид Түүнтэй адилхан болж, Шүүлтийн өдрийг баяртайгаар хүлээх болно.

Таныг Бурханаас халхлан далдалж байгаа мэт санагдах асар нь бусдад үйлчлэх хүсэл биш, харин хүнээс айх айдас байж мэднэ. Аврагчийн цорын ганц хүсэл бол хүмүүст туслах явдал мөн. Та нараас олон нь миний нэгэн адил өөрийнхөө гомдоосон хэн нэгэнтэй эсвэл өөрийг тань гомдоосон хүнтэй ойртон дотносохоос гэрэвшдэг биз ээ. Гэвч Их Эзэн хүмүүсийн зүрх сэтгэлийг, мөн минийхийг ч бас, цагаас цагт уяруулан зөөлрүүлдэг билээ. Иймээс би та нарт өөртөө байж болох ямар нэг айдсыг эс хайхран, Их Эзэнийг төлөөлж, хэн нэгэн рүү очиж, хайр, уучлалаа илэрхийлэх даалгаврыг өгч байна. Хэрэв та ингэх юм бол, тэр хүнийг хайрлах Аврагчийн хайрыг бас өөрийг тань хайрлах Түүний хайрыг мэдрэх болно. Энэхүү мэдрэмж их холоос ирэхгүй. Таны хувьд энэ даалгавар гэр бүл, нийгэм, хамт олонд чинь байж болно.

Хэрэв та бусдыг адислахаар Их Эзэнд үйлчлэх юм бол, Тэр таныг харж, шагнах болно. Хэрэв та үйлчлэлээ хангалттай олон удаа, хангалттай урт хугацаанд хийвэл Есүс Христийн Цагаатгалаар дамжин зүрх сэтгэлд тань өөрчлөлт гарч байгааг мэдрэх болно. Та Түүнд ойрхон байгаагаа төдийгүй бас Түүнтэй улам илүү адилхан болж байгаагаа түүнчлэн мэдрэх болно. Тэгээд бид бүгд Түүнтэй учран золгохоор явах үед, та Моронайн хэлсний адил байх болно: “Мөн эдүгээ би та нарт сайныг ерөөе. Миний сүнс болон махбод дахин нэгдэж, мөн амьд үхсний аль алиных нь Мөнхийн Шүүгч агуу Иеховагийн таалалт тавцангийн өмнө та нартай уулзахаар би ялгуусан байдалтайгаар хүргэгдэх хүртэл Бурханы диваажинд амрахаар удахгүй явах болно би. Амен.”<sup>9</sup>

Хэрэв бид Бурханы хүслийг биелүүлэхийн тулд итгэл, даруу байдал, хүсэл эрмэлзэлтэйгээр үйлчлэх юм бол, агуу Иеховагийн шүүлтийн индэр бидний хувьд баярт үйл явдал байх болно гэдгийг би гэрчилж байна. Хайрт Тэнгэрлэг Эцэг, Түүний Хүү Есүс хоёр одоо биднийг төгс тодорхой байдлаар, төгс хайраар харж байгаа шиг бид тэр үед Тэднийг харах болно. Есүс Христийн ариун нэрээр, амен.

*Эшлэлүүд*

1. Сургаал ба Гэрээ 121:1.
2. Матай 6:10; Лук 11:2; 3 Нифай 13:10; Ифер 12:29; Сургаал ба Гэрээ 109:44; Мосе 4:2 -г үзнэ үү.
3. Сургаал ба Гэрээ 130:22 -г үзнэ үү.
4. Сургаал ба Гэрээ 121:15.
5. Сургаал ба Гэрээ 121:24–25.
6. Лук 1:38.
7. Матай 25:34.
8. Матай 25:35–40.
9. Моронай 10:34.

# Цагаатгал

**Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын**

*Ерөнхийлөгч Бойд К.Пакер*

---

*Манай гишүүд хийгээд номлогчид хаана байгаагаас үл хамааран бидний чухалчлан өгдөг ганц захиас бол Аврагч Есүс Христэд итгэх итгэл ба найдварын талаар байдаг билээ. Бидний эргэн тойронд маань байгаа зовж шаналж, хүнд ачаа үүрч байгаа тэдгээр хүмүүст би хандан өөрийн захиасыг ярина.*

---

Би 1971 онд Уполо арал дээр шинэ гадас зохион байгуулах үеэр Баруун Самоагийн гадаснуудын чуулганд оролцохоор томилогдсон юм.

Ярилцлагууд хийснийхээ дараа Саваий арал руу гадасны чуулган явуулахаар нэгэн жижигхэн онгоцоор нисэв. Онгоц Фаала дахь зүлэгт талбай дээр газардсан бөгөөд маргааш үдээс хойш нь биднийг Уполо арал руу аваачихаар ирэх ёстой байлаа.

Саваийгаас бидний буцах ёстой байсан өдөр бороо орж байлаа. Онгоц нойтон талбай дээр газарддаггүйг мэдэх учир оройн хэсэг дээрээ онгоцны гүйлтийн зурвас бүхий арлын баруунтаа машинаар хүрч очив. Бид харанхуй болтол хүлээсэн ч онгоц ирсэнгүй. Эцэст нь тэнд хүчтэй шуурга болоод онгоц хөөрөөгүйг радиогоор бидэнд өгсөн мэдээнээс олж мэдсэн юм. Бид завиар явах болсноо эргүүлээд радиогоор мэдэгдэв. Мулифануад бидэнтэй хэн нэгэн нь ирж уулзах ёстой байв.

Биднийг Саваийгийн боомтоос хөдлөх гэж байтал 12 метр урт усан онгоцны ахмад манай номлолын ерөнхийлөгчөөс гар чийдэн байгаа эсэхийг асуув. Аз болоход түүнд гар чийдэн

байсан тул түүнээ ахмадад өглөө. Догшин давалгаат далайгаар 21 километр сэлж байж Уполо арлыг гатлав. Энэ арал дээр халуун орны аймшигт шуурга эхэлснийг бидний хэн нь ч анзаарсангүй, харин бид бүр шуургыг сөрөн хөвж явсныг яана.

Бид Мулифануа боомт дээр ирлээ. Тийш очихын тулд усан доорх хад бүхий нарийхан хавцлаар гарах хэрэгтэй болов. Далайн эргийн дээдэх толгодын орой дээрх гэрэл болон арай доохнуур нь харагдах нэмэлт гэрэл хавцлыг зааж өгдөг юм байна. Нэг гэрэл нөгөөгийнхөө дээрээс гэрэлтүүлдэг учир усан онгоц аюултай том хаднуудын дундуур сүлжин, хонгилоор нэвтэрч гардаг ажээ.

Гэвч тэр шөнө тэнд ганцхан гэрэл байлаа. Очих газарт маань хоёр ахлагч биднийг хүлээж байх ёстой байсан ч, тийш очих бидний явдал сунжирсаар л байлаа. Усан онгоц дохио өгөхийг хэдэн цагийн турш хүлээсний эцэст ядарсан, мөнөөх хоёр ахлагч нэмэлт гэрлээ асаахаа мартаад унтчихсан байлаа. Үүнээс болж усан доорх хадны хоорондох хонгилоор явах зам хүндрэлтэй болов.

Ахмад эрэг дээрх дээд гэрлээр баримжаалан чадах чинээгээрээ маневр хийхэд хөлгийн багийн хэн нэг нь зээлдсэн гар чийдэнгээ өмнөх хаднууд руу тусгаж байлаа. Бид давалгаа усан доорх хаднуудыг цохих чимээг сонсон, гар чийдэнгээрээ хаднуудыг гэрэлтүүлэхээр ойрхон зайд ойртож ирэхэд ахмад галзуу мэт орилон буцахыг шаардан ухарна. Тэгээд хонгил дундуурх замыг олохыг хичээн дахин урагшила.

Ахмад олон удаа оролдсоны эцэст хонгилыг олж чадахгүй юм байна гэдгээ мэджээ. Бидний зорьсон газар бол 64 км-ийн цаана орших Апиа дахь боомт юм. Бид шуурганы аймшигт хүчний эсрэг үнэндээ юу ч хийж чадсангүй. Би тийм тас харанхуй шөнийг харж байснаа огт санахгүй байлаа.

Хөдөлгүүр бүрэн хүч чадлаараа ажиллаж байсан ч, бид бүтэн цагийн турш юу ч хийж чадсангүй. Усан онгоц уул шиг өндөр давалгааг сөрөн хүчлэн зүтгэх тэр хоромд давалгаа буцмагц моторын сэнс ил гарч, хий эргэснээ, зогсчихоод байв. Усан онгоцыг давалгааны нөгөө тал руу гулган ороход сэнс усан онгоцыг бараг л хэдэн хэсэг болтол салгах гэж буй мэт хүчтэй эргэлдэнэ.

Бид тавцангаас шидэгдчихгүйн тулд хоёр гараараа нэг талынх нь хэтэгнээс бариад, хөлийнхөө хуруугаар нөгөө талынх нь хэтэгнээс зууран яг л онгоцны ачааны хучлага мэт хөл гараа алдлан явж байлаа. Марк Литтлфорд ах барьцаа алдсанаас болж шидэгдэн доор байх төмөр бариулд цохиулав. Толгой нь шалбарсан ч, төмөр бариул түүнийг тавцангаас шидэгдэхээс хамгаалсан юм.

Бид тийн цааш хөдөлсөөр, үүр цайхын алдад Апиагийн боомтод арайхийн хүрэв. Аюулгүй байдлын усан онгоцуудыг хооронд нь холбож уясан байлаа. Олон усан онгоц зэрэгцэн зогссоноос болж, зогсоол хаагдсан байв. Бид онгоцныхоо тавцан дээр унтсан хүмүүсийг сэрээхгүйн тулд, тэдний дундуур чимээ гаргалгүй явж өнгөрөв. Бид Песегад ирж хувцас хунараа хатаагаад, шинэ гадас байгуулахаар Вайлуутай руу хөдөлсөн билээ.

Биднийг Мулифануагийн эрэгт хэн хүлээж байсныг би мэдээгүй. Тэдний тухай надад хэлээд хэрэггүй гэж би өөрөө хүссэн юм. Гэвч бид бүгд нэмэлт гэрэлгүйгээр төөрөх байсан нь үнэн билээ.

Бидний дууллын номонд маш эртний бөгөөд тун ховор дуулагддаг ч надад маш их онцгой учир утга бүхий нэг дуулал байдаг.

*Эцэгийн минь энэрлийн хурцаар  
Эгнэгт биднийг гийгүүлэх гэрэлт цамхагт,  
Эрэг дээрх гэрлүүдийг  
Ээлжгүй манах үүрэг нь биднийх.  
Далайн мандал дээгүүр гэрэлтэж байхаар  
Нэмэлт гэрлээ үргэлж асаацгаая.  
Доройтож ядарсан, даруухан далайчныг  
Дээдлэн энэрч, авран хамгаалцгаая.*

*Түнэр харанхуй хилэнцэт шөнөөр  
Түрэх давалгааны догшин чимээ гаарна.  
Төөнөх адил ширтэх хурц нүд,  
Тэртээх эргийн гэрлүүдийг ширтсээр байна.*

*Давалгаанд шидэгдсэн хөөрхий далайчин  
Даалмай ихээр хичээж явна, боомт руу.  
Харанхуйд төөрөхвий хөөрхий тэр,  
Хуруц гэрэлт дэнлүүгээ сайн манаарай, дүү минь.*<sup>1</sup>

Би өнөөдөр алдагдсан болон эргэж ирэх замаа олохын тулд нэмэлт гэрлийг хайж яваа хүмүүст хандан ярих болно.

Бид мөнх бус амьдралд төгс төгөлдөр байж чадахгүй нь анхнаасаа ойлгомжтой байсан. Хуулийг огт зөрчилгүйгээр амьдрахыг биднээс хүсэн хүлээгээгүй юм.

“Учир нь эгэл хүн бол Бурханы дайсан, мөн Адамын уналтаас тийм байсаар ирсэн, мөн тэрээр Ариун Сүнсний таталтанд автагдан, эгэл хүмүүнээ орхиж мөн Их Эзэн Христийн цагаатгалаар гэгээнтэн болж, . . . үүрд мөн үргэлж тийм байх болно.”<sup>2</sup>

Агуу Үнэт Сувдаас бид “[Бурханы Хаант улсад] . . . цэвэр ариун бус зүйл . . . оршиж чадахгүй”<sup>3</sup> гэдгийг ойлгодог бөгөөд үүний тулд нүгэл үйлдсэн хүмүүст наманчилж, Тэнгэр дэх Эцэгийнхээ өмнө дахин нэгэнтээ очихдоо зохистой болох арга зам өгөгдсөн билээ.

Амьдралаа төгс төгөлдөрөөр авч явсан, ямар ч гэм нүгэл үйлдээгүй Зууч, Гэтэлгэгч сонгогдож, “харууссан зүрх, гэмшсэн сэтгэлтэй хэний ч төлөө хуулийн шаардлагуудыг хангаж, тэрээр нүглийн золиос болгон өөрийгөө өргө[sөн билээ]; мөн хуулийн бүх шаардлагууд өөр хэний ч төлөө хангагдаж чадахгүй.”<sup>4</sup>

Цагаатгалын ач холбогдлын талаар Алмагаас бид “Учир нь цагаатгал хийгдэх нь зайлшгүй юм; . . . эс бөгөөс бүх хүн төрөлхтөн гарцаагүй мөхөх ёстой.”<sup>5</sup> гэдгийг ойлгож авдаг.

Хэрэв та нар алдаа гаргадаггүй бол та нарт Цагаатгал хэрэггүй байх байсан. Бид бүгд л жижиг эсвэл ноцтой аль нэг байдлаар алдаа гаргадаг. Хэрэв та бид дахин харанхуйд байхгүйн тулд бүх алдаагаа хэрхэн арилгахыг олж мэдэх агуу хэрэгцээ бид бүгдэд байх л болно.

“[Есүс Христ] бол дэлхийн гэрэл хийгээд амь амьдрал болой.”<sup>6</sup> Бид Түүнд болон Түүний сургаалуудад анхаарлаа төвлөрүүлснээр бид сүнслэг байдлын аюулгүйн боомт уруу удирдагдах болно.

Итгэлийн Тунхагийн гуравт, “Христийн Цагаатгалаар дамжин Сайн мэдээний хуулиуд хийгээд ёслолуудад дуулгавартай байснаар бүх хүн төрөлхтөн аврагдана гэдэгт бид итгэдэг”<sup>7</sup> гэсэн байдаг.

Ерөнхийлөгч Жозеф Ф.Смит ингэж сургасан юм: “Хүн өөрийн гэм нүглийг өршөөж чадахгүй; тэд өөрсдийгөө нүглийнхээ үр дагавраас цэвэрлэж чадахгүй. Хүн нүгэл үйлдэхээ болиод, ирээдүйд зөвийг хийж чадах ч, зөвхөн тэдний үйлдэл нь Их Эзэний өмнө л зохистой [болоход] хүлээн авагдах ёстой юм. Өөрсдөө засаж залруулах нь тэдэнд боломжгүй мэт санагдаж байгаа, өөрсдөдөө болон бусдад хийсэн буруу зүйлсийг хэн засаж чадах вэ? Есүс Христийн Цагаатгалаар дамжин наманчлагчийн гэм нүгэл угаагдах болно; хэдийгээр тэдгээр нь хүрэн улаан боловч ноос шиг цагаан болгогдох болно [Исаиа 1:18-г үзнэ үү]. Энэ бол та бидэнд өгөгдсөн амлалт юм.”<sup>8</sup>

Бид Цагаатгалын талаар Их Эзэн үүнийг хэрхэн хийж гүйцэтгэснийг мэдэхгүй. Харин зовлон зүдгүүрийн ариун талбар болох Гетсеманигаас эхлэн Голготад төгсгөл болсон аймшигт өвдөлтийн нэг хэсэг нь цовдлолтын харгис тамлалт байсан гэдгийг мэднэ.

Лукын номонд ингэж тэмдэглэсэн байдаг:

“Тэр тэднээс чулуу шидэх зайтай холдон, өвдөг сөгдөөд ингэж залбирав.

“Эцэг минь, хэрэв Та хүсэж байгаа бол энэ аягыг Надаас зайлуулаач. Гэвч миний хүсэл бус, харин Таны хүсэл биелэгдэг гэв.

“Тэгтэл тэнгэрээс тэнгэр элч Түүнд үзэгдэн, Түүнийг тэнхрүүлж байлаа.

“Тэр зовж, шаналж байсан тул маш шаргуу залбирч байлаа. Түүний хөлс нь цусны дусал мэт газарт дусалж байв.”<sup>9</sup>

Одоогийн байдлаар Аврагч Гетсеманий цэцэрлэгт юуг тэсэж гарч байснаа Өөрийн үгээр илэрхийлсэн миний хэлж чадах ганц л тохиолдол байна. Илчлэлтэд ингэж бичсэн байдаг:

“Учрыг болгоогтун, хэрэв тэд наманчлах аваас, тэд зовохгүй байж болохын тулд Бурхан, би бээр бүхний төлөө эдгээр зүйлүүдийг амссан билээ;



“Гэвч хэрэв тэд үл наманчлах аваас, бүр миний адилаар тэд зовох ёстой;

“Бүр бүхнээс хамгийн агуу Бурхан намайг өвдөхийн улмаас дагжин чичрэх, мөн сүв бүрээс цус шүүрсэн билээ.”<sup>10</sup>

Амьдралдаа хэзээ ч тийшээ явах хэрэггүй байсан газар руу явсан, мөн хэзээ ч хийх хэрэггүй зүйлийг хийсэн тохиолдол та нарт байж мэднэ. Хэрэв та нар гэм нүглээс эргэж, бүрэн наманчлалын замыг дагасан бол амар амгаланг нэг л өдөр мэдрэх болно.

Бидний хийсэн буруу зүйл юу болохоос, бидний үйлдэл хэн нэгнийг хэр зэрэг их гомдоосноос үл хамааран, бүх буруу зүйлс алга болно. Миний хувьд бүх судрууд дахь хамгийн гайхамшигтай үгс бол, “Болгоогтун, нүглүүдээ наманчилсан тэрээр, мөнхүү тэр нь өршөөгддөг ажгуу, мөн Их Эзэн, би бээр тэдгээрийг цашид санах нь үгүй”<sup>11</sup> хэмээн сударт өгүүлсэн Их Эзэний үгс билээ.

Бидэнтэй нэгдэх бүгдийг бид хүлээн авч, өөрсдийн туршлагаар дамжуулан тэдэнд гэм нүглээ наманчилж, Христийн цусаар цэвэр болгогдож, амьдралынхаа эцэст хөшгөөр дамжин гарах боломжийг олгох нь Есүс Христийн сайн мэдээ болон Цагаатгалын зорилго юм.<sup>12</sup>

Энэ бол Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн дэлхий даяар хийдэг зүйл бөгөөд харанхуйд байгаа болон замаа алдсан хүмүүст бидний өргөх Гэрэл юм. Манай гишүүд хийгээд номлогчид хаана байгаагаас үл хамааран бидний чухалчлан өгдөг ганц захиас бол Аврагч Есүс Христэд итгэх итгэл ба найдварын талаар байдаг билээ.

Рөнхийлөгч Жозеф Фиелдинг Смит “Аяны зам тань алс хол, хэцүү мэт санагдана уу?” дууллын үгийг бичсэн юм. Тэр миний дотны анд байлаа. Үүнд Аврагчийн сургаалыг дагахаар эрэлхийлж буй хүмүүст урам зориг, амлалт агуулагдсан байдаг:

Аяны зам тань хүнд бөгөөд өгсүүр,  
 Алс хол юм шиг хэцүү санагдана уу?  
 Өргөс хийгээд хатгадаг мод замд тань байна уу?  
 Өндөрт мацаж, өдрийн халуунд  
 Өндийж босохоор зүдэрч явахад тань  
 Үзүүртэй хад хөлийг тань зүсэв үү?

Үүрэх ёстой ачаандаа дарагдан байхдаа,  
 Үргэлж сэтгэлээр унаж, гунигт автан,  
 Үүрдийн Сүнс тань ядарч туйлдана уу?  
 Дахин өргөхийг хүчилсэн ачаа тань  
 Даагдашгүй хүнд мэт санагдана уу?  
 Дарамтыг тань хуваалцах хэн ч алга мэт байна уу?

Нэгэнт эхэлсэн хүнд аяндаа  
 Найдвар итгэлээ бүү алдаарай;  
 Таныг дуудсаар буй Нэгэн бий.  
 Тиймээс баяртайгаар дээш хараад,  
 Түүний гараас атгаарай;  
 Тэр таныг шинэ өндөрлөгүүдэд—

Адын зовлон бэрхшээл эцэс болох,  
 Ариун нандин газруудаар удирдана,  
 Тэгээд амьдрал тань нүглээс чөлөөлөгдөнө.  
 Тэнд гуниг зовлон үгүй учир,  
 Таны нулимс үл урсана.  
 Түүний гараас атгаад, дотогш ор.<sup>13</sup>

Есүс Христийн нэрээр, амен.

#### Эшлэл

1. "Brightly Beams Our Father's Mercy," *Hymns*, no. 335.
2. Мозая 3:19.
3. Мосе 6:57.
4. 2 Нифай 2:7.
5. Алма 34:9.
6. Мозая 16:9.
7. Итгэлийн Тунхаг 1:3.
8. Сүмийн Ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит (1998), 99–100.
9. Лук 22:41–44.
10. Сургаал ба Гэрээ 19:16–18.
11. Сургаал ба Гэрээ 58:42.
12. Илчлэлт 1:5-ыг үзнэ үү.
13. "Does the Journey Seem Long?" *Hymns*, no. 127.

# Эхлээд ажигла, тэгээд үйлчил

Линда К.Бөртэн

Нийгмийн Халамжийн Бүлгийн Ерөнхий Ерөнхийлөгч

*Бид бүгд үүнийг хийж, Бурханы хүүхдүүдэд  
үйлчилснээр Аврагчтайгаа илүү адилхан болж  
чадна.*

Бидний хайрт бошиглогч Ерөнхийлөгч Томас С.Монсон Их Эзэний сонгогдсон үйлчлэгч гэдгийг батлах агуу баталгаануудын нэг бол тэрээр Аврагчийн жишээг даган хүмүүст нэг нэгээр нь хувьчлан үйлчилдэг явдал билээ. Баптисмын усанд орсон бид ч гэсэн мөн адил гэрээг хийсэн байдаг. Бид “Үргэлж [Аврагчийг] санаж, Түүний зарлигуудыг дагана,”<sup>1</sup> хэмээн гэрээ хийсэн, мөн Тэрээр “Энэ бол миний тушаал, Би та нарыг яаж хайрласан шиг та нар бие биеэ хайрлагтун”<sup>2</sup> гэж хэлсэн.

Ерөнхийлөгч Монсоны дараах үгс үүнтэй яг адил урилгыг агуулдгийг ажиглаж болно: “Бидний эргэн тойронд бидний анхаарал, урамшуулал, дэм, тайтгарал, сайхан сэтгэлийн тусламж хэрэгтэй олон хүмүүс байна. . . . Бид Түүний энэ дэлхий дээрх хүүхдүүдийг өргөх, тэдэнд үйлчлэх үүргийг хүлээсэн Их Эзэний гар юм. Тэрээр бид бүхэнд найддаг юм.”<sup>3</sup>

Бие биенээ хайрла гэсэн урилгыг та нар сонссон уу? Заримд маань Аврагчийн жишээг даган хүн нэг бүрд үйлчилж тохинуулах нь тийм ч амар байдаггүй. Гэлээ ч бид бүгд үүнийг хийж, Бурханы хүүхдүүдэд үйлчилснээр Аврагчтайгаа илүү адилхан болж чадна. Бид бие биенээ илүү сайн хайрлаж сурахад маань тус болох дөрвөн үгийг би санаж явахыг санал болгох гэсэн юм: “Эхлээд ажигла, тэгээд үйлчил.”

Бараг л дөчин жилийн өмнө, нөхөр бид хоёр нэгэн баасан гарагийн үдшийн болзооны цагаараа ариун сүмд орсон юм. Бид гэрлээд удаагүй байсан үе, мөн гэрлэснийхээ дараа ердөө хоёр дахь удаагаа л тэнд очиж, байгаа учраас их сандарч байлаа. Миний хажууд сууж байсан эгч үүнийг маань анзаарч л дээ. Тэрээр над руу бөхийн намуухнаар, “Бүү санаа зов. Би чамд туслана.” гэж шивнэн хэлэхэд айдас минь арилж, тайвшран ёслолын үлдсэн хугацаанд тайван сайхан байж чадсан. Тэр эгч эхлээд ажиглаж, тэгээд үйлчилсэн юм.

Бид бүгдээрээ Есүсийн сургаалыг дагаж, бусдад номлох урилгыг хүлээн авсан. Энэхүү урилгыг зөвхөн тэнгэрлэг элч мэт эгч нарт өгсөн юм биш. Эхлээд ажиглаж тэгээд үйлчилж сурсан гишүүдийн хэдэн энгийн жишээг хуваалцахад маань тэдний хийсэн үйлчлэл хэрхэн Есүсийн сургаалын жишээ болж байгааг анхааран сонсоорой.

Хүүхдийн ангийн зургаан настай нэгэн хүү: “Хичээл дээр туслуулахаар намайг сонгоход, надтай хамтарч ажиллах найзаа сонгох боломж надад олдсон юм. Намайг дээрэлхдэг байсан ангийнхаа хөвгүүнийг би сонгосон, яагаад гэвэл өөр хэн ч тэр хүүг хэзээ ч сонгож байгаагүй билээ. Би түүнийг баярлуулахыг хүссэн юм”<sup>4</sup> гэж ярьжээ.

Энэ хүүхэд юуг ажигласан бэ? Тэрээр ангийнх нь дээрэлхүү хүү хэзээ ч сонгогдож байгаагүйг ажиглажээ. Тэр тэгээд яаж үйлчлэв? Тэр хүүхдийг түүнд хичээл бэлдэхэд нь туслах найзаараа л сонгосон байна. Есүс, “Дайснуудаа хайрла, та нарыг хавчдаг хүмүүсийн төлөө сайныг үйлд”<sup>5</sup> гэж зааж байсан билээ.

Нэгэн тойргийн Аароны санваартнууд эхлээд ажигласны үндсэн дээр үр өгөөжтэй нэгэн үйлчлэл хийж эхэлсэн байна. Долоо хоног бүр, залуу эрэгтэйчүүд сүмдээ эрт ирж, бороо, цас, шатам халууныг ч үл харгалзан цуглааны байрныхаа гадна тойргийнхоо нас өндөр олон гишүүдийг ирэхийг хүлээн зогсдог болжээ. Тэд тэдний тэргэнцэр болон алхахад дэмждэг тулгууруудыг нь машинаас буулгахад тусалж, түшэж болох гараа тэдэнд өгч, буурал толгойтой ахмадуудаа тэвчээртэйгээр дагалдан байр руу нь оруулдаг болсон байна. Тэд Бурханы өмнө хүлээсэн үүргээ үнэнчээр биелүүлж байгаа билээ. Тэд ажиглаад, дараа нь үйлчилснээр: “Та нар эдгээр ах

дүүсийн маань нэгэнд нь, тэр ч байтугай хамгийн дордод нь тийнхүү хандсан бол Надад хийсэн хэрэг”<sup>6</sup> хэмээх Аврагчийн сургаальн амьд жишээ болцгоож байна. Залуучуудад зориулсан шинэ хөтөлбөр хэрэгжиж эхлэхэд эдгээр залуу эрэгтэйчүүдийн нүд нээгдэн Аврагчтай адил арга замаар үйлчлэх илүү олон боломжуудыг олж харах болно гэдэгт би эргэлзэхгүй байна.

Ажиглан харж, үйлчлэх нь заримдаа агуу их хичээл зүтгэлийг шаарддаг. Александра хэмээх урмаар өдөөгдсөн залуу эмэгтэй өөрийн үеэл дүү Мэдисон нь нэгэн төрлийн сэтгэцийн өвчний улмаас Хувийн хөгжил дэвшлийнхээ шаардлагуудыг гүйцээж чадахгүй байгааг ажигласан байна. Александра тойргийнхоо залуу эмэгтэйчүүдийг цуглуулан, удирдагч нартайгаа зөвлөлдөж, Мэди өөрөө хийж чадахгүй байгаа зүйлд нь туслахаар шийджээ. Ингээд залуу эмэгтэй бүр Хувийн хөгжил дэвшлийн үйл ажиллагаа болон төслүүдийн хэсгийг гүйцээж Мэдид медалиа авахад нь тусалсан.<sup>7</sup>

Эдгээр залуу эмэгтэйчүүд эхлээд ажиглаж, тэгээд энэрэн халамжлах аргаар үйлчилж сурч байгаа учраас ээж хүний болон Нийгмийн Халамжийн эгч дүүсийн үүргийг сайн сурч өсөн хөгжих болно.

Ерөнхийлөгч Монсоны бидэнд “энэрэл бол Христийн цэвэр хайр”<sup>8</sup> гэж сануулсан бөгөөд өөрөөр хэлбэл “өндөр настай бэлэвсэн эгчийгээ марталгүй тойргийнхоо үйл ажиллагаандаа оролцуулах” мөн “Нийгмийн Халамжийн хичээл дээр ганцаархнаа сууж байгаа эгчийг ‘Нааш ирж, бидэнтэй суугаач’ гэж урих”<sup>9</sup> нь ажиглан харж мөн үйлчлэх явдал мөн. Ингэх нь “Хүмүүн өөрсдөд тань хэрхэн хандахыг хүсдэгчлэн юуг боловч, бүх зүйлийг та нар тэдэнд түүнчлэн үйлд”<sup>10</sup> гэх алтан дүрмийн дагуу юм.

Нэгэн ажигч ах үйлчлэл үзүүлэх хоёр арга олжээ. Тэр дараах түүхийг хуваалцсан:

“Нэгэн Ням гарагт би Хүүхдийн хэсэгт эхнэртээ туслан эрч хүч дүүрэн долоон настангуудтай хамт байсан юм. Хүүхдийн ангийн хуваалцах цаг эхлэх үед ангийн нэг охин сандал дээрээ их л тавгүй байдалтай сууж байхыг би анзаарлаа. Түүнийг тайвшруулах хэрэгтэй гэсэн Сүнсний шивнээг мэдрэн хажууд нь очиж суугаад юу болсныг асуусан.

Тэр надад юу ч хэлээгүй учир . . . , би түүнд намуухнаар дуу дуулж эхлэв.

“Хүүхдийн хэсэгт шинэ дуу сурч байсан бөгөөд, ‘Хэрэв би чин сэтгэлээсээ сонсвол, Аврагчийнхаа дуу хоолойг сонсох болно’ хэмээн бид дуулж байх үед зүрх сэтгэл минь гайхалтай дулаан илч, гэрлээр дүүрэхийг би мэдэрлээ. . . . Аврагч тэр охинд хайртай, мөн надад ч хайртай гэсэн хувийн онцгой гэрчлэлийг би хүлээн авсан юм. . . . Хэн нэгэнд үйлчилснээр бид [Аврагчийн] гар нь болдог юм байна гэдгийг би сурч билээ.”<sup>11</sup>

Энэ Христтэй адил ах маань эрч хүчээр дүүрэн 7 настангуудаар дүүрсэн ангид эхнэрт нь тусламж хэрэгтэй байгааг анзаараад зогсоогүй; тэрээр мөн тусламж хэрэгтэй байсан хүүхдэд бас үйлчилсэн байна. Тэрээр, “Миний хийснийг та нар харсан, бүр түүнийг та нар хийх болно”<sup>12</sup> хэмээн сургасан Аврагчийг дагасан юм.

Саяхны болсон үер Есүс Христийн дагалдагчдад эхлээд ажиглан дараа нь үйлчлэх олон боломжуудыг нээсэн юм. Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд, өсвөр насныхан, мөн хүүхдүүд эвдэрч сүйрсэн бизнес болон гэр орнуудыг хараад, тухайн үед хийж байсан бүх зүйлээ орхин, нурсан байруудыг цэвэрлэж, засах ажилд орцгоосон юм. Зарим нь асар их угаалга хийх хэрэгцээг олж харсан байхад бусад нь гэрэл зураг, хуулийн бичиг баримт, захиа болон бусад чухал цааснуудыг арчин, тэгээд чадах бүхнээ хамгаалж үлдэхийн тулд болгоомжтойгоор өлгөн хатааж байлаа. Ажиглан хараад үйлчлэх нь үргэлж хялбар байдаггүй, бас бидний цаг завтай ямагт нийцээд байдаггүй.

Эхэлж ажиглаад, дараа нь үйлчлэх ёстой хамгийн чухал газар маань гэр орон маань биш гэж үү? Ахлагч Ричард Г.Скоттын жишээнээс хуваалцъя. Тэрээр:

“Нэгэн шөнө зүрхний өвчтэй бага хүү Ричард маань сэрж уйлсан юм. Голдуу эхнэр маань босч уйлж буй хүүгээ арчилдаг байсан ч тэр удаа би, ‘Би очиж тайвшруулья’ гэж билээ.

“Хүүг уйлж эхлэхэд өвчний улмаас түүний бяцхан зүрх маш хурдан цохилж, тэр маань бөөлжин ор дэвсгэрээ бохирдуулчихна. Тэр шөнө би түүнийг энгэртээ чанга тэврэн,

хурдан цохилж буй зүрхийг нь тайвшруулж, уйлахыг нь болиулахыг хичээж байхдаа хувцас мөн ор дэвсгэрийг нь сольж өгсөн юм. Хүүгээ унтгал нь гэвэрч байсан сан. Тэгэхэд хүү маань хэдхэн сарын дараа өнгөрнө гэдгийг би мэдээгүй байсан юм. Тэр шөнө би хүүгээ тэврэн байснаа үргэлж санах болно”<sup>13</sup> гэж ярьж билээ.

Есүс хэлэхдээ, “Та нарын дунд хэн чинь агуу нэгэн болохыг хүснэ, тэр нь та нарын зарц болог.”<sup>14</sup> гэсэн юм.

Заримдаа бид өөрсдийн хүссэнээр л үйлчлэхийг хүсэж, тэр үед яг юу хэрэгтэй байгааг хийдэггүй. Ахлагч Роберт Д.Хейлс арвич хямгач амьдралын зарчмын талаар заахдаа, эхнэртээ бэлэг худалдан авч өгсөн тухайгаа хуваалцсан байдаг. Эхнэр нь түүнээс, “Чи наад бэлэгээ надад авч өгөх гээд байна уу, эсвэл өөртөө юу?”<sup>15</sup> гэж асуужээ. Энэ асуулт үйлчлэл хийх гэж буй бидэнд сургамж болох ёстой юм. “Би үүнийг Аврагчийн төлөө хийж байна уу, эсвэл өөрийнхөө төлөө юу?” гэж асуух юм бол бидний үйлчлэл Аврагчийн тохинуулалтай илүү адил болж ирнэ. Аврагч маань, “Өөрсдийнхөө төлөө надаар юу хийлгэхийг хүснэ вэ?”<sup>16</sup> гэж асуусантай адил бид ч мөн адил асуух хэрэгтэй.

Хэдхэн 7 хоногийн өмнө надад хийх ёстой ажил маш их байсан учир би яарч мөн цухалдаж байв. Тэр өдөр Ариун сүм рүү явна гэж найдаж байсан ч хэтэрхий завгүй байгаагаа мэдэрч байв. Ариун сүмийн үйлчлэлд оролцохоос илүү завгүй байгаа юм гэж үү гэсэн бодол зурвасхийн орж ирэх тэр мөчид би миний хувьд юу чухал байх ёстойг санаж билээ. Би ажлын өрөөгөө орхин Солт Лейкийн Ариун сүм рүү алдсан цагаа яаж нөхөх талаараа бодон явсан юм. Аз болоход Их Эзэн маань тэвчээртэй мөн энэрэнгүй бөгөөд тэр өдөр надад гайхалтай хичээл заасан.

Ариун сүмийн өрөөнд ортол нэгэн залуухан эгч над руу бөхийн намуухнаар, “Би их сандраад байна. Би энд дөнгөж хоёр дахиа л ирж байна. Та надад туслаач?” гэж шивнэсэн юм. Тэр үгсийг яг тэр үед би сонсох ёстой байсан юм гэдгийг тэр яаж мэдсэн юм бол? Тэр мэдээгүй ээ, харин Тэнгэрлэг Эцэг маань мэдэж байсан. Надад юу хэрэгтэй гэдгийг тэр ажиглажээ. Би үйлчлэх ёстой байж. Бурхан тэр залуухан даруу эмэгтэйг над руу явуулж, тусламж гуйлгуулснаар

намайг бас түүнд үйлчлэх боломжийг нээсэн юм. Энэ бүхнээс хамгийн их ашиг тусыг хүртсэн хүн нь би байж билээ.

Он жилүүдийн турш манай гэр бүлд Христийн адил үйлчлэл үзүүлсэн олон хүмүүс байсан гэдгийг би талархалтайгаар хэлж байна. Мөн би агуу хайраар, сэтгэл харамгүй үйлчлэл үзүүлдэг миний хайртай нөхөр болон гэр бүлийнхэндээ чин сэтгэлийн талархал илэрхийлмээр байна.

Бид бүгд эхлээд ажиглаж, тэгээд үйлчлэхийг хүсэж байгаасай. Хэрэв бид ингэж үйлчлэх юм бол, бид гэрээгээ сахих бөгөөд мөн бидний үйлчлэл Ерөнхийлөгч Монсоныхтой адил биднийг дагалдагч гэдгийг маань нотлох болно гэдгийг би гэрчилж байна. Аврагч амьд мөн Түүний Цагаатгал нь бидэнд Түүний сургаалийн дагуу амьдрах боломжийг олгодог гэдгийг би мэднэ. Мөн Ерөнхийлөгч Монсон өнөөдөр бидний бошиглогч гэдгийг би мэднэ, Есүс Христийн нэрээр, амен.

#### Эшлэлүүд

1. Сургаал ба Гэрээ 20:77.
2. Иохан 15:12.
3. Томас С.Монсон, “Өнөөдөр би хэнд юу хийж тусласан бэ?” *Лиахона*, 2009 оны 11сар, 86.
4. Канион Х., “A Good Choice,” *Friend*, 2012 оны 1 сар, 31
5. Матай 5:44.
6. Матай 25:40.
7. “For Madison,” [lds.org/youth/video/for-madison-ыг үзнэ үү](http://lds.org/youth/video/for-madison-ыг үзнэ үү).
8. Моронай 7:47.
9. Томас С.Монсон, “Хайр хэзээ ч дуусдаггүй,” *Лиахона*, 2010 оны 11 сар, 125-г мөн *Миний хаант улсын охид: Нийгмийн халамжийн бүлгийн түүх ба ажил* (2011)-ыг үзнэ үү.
10. 3 Нифай 14:12.
11. Al VanLeeuwen, “Serving the One,” *Liahona*, Aug. 2012, 19 ; Sally DeFord, “If I Listen with My Heart,” *2011 Outline for Sharing Time*, 28-ыг үзнэ үү..
12. 3 Нифай 27:21.
13. Ричард Г.Скотт, “Мөнхийн гэрлэлтийн адислалууд,” *Лиахона*, 2011 оны 5сар, 96.
14. Матай 20:26.
15. Роберт Д.Хейлс, “Материаллаг болон сүнслэг байдлаараа аз жаргалтай хангалуун амьдрах нь,” *Лиахона*, 2009 оны 5сар, 9.
16. Матай 20:32.



---

# Зүрх сэтгэлээрээ сурах нь

Далын Ерөнхийлөгчийн Зөвлөлийн

Ахлагч Волтер Ф.Гонзалес

---

*Христэд ирэх нэг арга зам бол чухал үнэнүүдийг зүрх сэтгэлээрээ суралцахыг эрэлхийлэх явдал юм.*

---

“Та нар тэмтэрч мөн харж болохын тулд надад ир.”<sup>1</sup> Энэ нь Аврагчийн эртний Америкийн оршин суугчдад өгсөн зарлиг юм. Тэд Есүс бол Христ гэдгийг гараараа тэмтэрч үзэн, нүдээрээ харсан. Тэдний хүлээн авсан энэхүү зарлиг нь тэдэнд чухал байсны адил өнөөдөр ч гэсэн бидэнд чухал. Бид ч бас Христэд ирснээр гар болон нүдээрээ биш ч гэсэн зүрх сэтгэл, оюун санаагаараа Есүс бол Христ гэдгийг мэдэрч, “баттай мэдэж”<sup>2</sup> чадна.

Христэд ирэх нэг арга зам бол чухал үнэнүүдийг зүрх сэтгэлээрээ суралцахыг эрэлхийлэх явдал юм. Ингэснээр Бурханаас ирэх мэдрэмж, сэтгэгдлүүд бидэнд өөр ямар ч замаар олж авч чадахгүй мэдлэгийг өгөх болно. Төлөөлөгч Петр Есүс бол Христ, Амьд Бурханы Хүү гэдгийг мэддэг байжээ. Аврагч Петрт түүний олж авсан мэдлэгийн эх сурвалжийг “мах цус нь биш, харин тэнгэр дэх Эцэг минь илчилсэн”<sup>3</sup> гэж тайлбарлажээ.

Бурханаас ирдэг эдгээр мэдрэмжүүдийн зорилгыг бошиглогч Абинадай хаан Ноагийн өмнө санваартнуудад тайлбарласан байдаг. Бид судруудыг зүрх сэтгэлээсээ ойлгохыг хичээхгүй бол тэдгээрийг бүрэн дүүрэн ойлгож чадахгүй хэмээн Абинадай заасан.<sup>4</sup>

Уг үнэнийг бидний сайн мэдэх Сейнт Ексюперигийн бичсэн *Бяцхан Ханхүү* хэмээх хүүхдийн номонд гайхамшигтайгаар дүрсэлсэн байдаг. Уг номонд бяцхан ханхүү үнэгтэй найзалдаг. Үнэг явахасаа өмнө бяцхан

ханхүүтэй нэгэн нууц хуваалцжээ. Тэр “Надад нэг нууц байна . . . { : Нүдэнд үл харагдах энэ чухал зүйлийг зүрхээрээ л ганцхан харж болно”<sup>5</sup> гэжээ.

88 настай Томас Коелхо ах бол зүрх сэтгэлээрээ мэдэрч, харсан хүний гайхалтай жишээ юм. Тэрээр Уругвай улсын Пайсанду дахь манай дээд зөвлөлийн итгэлтэй гишүүн билээ. Коелхо ах Сүмийн гишүүн болохоосоо өмнө мотоцикль барьж яваад осолд оржээ. Тэрээр газарт хөдөлж чадахгүй хэвтэж байх үед нь хоёр номлогч хажуугаар нь явсан байна. Тэд түүнд босч, гэртээ харихад нь тусалжээ. Коелхо ах номлогч нарыг түүнд туслахаар ирэх үед ямар нэгэн онцгой мэдрэмж мэдэрсэн гэдгээ хэлсэн. Хожим нь номлогч нар түүнд хичээл заахад тэрээр хүчтэй мэдрэмжийг дахин хүлээн авчээ. Тэрээр Мормонь Номыг эхнээс нь дуустал нь хэдхэн өдөр уншихдаа мөн адил мэдрэмжийг мэдэрчээ. Тэрээр тэр цаг үеээс хойш итгэлтэйгээр, хичээнгүй үйлчилсэн. Тэрээр бүр тэтгэм хүйтэн өвлийн өдрүүдэд ч бусдыг Сүмд авчрахын тулд мотоцикль унаад манай гудамжаар явдаг байсныг би санадаг. Тэр хүмүүст үлгэр жишээ болдог байв.

Өнөөдөр бидний эргэн тойронд тоо томшгүй их мэдээлэл байгаа бөгөөд бид мэдэхийг хүссэн бүх зүйлээ сая сая вэб хуудсаас олж чадна гэж бодож магадгүй. Бид интернетээс сайн, муу мэдээллийг олж болох боловч мэдээлэл дангаараа хангалтгүй. Бурхан бидэнд илүү агуу мэдлэгийг бүр тэнгэрээс ирэх мэдлэгийг олж болох нэгэн эх сурвалжийг өгсөн билээ.<sup>6</sup> Бид зүрх сэтгэл, оюун санаандаа тэнгэрлэг эх сурвалжуудаас мэдлэгийг эрэлхийлэх юм бол Тэнгэрлэг Эцэг маань бидэнд мэдлэгийг өгөх болно. Бошиглогч Иосеф Смит “хамгийн эртний ном болох Ариун Сүнсний бэлэг [миний] зүрхэнд байдаг”<sup>7</sup> гэжээ.

Бид судруудыг судалж, амьд бошиглогчдын үгсийг анхааран сонсож, залбирах үед Ариун Сүнс бидэнд ирдэг. Мөн үүний хажуугаар селестиел өдөөлтүүдийг тунгаан бодож, мэдрэх цаг гаргах нь чухал юм.<sup>8</sup> Бид эдгээрийг хийснээр орчин үеийн техник технологиос олох боломжгүй зүйлсийг “мэдэрч, харах” болно. Бид тэнгэрлэг эх сурвалжуудаас эрэлхийлэх илүү туршлагатай болсон үедээ сүнслэг бус түүх эсвэл сэдвийг унших үедээ ч үнэнийг ялгаж

салгаж чадах болно. Үнэнийг үнэхээр эрэлхийлэгчид Ариун Сүнсний хүчээр бүх зүйлийн үнэнийг мэдэж болно.<sup>9</sup>

Одоо би анхааруулгын үгсийг хэлмээр байна. Энэхүү селестиел эх сурвалжаас эрэлхийлэх бидний чадвар алдсыг үйлдэж, Их Эзэнийг мартсан үед багасдаг. Нифай ах нартаа тэд “алдсыг үйлдэхдээ шаламгай боловч Их Эзэн Бурханаа санахдаа удаан”<sup>10</sup> учраас “түүний үгсийг мэдэрч чадсангүй” гэж хэлдэг. Алдас нь харж, мэдэрч, бусдыг хайрлах чадварыг буруулдаг. Зүрхнийхээ бүхий л эрч хүчээр залбирч,<sup>11</sup> сүнслэг туршлагаа даансанаар, Их Эзэнийг санахдаа шаламгай байх нь бидний Христийн зүйлсийг харж, мэдрэх чадварыг нэмдэг. Би одоо та нараас нэг асуулт асууя!

- Та их зовлонгийн үед тусламж хүсэн Эцэгт хүчит залбирал өргөснийхөө дараа мэдэрсэн амар амгаланг санаж байна уу?
- Та зүрх сэтгэлд тань ирсэн өдөөлтүүдийн дагуу хийх зүйлсийнхээ жагсаалтыг өөрчилж байсан уу?

Мормоны Номонд гардаг агуу эрс чухал сүнслэг туршлагаа даансанаар агуу мэдлэгийг хүлээн авах чадвараа сайжруулсан. Алма хүүхдүүддээ өөрийнхөө хөрвөлтийн туршлагын талаар сануулж тэднийг хүчирхэгжүүлсэн байдаг.<sup>12</sup> Хиламан Нифай, Лихай хоёрт Христийн хадан дээр сууриа тависнаар чөтгөр тэднийг дийлэх хүчгүй байх болно<sup>13</sup> гэдгийг санаж явахыг заадаг. Бид ч бас үүнийг хийх ёстой. Бурханыг санах нь бидэнд мэдэрч, амьдрахад тусалдаг. Энэ нь “Мөн эдүгээ, Ай хүмүүн, санагтун, мөн бүү мөхөгтүн”<sup>14</sup> хэмээн хэлсэн хаан Бенжамины үгст илүү гүнзгий ач холбогдол өгдөг.

Миний хамгийн ариун нандин, үнэ цэнэтэй дурсамжуудын нэг нь Мормоны Ном Бурханы үг гэдгийг мэдэх үедээ мэдэрсэн мэдрэмж байдаг. Би тэр өдөр өөр ямар ч замаар сурч чадаагүй зүйлсийг мэдэрч, баттай мэдсэн юм. Үгээр илэрхийлэхийн аргагүй баяр баясгаланг хүн эдэлж болдгийг би ойлгосон. Энэ дурсамж нь миний амьдралын төгсөшгүй талархлын шалтгаан бөгөөд хүнд хэцүү үед намайг хүчирхэгжүүлдэг билээ.

Мах болон цуснаас биш харин Тэнгэрлэг Эцэгээс мэдлэг хүлээн авдаг тэд Есүс бол Христ, энэ бол Түүний Сүм гэдгийг баттай мэддэг. Энэ мэдлэг нь бидэнд Христ рүү ирэхэд шаардлагатай өөрчлөлтүүдийг хийх хүч чадлыг өгдөг. Ийм учраас бид одоо бодгаль бүрийг нүглээ наманчлан, баптисм хийлгэн мөн Түүн рүү ирэхийг урьж байна.<sup>15</sup>

Христэд ирснээр бодгаль бүр Христ бидний нүглийн төлөө, бидэнд мөнхийн амьдралыг өгөхийн тулд зовж шаналан мөн цагаатгасан гэдгийг харж, мэдэрч, баттай мэднэ. Хэрэв бид наманчлах юм бол дэмий шаналж зовохгүй байх болно.<sup>16</sup> Шархадсан зүрх сэтгэлийг эдгээж, харууссан зүрхийг тайтгаруулах боломжтой байгаад Түүнд талархаж байна. Түүнд бидний нуруунаас авч, хөнгөлж чадахгүй ямар ч ачаа байхгүй. Тэрээр бидний өвчин зовлон, дутагдлыг мэддэг. Бүх хаалга хаалттай, бүх зүйл нурсан мэт санагдах үед Тэрээр биднийг сэтгэлээр унагаахгүй гэдгийг би амлаж, гэрчилж байна. Бидэнд донтолт, сэтгэл санааны хямрал эсвэл өөр юу ч тохиолдсон байсан гэсэн Христ бидэнд туслах болно мөн бидний гарах гарц байх болно. Тэр Өөрийн хүмүүст хэрхэн туслахаа мэддэг.<sup>17</sup> Эдийн засаг, хэвлэл мэдээллийн муу нөлөөллөөс эсвэл гэр бүлийн нөхцөл байдлаас болж зовж байгаа гэрлэлт, гэр бүл тэнгэрээс тайтгаруулагч нөлөөг мэдрэх болно. Тэрээр жигүүртээ эдгээх чадлыг эзэмдэн<sup>18</sup> үхлээс боссон гэдгийг “тэмтэрч, харах” нь сайхан бөгөөд Түүний ачаар бид нас барсан хайртай хүмүүстэйгээ дахин уулзаж, тэднийг тэврэх болно. Түүнд хөрвөсөн хөрвөлт маань эдгээлтээр шагнагдсан нь гарцаагүй.<sup>19</sup>

Энэ бүхэн үнэн гэдгийг би баттай мэднэ. Энэ шалтгааны учир би эртний Америкийн оршин суугчидтай нэгдэн дуу алдмаар байна: “Хосанна! Бүхний Дээд Бурханы нэр алдаршиг!”<sup>20</sup> Тэр бидэнд авралыг хайрласан. Есүс бол Христ, ариун Мессиа гэдгийг би гэрчилж байна. Тэр бол түмэн цэргийн Эзэн, бидний Аврагч, Гэтэлгэгч билээ. Есүс Христийн нэрээр, амен.

#### Эшлэлүүд

1. 3 Нифай 18:25.
2. 3 Нифай 11:15.
3. Матай 16:16–17-г үзнэ үү.
4. Мозая 12:27-г үзнэ үү.

5. Антони Сейнт Ексюпери *Бяцхан Ханхүү* Катрин Воодсийн орчуулга (1971), 87.
6. Ифер 4:13-г үзнэ үү.
7. *Сүмийн Ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит* (2007), 132.
8. Сургаал ба Гэрээ 101:16-г үзнэ үү.
9. Моронай 10:3–5-г үзнэ үү.
10. 1 Нифай 17:45.
11. Моронай 7:48.
12. Алма 36:5–24; 38:6–9-г үзнэ үү.
13. Хиламан 5:12-г үзнэ үү.
14. Мозая 4:30.
15. 3 Нифай 9:13-г үзнэ үү.
16. Сургаал ба Гэрээ 19:16-г үзнэ үү.
17. Алма 7:12.
18. 2 Нифай 25:13; мөн 3 Нифай 25:2-г үзнэ үү.
19. 3 Нифай 11:15–17 мөн 3 Нифай 9:13-г үзнэ үү.
20. 3 Нифай 11:15–17-г үзнэ үү.

---

# Эхний агуу зарлиг

**Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын**

*Ахлагч Жеффри Р.Холланд*

---

*Бид насан туршдаа чин үнэнч шавь байж, Их  
Эзэнд хайраа харуулах ёстой*

---

Дэлхийн Аврагчийг амиа алдсаны дараахан амьдарч байсан арваннэгэн Төлөөлөгчийг би дэлхий дээр амьдарч байсан бусад ямар ч хүмүүсээс илүүтэйгээр хайрлаж, дээдлэн хүндэлдэг билээ. Тэд тухайн үедээ хараахан туршлага суугаагүй байсан болохоор Есүсээс бүрэн хамааралтай байсныг бид заримдаа мартдаг болов уу гэж би боддог. Тэрбээр тэдэнд, “Би та нартай ийм удаан хамт байхад, чи Намайг таньсангүй гэж үү?”<sup>1</sup> хэмээн хэлсэн.

Гэвч, тэд Аврагч өөрсөдтэй нь хамт тийм ч удаан байсан гэж боддоггүй ажээ. Гурван жил гэдэг бол шинээр хөрвөгчид цөөхөн байсан тэр үед тэднийг хуучин ёс заншлын алдаанаас нь ангижруулж, Есүс Христийн сайн мэдээний гайхамшигийг тэдэнд заан, Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүдийг алагдаж дуусах хүртэл энэ ажлыг үргэлжлүүлэн авч явахын тулд тэднийг бэлтгэхэд хангалттай удаан хугацаа биш байлаа. Шинээр томилогдсон ахлагч нарын бүлэгт энэ ажлыг ирээдүйд үргэлжлүүлэх нь үнэхээр хүнд байсан юм.

Аврагч тэдний дэргэд өөрийн биеэр байхаа больсон нь тэдэнд бүр ч хэцүү байжээ. Есүс өөрийн биеэр тэдэнтэй цаашид хамт *байхгүй* гэдгийг удаа дараа хэлж байсан ч тэд ийм гунигтай үгийг нэг бол ойлгоогүй, эсвэл ойлгохыг хүсээгүй хэрэг. Марк ийн бичсэн байдаг:

“Есүс шавь нартаа зааж, тэдэнд, Хүний Хүү хүмүүсийн гарт тушаагдана. Тэд Түүнийг ална.Тэр алагдсанаасаа хойш гурав хоногийн дараа амилах болно гэж айлдав.

“Гэвч шавь нар энэ үгийг нь ойлгосонгүй.”<sup>2</sup>

Тиймээс ийм богинохон хугацаанд Христээс өөрөөс нь мэдлээ ч үүнд бэлтгэх цаг байгаагүй болохоор тэдний огт бодоогүй эсвээс огт итгэхийн аргагүй үйл явдал болж өнгөрсөн юм. Тэдний Их Эзэн, Багш, тэдний Зөвлөгч бөгөөд Хаан цовдлогдов. Мөнх бус амьдрал дахь Түүний үйлчлэл дуусч, Түүний үндэслэн байгуулсан жижигхэн Сүм хүнд байдалд орж, нүд үзүүрлэгдэн, мөхлийн хувь тавилан түүнд нүүрлэсэн билээ. Түүний Төлөөлөгчид Түүний амилалтыг гэрчилсэн ч, энэ нь тэдэнд мөн л ойлгохын аргагүй хачирхалтай хэрэг байлаа. Тэд яах ч учраа олохгүй, “Одоо бид яах билээ?” хэмээн гайхширч байсан нь лавтай. Тэд энэ асуултандаа хариу авахаар ахлах Төлөөлөгч Петрт ханджээ.

Тэд судруудад байдаггүй үгсээр бие биедээ хандан юу гэж ярилцсан байж болохыг төсөөлөн дүрслэхийг надад зөвшөөрнө үү. Петр нөхдөдөө ингэж л хэлсэн болов уу: “Ах нар аа, яруу алдарт түүхт гурван жил ард өнгөрлөө. Бидний хэн нь ч ийм гайхамшиг болно гэдгийг бас ийм бурханлаг туршлага бидэнд тохиох юм гэдгийг ганц хоёрхон сарын өмнө ч болов төсөөлж чадсангүй. Бид Бурханы Хүүтэй яах аргагүй мөр зэрэгцэн алхаж, Түүнтэй хамт залбиран, Түүнтэй цуг ажиллаж байжээ. Бид Түүнтэй хамт алхаж, Түүнтэй хамт уйлж явлаа. Тэрхүү аймшигт шөнийн төгсгөлд, над шиг гашуунаар уйлсан хүн нэг ч байсангүй. Гэвч энэ бүхэн төгсгөл боллоо. Тэрбээр Өөрийн ажлыг дуусган, булшнаас амилан бослоо. Тэр Өөрийн авралыг бас биднийхийг гүйцээлээ. Тиймээс та нар , ‘Одоо бид яах билээ?’ гэж асуулаа. Хуучин амьдралдаа эргэн орж, баяртай бай гэхээс өөр юуг та нарт хэлэхээ мэдэх юм надад алга. Миний хийхээр төлөвлөж буй хамгийн чухал зүйл бол ‘загасчлахаар явах’ ” хэмээн хэлэхэд бусад арван Төлөөлөгчийн хамгийн багаар бодоход зургаа нь, “Бид бас чамтай хамт явна” гэж нэгэн дуугаар хэлсэн биз ээ. Тэдний нэг нь болох Иохан, “Тэд явж, завиндаа суув”<sup>3</sup> хэмээн бичсэн юм.

Гэвч, харамсалтай нь, тэдэнд загас баригдсангүй. Тэд анхны шөнө нуур руу очиж загасчилсан боловч, ганц ч загас барьсангүй. Үүр цайхад тэд эрэг рүү завиа урамгүйхэн эргүүлэн буцаж явтал, нэг хүн нэлээд хол зогсон, “Хүүхдүүд ээ, та нар загас барив уу?” гэж хашгирах нь сонсогдов.

Урьдынх шигээ загасчид болохоор шийдсэн эдгээр Төлөөлөгчид “Бид юу ч барьж чадсангүй” гэж загасчин хүний хэлэх дургүй тэрхүү үгсээр хариулжээ. Тэгээд бас тэднийг “хүүхдүүд”<sup>4</sup> гэсэнд нь тэд гоморхсон нь лавтай.

“Завиньхаа баруун талд тороо хая. Тэгвэл та нар олз олно”<sup>5</sup> гэж үл таних хүн эдгээр энгийн үгсийг чанга хэлэхэд, хэн ингэж хэлснийг тэд тэр дороо таньжээ. Яг гурван жилийн өмнө эдгээр эрчүүд мөн энэ газартаа энэ тэнгист загасчилж байсан билээ. Тэр үед тэд мөн л “шөнөжингөө загасчлаад юу ч бариагүй”<sup>6</sup>-г судрууд өгүүлдэг. Гэтэл эрэг дээр байсан Галилын нэгэн хүний хэлсний дагуу, тороо тавьтал тор нь урагдаж эхлэн, “маш их хэмжээний загас”<sup>7</sup> барьж, хоёр завийг дүүргэхэд тэд живж эхэлсэн ажээ.

Эдүгээ энэ явдал давтагдах нь тэр. “Хүүхдүүд” хэмээн дуудагдсан мөнөөх загасчид тороо хэлсний дагуу дуртайяа хаяхад, “маш их загас торонд нь орсон тул тороо ч татаж чадахааргүй болжээ.”<sup>8</sup> “Энэ чинь Эзэн мөн байна”<sup>9</sup> гэж Иоханыг баярлан хэлэхэд Петр өөрийн мэдэлгүй завины ирмэг дээрээс харайн босчээ.

Петр амилсан Есүстэй баяртайгаар эргэн уулзаж, Аврагчтай ярилцсан юм. Энэхүү яриа нийт төлөөлөгчдийн үйлчлэлийн түүхэнд, ялангуяа халшрахыг үл мэдэгч, хатан зоригт Петрийн хувьд төлөөлөгчийн амь насаа зориулсан агуу үйлчлэлд шийдвэрлэгч эргэлтийн үе болж, түүнд сүнслэгээр нөлөөлсөн гэж би боддог. Есүс, ачаагаа дааж ядсан тэдний завь, урагдаж сэмэрсэн тор, завин дээр овоолсон 150 гаруй загасыг харснаа ахлах Төлөөлөгч Петртээ хандан, “Петр ээ, чи намайг тэднээс илүү хайрладаг уу?” гэж асуухад Петр, “Тийм ээ, Эзэн; миний Танд хайртайг Та мэднэ”<sup>10</sup> гэж хариулав.

Аврагч хариу хэлсэн шавийнхаа нүдийг ширтэн байж, “Петр ээ, чи Намайг хайрладаг уу?” гэж хоёр дахь удаагаа асуужээ. Аврагч хоёр дахь удаагаа ингэж асуусанд агуу загасчин бага зэрэг гайхсан ч, “Тийм ээ, Эзэн. Миний Танд хайртайг Та мэднэ”<sup>11</sup> гэсэн билээ.

Аврагч дахин товчхон хариулсан ч, гурав дахь удаагаа бүр их сонжсон байдалтайгаар, “Петр ээ, чи намайг хайрладаг уу?” гэж асуужээ. Ийнхүү Их Эзэнийг гурав дахь удаагаа асуухад Петр үнэхээр гунигласан нь мэдээж хэрэг. Хэдхэн



хоногийн өмнө өөр нэг асуултыг түүнээс гурван удаа асуухад тэрээр үгүй гэж эрс шулуухан хариулсан нь санаанд нь орсон байх. Эсвэл тэр Их Эзэнийхээ асуултыг буруу ойлгосон юм болов уу гэж тээнэгэлзсэн ч байж мэдэх. Магадгүй тэр бэлэн зэлэн үгээр шууд хариулж байснаа зүрх сэтгэлдээ шинжиж, чин шударга хариугаа батлах гэсэн байж ч бас болно. Петр тэрхэн агшинд юу гэж бодож байсан нь хамаагүй, харин гурав дахь удаагаа, “Эзэн, . . . Миний Танд хайртайг Та мэднэ гэсэн билээ.”<sup>12</sup>

Есүс Түүний энэ хариултанд иймэрхүү янзаар хариулсан болов уу (Миний энэхүү зохиомол түүх судруудад байхгүй гэдгийг дахин хэлье). “Петр ээ, тэгвэл чи яагаад энд байгаа юм бэ? Яагаад бид мөн нөгөөх эрэг дээрээ нөгөөх загасны торныхоо дэргэд, мөн нөгөөх л зүйлээ ярьцгааж байгаа билээ? Загасчлах нь тэр үед ч миний хүсэл байгаагүй, одоо ч миний хүсэл биш гэдэг нь тодорхой байгаа бус уу? Би загас барих гэж байгаа юм гэж үү? Петр ээ, надад шавь нар хэрэгтэй. Тэд надад үүрд хэрэгтэй. Хоньдыг минь тэжээж, хургануудыг минь аврах хүмүүс надад хэрэгтэй байна. Сайн мэдээг минь номлож, сүмийг минь хамгаалах хүмүүс надад хэрэгтэй байна. Намайг чин үнэнээсээ хайрладаг бөгөөд та биднээр хийлгэхээр Тэнгэр дэх бидний Эцэгээс надад итгэл хүлээлгэн өгсөн ажлыг хийх сэтгэл бүхий хүмүүс надад хэрэгтэй байна. Бидний захиас үлбэгэр сулхан байх ёсгүй, бидний ажил үтэр түргэн дуусах ёсгүй. Энэ ажлыг амжилт олох хувь тавилангүй, найдваргүй гэж үзэж болохгүй юм. Үүнийг бас түүхийн хог гэж үзэх ёсгүй. Энэ бол Бүхнийг Чадагчийн ажил бөгөөд энэ нь дэлхийг өөрчлөх болно. Тиймээс Петр чамаас загасчлах ажлаа орхиод, ёс бус хүмүүс Миний амийг егүүтгэсэн шиг чиний амийг хөнөөх тэр өдрийг хүртэл хүмүүст зааж, гэрчлэн, үйлчилж, чин үнэнчээр хөдөлмөрлөхийг би хоёр дахь удаагаа, магадгүй сүүлчийн удаа хүсч байна.”

Тэгээд Тэрбээр бүх Төлөөлөгчид рүүгээ эргэн харж, “Та нар хуульчид, фарисайчууд, Херод, Пилат нар шиг муйхар хүмүүс юм гэж үү? Та нар мөн тэдэнтэй адил намайг хөнөөчихвөл энэ ажлыг үгүй болгочихно гэж бодсон уу? Та нар тэдэнтэй адил загалмай, хадаас, булшаар бүх зүйлийг дуусгавар болгож, урьдын байдалдаа орно гэж бодож байна

уу? Хүүхдүүд ээ, миний амьдрал, миний хайр та нарын сэтгэл зүрхэнд шингээгүй юм гэж үү, тийм үү?” гэсэн байх.

Хайрт ах эгч нар аа, бид Эцсийн Шүүлтийн Өдөр юу тохиолдохыг сайн мэдэхгүй. Эцсийн Шүүлтийн Өдөр Эцэг маань биднээс Христ Петрээс асуусаны адилаар бүх зарлигуудаас хамгийн чухал *нэгийг нь* “Чи бүх зүрх, бүх сэтгэл, бүх оюун ухаанаараа өөрийн Бурхан Эзэнээ хайрла”<sup>13</sup> гэсэн “эхний бөгөөд хамгийн агуу” зарлигийг бид мөнх бус, нэн дутуу дулимаг, заримдаа хүүхдийнх шиг гэнэн цайлган оюун ухаанаараа, яс махандаа шингэтэл ойлгосон эсэхийг мэдэхийг хүсэх болно гэж би боддог. Тэр үед бид түгдрэн байж, “Тийм ээ, Эзэн. Миний Танд хайртайг Та мэднэ” гэж хэлэхэд, Тэрбээр хайрын дээд охь манлай нь чин үнэнч зан чанар гэдгийг бидэнд сануулах биз ээ.

“Хэрвээ та нар Намайг хайрладаг бол, Миний тушаалуудыг сахь”<sup>14</sup> гэж Есүс хэлсэн билээ. Тэгэхээр бидэнд адислах хөршүүд, хамгаалах үр хүүхдүүд, дэмжин туслах ядуус бий. Бид бас үнэнийг өмгөөлөн хамгаалах ёстой. Бид буруу зүйлийг зөв болгон, үнэнийг хуваалцаж, сайныг үйлдэх ёстой. Товчоор хэлбэл, бид насан туршдаа чин үнэнч шавь байж, Их Эзэнд хайраа харуулах ёстой. Бид бууж өгч болохгүй, замаасаа ухарч няцах ёсгүй. Амьд Бурханы, амьд Хүүтэй учирсны эцэст бүх зүйл урьдын адил хуучин хэвээрээ байх ёсгүй. Есүс Христийн Цовдлолт, Цагаатгал болон Амилалт нь Христэд итгэгчдийн амьдралын эхлэл болохоос, төгсгөл нь биш юм. Галилын хуруу дарам цөөхөн загасчид дахин Төлөөлөгчид болж, ганц ч синагоггүйгээр эсвээс нэгээхэн ч илдгүйгээр эдүгээ бидний амьдарч буй дэлхийг өөрчлөхөөр явцгаасан билээ.<sup>15</sup>

Тэдгээр төлөөлөгчдийн түлхүүрүүд дэлхийд сэргээгдсэн бөгөөд Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд байгаа гэдгийг би бүх хүмүүст чин сэтгэлийнхээ угаас гэрчилж байна. Христийн энэхүү агуу үйл хэрэгт бидэнтэй хараахан нэгдээгүй байгаа хүмүүсийг бид “Христэд ирэгтүн” хэмээн урьж байна. Бидэнтэй нэгэн үед хамт байсан ч Сэргээлтийн найрын ширээн дээрх зоогноос дөнгөж амсаад найрыг орхиж явсан хүмүүст хандаж, “Та нар олон шөнийг нойргүй өнгөрөөсөн ч, загасны тор чинь хоосон байна”

гэдгийг би хэлэх гэсэн юм. Та бүхнийг эргэж ирэн, Бурханыг хайрлаж, Түүнд үнэнч байж, тусламжийн гараа сунгана уу гэж уриалъя. Энэхүү уриалгад би баптисмын усан санд зогсоод, гараа дээш өргөн, “Есүс Христийн итгэмжлэгдсэнээр”<sup>16</sup> хэмээн хэлж байсан, бүх буцаж ирсэн номлогчдыг оруулж байна. Энэхүү итгэмжлэл нь зөвхөн хөрвөгчийг үүрд өөрчлөхөөс гадна мөн та бүхнийг ч өөрчилсөн байх ёстой. Бид ариун сүм, номлол, гэрлэлтэд бэлтгэгдэж байгаа Сүмийн залуучуудад хандан “Бурханыг хайрла, итгэлтэй бай. Энэ үеийн цус болон нүглээс хол байж, цэвэр ариун хэвээр үлдээч” хэмээн хэлэхийг хүсч байна. Та бидэнд хийх агуу ажил байна. Ерөнхийлөгч Томас С.Монсон өчигдөр өглөө хэлсэн гайхамшигт үгэндээ энэ ажлын ач холбогдлыг өндрөөр үнэлсэн билээ. Тэнгэрлэг Эцэг маань та бүхнийг амьдралынхаа туршид Түүнийг хайрлаж мөн Түүнд чин үнэнч байхыг үргэлж хүсэн хүлээж байдаг.

Миний захиасыг сонсож байгаа бүх хүмүүст хандан, “Чи Надад хайртай юу?” хэмээн Христийн дуу хоолой биднээс нэг бүрчлэн асуух цаг айсуу. Би та бүхний өмнөөс чин сэтгэлийнхээ угаас, “Тийм ээ, бид Танд хайртай” гэж хариулъя. Бид Их Эзэний ажилд гар бие оролцсон л бол ажлаа хийж дуустал, Бурханыг болон хөршөө хайрлах үнэнч хайр, бидний хайр дэлхийд ноёрхох хүртэл ухарч няцах ёсгүй.<sup>17</sup> Есүс Христийн нэрээр, Амен.

#### Эшлэлүүд

- |                           |   |
|---------------------------|---|
| 1. Иохан 14:9.            | 11. Иохан 21:16.  |
| 2. Марк 9:31–32.          | 12. Иохан 21:17.  |
| 3. Иохан 21:3.            | 13. Лук 10:27; мөн Матай 22:37–38-ыг үзнэ үү.                                     |
| 4. Иохан 21:5-ыг үзнэ үү. | 14. Иохан 14:15.  |
| 5. Иохан 21:6.            | 15. Фредрик В.Фаррар <i>The Life of Christ</i> (1994), 656; 62-р бүлгийг үзнэ үү. |
| 6. Лук 5:5.               | 16. Сургаал ба Гэрээ 20:73.   |
| 7. Лук 5:6.               | 17. Лук 9:62.   |
| 8. Иохан 21:6.            |   |
| 9. Иохан 21:7.            |   |
| 10. Иохан 21:15.          |   |

# Адислалуудын тухай тунгаан бод

Ерөнхийлөгч Томас С.Монсон

---

*Тэнгэрлэг Эцэг маань бидний хэрэгцээг мэднэ,  
түүнээс тусламж хүссэн цагт Тэр тусалдаг*

---

Хайрт ах, эгч нараа, 1963 оны 10-р сарын 4-нд би Арванхоёр Төлөөлөгчийн Чуулганы гишүүнээр дэмжигдсэнээс хойш 49 жил өнгөрч. Энэ бол урт хугацаа. Гэсэн хэдий ч Табернеклын индэр дээр зогсон анхны яриагаа өгснөөс хойш нэг их удаагүй юм шиг бас надад санагдаад байна.

1963 оны 10-р сарын 4-өөс хойш их ч зүйл өөрчлөгдөж. Дэлхийн түүхэн дэх их өвөрмөц цаг хугацаанд бид амьдарч байна. Бид ихээр адислагджээ. Гэвч заримдаа эргэн тойронд маань байгаа асуудал, нүглийг хүлцэнгүйгээр тэвчиж байгааг хараад сэтгэлээр унахгүй байхын аргагүй. Болох бүтэхгүй дээр анхаарлаа төвлөрүүлж байснаас, ганцхан алхам ухарч, бага мэт санагддаг, тэр болгон анзаарагдаад байдаггүй амьдралдаа хүлээн авсан адислалуудаа тоолоход бид илүү их аз жаргалтай болдгийг би анзаарсан юм.

Би сүүлийн 49 жилийг судлан нилээн хэдэн нээлт хийлээ. Нэгийг нь дурдвал, надад тохиолдож байсан тоо томшгүй олон зүйлээс өнгөцхөн харахад ганц нь ч ер бусын байгаагүй юм шиг. Харин ч бүр эсрэгээрээ яг тохиолдож байх үедээ тэдгээр нь ихэнхдээ жирийн, заримдаа бүр хэт энгийн мэт санагдаж байсан байх юм. Гэсэн хэдий ч, эргээд харахад тэдгээр нь хүмүүсийн амьдралыг сайжруулж мөн адисалсан байдаг-тэр дундаа миний ч амьдралыг адислажээ. Та бүгд бас миний хийснийг хийгээд үзээсэй гэж би хүсч байна. Та бүгд

амьдарлаа эргэн харж, хүлээн авч байсан том, жижиг адислалуудаа хэрэг болгон санах гээд үз дээ.

Өнгөрүүлсэн амьдралаа эргэн харах явцад залбирлын хариу ирдэг гэдэг мэдлэг маань дахин дахин нотлогдож байсан юм. Мормоны номны 2 Нифайд гардаг: “баясгалантай байж болохын тулд хүмүүн байх бөлгөө”<sup>1</sup> гэх үнэнийг бид бүгд мэднэ. Залбирлаараа бид Тэнгэрлэг Эцэгтэйгээ харьцаж болдог, Тэр бидний залбирлыг сонсож мөн хариулдаг гэдгийг мэдэх цагт энэ баяр баясгалан ирдэг гэдгийг би гэрчилж байна. Залбирлын хариунууд маань яг одоо ч юмуу эсвэл яг хүссэн үед маань ирэхгүй байж магад, гэхдээ л эрт орой хэзээ нэгэн цагт заавал *ирнэ* биднийг төгс хайрлаж, жаргалтай байхыг хүсдэг Тэнгэрлэг Эцэг хариултыг маань өгөх л болно. “Чи даруу бай; тэгвэл чиний Бурхан Их Эзэн чамайг гараас чинь хөтөлж мөн залбирлуудад чинь чамд хариу өгөх болно”<sup>2</sup> гэж Тэр амласан шүү дээ.

Надад олдсон цагийг ашиглан би та нартай залбирлууд хариулагдаж байсан талаар хэдхэн туршлага хуваалцаж, эргээд харахад тэдгээр нь намайг болон бусдын амьдралыг хэрхэн адислаж байсан талаар ярихаар шийдээд байна. Харин ингэхийн тулд өнгөрсөн он жилүүдийн турш өдөр болгон хөтөлж байсан өдрийн тэмдэглэлээсээ мартсан байсан зарим нэг мэдээллүүдийг олж авлаа.

1965 оны эхээр намайг Өмнөд Номхон Далайн бүс нутгийн гадасны чуулганууд болон бусад цуглаануудыг удирдуулахаар томилсон юм. Би дэлхийн тэр хэсэгт анх удаагаа л очиж байсан бөгөөд тэр үеийг хэзээ ч мартдаггүй. Тэрхүү томилолтын хугацаанд удирдагч, гишүүд, номлогч нартай уулзаж байхад ихэнх сүнслэг туршлагаууд маань тохиож билээ.

Бямба, Ням гарагууд болох 2-р сарын 20, 21-нд бид Австралийн Бризбен хотод Бризбен Гадасны Чуулганыг хийхээр очоод байлаа. Бямба гарагийн цуглаан дээр би нэгэн Дүүргийн Ерөнхийлөгчтэй танилцав. Түүнтэй гар барих агшинд, түүнтэй ярилцаж, зөвлөгөө өгөх ёстой юм байна гэсэн хүчтэй мэдрэмж надад төрөв. Түүнтэй уулзахын тулд би түүнд маргааш өглөөний цуглаанд надтай нэгдэхийг санал болгосон юм.

Ням гарагийн цуглаан дуусахад бид хоёрт сууж ярилцах боломж олдлоо. Дүүргийн Ерөнхийлөгчийн олон хариуцлагынх нь талаар нилээн ярилцлаа. Тэгж байтал надад номлолын ажил, тэр дундаа тэр удирдагч, гишүүдтэйгээ хамтран өөрсдийн нутагт үйлчилж байгаа номлогч нартаа хэрхэн тусалж болох талаар тодорхой хэдэн зөвлөмж өгөх ёстой юм шиг санагдаад явчихав. Тэр ерөнхийлөгч яг энэ тал дээр яах ёстойгоо мэдэхийн тулд залбирч байсныг би хожим нь мэдсэн юм. Надтай ярилцах завшаан нь түүний залбирлын хариу байсан гэдэг онцгой гэрчлэлийг тэрээр олж авчээ. Өнгөцхөн харахад тэр уулзалт жирийн л нэг уулзалт байсан боловч, уг хэрэгтээ тэр уулзалт тэр дүүргийн ерөнхийлөгч, түүний ажил болон гишүүдэд туслахуйц, номлогч нарт нь амжилт авчирахуйц Сүнсээр удирдуулсан нэгэн байсан гэдэгт би огт эргэлздэггүй.

Ах эгч нараа, бид Сүнсний удирдамжийг дуулгавартай дагасан цагт Их Эзэний зорилгууд биелж байдаг. Бидэнд ирсэн мэдрэмж, өдөөлтүүдийг дагах тусам Их Эзэн бидэнд итгэж өөрийн ажлаа даатган өгөх болно.

Ирсэн өдөөлтийг хойш нь тавилгүй дагах ёстойг сурсан талаараа би өмнө өгсөн ярианууд дээрээ хэлж байсан. Нилээн хэдэн жилийн өмнө, хуучин Дезерет спорт цогцолборын усан санд сэлж байхад их сургуулийн эмнэлэгт хэвтэж байгаа, ясны хавдрыг нь авах хагалгааны дараа хөл нь мэдээгүй болсон сайн найз дээрээ очих ёстой юм байна гэсэн мэдрэмж надад төрсөн юм. Тэр даруй би уснаас гарч, хувцасаа өмсөөд, найз руугаа яаран гарлаа.

Өрөөнд нь ороход, тэр өрөөндөө байсангүй. Асууж сураглаж байж, найз маань физик эмчилгээнд ашигладаг эмнэлгийн усан санд байгаа гэдгийг олж мэдэв. Тэр үнэхээр тэнд байлаа. Тэрээр тэргэнцэр дээр суун усан санд очоод, тэнд ганцаарханаа байхад нь би түүнийг олсон юм. Тэрээр усан сангийн нөгөө талд, гүн устай хэсгийн дэргэд очсон байв. Түүнийг дуудахад тэр надтай гар барих гэж тэргэнцэрээрээ хажууд минь ирсэн. Бид олон янзын юм ярьж цагаа сайхан өнгөрөөсний эцэст би түүнийг өрөөнд нь аваачаад, адислал өгч билээ.

Хожим найз минь надад тэр өдөр маш их сэтгэлээр унасан байсан бөгөөд амиа хорлохоор шийдээд байснаа ярьсан юм. Зовлонгоос ангижрахыг хүсэн залбирсан боловч, хариу нь ирэхгүй юм шиг түүнд санагджээ. Усан санд очиж тэргэнцэртэйгээ хамгийн гүн хэсэг рүү орж зовлонгоосоо нэг мөсөн салахаар шийдээд тийшээ явсан байна. Яг тэр эгзэгтэй мөчид би тэнд очсон нь дээрээс ирсэн өдөөлт байсан гэдэгт би огт эргэлздэггүй.

Найз маань олон жилийн турш аз жаргал, баяр талархалаар дүүрэн амьд явсан юм. Тэр нэгэн өдөр усан санд Их Эзэний мутар дахь зэмсэг болж чадсандаа би хичнээн сэтгэл хангалуун явдаг гээч.

Өөр нэг болсон явдлыг дурдая. Нэг өдөр Монсон эгч бид хоёр найзынхаасаа гараад гэр рүүгээ явж байтал, нилээн хол, өөр хотод амьдардаг, урьд нь манай тойрогт явж байсан нэгэн настай эгч дээр оч гэсэн мэдрэмж надад төрсөн юм. Түүнийг Зелла Томас гэдэг байсан. Тэр үед тэрээр өндөр настангуудыг асрах төвд амьдарч байсан юм. Тэр үдэш түүн дээр ороход тэрээр орон дээрээ их сульдсан шинжтэй гэхдээ тайван хэвтэж байв.

Зелла сохроод удаж байсан боловч биднийг дуугаар минь шууд таньж билээ. Намайг түүнийг адислахыг хүсэж, Их Эзэн түүнийг аваачихыг хүсэж байвал үхэхэд бэлэн байгаагаа нэмж хэлсэн юм. Тэр өрөөнд гайхалтай сайхан, амар амгалан мэдрэгдэж, бид бүгдээрээ түүнийг энд удахгүй гэдгийг мэдэцгээсэн юм. Зелла гарыг маань атган байж намайг түүн дээр ирж адислаасай гэж чин сэтгэлээсээ гуйж байснаа хэлж билээ. Тэнгэрлэг Эцэгээс шууд удирдамж аван түүн дээр ирснээ хэлээд духан дээр нь үнсэхдээ түүнтэй энэ дэлхийд дахин уулзахгүй гэдгээ мэдэрсэн юм. Үнэхээр дараагийн өдөр нь тэр нас барж билээ. Сайхан сэтгэлт Зелладаа тайтгарал болон амар амгаланг мэдрүүлсэнээр түүнд болон өөртөө адислал авчирсан юм.

Бусдын амьдралд адислал болох боломж ихэнхдээ санаандгүй байхад ирдэг. 1983–84 оны нэг их хүйтэн хагас сайны орой Монсон эгч бид хоёр Ютагийн Мидвэй-ийн уулархаг нутагт очихоор гарсан юм. Бид тэнд нэг байшинтай бөгөөд тэр орой гадаа хасах 31 хэмийн хүйтэн байсан учир

байшингаа шалгахаар явцгааж байгаа нь тэр юм. Тэнд очоод бүх юм хэвийн байсан тул тэр оройдоо буцаж Солт Лейк орохоор шийдэж билээ. Хурдны зам дээр гараад удаагүй байтал машин маань унтраад зогсчихлоо. Их хэцүү байсан шүү. Би тэр үед даарсан шиг урьд өмнө нь хэзээ ч тэгтлээ их даарч байгаагүй юм шиг санагдсан.

Хажуугаар машинууд сүнгэнэнэ. Дуртай дургүй бид хоёр ойролцоох хот руу алхаж эхлэв. Аз болоход бидний хажууд нэг машин зогсож дотор нь сууж явсан залуу бид хоёрт туслахаар болов. Эцэст нь бид машины маань дизель шатахуун хүйтнээс болж өтгөрсөн учир цааш машинаараа явах ямар ч аргагүйг олж мэдсэн. Сайхан сэтгэлт нөгөөх залуу бид хоёрыг Мидвэйд дахь байшинд минь хүргэж өгч билээ. Би түүнд төвөг удсан учир хэдэн төгрөг өгөх гэсэн боловч тэр авсангүй. Тэр өөрийгөө скаут учир аливаа сайн зүйл хийх ёстой гэж байв. Тэгэхэд нь би түүнд өөрийгөө танилцуулж, тэр бидэнд үйлчилсэндээ баяртай байгаагаа хэлсэн юм. Миний бодсоноор тэр номлолд явах насных байсан тул би түүнээс ийм төлөвлөгөөтэй байгаа эсэхийг асуулаа. Тэр яг яах ёстойгоо арай шийдэж амжаагүй байна гэж хариулсан юм.

Дараагийн нэг дэхь өдөр нь би тэр залууд захиа бичиж, гаргасан сайхан сэтгэлд нь талархаснаа дахин илэрхийлсэн юм. Тэр захиандаа би түүнийг бүрэн цагийн номлогч болохыг урьж урмын хэдэн үг бичиж билээ. Номлолын ажлын талаар гардаг бүлгүүдийг нь тэмдэглэсэн өөрийн номноос нэгийг бас түүнд явуулав.

Ойролцоогоор долоо хоног өнгөрсний дараа тэр залуугийн ээж нь над руу залгасан юм. Тэрээр хүүгээ маш сайн хүн болохыг хэлээд хүүгийнх нь амьдралд тохиолдсон хэдэн зүйлээс болоод түүний номлолд үйлчлэх хүсэл нь буурсан талаар ярилаа. Түүний зүрх сэтгэлийг өөрчлөхийг хүсэн нөхөртэйгээ нийлэн мацаг барин залбирснаа ч тэр хэлэв. Тэд түүний нэрийг Юта мужийн Прово хотын Ариун Сүмийн залбирлын хайрцагт бас хийсэн байна. Хэзээ нэгэн цагт, ямар нэгэн зүйл түүний зүрхийг зөөлрүүлж, номлолд явж Их Эзэндээ үйлчлэх хүсэл түүнд эргэн төрөх байх гэж тэр хоёр найдаж байжээ. Тэр нэгэн хүйтэн үдэш тохиолдсон явдал



тэдний залбирлынх нь хариу байж гэдгийг тэр эх надад хэлсэн юм. Би санал нэг байсаан.

Хэдэн сарын дараа, бас хэдэн захиа солилцсоны эцэст тэр залууг Канадын Ванкувер Номлолд гаргаж өгөхдөө Монсон эгч бид хоёр туйлын их баяртай байж билээ.

Тэрхүү хүйтэн тачигнасан 12 сарын үдэш бид таарсан нь тохиолдлын хэрэг үү? Үгүй гэж би баттай хэлнэ. Бүр эсрэгээрээ, бид таарсан нь эцэг эх хоёрынх нь хүүгээ гэсэн чин сэтгэлийн залбирлын хариу байсан гэдэгт би итгэдэг.

Дахин хэлэхэд ах эгч нараа, Тэнгэрлэг Эцэг маань бидний хэрэгцээг мэднэ, түүнээс тусламж хүссэн цагт Тэр тусалдаг. Биднийг зовоож буй зүйлс Түүний хувьд хэзээ ч үл ялих, чухал биш байдаггүй. Бидний амьдралын мөч бүхэнд Их Эзэн минь байдаг.

Хэдэн зуун хүнд нөлөөлсөн саяхан болсон нэгэн явдлыг хуваалцсанаар би яриагаа төгсгөө гэж бодлоо. Тавхан сарын өмнө Канзас хотын Ариун Сүмийн нээлтийг тэмдэглэж байхад болсон явдал л даа. Бидний амьдралд өдөр тутам болоод л өнгөрдөг явдлууд шиг тэр үед бүх зүйл болдгоороо болоод л өнгөрсөн юм шиг санагдаж билээ. Харин хожим нь Ариун Сүмийг онцгойлон адислахыг тэмдэглэн урд өдөр нь болдог урлагийн үзүүлбэр нь тийм ч ердийн нөхцөл байдалд болчихоогүй юм байна гэдгийг би олж мэдсэн юм. Их гайхалтай юм болсон байна лээ.

Ариун Сүмийн нээлтэнд зориулан бэлддэг урлагийн тоглолтыг Канзас хотын Ариун Сүмийн Дүүргийн залуус өөр өөрсдийн салбартаа бэлдэцгээжээ. Хэн, хэзээ, хаанаас гарч ирэх, хаана зогсох, хоорондох зай нь ямар байх, тоглолтын дараа хаашаа гарах зэрэг маш олон зүйлийг туршиж үзэх төлөвлөгөөтэй хагас сайны өглөө хотын захиргааны байранд түрээсэлсэн том өрөөнд бүгдээрээ цугларсан байна. Оройноос өмнө тус тусдаа бэлдсэн хэсгүүдийг нэгэн цогц, мэргэжлийн түвшинд хийгдсэн үзүүлбэр болгохын тулд маш олон нарийн деталийг тэд сурах ёстой байжээ.

Гэтэл нэгэн том асуудал гарав. Тэдний бэлдсэн үзүүлбэр Жамботрон хэмээн нэрлэгддэг томоос том дэлгэцэн дээр гаргах урьдчилан бичсэн видео хөтөлбөрийн дагуу явах ёстой байж л дээ. Тэдгээр бичсэн хэсгүүд нь үзүүлбэр амжилттай

болоход амин чухал байсан байна. Тэдгээр нь бүх үзүүлбэрийг хооронд нь уялдуулж өгөхөөс гадна, дараагийн үйлдлийг ч тайлбарлах зорилготой байж. Тэр видео бичлэгүүд тэдний бэлдсэн хөтөлбөрийн үндсэн хэсэг нь байсан юм. Гэтэл Жамботрон нь ажиллахаа больчихож.

Асуудлыг шийдэх гэж техникийн ажилтнууд хичээж байх хооронд бэлтгэл хийх үнэт цаг нь алдагдаж байсан хэдий ч хэдэн зуун залуус тэвчээртэй хүлээцгээж байжээ.

Тэрхүү хөтөлбөрийг зохиож, удирдан явуулсан Сьюзан Күүпэр хожим, “Бид А төлөвлөгөөнөөсөө Я-г хүртэл үзээд болохгүй л байсан. . . Тэгээд бид өөрсдөө юу ч хийж чадахгүйгээ мэдэцгээсэн, гэвч хамгийн агуу хүч болох 3000 залуус тэр доор биднийг хүлээж байсан юм. Бид доошоо буун, тэдэн дээр очиж юу болсныг тайлбарлан, тэдний итгэлд нь найдахаас өөр арга олдоогүй юм”<sup>3</sup> гэж дурсаж билээ.

Үзэгчид орж ирэхээс цагийн өмнө тэр 3000 залуус хатуу шалан дээр өвдөг сөхрөн хамтдаа залбирчээ. Жамботроныг засах гэж оролдож байгаа тэд нарт юу хийхийг нь хэлж өгөөч гэж тэд гуйсан байна; тэд бас цаг байгаагүй учраас тэдний хийж чадаагүй бүхэнд нь туслахыг Тэнгэрлэг Эцэгээсээ гуйцгаажээ.

Үүний талаар бичсэн нэгэн, “Тэр бол залуусын хэзээ ч мартахгүй залбирал байсан юм. Хатуу шалан дээр өвдөглөснөөс болж мэдэрсэн өвчнөө биш харин тэр үед мэдэрсэн маш хүчтэй Сүнснийг тэд мартаж чадахгүй”<sup>4</sup> гэж хэлсэн юм.

Удаагүй байтал нэг техникч ирэн асуудлыг олж, Жамботроныг заслаа гэж тэдэнд хэлсэн байна. Тэр сохор азаар асуудлыг шийдлээ гэсэн боловч залуус яг юу болсныг илүү мэдэж байсан юм.

Бид хотын захиргааны байранд тэр үдэш очихдоо өдөр нь тэдэнд тулгарсан асуудлын талаар юу ч мэдээгүй байсан. Хэзээ хойно тэр талаар мэдсэн юм. Харин бидний үзсэн тэр хөтөлбөр миний мэдэхийн хамгийн гайхалтай, мэргэжлийн өндөр түвшинд хийгдсэн хөтөлбөр байсан. Залуусаас гарч буй агуу болон хүчтэй сүнснийг тэнд очсон хүн бүр мэдэрсэн билээ. Тэд хаанаас гарч ирэх, хаана зогсох, бусадтайгаа хэрхэн хамтран ажиллахаа сайн мэдэцгээж байх шиг харагдсан.

Тэдэнд бараг бэлтгэл хийх цаг байгаагүй, мөн үзүүлбэрийн ихэнх хэсгийг хамтдаа бэлдээгүй байсныг дуулаад миний гайхсаныг яанаа. Хэн ч бэлтгэл муутай байсныг нь анзаараагүй. Их Эзэн үнэхээр тэдэнд тусалжээ.

Их Эзэн өөрийн хаант улсынхаа бүх л хэсгийг захиран зохицуулж байгаа хирнээ ганц хүнд - ганц үзүүлбэр хийж, ганц Жамботрон засах-ганцхан хувь хүнд чиглэсэн өдөөлтийг өгдөгийг хараад би гайхахгүй байж үл чадна. Тэр ингэж чаддаг мөн хийдэг гэдэг нь надад гэрчлэл болдог юм.

Ах эгч нараа, Их Эзэн бид бүхний амьдралд байгаа. Тэр бидэнд хайртай. Биднийг адислахыг тэр хүсдэг. Тусламж хүсэн Түүнд хандаасай гэж Тэр хүсдэг. Тэр биднийг удирдан чиглүүлдэг. Бидний залбирлыг сонсож мөн хариулахад нь, бид Түүний бидэнд өгөхийг хүсэж буй тэрхүү аз жаргалыг олж авдаг юм. Бид Түүнээс ирдэг адислал болгоныг таньж, харж чаддаг байгаасай хэмээн би бидний Аврагч Есүс Христийн нэрээр залбирч байна, Амен.

#### Эшлэлүүд

1. 2 Нифай 2:25-г үзнэ үү.
2. Сургаал ба Гэрээ 112:10-г үзнэ үү.
3. Сюзан Күүпер, Моүрийн Проктор, "Nothing's Too Hard for the Lord: The Kansas City Cultural

- Celebration, "Meridian Magazine, 2012 оны 5-р сарын 9, ldsomag.com.
4. Проктор, Meridian Magazine, 2012 оны 5 сарын 9 .

# Илүү Христтэй адил Христийн шашинтан байх НЬ

**Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын**

*Ахлагч Роберт Д.Хейлс*

---

*Миний хургануудыг тэжээ. . . Миний хоньдыг тэжээ” Энэ бол өнөөгийн Христийн шашинтай хүн бүрийн дуудлага юм.*

---

Христийн шашинтан байна гэдэг юу гэсэн үг вэ?

Христийн шашинтан нь бидний сайн мэдэх хайрын хамгийн дээд илэрхийлэл болсон Цагаатгалыг хийн бидний нүглүүдийн төлөө зовон шаналахаар Эцгээр илгээгдсэн Бурханы жинхэнэ Хүү, Их Эзэн Есүс Христэд итгэх итгэлтэй байдаг.

Христийн шашинтан нь Бурхан Эцэг ба Түүний Хүү, Есүс Христийн нигүүлслээр дамжуулан бид наманчилж, бусдыг уучилж, зарлигуудыг сахиж мөн мөнхийн амьдралыг өвлөж болно гэдэгт итгэдэг.

*Христийн шашинтан* гэсэн үг Христийн нэрийг өөрсөд дээрээ авна гэсэн утгыг илэрхийлнэ. Бид үүнийг баптисм хүртэж, Түүний санваарын эрх мэдлийг атгагчдын гар тавилгаар Ариун Сүнсний бэлэг хүлээн авснаар эхэлдэг.

Христийн шашинтанууд олон жилийн туршид Бурханы бошиглогчид үргэлж Есүс Христийг гэрчилсэн гэдгийг мэддэг. Есүс 1820 онд Бошиглогч Иосеф Смитэд Тэнгэрлэг Эцэгийн хамт үзэгдэж, сайн мэдээ болон Түүний жинхэнэ Сүмийг зохион байгуулан, сэргээсэн.

Судар болон Иосеф Смитийн гэрчлэлээр дамжуулан Бурхан, Тэнгэрлэг Эцэг маань алдаршуулан, төгөлдөржүүлсэн мах хийгээд ясан биетэй гэдгийг бид мэддэг. Есүс Христ бол Түүний Цорын Ганц махбодтой Хүү нь юм. Ариун Сүнс нь Эцэг ба Хүүгийн ажлыг гэрчилдэг сүнсэн биет билээ. Бурхан Тэргүүтэн нь зорилгодоо нэгдмэл нэг, гурван салангид биетүүд мөн.

Эдгээр сургаалыг итгэлийнхээ үндэс сууриа болгосон биднийг Христийн шашинтан гэдэгт ямар нэгэн байдлаар эргэлзэх эсвэл маргах зүйл байна гэж үү? Христийн шашинтан бүрт нэгэн энгийн асуулт байдаг: Бид ямархуу Христийн шашинтан бэ? Өөрөөр хэлвэл, бид Христийг дагах аян замдаа хэр сайн байна вэ?

Хоёр Христийн шашинтанд тохиолдсон явдлыг хамтдаа тунгаан бодоцгооё:

“Тэр [Есүс] Галилын нуурын эргээр явж байгаад ах дүү болох Петр гэгддэг Симон, түүний дүү Андрей нарыг нуурт тор тавьж байгааг харжээ. Тэд загасчид аж.

“Есүс тэдэнд, Намайг дага, Би та нарыг хүмүүсийн загасчин болгоно гэв.

“Тэд тэр даруй тороо орхиж Түүнийг дагалаа.”<sup>1</sup>

Өнөөдөр Христийн шашинтны хувьд бид тэр даруй, маш түргэн, эрс шийдэмгийгээр яг л Петр, Андрей нар “тэр даруй тороо орхиж Түүнийг дагасан”<sup>2</sup> шиг үйлдэх боломжтой. Бид бас дэлхийн зуршил, ёс заншил, уламжлалуудаасаа татгалзан, Христийг дагахад саад болох аливаа зүйлийг ардаа орхихоор дуудагдсан. Бид бас нүглүүдээ орхихоор дуудагдсан.[Есүс] хүмүүсийг өөртөө дуудахдаа Тэр тэдэнд, “Хэрэв хэн нэг нь Миний араас явахыг хүсвэл, тэр хүн өөрийгөө үгүйсгэж, загалмайгаа барьж Намайг дага”<sup>3</sup> гэж хэлсэн. Бурханлаг бус зан төлвөөс өөрийгөө үгүйсгэх нь бидний “хилэнцийг үйлдэх хүслийг үгүй болгож”<sup>4</sup> зүрх сэтгэлийн агуу өөрчлөлтийг авчирах наманчлалын эхлэл юм.

Зөвхөн Аврагчаар дамжуулан боломжтой болох энэ өөрчлөлтийг хөрвөлт гэж нэрлэдэг. Есүс амлахдаа: “Хэрэв хүмүүс надад ирэх аваас би тэдэнд өөрсдийнх нь сул доройг үзүүлэх болно . . . миний ач ивээл хангалттай; учир нь хэрэв тэд миний өмнө өөрсдийгөө даруусгаж, мөн надад итгэлтэй

байх аваас, тэгвэл *битэдэнд сул дорой зүйлүүдийг нь хүчирхэг болгож өгнө*” гэсэн.<sup>5</sup> Бид Христээр дамжуулан *шинэ хүн болсноор* бидний эгэл шинж өөрчлөгдөн, бид хуучин зуршилдаа эргэн орох хүсэлгүй болдог.

Тэр бүү хэл итгэлтэй Христийн шашинтнууд хүнд хэцүү, зовлон зүдгүүрүүдийг туулснаар байнга адислагдсан байх болно. Эдгээр сайжруулах саад бэрхшээлүүд тулгарах үед бид хуучин зуршилдаа орохоор уруу татагдаж магадгүй. Аврагч Цовдлогдсоныхоо дараа Тэрээр эмэгтэйчүүдэд үзэгдэн, ах нар нь Түүнийг Галилейд олж болохыг хэлсэн. Ахмад Төлөөлөгч Петр Галилейд буцаж ирээд өөрийн мэддэг—өөрт тааламжтай зүйлсээ дахин хийсэн. Түүнтэй хамт хэдэн шавийг дагуулан, “Би загас барихаар явлаа”<sup>6</sup> гэж тэр тайлбарласан.

Үнэндээ Петр мөн бусад нь нэг ч загас барилгүй, шөнөжин загасчилсан. Дараагийн өглөө нь Есүс эрэг дээр үзэгдэж, эргээс тэдэнд “баруун талд тороо хая” гэж хэлсэн. Иохан тэр даруйдаа Аврагчийн дууг таньж, Петр агшин зуур усанд шумбан орж, эрэг рүү сэлсэн. Завин дээр үлдсэн шавь нар нь Түүний зааврыг дагах үед тэр даруй тэдний торонд дүүрэн загас баригдсаныг олж мэддэг.<sup>7</sup>

Өөрсдийн хуучин, итгэл багатай зуршилдаа эргэн орсон Христийн шашинтнууд Петрийн үлгэр жишээг тунгаан бодоорой. Ирж Эзэний дуудах дуу хоолойг сонс мөн таньж мэд. Дараа нь тэр даруй Түүн рүү эргэн ирж, Түүний элбэг дэлбэг адислалуудыг дахин хүлээн аваарай.

Ах нар эрэг дээр ирэх үед тэд загас болон талхаар цалгин цэнгэж байгааг олж мэдсэн. “Нааш ир. Өглөөний хоолоо идэцгээ”<sup>8</sup> хэмээн Аврагч урьсан. Тэрээр тэднийг хооллохдоо Петрээс гурван удаа “Иоханы хүү Симон оо, чи Намайг хайрладаг уу?” гэж асуудаг. Петр өөрийн хайрыг илэрхийлэхэд, Аврагч түүнд “Миний хургануудыг тэжээ. . . Миний хоньдыг тэжээ”<sup>9</sup> гэж хэлсэн.

Энэ бол өнөөдрийн Христийн шашинтан бүрт өгсөн Христийн дуудлага: “Миний хургануудыг тэжээ. . . Миний хоньдыг тэжээ”—хөгшин залуу харгалзалгүй бүгдийг өөдрөгөөр дэмжиж, адислаж, тайвшруулж, урамшуулан зоригжуулж мөн бусдыг хүчирхэгжүүлэн төлөвшүүлж ялангуяа биднээс өөр ойлголт, өөр итгэлтэй тэдгээр

хүмүүстэй Миний сайн мэдээг хуваалц. Бид сайн мэдээний дагуу зарлигуудыг сахиж, залбирч, судруудаас судалж, Түүний хайрын үлгэр жишээг даган амьдарч байгаагаараа Түүний хургануудыг орон гэртээ тэжээдэг. Бид Сүм дээр санваарын чуулган ба туслах бүлгүүдэд үйлчлэхдээ Түүний хоньдыг тэжээдэг. Бид Христийн шашинтан учраас хөрш, цэвэр ариун шүтлэгтэн байж, бэлэвсэн, эцэггүй, ядуу болон гачигдалд байгаа бүх хүмүүст хүрч очин, үйлчилснээр дэлхийн өнцөг булан бүрт байгаа Түүний хоньдыг тэжээдэг.

Олон хүмүүсийн хувьд Христийн шашинтан байх дуудлага нь албадсан мэт, тэр бүү хэл дааж давшгүй мэт санагдаж болох юм. Гэхдээ бид айх эсвэл үүнд өөрийгөө хангалтгүй гэж бодох ёсгүй. Биднийг Түүний ажилд бэлтгэгдсэн, хийх боломжтой болгоно гэж Аврагч амласан. “Намайг дага. Би та нарыг хүмүүсийн загасчин болгоно”<sup>10</sup> гэж Тэр хэлсэн. Түүнийг дагахад Тэр биднийг өөрсдийн чадлаас илүү зүйлийг хийж өсч хөгжих боломжийг олгох ба өмнө нь хэзээ ч хийж байгаагүй зүйлсийг хийх бэлэг, авьяас ба Түүний тааллыг гүйцээх хүчээр адисладаг. Энэ нь хөршүүдтэйгээ сайн мэдээ хуваалцах, сүнслэг байдлын хувьд алдагдсан хүмүүсийг аврах, бүрэн цагийн номлолд үйлчлэх, ариун сүмд ажиллах, онцгой халамж хэрэгтэй хүүхэд өсгөх, ачлалгүй хүүг хайрлах, эмгэг хуучтай ханиа асрах, үл ойлголтууд буюу зовлон шаналлыг эцсээ хүртэл тэвчих зэргийг хэлсэн байж болно. Энэ нь Түүний дуудлагад хариулахын тулд өөрсдийгөө: “Хаа дуудсан ч би үйлчлэх болно; Хэл гэснийг тань хэлнээ гэнэм; Хий гэснийг тань хийх болно би; Хэн бол гэснээр тань би болох болно”<sup>11</sup> хэмээн хэлж бэлтгэнэ гэсэн үг юм.

Тэнгэрлэг Эцэг биднийг хэн бол гэснээр болж, бид Есүс Христийг дагадаг. Тэр намайг дага хэмээн дуудсаар байгаа гэдгийг би гэрчилж байна. Хэрэв та дөнгөж Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүн, Христийн шашинтан байх амлалтын талаар суралцаж байгаа бол эсвэл та Сүмдээ бүрэн идэвхтэй бус бөгөөд Түүнийг дахин дагахыг хүсч байгаа бол—бүү ай! Аврагчийн анхны шавь нар бүгд Сүмийн шинэ гишүүд, Түүний сайн мэдээний шинэхэн хөрвөгчид байсан. Есүс тэвчээртэйгээр хүн бүрт заасан. Тэр тэдэнд үүрэг хариуцлагуудаа бүрэн биелүүлэхэд нь тусалсан. Тэр тэднийг

Өөрийн найз хэмээн дуудаж, Өөрийн амьдралыг тэдний гарт өгсөн. Тэр аль хэдийнээ таны мөн миний төлөө үүнтэй адил зүйлийг хийсэн.

Түүний жинхэнэ хайр ба нигүүлслээр дамжуулан бид Христтэй илүү их адил Христийн шашинтан болж чадна гэдгийг би гэрчилж байна. Христтэй адил зан төлөвүүдийг дагах талаар бодоорой. Тэдгээрийг өөрсөддөө хүчирхэгжүүлэхийг бид хэрхэн хийж байна вэ?

*Христийн адил хайр.* Аврагч хүн бүрийг үнэлдэг байв. Бүгдэд эелдэг, энэрэнгүй Тэр нэгийг олохын тулд ерэн есийг орхисон,<sup>12</sup> тийм ээ, Түүнд “[бидний] толгой дээрх үс бүр тоологдсон.”<sup>13</sup>

*Христийн адил итгэл.* Уруу таталт, зовлон шаналал, хавчлагуудыг үл харгалзан Аврагч Тэнгэрлэг Эцэгтээ итгэж, Түүний зарлигуудад дуулгавартай, итгэлтэй байхыг сонгосон.

*Христийн адил золиослол.* Өөрийн амьдралын турш Аврагч Өөрийн цаг, Өөрийн хүч тэнхээг, бүр цаашлаад Бурханы бүх хүүхэд амилуулагдаж, мөнхийн амьдралыг өвлөх боломжтой болгохын тулд Цагаатгалаар дамжуулан Өөрийгөө өгсөн.

*Христийн адил халамж.* Сайн Самари хүний адил Аврагч Түүний эргэн тойронд байгаа хүмүүсийг тэдний соёл боловсрол, итгэл бишрэл болоод нөхцөл байдлуудыг хайхралгүй аварч, хайрлаж, асран тэтгэхийн тулд байнга гараа сунгасаар байсан.

*Христийн адил үйлчлэл.* Худагнаас ус татах, загасаар хоол хийх эсвэл бохир хөлийг угаах байсан ч хамаагүй Аврагч Өөрийн өдрүүдийг бусдад үйлчлэхээр—ядарч цуцсанд тусалж, сул доройг хүчирхэгжүүлэхэд зориулсан.

*Христийн адил тэвчээр.* Өөрийн уй гашуу, зовлон шаналалд Аврагч Өөрийн Эцэгийн тусламжийг тэвчээртэйгээр хүлээсэн. Тэр биднийг зөвийг мэдэж, гэртээ ирэхийг маань тэвчээртэйгээр хүлээдэг.

*Христийн адил амар амгалан.* Өөрийн номлолынхоо турш Тэрээр ойлголтыг өдөөж, амар амгаланг сайшаасаар ирсэн. Ялангуяа Өөрийн шавь нарын дунд Тэрээр Христийн шашинтан нь бусад Христийн шашинтануудтай, хоорондын ялгааг үл харгалзан, тэмцэлдэж болохгүйг заасан.



*Христийн адил уучлал.* Түүнийг цовдолсон хүмүүсийг уучлахыг гуйсан залбирлаараа биднийг хавчдаг хүмүүсийг адислах жишээг үзүүлэн, Тэр бидэнд заасан.

*Христийн адил хөрвөлт.* Петр ба Андрейгийн адил олон хүн сонсонгуутаа сайн мэдээний үнэнийг таньж мэддэг. Тэд тэр даруйдаа хөрвөгддөг. Бусад хүмүүсийн хувьд арай урт хугацаа шаардагдаж магадгүй. Иосеф Смитээр дамжуулан өгөгдсөн илчлэлтэд Аврагч, “Бурханаас буй тэр нь гэрэл болой; мөн гэрлийг хүлээн авдаг мөн Бурханд үлддэг тэр нь илүү их гэрэл хүлээн авдаг; мөн тэрхүү гэрэл төгс өдрийг хүртэл улам улам хурц болон өсдөг.”<sup>14</sup> Есүс бол “гэрэл мөн дэлхийн Гэтэлгэгч; үнэний Сүнс”<sup>15</sup> хэмээн заасан.

*Христийн адил эцсээ хүртэл тэвчих.* Өөрийн бүхий л өдрүүдэд Аврагч маань Өөрийн Эцэгийн тааллын дагуу үйлдэхээс хэзээ ч шантраагүй, харин ч Өөрийн мөнх бус амьдралынхаа эцсийг хүртэл үнэн, зөв шударга байдал, бурханлаг, нигүүлсэнгүй байсан.

Эдгээр нь Аврагчийн дуу хоолойг сонсож, анхаарал тавьдаг хүмүүсийн зарим зан чанарууд юм. Дэлхий дээрх Түүний онцгой гэрч нарын нэгийн хувьд Тэр өнөөдөр та нарыг “Ирээд, Намайг дага”<sup>16</sup> хэмээн дуудаж байна гэсэн өөрийн Христийн шашинтны гэрчлэлийг би өгч байна. Нааш ирж, Тэнгэрлэг Эцэгийн хаант улс дахь мөнхийн аз жаргал, баяр баясгалан, мөнх амьдрал руу хөтлөх зам дээр алх. Бидний Аврагч мөн Гэтэлгэгч Есүс Христийн нэрээр, амен.

#### *Эшлэл*

- |                                      |   |
|--------------------------------------|---|
| 1. Матай 4:18–20                     | 9. Иохан 21:15–17-г үз.   |
| 2. Марк 1:18.                        | 10. Матай 4:19; тодруулга нэмэгдсэн.                                  |
| 3. Марк 8:34.                        | 11. “Хаа ч дуудсан би үйтчлэх болно” <i>Сүмийн дуулал</i> , 46-р дуу. |
| 4. Мозая 5:2.                        | 12. See Матай 18:12–14.   |
| 5. Ифер 12:27; тодруулгал нэмэгдсэн. | 13. Лук 12:7.   |
| 6. Иохан 21:3.                       | 14. Сургаал ба Гэрээ 50:24.   |
| 7. Иохан 21:3–8-г үзнэ үү            | 15. Сургаал ба Гэрээ 93:9.  |
| 8. Иохан 21:12..                     | 16. Лук 18:22.  |

# Нас барагсдын авралаас ирдэг баяр баясгалан

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын

Ахлагч Ричард Г. Скотт

---

*Елиагийн Сүнс дэлхий даяарх Тэнгэрлэг Эцэгийн олон хүүхдийн зүрх сэтгэлд нөлөөлж байна.*

---

Их Эзэн баптисмын тухай сүнслэг нөлөө бүхий чухал илчлэлтийг Бошиглогч Иосеф Смитэд илчилсэн юм. Үхэл бол хүмүүний хувь тавилангийн үүрд мөнхийн, эргэлт буцалтгүй төгсгөл мөн хэмээн Христийн бусад сүмүүд зааж байсан үед энэхүү илчлэлт ирсэн юм. Баптисм хүртсэн хүмүүст эцэс төгсгөлгүй баяр баясгалан шагнал нь байдаг бол бусад бүх хүмүүс гэтэлгэлийн найдваргүйгээр мөнхийн зовлонд унана хэмээн тэд заадаг байлаа.

“Хэн ус болон Сүнснээс эс төрнө, тэр хүн Бурханы хаанчлалд орж чадахгүй”<sup>1</sup> гэсэн Түүний үгс үнэн болохыг нотлон, санваарын зохих эрх мэдлээр дамжуулан нас барагсдын өмнөөс төлөөлөн гүйцэтгэх баптисмыг хийж болно гэдгийг Их Эзэн илчилсэн билээ. Төлөөлөн гүйцэтгэх баптисмыг мөнх бус амьдралдаа үүнийг хүлээн авалгүйгээр нас барсан бүх хүмүүсийн төлөө хийж болно.

Энэхүү онцгой чухал сургаал бол Есүс Христийн Цагаатгалын бүхнийг хамарсан, төгс, хязгааргүй шинж чанарын бас нэгэн гэрч юм. Тэрбээр наманчилдаг хүн бүрт авралыг боломжтой болгосон билээ. Түүний Цагаатгал үхлийг ялж, Тэрээр зохистой байдалд нас барсан бүх хүмүүст авралын төлөөлөн гүйцэтгэх ёслолуудыг хүлээн авах боломжийг олгосон юм.

Иосеф Смит 150 гаруй жилийн өмнө бичсэн нэгэн захидалдаа: “Нас барсан төрөл төрөгсдийнхөө төлөө . . .

баптисм хүртэх онцгой боломж Гэгээнтнүүдэд бий. Тэдгээр нас барсан хүмүүс тэдэнд номлохоор итгэмжлэл хүлээсэн хүмүүсээр дамжуулан сүнсний дэлхийд Сайн мэдээг хүлээн авах болно.”<sup>2</sup> “Нас барсан төрөл төрөгсдийнхөө төлөө хийх энэхүү ёслолыг үл тоомсорлодог эдгээр Гэгээнтнүүд өөрсдийнхөө авралд мөн аюул учруулдаг”<sup>3</sup>. гэж бичжээ.

“Тэрээр эцгүүдэд нь хийгдсэн амлалтуудыг хүүхдүүдийнх нь зүрх сэтгэлд суулгах болно, мөн хүүхдүүдийнх нь зүрх сэтгэл, эцгүүд рүүгээ эргэх болно”<sup>5</sup> гэсэн Их Эзэний амлалтыг биелүүлэхийн тулд Бошиглогч Елиа нас барагсдын өмнөөс төлөөлөн гүйцэтгэх ёслолын түлхүүрүүдийг Көртландын Ариун сүмд<sup>4</sup> Иосеф Смитэд итгэмжлэн хүлээлгэн өгсөн юм.

Иосеф Смит болон түүнийг залгамжилсан бошиглогчдод өгөгдсөн нэмэлт илчлэлтээр ариун сүмийн ажил болон үүнийг дэмжих гэр бүлийн түүхийн талаарх ойлголт болон бэлтгэл ажил илчлэгдсэн юм. Бид өөрсдийнхөө болон нас барсан төрөл төрөгсдийнхөө төлөө бүх ёслолуудыг хийлгэх нь чухал болохыг Иосеф Смитээс хойших бошиглогч бүр бидэнд онцгойлон анхааруулсаар байгаа билээ.

Ариун сүмийн болон гэр бүлийн түүхийн ажил бол нэг ажлын хоёр хэсэг юм. Эдгээр нь баптисм ба Ариун Сүнсний бэлэг өгөх ёслолууд хоорондоо холбоотой байдаг шиг тийм нягт холбоотой юм. Зарим гишүүд эрүүл мэндийн байдлаас болон ариун сүмээс алс хол амьдардаг учраас энэ хоёр ажлыг хоёуланг нь хийх боломжгүй байж болно.

Ерөнхийлөгч Ховард В.Хантер ийн сургажээ:

“Бид эхлээд өөрийнхөө өргөмжлөлийн төлөө ариун сүмд санваарын ёслолуудыг гүйцэтгэх ёстой. Дараа нь бид амьд сэрүүн байхдаа сайн мэдээг хүлээн авах боломжгүй байсан хүмүүсийн төлөө шаардлагатай ёслолын ажлыг хийх ёстой. Бусдын төлөө хийх ажил нь хоёр үе шаттай байдаг. Нэгдүгээрт, өвөг дээдсээ тогтоох гэр бүлийн судалгааны ажил, хоёрдугаарт, тэдний төлөө ариун сүмийн ёслолуудыг гүйцэтгэснээр амьд хүмүүстэй адил тэгш боломжийг тэдэнд олгох.

“Ариун сүмд орох боломж нь хязгаарлагдмал Сүмийн гишүүд олон байгаа. Тэд чадах бүхнээ хийж байна. Тэд өөрсдөө гэр бүлийн түүхийн судалгаа хийж, бусад хүмүүсээр

ариун сүмийн ёслолуудыг нь хийлгэж байна. Харин гэтэл зарим гишүүд ариун сүмийн ажилд идэвхтэй оролцдог хэрнээ гэр бүлийн түүхээ судалж, бичих талаар санаачлага гаргахгүй байна. Тэд бусдад туслах талаар бурханлаг үйлчлэл хийдэг ч, хожмын үеийн бошиглогчдын өгсөөр байгаа тэнгэрлэг удирдамжийн дагуу өөрсдийнхөө өвөг дээдэс, төрөл төрөгсдийг судалж тогтоохгүй байгаагаас адислалаа алдаж байна. . . .

“Гэр бүлийн судалгааны ажилд идэвхтэй оролцож, олж тогтоосон хүмүүсийн нэрсээр ариун сүмийн ёслолууд хийлгэдэг хүмүүс дээрх хоёр ажлаас ирдэг адислалуудын аль алиныг нь авахдаа илүү баяр баясгаланг олж мэдэх болно.”<sup>6</sup>

Энэхүү төлөөлөн гүйцэтгэдэг амин чухал хоёр ажлын хоёулангаас нь адислал хүртэхийг Тэнгэр дэх Эцэг биднээс хүсдэг. Тэрбээр бидэнд хэрхэн энэ бүхнийг хүлээн авч болохыг харуулахын тулд бусдыг удирдсан билээ. Эдгээр адислалуудыг хүртэх боломж та бидэнд бүгдэд нь байдаг.

Ариун сүмд таны хийдэг ямар ч ажил таны цагийг дэмий гарзадна гэж байхгүй, харин өвөг дээдсийнхээ хэн нэгний төлөө төлөөлөн гүйцэтгэх ёслол хийлгэснээр ариун сүмд өнгөрүүлсэн цаг тань улам ариун болж, агуу адислалуудыг хүлээн авах боломжийг танд олгоно. “Бидний хамгийн чухал үүрэг бол *өөрсдийнхөө* өвөг дээдсийг хайж олох явдал мөн”<sup>7</sup> хэмээн Тэргүүн Зөвлөл тунхагласан билээ.

Залуу хүмүүс та нар дайсны нөлөөг амьдралаасаа шахан зайлуулах найдвартай арга замыг мэдэхийг хүсч байна уу? Тэгвэл өвөг дээдсээ эрж олон, тэдний нэрсийг ариун сүмийн төлөөлөн гүйцэтгэх ёслолуудад бэлтгэж, улмаар ариун сүмд очиж, тэдний төлөө баптисмын болон Ариун Сүнс хүлээн авах ёслолуудыг хийлгэхэд бие сэтгэлээ дайчлан ажиллагтун. Амьдралд тань нөлөөлөх дайсны муу нөлөөнөөс хамгаалах үүнээс илүү найдвартай хамгаалалтыг би мэдэхгүй.

Оросын Ростовын Номлолд ариун сүмийн ёслолууд хийлгэхээр 2000 нэрсийг залуучуудад урилга болгон тараахдаа тэдний өөрсдийнх нь өвөг дээдсийн дор хаяж нэг нэрийг оруулж өгсөн байна. Энэ ажлыг гүйцэтгэсэн хүмүүсийг Украйны Киевийн шинэ ариун сүм рүү урт удаан аялал хийхэд урьсан ажээ. Нэг залуу туршлагаа ийн

хуваалцжээ: “Би компьютерийн тоглоом тоглож хамаг цагаа үрдэг байлаа. Ариун сүмд ёслол хийлгэх хүмүүсийн нэрсийн индекс дээр ажиллаж эхэлснээс хойш компьютер дээр тоглох зав гардаггүй болсон. Би эхлээд, ‘Өө яаж үүнийг хийх юм бэ! Ёстой барахгүй юм байна!’ гэж бодсон шүү. Гэтэл төсөл дуусахад би компьютер тоглох сонирхолгүй болсон байлаа. Гэр бүлийн түүхийн ажил бол дэлхий дээр бидний хийх ёстой ажил. Энэ ажил тэнгэрт үргэлжлэх болно.”

Итгэлтэй олон Гэгээнтнүүд гэр бүлийнхээ түүхийн судалгааны ажлыг хийж, гэр бүлийнхээ гишүүдийн төлөө ариун сүмийн ёслолуудыг хийлгэхийн тулд Family Search буюу Гэр бүлийн хайлтын систем дэх нэрсийг ашиглаж байна. Өвөг дээдсийнхээ нэрсийг олж тогтоохын зорилго нь тэдний төлөө болон тэдэнтэй холбоотой гэр бүлүүд дэх хүмүүсийн төлөө ариун сүмийн төлөөлөн гүйцэтгэх ёслолуудыг хийх боломжийг хувь хүмүүст олгох явдал мөн. Эдүгээ 12 сая гаруй нэрс ариун сүмийн ёслол хийлгэхэд бэлэн болоод байна. Олон нэрс олон жилийн турш хадгалагдсаар байна. Нэрс нь тогтоогдсон өвөг дээдэс өөрсдийнх нь нэр ариун сүмийн ёслолуудад бэлэн болохыг сэтгэл догдлон хүлээж байгаа нь эргэлзээгүй юм. Гэвч өөрсдийнх нь төлөө хийгдэх ёслолууд цаашид хүлээгдсээр байвал тэд баярлахгүй нь лавтай шүү дээ.

Олон тооны нэрс бэлтгэж, эдгээрийг өнөр бүлийнхээ гишүүд эсвэл тойрог болон гадасныхаа гишүүдтэй хуваалцан ёслолуудыг нь хийлгэхээр төлөвлөж байгаа та нарын дундах хүмүүст бид урам хайрлан дэмжиж байна. Та нар ариун сүмийн картуудыг энэ ажилд туслах хүсэлтэй буюу Гэр Бүлийн хайлтын системийг ашиглан нэрсийг ариун сүмд шууд явуулах боломжтой гишүүдэд өгснөөр энэ ажлыг хийж болно. Сүүлчийн энэ хувилбарыг Вайомингийн Касперийн Синди Блевинс олон жилийн турш ашиглаж байна.

Блевинс эгч өсвөр насны охин байхдаа баптисм хүртсэн бөгөөд гэр бүлээсээ цорын ганц Сүмийн гишүүн байжээ. Тэрээр гэр бүлийн түүхийн өргөн цар хүрээтэй ажил хийсэн ажээ. Гэвч түүний өөрийнх нь болон үндсэн гэр бүлийнхнээс олж тогтоох ёстой олон нэр байгаа гэнэ. Иймээс Блевинс эгч нэрсийг хоёр гурван долоо хоногт багтаан бэлтгэж, ихэвчлэн гэртээ хамгийн ойрхон нэг юм уу хоёр ариун сүмд явуулдаг

гэнэ. Өвөг дээдсийнх нь төлөө судалгааны ажлыг дуусгахад тойрог болон гадасных нь найз нар, хөршүүд нь тусална гэж бодоход гэр баяртай байдаг гэсэн юм. Тэр бас тэдний хийж байгаа ажлыг өндөр үнэлдэг.

Миний хайрт гэргий Женин гэр бүлийн судалгааны ажил хийх дуртай байсан юм. Хүүхдүүд маань бага байхад эхнэр маань найз нартайгаа өөрийн болон тэдний хүүхдүүдийг ээлжлэн харж, дараа нь гэр бүлийн түүхийн судалгаа хийх цөөхөн хэдэн цаг завтай болдог байлаа. Отгон хүүхдээ ам бүл тусгаарлахад ээж нь хувийн тэмдэглэлдээ: “Би дөнгөж сая нэг шийдвэр гаргаад үүнийхээ төлөө сэтгэл догдлон, босч, хашгирмаар санагдлаа. Майкийн унтлагын өрөө одоо миний гэр бүлийн түүхийн ажлын өрөө болно. Энэ бол ажил хийх, бичиг баримтуудыг эмх цэгцтэй хөтлөхөд маш тохиромжтой, сайн тоноглогдсон өрөө. Одоо миний амьдрал, гэр бүлийн нэн чухал судалгаа болон ариун сүмд нэрс явуулахад төвлөрөх болно. Миний сэтгэл ихэд догдолж, ажлаа шалавхан эхлэхэд яарч байна”<sup>8</sup> хэмээн бичсэн байлаа.

Өөр нэгэн тэмдэглэлд: “Компьютержсэн Ancestral File буюу Өвөг дээдсийн мэдээлэл -ийн шинэчилсэн удмын судалгаанаас авч удмын судалгаа хийдэг хүмүүст явуулж бэлдүүлсэн миний өвөг дээдсийн хэвлэмэл цэдгийг надад үзүүлсэн Мел Өүлсоны Гэр Бүлийн түүхийн оффист . . . нэгэн гайхамшиг тохиолоо. Эдгээр цэдэг нь өвөг дээдсийнхээ дөрвөн үеийнхний гэр бүлийн түүхийг бэлтгэхэд хүн бүрийг урамшуулан дэмжихэд олон жилийн турш ашиглаж байсан Сүмийн хөтөлбөрийн үр дүнд бий болсон ажээ. Гэр бүлийн байгууллагуудаас өөрийнхөө өвөг дээдсийн талаарх судалгааны бүртгэлийг бүгдийг нь цуглуулан Ancestor File буюу Өвөг дээдсийн мэдээлэл – ийн анхны компьютержсэн системд хэрхэн оруулах тал дээр би нэлээн санаа зовниж байсан билээ. Гэтэл маш сайхан, эмх цэгцтэй хэвлэчихсэн өвөг дээдсийн минь тухай цэдгүүд миний өмнө ширээн дээр тавиастай байлаа. Сэтгэл маш их догдолсноос би юу ч хэлэлгүй зүгээр л эдгээрийг хараад тэнд суусаар байсан бөгөөд баярласандаа болоод уйлж билээ. Гэр бүлийн түүхийг гараараа цөхрөлтгүй шаргуу хийдэг байсан миний хувьд эдгээр бүртгэлийг Family Search буюу Гэр бүлийн хайлтын

системд оруулна гэдэг бол үнэхээр гайхамшигтай байлаа. Удахгүй хэдэн зуун мянган хүмүүст зориулан хүн амын тооллогын болон хувийн судалгааны асар их мэдээлэл агуулсан дискүүдийг тун удахгүй компьютерийн энэхүү системд оруулах болно гэдгийг би бодох үед, миний сэтгэл маш их хөдөлдөг. Энэ бол үнэхээр Их Эзэний ажил бөгөөд Тэрбээр үүнийг удирдан чиглүүлдэг юм” хэмээн бичсэн байлаа.”<sup>9</sup>

Иосеф Смитэд Елиагийн сэргээсэн түлхүүрүүд, бидний тусламжийг хүлээж байгаа өвөг дээдэстэй бид бүгдийг холбож, бидний зүрх сэтгэлийг тэдэн рүү эргүүлж буй энэхүү агуу ажлын үр жимсийг би хангалттай амталсан хүн. Аврагчаас томилон олгосон эрх мэдлийг ашиглан, дэлхий дээрх ариун сүмүүдэд бидний хийдэг ажлаар дамжуулан манай өвөг дээдэс авралын ёслолуудыг хүлээн авах бөгөөд энэ нь тэдэнд мөнхийн аз жаргалыг эдлэх боломжийг олгох болно.

Өнгөрсөн үед хувь хүмүүс энэхүү ажлын ариун мөн чанараар өдөөгдөн Небраск мужийн бүх үр тариаг ганцаархнаа гараараа хураахтай адил санагдах тийм хүнд сорилтыг итгэлээрээ даван туулдаг байлаа. Одоо энэ ажилд олон хүчирхэг машиныг ашиглаж байна. Бид хамтран хүчээ нэгтгэсэн үед шаардлагатай ажлыг хийж чадах бөгөөд хийх ч болно.

Елиагийн Сүнс дэлхий даяарх Тэнгэрлэг Эцэгийн олон хүүхдийн зүрх сэтгэлд нөлөөлж, нас барагсдын төлөөх ажлыг урьд өмнө үзэгдээгүй хурдацтай болгож байгааг би гэрчилж байна.

Харин та нарын хувьд байдал ямар байгаа вэ? Өвөг дээдсийн төлөө хийх ажлын талаар та нар залбирч үзсэн үү? Амьдралд тань төдийлөн чухал биш зүйлсийг хойш нь тавь. Мөнхийн үр дагавартай зүйлсийг хийхээр сонго. Өвөг дээдсийнхээ тухай мэдэхсэн гэж хүсэвч, би чинь удмын судлаач биш шүү дээ гэж бодогдож магадгүй. Өвөг дээдсээ судалж тогтооход ямар нэг тусгай зүйл хэрэггүйг та ойлгож байгаа биз дээ? Хөшигний цаана байгаа, өөртөө туслах боломжгүй хүмүүсийг хайрлах хайр, тэдэнд туслах чин сэтгэлийн хүсэл байхад л болно. Энэ ажилд надад тусалж чадах ямар хүмүүс байгаа билээ гэдгийг бод. Амжилт олоход

тань тусалж чадах хэн нэгэн таньдаг хүмүүсийн тань дотор байж л байгаа.

Энэ ажил бол сүнсний ажил бөгөөд хөшигний хоёр тал дахь хамтын хүч чармайлтын үр дүнд газар дээрх болон тэнгэр дэх хүмүүсийн аль алинд нь тусалдаг. Та дэлхийн хаана ч амьдардаг бай, итгэл, залбирал, шийдвэр төгс байдал, шаргуу хичээл зүтгэл, багахан золиослолоор энэ ажилд чухал хувь нэмэр оруулж чадна. Яг одоо эхлэгтүн. Их Эзэн та нарт замаа олоход тань тусална гэдгийг би та нарт амлаж байна. Энэ ажил танд гайхалтай сайхан сэтгэгдэл төрүүлэх болно. Есүс Христийн нэрээр, амен.

#### Эшлэл

1. Иохан 3:5.
2. *History of the Church*, 4:231.
3. Сүмийн Ерөнхийлөгч нарын сургаалууд: Иосиф Смит(2007), 471–72.
4. Сургаал ба Гэрээ 110:13–16-г үзнэ үү.
5. Сургаал ба Гэрээ 2:2; тодотгол нэмэгдсэн.
6. Ховард В.Хантер, “A Temple-Motivated People,” *Лиахона*, 1995 оны 5-р сар, 5–6.
7. Тэргүүн Зөвлөлийн захидал, 2012 оны 2-р сарын 29; тодотгол нэмэгдсэн.
8. Женин Скоттын хувийн тэмдэглэл, 1988 оны 4-р сар.
9. Женин Уоткинс Скотт, хувийн тэмдэглэл, 1989 оны 9-р сарын 23.



# Аврагчид нэг алхмаар ойртох

Рассел Т.Осгаторп

*Ням гарагийн ангийн Ерөнхий Ерөнхийлөгч*

---

*Сургаалаас суралцах болон заахын бүхий л зорилго хөрвөлт юм. Хөрвөлт бол нэг удаагийн үйл явдал биш юм. Аврагчтай илүү адил болохын тулд энэ нь амьдралын турш үргэлжлэх аян зам юм.*

---

Өнгөрсөн зун миний бичсэн товч өгүүлэл *Лиухона* болон *Ensign*-дээр гарсан юм. Манай хүү над руу э-мэйл бичихдээ “Ааваа, таны өгүүлэл хэвлэгдэх гэж байгааг та урьдчилан хэлж болох байсан шүү дээ” гэсэн байв. Би тэгэхэд нь, “Та нарыг сүмийн сэтгүүлээ уншиж байна уу, үгүй юу мэдмээр байсан юм” гэж хариу бичсэн юм. Тэр, түүний 10 настай охин нь уг шалгалтыг “амжилттай давсныг тайлбарлан хариу бичсэн. Тэр шуудангийн хайрцагнаас *Ensign*-авч гэртээ ирээд үүнийгээ уншсан. Дараа нь тэр бидний өрөөнд ирээд таны өгүүллийг бидэнд үзүүлсэн” гэж тэр бичсэн байсан.

Миний ач охин сурахыг хүссэн учраас *Ensign* - ийг уншсан. Тэр сонголтынхоо дагуу бас үйлдлээ ч хийсэн. Тэргүүн Зөвлөл саяхан, залуучуудын суралцах, даган амьдрах, болон сургаалыг хуваалцах дотоод сэтгэлийн хүслийг нь дэмжих шинэ сургалтын сурах материал баталсан. Эдгээр шинэ сурах материалуудыг одоо интернетээс харах боломжтой. Нэгдүгээр сараас эхлэн бид энэхүү сурах материалуудыг ангиуддаа хэрэглэж эхлэнэ. (Илүү ихийг сурахыг хүсвэл [lds.org/youth/learn](https://www.lds.org/youth/learn))

Аврагчийг зааж байхад, суралцагчийн идэвх тэргүүн чухал байсан. Тэр зөвхөн юу заахыг бидэнд үзүүлсэн төдийгүй мөн хэрхэн заахыг үзүүлсэн юм. Тэр суралцагчийн хэрэгцээнд

анхаардаг байсан. Тэр хувь хүнд өөрсдөө бие даан үнэнийг хэрхэн олж мэдэхэд нь тусалсан.<sup>1</sup> Тэр үргэлж тэдний асуултуудыг сонсдог байв<sup>2</sup>

Эдгээр шинэ сурах материал нь бид бүгдэд гэртээ болон ангидаа Аврагчийн арга барилаар суралцах болон заахад туслах болно.<sup>3</sup> Бид үүнийг хийх үедээ, Ахлагч Роберт Д.Хейлсийн сая зааснаар Аврагчийн “Ирээд, Намайг дага”<sup>4</sup> гэсэн урилгад хариулах болно. Эдгээр шинэ материалуудыг бэлэн болгож байх зуур, суралцагч нарынхаа хэрэгцээ шаардлагыг хангахын тулд туслах байгууллагууд болон семинарын зөвлөлийн удирдагчид мөн багш нар нь эцэг эхчүүдтэй хамтран зөвлөлдөж байхыг би харсан. Залуу эмэгтэйчүүдийг ангидаа, залуу эрэгтэйчүүдийг Аароны санваарын чуулгадаа, залуучуудыг Ням гарагийн ангид, тэд чөлөөт сонголтоо ашиглан мөн өөрсдийн төлөө үйлдэхийг сурч байгааг би харсан.

Залуучуудын Ням гарагийн ангийн нэгэн багш, зожигрох хам шинж буюу аутизмтай хоёр залуу эрэгтэйд хэрхэн чөлөөт сонголтоо ашиглан мөн өөрсдийн төлөө үйлдэхэд нь туслах талаар эргэцүүлэн бодож байлаа. Ангийн гишүүдийг юу сурсан тухайгаа хуваалцахыг урихдаа тэр энэ хоёр залуу эрэгтэйг түүний урилгаас татгалзах вий хэмээн санаа нь зовж байсан юм. Гэвч тэд тэгсэнгүй. Нэг нь юу сурснаа заахаар зогсож, дараа нь нөгөө аутизмтай ангийн найзаа өөртөө туслуулахаар урив. Эхнийх нь гацаж эхлэхэд түүний ангийн найз нь түүний хажууд байж чи амжилттай байж чадна гэж түүний чихэнд шивнэж байсан. Тэр өдөр, тэд хоёулаа заасан. Тэд Аврагч юу заасныг заасан юм, мөн түүнээс гадна тэд Аврагч хэрхэн заасны адил заасан. Энэ ангийн хүүхэд найзынхаа төлөө үйлдсэний адил, Аврагч зааж байгаа хүндээ хайрын үүднээс үйлддэг билээ.<sup>5</sup>

Түүний арга замаар, Түүний үгнээс суралцах болон зааж байгаа үедээ бид түүний “Ирээд, Намайг дага” гэсэн урилгыг хүлээн авдаг. Бид Түүнийг нэг удаад нэг алхмаар дагадаг. Алхам бүрд бид Аврагч руу ойртдог. Бид өөрчлөгддөг. Их Эзэн сүнслэг өсөлтийг гэнэт бий болдоггүйг мэднэ. Энэ нь аажмаар бий болдог. Бид түүний урилгыг хүлээж авах бүрдээ,

түүнийг дагахаар сонгох болгондоо бид бүрэн дүүрэн хөрвөгдөх зам дээрээ өсч хөгжиж байдаг.

Сургаалаас суралцах болон заахын бүхий л зорилго нь хөрвөлт юм. Хөрвөлт бол нэг удаагийн үйл явдал биш юм. Аврагчтай илүү адил болохын тулд энэ нь амьдралын турш үргэлжлэх аян зам юм. Ахлагч Даллин Х.Өүкс “*мэдэх нь*” хангалттай биш гэж бидэнд сануулсан. “Хөрвөгдөх нь . . . биднээс *хийх*, болон *болохыг* шаарддаг.”<sup>6</sup> Хөрвөлтийн төлөө сурах нь мэдэх, хийх болон болохын үргэлжилсэн үйл явц юм. Үүний нэгэн адил хөрвөлтийг заах нь түлхүүр сургаал, үйлдэх урилга, амлагдсан адислалуудыг шаарддаг.<sup>7</sup> Үнэн сургаалыг зааж байгаа үедээ, бид суралцагчид үнэнийг мэдэхэд нь тусалж байгаа хэрэг юм. Бид бусдыг үйлдэхийг урьж байгаа үедээ тэднийг сургаалын дагуу үйлдэхэд эсвэл амьдрахад нь тусалдаг. Их Эзэний амласан адислалууд ирэхэд бид өөрчлөгддөг. Алмагийн адил, бид шинэ бүтээлүүд болж чадна.<sup>8</sup>

Залуучуудад зориулсан шинэ сурах материал нь нэг үндсэн зорилготой: Есүс Христийн сайн мэдээнд хөрвөгдөхөд залуучуудад туслах. Би саяхан нэг залуу эрэгтэйг залуучуудын Ням гарагийн ангиас өөрөө үнэнийг мэдэж авч байгааг харсан. Цагаатгалыг өөрийнхөө амьдралтай холбох нь түүнд хэцүү байгааг би анзаараад, түүнээс чи уучлалыг мэдэрч байсан уу гэж асуухад тэр “Тийм ээ, би хөл бөмбөг тоглож байгаад нэг залуугийн хамрыг гэмтээсэн нь надад их хэцүү байсан. Би санаагаа амраахын тулд юу хийх хэрэгтэй талаар бодсон. Тиймээс би түүний гэр рүү явж түүнээс намайг уучлахыг гуйсан юм, гэвч би үүнээс илүүт хийх хэрэгтэйгээ мэдэж байсан. Тэгээд би залбирсан. Дараа нь Тэнгэрлэг Эцэг намайг бас уучилсныг би мэдэрсэн юм. Миний хувьд Цагаатгал гэдэг нь ийм утга учиртай юм” гэж хариулсан.

Тэр энэ туршлагаа ангидаа хуваалцаж байхдаа Иохан 3:16-аас — “Бурхан ертөнцийг үнэхээр хайрласан тул цорын ганц Хүүгээ өгсөн” — гэж уншаад мөн Цагаатгалын хүчний тухай гэрчлэлээ хуваалцсан юм. Энэ сургаал нь уг залуу эрэгтэйн хувьд хийсвэр ойлголт байхаа больсон билээ. Энэ нь түүний амьдралын хэсэг болсон. Учир нь тэр асуулт асууж дараа нь үйлдэхэд сонгох эрхээ ашигласан юм.<sup>9</sup>

Энэ залуу эрэгтэй илүү хөрвөгдсөн мөн ангийнхан нь ч гэсэн. Тэд судруудыг судалснаар түлхүүр сургаал дээр анхаарал хандуулсан. Тэд тэдгээр ариун нандин үгсийг амьдралтайгаа холбож дараа нь сургаальн дагуу амьдарснаар тэдэнд ирсэн адислалуудын талаар гэрчилсэн. Бид Есүс Христийн сайн мэдээг заахдаа судар болон өнөөгийн бошиглогчдын үгс дээр анхаарлаа төвлөрүүлдэг. Бид итгэлийг хүчирхэгжүүлэхэд, гэрчлэлтэй болоход, хүн бүрт бүрэн хөрвөхөд нь туслахдаа ариун бичээсүүдэд найддаг. Залуучуудад зориулсан шинэ сурах материал нь хэрэглэж байгаа бүгдэд, Бурханы үгийг ойлгож, түүний дагуу амьдрахад тусалж чадна.

Би Коста Рика – д Гэгээнтнүүдэд зааж байхдаа *Teaching, No greater call* буюу Заахаас илүү агуу дуудлага гэж үгүй – номыг бариад “та нарын хэн хэнд энэ гарын авлага байгаа вэ?” гэж асуухад бараг хүн бүр гараа өргөсөн юм. Би инээгээд та нар энэ гарын авлагаас өдөр бүр уншиж байгаа байлгүй дээ гэж хэллээ. Гайхалтай нь урд эгнээнд сууж байсан эгч би энэ номыг өдөр бүр уншдаг гээд гараа өргөлөө. Би түүнийг индэр дээр гарч тайлбарлахыг хүссэн юм. Тэр “Би Мормоны номыг өглөө бүр уншдаг. Дараа нь сурснаа хүүхдүүддээ хамгийн шилдэг аргаар заахын тулд би *Teaching, No greater call* буюу Заахаас илүү агуу дуудлага гэж үгүй номноос ямар нэгэн зүйл уншдаг” хэмээн тэр хариулсан.

Тэр эгч, Сайн мэдээг Аврагчийн арга замаар сурч, заахыг хүссэн бөгөөд Аврагчийн үгийг судраас суралцаж, дараа нь хүүхдүүд нь бүрэн хөрвөгдөж болохын тулд тэдэнд хэрхэн заах талаараа бас суралцжээ. Түүний сайн мэдээг сурах ба заах хэв маяг нь гэнэт бий болоогүй юм. Тэр ямар нэгэн зүйлийг хийх шийдвэр гаргасан. Тэр хийх хэрэгтэй гэж мэддэг зүйлээ хийхийн хэрээр Их Эзэн түүнийг Өөрийн замаар алхахад нь хүчирхэгжүүлсэн юм.

Заримдаа хөрвөлтийн үе шат удаан бас хэцүү байж болох юм. Манай хүргэн ах Сүмд 50 жилийн турш идэвхгүй байсан юм. 60 гарсан насандаа л, тэр Аврагчид буцаж ирэх урилгыг хүлээн авч эхэлсэн юм. Тэр явцад нь олон хүн түүнд тусалж байсан. Нэгэн гэрийн багш нь 22 жилийн турш сар бүр түүнд ил захидал илгээдэг байсан байна. Гэвч тэр буцаж ирэх эсэхээ

өөрөө л шийдэх ёстой байв. Тэр сонгох эрх чөлөөгөө эдлэх хэрэгтэй байв. Тэр хамгийн эхний алхамыг хийх хэрэгтэй байв. Тэгээд дараа дараагийнх нь алхамуудыг хийх болов. Одоо тэр эхнэртэйгээ мөнхөд холбогдсон ба тэр бишопын зөвлөлд үйлчилж байна.

Саяхан бид шинэ сургалтын материалыг хэрэглэхэд нь удирдагч болон багш нарт туслахад зориулан бүтээсэн нэгэн видео бичлэгийг түүнд үзүүлсэн юм. Үзсэнийхээ дараа хүргэн ах маань сандал дээрээ арагшаа налан “Хэрэв энэ нь намайг залуу байхад байсан бол би идэвхгүй болохгүй байсан байхаа” гэж билээ.

Хэдэн долоо хоногийн өмнө би эргэлзэж байсан нэгэн залуу эрэгтэйтэй уулзсан юм. Би түүнээс сүмийн гишүүн эсэхийг нь асуусан. Тэр үл итгэгч, гэвч бага байхдаа Сүмтэй холбоотой байдаг байсан гэж хэллээ. Би түүнд Ням гарагийн ангид дуудлагатай гэдгээ мөн удахгүй ерөнхий чуулганд яриа өгөх гэж байгаагаа хэлэхэд тэр “Хэрвээ та ярих гэж байгаа бол би тэр хуралдааныг үзнээ гэж хэлсэн юм”. Би түүнийг өнөөдөр үзэж байгаа гэж найдаж байна. Хэрэв тэр үзэж байгаа бол ямар нэгэн зүйлийг сурсан гэдгийг би мэднэ. Энэ чуулганы төв бол хөрвүүлэлтийн төлөө сурах болон заах онцгой газар юм.

Бидний бошиглогч, үзмэрч, илчлэлт хүлээн авагчаар дэмжин баталдаг тэдгээр хүмүүсээр заагдсан зарчмуудын дагуу амьдрах үед бид Аврагчийн арга замаар суралцдаг.<sup>10</sup> Бид түүнд нэг алхмаар ойртдог. Энэ чуулган өндөрлөх дөхөх зуур, миний яриаг сонсож байгаа хүн нэг бүрийг тэрхүү алхамыг хийхийг би урьж байна. Эртний Нифайчуудын адил “мөн миний хэлсэн зүйлсийг эргэцүүлж, мөн, та нар ойлгож болохын тулд миний нэрээр Эцэгээс асууж” бид гэртээ харьж болно.<sup>11</sup>

Бид залуу хүн бүрийг ойлгоосой гэж хүсч байна. Бид тэднийг өдөр бүр сурч, зааж, Есүс Христийн сайн мэдээгээр амьдраасай гэж хүсч байна. Энэ бол Их Эзэний бүх хүүхдүүдээсээ хүсдэг зүйл юм. Та хүүхэд ч бай, залуу ч бай, насанд хүрэгч ч бай, би та нарыг Түүний зам дээр ирж дагахыг урьж байна. Бидний ойртох алхам бүрээр Их Эзэн биднийг хүчирхэгжүүлэх болно гэдгийг би гэрчилж байна.

Тэр бидэнд үлдсэн зам дээрээ ирэхэд туслах болно. Саад бэрхшээл тохиолдоход бид аян замаа үргэлжлүүлэх болно. Бид хэзээ ч эргэж буцахгүй. Бид хэзээ ч холдож гарахгүй.

Би Бурхан Эцэг болон Түүний хүү, Есүс Христ амьдыг мэднэ. Аврагч хуучин цагийн адил Түүнд ир хэмээн биднийг дуудсаар байгаа гэдгийг би гэрчилж байна. Бид бүгд Түүний урилгыг хүлээн авч чадна. Бид бүгд Аврагчид илүү ойртсоноор Түүний арга замаар сурч, зааж, мөн Түүний үгийн дагуу амьдарч чадна. Бид ингэж хийвэл бид үнэнээр хөрвөгдөх болно. Есүс Христийн нэрээр, амен.

### Эшлэл

1. Иохан 3:1–7 – г үз. Энэ ишлэл дээр Аврагч Никодемийн асуусан асуултанд хариулдаг. Тэр Никодемийн хэрэгцээний дагуу түүнд заасан. Тэр Никодемид сурах эрхээ эдлэхийг нь зөвшөөрсөн юм. Тэр Никодемд хариултаа өөрөө олж мэдэхэд нь тусалсан юм.
2. Иохан 3:4; Иосеф Смитийн – Түүх 1:18-г үз.
3. lds.org/youth/learn/guidebook/teaching. хуудасны “Teaching the Gospel in the Savior’s Way,”– г үз.
4. Лук 18:18–22-г үз..
5. 1 Иохан 4: 19-г үз.
6. Даллин Х.Өүкс “The Challenge to Become,” *Лиахона*, 2001 оны нэгдүгээр сар, 41: “Гэрчлэх нь мэдэх ба тунхаглах юм. Сайн мэдээ нь биднээс үйлдэх болон түүн шигээ болохыг шаарддаг ‘хөрвөгдөх’ хэмээх зүйлд биднийг урьдаг. Бид сайн мэдээний талаарх мэдлэг болон гэрчлэлдээ зөвхөн найддаг бол бид адислагдсан хэвээрээ. Гэвч Христийн урьсанчлан бүрэн гүйцэд хөрвөгдөөгүй хэвээрээ байх болно. Бид бүгдээрээ хүчтэй гэрчлэлтэй боловч хөрвөгдөөр үйлддэггүй хүмүүс байдгийг мэддэг шүү дээ.”
7. Абрахам 2:11- үз.
8. Мозая 27:24–26; 2 Коринт 5:17-г үз.
9. Дэвид А.Беднар “Watching with All Perseverance,” *Лиахона*, 2010 оны тавдугаар сар, 43: “Та бид хүүхдүүдээ өөрсдөө хийж, судалж мөн итгэлээрээ сурахыг эрэлхийлдэг биеэ даасан хувь хүн болоход нь тусалж чадаж байна уу эсвэл заалгуулж, хийхдээ үргэлж хүлээдэг хүн болгон хүмүүжүүлж байна уу? Эцэг эхийн хувьд бид тэдэнд сүнслэг байдлыг тэнцүү өгч чадаж байна уу эсвэл тэдэнд өөрсдөө үйлдэж, өөрсдийнхөө төлөө сурч, гуйвшгүй хөдөлшгүй зогсоход нь байнга тусалж чадаж байна уу? Бид хүүхдүүдээ асууж, эрэлхийлж, тогшихдоо санаа сэтгэлээ бүрэн зориулдаг байхыг сургадаг уу?
10. Dennis B. Neuenschwander, “Living Prophets, Seers, and Revelators,” *Liahona*, 2001 оны нэгдүгээр сар, 49–51.
11. 3 Нифай 17:3..

# Итгэлээр бүх зүйл гүйцэлддэг

Далын

Ахлагч Маркус Б.Нэш

*Итгэл нь бидэнд сайн мэдээний замаар аюулгүйгээр аялахад, мөнх бус амьдралын турши зовлон зүдгүүрүүдийг даван туулахад, мөн Тэнгэрлиг Эцгийн сүр жавхланта оршихуйд эргэн очиход маань бидэнд туслах туслах болно.*

Саяхан бид гэр бүлээрээ Перугийн уулан дахь эртний Инкийн Мачу Пичу хэмээх балгастай залгаа нэгэн өндөр оргил болох Хюана Пичугийн орой дээр авирч гарсан юм. Энэ газар нь үзэсгэлэнт байгалиар хүрээлэгдсэн, эгц шулуун хад хясаатай, авирч гарахад их өгсүүр газар байсан. Харамсалтай нь, зарим хүмүүс энэ нарийн бөгөөд өгсүүр замаас унаж амь эрсэдсэн тохиолдол гарч байсан ажээ. Үүнээс хойш төмөр утсан бариулыг Мачу Пичу уулын энгэрийн дагуу бөх бат хаднаас аргамжиж бэхэлсэн байна. Бид энэ уул өөд гарахдаа энэ төмөр утсан бариулаас барьж явсан учир уулын оргил дээр эсэн мэнд гарч чадсан юм. Эргэн тойрон маш гайхамшигтай сайхан харагдаж байлаа.

Хюана Пичу дээрх замын адил бидний мөнх бус амьдралын аян маш өгсүүр хэцүү авиралт мэт байдаг. Аянаа амжилттай дуусгахын тулд бидэнд Тэнгэрлэг Эцгийн тусламж хэрэгтэй. Тийм учраас Аврагч руу болон Түүний авралын хүчинд биднийг авчрах сайн мэдээний зарчмууд болон ёслолуудыг Тэнгэрлэг Эцэг маань бүтээсэн юм.<sup>1</sup> Эдгээр зарчмуудын хамгийн эхнийх нь болох Их Эзэн Есүс Христэд итгэх итгэл<sup>2</sup> бөгөөд энэ нь Хюана Пичу дээрх төмөр утсан

бариултай адил юм: “Гэтэлгэгчийн хаднаас”<sup>3</sup> бат бөх бэхлэгдсэн тохиолдолд итгэл нь мөнх бус амьдралын бэрхшээл бүрийг дийлж,<sup>4</sup> сайн мэдээний замаар эсэн мэнд авирахад болон Тэнгэрлэг Эцэгийнхээ гайхамшигт оршихуйд буцаж очиход бидэнд тусалдаг. Итгэлээр бүх зүйлс гүйцэлддэг билээ.<sup>5</sup>

Итгэл нь үйлдэл хүч хоёрын аль алиных нь зарчим юм.<sup>6</sup> Энэ нь “юмсын тухай төгс мэдлэгтэй байх нь бус юм; тиймийн тул хэрэв [бид] итгэлтэй аваас [бид] үнэн хийгээд үл харагдах зүйлүүдэд найдах”<sup>7</sup> юм. Энэ нь биднийг сурсан зүйлсээ ашиглан үйлдэл хийхэд<sup>9</sup> өдөөдөг хүчирхэг хөшүүрэг<sup>8</sup> юм. Бид золиослол, хүнд сорилтын үед ч гэсэн Аврагчийн үлгэр жишээг дагаж, Түүний зарлигуудыг залбирч дагахаар удирдагддаг билээ.<sup>10</sup> Итгэл нь бидэнд бусад зүйлсийн хамт сайн сайхныг авчрах найдвар<sup>11</sup> бөгөөд итгэлийг батлан харуулах гайхамшиг<sup>12</sup> болох Их Эзэний хүчийг түүнчлэн сүнсний болон материаллаг аж байдлын зүйлсээр бурханлаг хамгаалалтыг бидэнд авчирдаг юм.<sup>13</sup>

Сүм анх байгуулагдах үед нэгэн анхдагч эмэгтэй Анн Раулийгийн амьдрал, бидний амьдралд итгэл хэрхэн сайн нөлөө үзүүлдэгийг харуулсан юм. Англиас ирсэнбэлэвсэн эхнэр Раулий эгч Сионд цугларах бошиглогчийн дуудлагыг дагаснаар итгэлээ харуулжээ. Тэрээр Виллигийн гар тэрэгтэй хэсгийн гишүүн байсан бөгөөд тэд 1856 оны намар маш хүчтэй цасан шуургатай тулгарсан юм. Тэдний долоон хүүхэд замдаа өлбөрч үхдэгийн даваан дээр ирсэн тухай тэр ийнхүүбичжээ: “Хүүхдүүдээ өлсөхийг нь харахад надад маш хэцүү байсан. . . . Үдэш болох гэж байдаг, гэтэл оройн хоолонд идэх юм юу ч байсангүй. Би урьд нь Бурханаас байнга тусламж гуйдаг байсан шигээ энэ удаа ч бас л гуйлаа. Далайн аяллаас үлдсэн хоёр хатуу жигнэмэгийг санаад би сөхөрч суув. Тэр хоёр жигнэмэг том биш байсан бөгөөд хагархааргүй маш хатуу байв. 8 хүнд аманд ч үгүй хамарт ч үгүй гэгч л болох байв. Гэтэл Есүс 5 талх 2 загасаар 5000 хүнийг хооллож, Өөрийн гайхамшигын хүчийг харуулсан шүү дээ. Иймээс Бурханы тусламжтайгаар болохгүй зүйл гэж үгүй. Би жигнэмэгүүдийг тогоонд хийж дээрээс нь ус хийгээд Бурханаас адислалыг гуйв. Тэгээд тогооны тагийг нь тавиад



нүүрсэн дээр тавилаа. Хэсэг хугацааны дараа тогооны тагийг авахад тогоо дүүрэн хоолтой болсон байв. Би гэрийнхэнтэйгээ хамт сөхөрч суугаад Бурханд сайхан сэтгэлийнх нь төлөө талархаж билээ.”<sup>14</sup>

Анн Раулий сайн мэдээгээр амьдрахдаа агуу золиослол хийсэн бөгөөд тусламж хэрэгтэй үедээ залбирлаар дамжуулан гуйдаг байжээ. Итгэлийнхээ ачаар тэр найдвараар жигүүрлэн, гэр бүлийнхнээ ер бусын замаар хооллосон ажээ. Их Эзэн бас түүнийг “эцсээ хүртэл тэвчих”<sup>15</sup> мөнхийн чадвараар адисалжээ. Ирээдүй нь тодорхой бус байсан ч тэрээр дараагийн өдөр хүүхдүүдээ хэрхэн хооллохыг мэдэхийг шаардсангүй харин үүний оронд тэрээр нэгэн сайхан дуулын үгийн адил “Их Эзэнд хүлээцтэй хандаж”<sup>16</sup> итгэл найдвартайгаар урагшилсан юм:

*Энэрэлт Гэрэл минь намайг хөтлөөч, түнэр харанхуй дунд  
намайг та хөтлөөч!*

*Үдэш болж харанхуй болоход орон гэрээсээ хол байна би,  
Намайг хөтлөөч Та минь!*

*Алхааг минь чиглүүлээч, тэртээх холыг харахыг би гуйсангүй  
Ганцхан алхам л надад хангалттай билээ.*<sup>17</sup>

Бид мөн Их Эзэнд итгэх итгэлээ хөгжүүлж, хувиршгүй сайхан сэтгэлт Бурхан<sup>18</sup> маань биднийг Өөрийн агуу хүчээр бидний нөхцөл байдалд тохируулан өөрийн цаг хугацааны дагуу адислах болно гэдэгт итгэн найдаж чадна. Ингэснээр бид Бурханы мутарыг өөрсдийн амьдралдаа олж харах болно.

Бурхан бидэнд “ёсон бусчуудын бүхий л галт сумнуудыг та нар унтраах боломжтой байх итгэлийн тэрхүү бамбайг гартаа ав”<sup>19</sup> хэмээн зарлиг болгосон билээ. Сатан эргэлзээ, айдас, нүгэл хилэнц зэргийг хэрэглэн бидний итгэл болон хамгаалалтыг алдуулахаар уруу татдаг. Итгэлийг сорих эдгээр бэрхшээлүүдэд хянамгай хандсанаар бид чөтгөрийн уруу таталтуудыг таньж, тэдгээрийг хайхрахгүй байж чадна.<sup>20</sup>

Нэгдүгээрт, Их Эзэн болон Түүний сайн мэдээнд үл итгэх нь биднийг Бурханы Ариун Сүнснийг эсэргүүцэхэд хүргэдэг.<sup>21</sup> Эргэлзээг үгүй болгох Их Эзэний арга зам нь энгийн зүйл байдаг. Хаан Бенжамин ийнхүү тунхаглажээ: “Бурханд итгэ; тэр байдагт итгэ, мөн тэр, тэнгэрт болон газарт аль алин дээрх

бүх зүйлийг бүтээсэнд итгэ; тэр бол тэнгэрт мөн газарт аль алинд нь бүх мэргэн ухааныг, мөн бүх хүч чадлыг эзэмшигч гэдэгт итгэ; Их Эзэний ухаарч чадах тэр бүх зүйлийг хүмүүн ухаардаггүйд итгэ.”<sup>22</sup>

Үл итгэх байдал болон эргэлзээнээс болоод итгэл тань гуйвах үед эртний төлөөлөгчид хүртэл Их Эзэнээс “итгэлийг нь өсгөж өгөхийг”<sup>23</sup> гуйж байсныг санагтун. Итгэл болон учир шалтгаан нь зайлшгүй хамтрагч гэдгийг санаад дараах нэгэн үзэл бодлыг тунгаан бодно уу. Итгэл, учир шалтгаан хоёр нь онгоцны хоёр далавч лугаа адил юм. Нисэхэд хоёулаа зайлшгүй шаардлагатай. Хэрэв та нарын үзэл бодлоор учир шалтгаан нь итгэлтэй зөрчилдвөл, та нарын үзэл бодол Их Эзэнийхтэй харьцуулахад маш хязгаарлагдмал байдгийг санагтун.<sup>24</sup> Нислэгийн үеэр онгоцны далавчийг салгаж болохгүйтэй адил итгэл нь гээгдэн алга болох ёсгүй. Харин итгэлийн жижиг хэсгүүдийг тордон хөгжүүлвэл үүний үр дүнд ирэх найдвар нь та нарын учир шалтгаан болон бодгалд зангуу болох боломжтой юм.<sup>25</sup> Тийм учраас бидэнд “судлахаар мөн тэрчлэн итгэлээр, суралцахыг эрэлхийлэхийг”<sup>26</sup> зарлиг болгосон юм. Бид өөрсдийн туршлагаар тайлбарлах боломжгүй гайхамшгуудын өмнө итгэл байх ёстойг мөн итгэл нь эдгээрээс үүдэлтэйг санагтун. Хоёрхон жигнэмгээс тогоо дүүрэн хоол бий болсон мөн бүх зүйл бидний эсрэг юм шиг санагдах хүнд хэцүү цагийг итгэлээр даван туулсан зэрэг нь гайхамшиг мөн.<sup>27</sup>

Хоёрдугаарт, айдас нь Аврагчид итгэх бидний итгэлийг сулруулж, Түүнд хандах бидний анхаарлыг сарниулдаг юм. Төлөөлөгч Петр нэгэн шуургатай шөнө Их Эзэнд хандсан бөгөөд усан дээр алхтал “салхийг харан айж” анхаарал сарниснаас болоод живж эхлэв.<sup>28</sup> Хэрэв тэр айгаагүй бол цаашид усан дээр алхаж чадах байсан. “Санаа бодол болгондоо над уруу харагтун; бүү эргэлз, бүү ай.”<sup>29</sup>

Гуравдугаарт, нүгэл нь Ариун Сүнснийг бидний амьдралаас холдуулдаг бөгөөд Ариун Сүнсгүйгээр бид итгэлээ хөгжүүлэх сүнсний хүч чадлаар дутагддаг. Бид “хилэнцэт бэлэгт, бас цэвэр бус зүйлд үл хүрэн”<sup>30</sup> мөн “итгэл чинь та нарт алдагдахгүйн тулд, мөн дайснууд чинь та нарыг ялахгүйн тулд . . . бүх зарлигийг сахихад хичээнгүй”<sup>31</sup> байх нь итгэлээ

хөгжүүлэх хамгийн зөв арга юм. Хэрэв нүгэл та бүхний амьдралыг булингартуулж, та бүхнээс Ариун Сүнсний дээрэмдсэн бол “наманчлалд хүргэх итгэлийг”<sup>32</sup> хөгжүүлээч гэж та бүхнээс хүсч байна, тэгснээр Цагаатгалаар дамжуулан, Аврагч та бүхний амьдралыг ариусган эдгээх болно.

Ах, эгч нараа, Их Эзэн бидний итгэлийн дагуу Өөрийн амлалтуудыг биелүүлэх бөгөөд бэрхшээл бүрийг даван туулахад бидэнтэй хамтран зүтгэх болно.<sup>33</sup> Тэрээр Анн Раулийд тусалсан шигээ бүх улс үндэстэн, бүх эрин зуунд амьдарч байсан болон одоо амьдарч байгаа бүх хүмүүст тусалсаар ирсэн, тусалж ч байгаа билээ. Тэрээр “гайхамшигийн Бурхан” мөн “Өөрчлөгдөшгүй Нэгэн” учраас бид бүхнийг Өөрт нь итгэх итгэлийн дагуу найдвар, хамгаалалт болон хүчээр адислах болно.<sup>34</sup> Их Эзэн Есүс Христэд гуйвшгүй итгэх итгэл нь тэрхүү Хюана Пичугийн зам дээрх төмөр утсан бариултай адил та нар болон та нарын хайрт хүмүүсийг Гэтэлгэгчийн хад болон Түүний юутай ч зүйрлэшгүй аврах хүчинд найдвартай бөхлөх болно.<sup>35</sup>

Ерөнхийлөгч Томас С.Монсон, “ирээдүй нь та нарын итгэлийн адил гэгээтэй”<sup>36</sup> юм гэж хэлжээ. Би тэрхүү гайхамшигт, найдвартай үнэнийг гэрчилж, та бүхэн Их Эзэндээ итгэлтэйгээр “ямар ч эргэлзээгүйгээр”<sup>37</sup> гуйвшгүй урагш тэмүүлэхийг урьж байна. Аврагч амьд бөгөөд Тэрээр “итгэлийн үндэслэгч мөн төгсгөгч”<sup>38</sup> бөгөөд “Өөрийг нь хайгч хүмүүст Тэр шагнагч нь болдог”<sup>39</sup> гэдгийг гэрчилж байна. Би энэ бүгдийг Есүс Христийн нэрээр гэрчилж байна, амен.

#### Эшлэл

1. Сургаал ба Гэрээ 84:19–21-г үзнэ үү.
2. Итгэлийн тунхаг 1:4-г үзнэ үү..
3. Хиламан 5:12.
4. Сургаал ба Гэрээ 76:53-г үзнэ үү.
5. Ифер 12:3-г үзнэ үү.
6. *Lectures on Faith* (1985), 3; мөн Иаков 4:6; Ифер 12:7–22; Еврей 11:4–40 - г үзнэ үү.
7. Алма 32:21.
8. Иосеф Смитийн орчуулга, Еврей 11:1 (in Еврей 11:1, footnote b)- г үзнэ үү..
9. 2 Нифай 25:23; Алма 34:15–17; Ифер 12:6; мөн Иаков 2:17–26-г үзнэ үү.
10. Ифер 12:4–6, ; *Lectures on Faith*, 69-г үзнэ үү.
11. Моронай 7:40–42-г үзнэ үү.
12. Мормон 9:8–21; Моронай 7:33–37 мөн Судруудын Удирдамж, “Итгэл”-ийг үзнэ үү.
13. Сургаал ба Гэрээ 27:17; мөн Алма 57:19–27; 58:10–13-ыг үзнэ үү .
14. Анн Раулий, Андро Д.Олсенний, *The Price We Paid: The Extraordinary*

- Story of the Willie and Martin Handcart Pioneers* (2006), 113.
15. Сургаал ба Гэрээ 20:25.
  16. Исаиа 40:31.
  17. "Lead, Kindly Light," *Дууны ном*, №. 97.
  16. Иаков 4:10; Мормон 9:9-г үзнэ үү.
  19. Сургаал ба Гэрээ 27:17 тодруулга нэмсэн.
  20. 1 Нифай 8:33–34; мөн Алма 37:33; Сургаал ба Гэрээ 20:22-г үзнэ үү.
  21. Алма 32:28-г үзнэ үү.
  22. Мозая 4:9–10.
  23. Лук 17:5..
  24. Мозая 4:9–10; Сургаалт Үгс 3:5–7; Исаиа 55:8–9-г үзнэ үү.
  25. Ифер 12:4-г үзнэ үү.
  26. Сургаал ба Гэрээ 88:118; тодруулга нэмэгдсэн.
  27. Моронай 7:33–38; Ифер 12:19-ийг үзнэ үү.
  28. Матай 14:25–31-ийг үзнэ үү.
  29. Сургаал ба Гэрээ 6:36.
  30. Моронай 10:30.
  31. Сургаал ба Гэрээ 136:42.
  32. Алма 34:15–17 мөн Ифер 12:3-г үзнэ үү.
  33. Ифер 12:29; Алма 7:27-г үзнэ үү.
  34. Мормон 9:18–21; мөн Моронай 7:33–38; Алма 37:16–17-г үзнэ үү.
  35. Хиламан 5:12.
  36. Томас С.Монсон, "Be of Good Cheer," *Лиэхона*, 2009 оны 5-р сар, 92.
  37. Иаков 1:6–8-ыг үзнэ үү.
  38. Моронай 6:4 мөн Еврей 12:2-г үзнэ үү.
  39. Еврей 1:6; мөн Ифер 12:41-ийг үзнэ үү.

---

# ЖИНХЭНЭ ШАВЬ БОЛОХ НЬ

Далын

Ахлагч Даниел Л.Жонсон

---

*Бид Түүний зарлигуудыг сахъж, нөхдөдөө  
үйлчилснээр Есүс Христийн сайн шавь нар болж  
чадна.*

---

Баптисмын усанд орж, Ариун Сүнсний бэлэг авсан хүмүүс Есүс Христийн нэрийг өөр дээрээ авах, өөрөөр хэлбэл, өөрийгөө Их Эзэний шавь хэмээн тунхаглах хүсэлтэй байгаа талаараа гэрээ байгуулдаг билээ. Бид энэхүү гэрээгээ долоо хоног бүр ариун ёслолоос хүртэж шинэчилдэг бөгөөд амьдарч байгаа байдлаараа Их Эзэний шавь болохоо харуулдаг билээ. Энэхүү шавийн барилдлагаа Мексикт болсон саяхны үйл явдлуудаар тод харагдлаа.

Хойд Мексикт жимс тариалагчдын хувьд энэ жилийн хавар тун ээлтэй сайхан байлаа. Жимсний модод сагсайтал цэцэглэсэн болохоор арвин их ургац авна гэсэн найдвар маш их байлаа. Хүмүүс зээлийн төлбөрөө хийж, шаардлагатай тоног төхөөрөмж худалдаж авах болон хөгширсөн моддыг солих, гэр бүлийнхээ гишүүдийн сургалтын төлбөр төлөх гэх мэт олон төлөвлөгөө гаргасан байлаа. Гэр бүлээрээ амралтаа сайхан өнгөрүүлэх төлөвлөгөө ч бас гарсан гэнэ. Уур амьсгал ерөнхийдөө өөдрөг өрнүүн байлаа. Гэтэл 3-р сарын сүүлчээр нэгэн даваа гарагийн өглөө цасаар шуурч эхэлснээ удалгүй цас лавшин орж эхлэв. Маргааш өглөөний гурван цаг хүртэл цас орсны дараа агаарын температур түргэн доошилж эхэлсэн аж. Хүмүүс жимсний ургацынхаа ядаж хагасыг нь ч болтугай аврахын тулд өглөөний зургаан цаг хүртэл шөнөжингөө ажилласан ч ямар ч үр дүн гарсангүй. Огцом хүйтрэлээс болж, ургац тас хөлдсөн байв. Ийнхүү энэ жил арвин ургац авч, худалдаж борлуулах найдвар замхран алга болов. Мягмар

гарагийн өглөө үүр цайхад ганцхан өдрийн өмнө хүн бүхний сэтгэлийг эзэмдэж байсан нөгөөх олон сайхан төлөвлөгөө, мөрөөдөл салхинд хийсэх мэт ор мөргүй алга болох нь тэр.

Тэрхүү сэтгэл эмзэглүүлэм мягмар гарагийн өглөөний талаар би Колония Хуарез Чихуахуа Ариун сүмийн ерөнхийлөгчийн зөвлөлийн нэгдүгээр зөвлөх Жон Хачийн эхнэр Сандра Хачаас э-мэйл хүлээж авлаа. Түүний э-мэйлээс энд эш татъя: “Жон өглөөний 6:30 минутын орчимд босч, тэр өглөөний цугларалтыг хойшлуулах хэрэгтэй эсэхийг мэдэхээр ариун сүм рүү явсан. Тэр буцаж ирээд, машины зогсоол, зам цасанд дарагдаагүй байна, тиймээс өглөөний цугларалтыг хуваарь ёсоор хийе гэв. Жимсний цэцэрлэггүй ажилчид ирэх байх тиймээс бүх ажилчдыг нэг хэсэг болгож, хуралдаанд оруулж болох юм гэж бодлоо. . . . Хүмүүс ар араасаа цувран ирж байгааг харахад урамтай байлаа. Тэд ургац алдахаас айж, шөнөжингөө нойргүй ажилласан шүү дээ. . . . Би хуралдааны бэлтгэл хангах явцад тэднийг ажиглавал үүргэлэхгүй хөл дээрээ тогтох нь хэцүү байгаа бололтой. Ирэхгүй байж болох хүндэтгэх шалтгаан тэдэнд байсан. Гэтэл сүмийн ёслолд 38 хүн ирж, ариун сүмийн хуралдааны өрөө пиг дүүрсэн байлаа! Тэр өглөө бидний хувьд онцгой сэтгэл догдлом өглөө байсан бөгөөд юу ч тохиолдлоо гэсэн үүргээ биелүүлдэг сайн хүмүүсийн төлөө бид Тэнгэрлэг Эцэгт талархлаа өргөсөн юм. Би тэр өглөө онцгой сүнснийг мэдэрсэн. Бид Түүний өргөөг хайрладаг бөгөөд ийм хүндхэн өглөө бидний байх ёстой сайхан газар байсныг Тэрбээр мэдсэндээ баяртай байгаа гэдэгт би итгэлтэй байна.”

Уг явдал үүгээр төгсөөгүй үргэлжилсээр байна.

Жимсний ургацаа алдсан хүмүүсийн ихэнх нь улаан чинжүү, вандуй зэрэг хүнсний ногоо тарих хэсэг газар нөөцөлж үлдээсэн байлаа. Энэ ургацаас дараа жилийн жимс тариалалтын ургац хураах хүртэл бага зэрэг орлого олох боломжтой байв. Гэвч нөөц газаргүй, энэ жил ямар ч орлогогүй болж байгаа, залуу гэр бүлтэй нэг сайн ах байсан гэнэ. Хамт олны дундах бусад хүмүүс энэ ахын хөөрхийлөлтэй байдлыг хараад өөрсдийн санаачлага болон зардлаар, хэсэг газар гаргаж, уг газрыг тариалахад зориулан боловсруулахад

өөрсдийн тоног төхөөрөмжийг ашиглан, тэр газар дээр улаан чинжүү тариалжээ.

Би дөнгөж саяхан ярилцсан тэр хүмүүсийг сайн танина. Би тэднийг мэддэг болохоор тэдний хийсэн зүйлд гайхсангүй. Харин тэднийг таньдаггүй хүмүүс *яагаад* гэсэн үгээр эхэлсэн хоёр асуултыг асуух байсан биз ээ. Бүтэн жилийн орлогынхоо ихээхэн хэсгийг алдсанаа мэдсэний эцэст, шөнөжингөө нойргүй хүнд хүчир ажил хийсний дараа яагаад тэд үүргээ биелүүлж, үйлчлэл хийхийн тулд ариун сүм дээр хүрч ирсэн юм бол? Тэд өөрсдөө санхүүгийн хүнд байдалд байсан атлаа тусламж амин чухал хэрэгтэй байсан өөр хүнд хомс тарчиг нөөцөөсөө илүүчлэн тусалсны учир юу юм бол?

Хэрэв та нар Есүс Христийн шавь байх утга учрыг ойлгох юм бол эдгээр хоёр асуултын хариуг мэдэх болно.

Христийн шавь байхаар гэрээ байгуулна гэдэг нь насан туршид үргэлжлэх үйл явцын эхлэл бөгөөд цаашдын зам нь үргэлж амаргүй байдаг. Бид нүглээ наманчилж, биднээр Түүний хийлгэх гэсэн зүйлийг хийхийг ямагт хичээж, Тэрбээр тэдэнд яаж үйлчлэх байсан тийм байдлаар нөхдөдөө үйлчлэх юм бол, бид зайлшгүй Түүнтэй илүү адилхан болж чадна. Түүнтэй адилхан болж, Түүнтэй нэг байх нь бидний хамгийн дээд зорилго бөгөөд жинхэнэ шавь байхын бодит утга учир мөн.

Аврагч Америк тивд очихдоо шавь нараасаа, “Тиймийн тул, та нар ямархуу маягийн хүмүүс байвал зохих билээ?” гэж асуугаад Өөрийнхөө энэхүү асуултанд, “Үнэнээр би та нарт хэлье, бүр миний адил буюу” (3 Нифай 27:27) хэмээн хариулжээ.

Аврагч шиг болох нь амаргүй, ялангуяа бидний амьдарч байгаа дэлхийд бүр ч хэцүү сорилт юм. Бид амьдралдаа өдөр бүр саад бэрхшээлтэй тулгардаг. Үүний шалтгаан нь тодорхой бөгөөд мөнх бус амьдралын үндсэн шинж билээ. Бид Абрахам 3:25-аас “Мөн Их Эзэн, тэдний Бурхан тэдэнд зарлиглах бүх зүйл юуг ч гэсэн тэд хийх нь үү гэдгийг харахын тулд үүгээр бид тэднийг нотлох болно” хэмээн уншдаг билээ.

Эдгээр сорилт эсвэл саад бэрхшээлүүд хэв маяг болоод өрнөлөөрөө олон янзын байдаг. Харин энэ мөнх бус оршихуйг биеэр үзэж туулахгүйгээр орхин одох нэг ч хүн үгүй билээ.

Ихэвчлэн бид сорилт, саад бэрхшээлийг ургац юм уу ажлаа алдах, дотны хайртай хэн нэгэн нь нас барах, өвчин эмгэг, биеийн, оюун ухааны эсвэл сэтгэцийн чадвараа алдах, ядуурал, найз нөхдөө алдах гэж ойлгодог. Гэвч бид тэнгэрийн сайшаалаас илүүтэй хүмүүний өмнө нэр хүндээ илүү дээдлэх аваас бүр үр дүнтэй мэт харагдах зүйл ч өөрийн гэсэн хэрэггүй бардамналыг авчирч болно. Эдгээрт дэлхийд нэр төртэй болох, олон түмний дунд нэрд гарах, биеийн ур чадвар, урлаг, спортын авьяас, ажлын амжилт, эд баялаг ордог. Эдгээр сүүлчийн сорилтуудтай холбоотой Тевигийн *Fiddler on the Roof* (“Дээвэр дээрх хийлчин”) дээр: “Хэрэв эд баялаг зүхэл юм бол Бурхан намайг хэзээ ч дахин сэргэхгүйгээр эд баялагтай хамт арчин хаяг”<sup>1</sup> хэмээн илэрхийлсэнтэй адил мэдрэмж бидний заримд нь байдаг.

Харин эдгээр сүүлчийн сорилтуудын хэв маяг нь өмнөхөөсөө улам аюултай бөгөөд даван туулахад илүү хүндрэлтэй. Бидэнд тулгарсан сорилт, саад бэрхшээлүүдийн хэв маягаар биш, харин бид тэдгээрийг хэрхэн эцсээ хүртэл гэсэн тэвчиж байгаагаар бидний шавь байх байдал өсөн хөгжиж, нотлогдох болно. Ерөнхийлөгч Хенри Б. Айрингийн бидэнд заасанчлан: “Тиймээс, амьдрал дахь агуу сорилт бол амьдралын зовлон бэрхшээл дунд Бурханы зарлигуудыг анхааралтай сонсож, дуулгавартай дагаж байна уу гэдгийг харах явдал мөн. Амьдралын зовлон бэрхшээлийг тэвчин туулах нь гол зүйл биш, харин тэднийг улангасан догширох үед зөв сонголт хийх явдал юм. Амьдралын эмгэнэл нь энэ сорилтод унах ба тэгснээр уналт тэнгэр дэх гэртээ алдар сууд эргэн очиход бэлтгэх явдал юм” (“Spiritual Preparedness: Start Early and Be Steady,” *Лиахона*, 2005 оны 11-р сар, 38).

Би бол 23 ач, зээгийнхээ агуу өвөө нь. Тэд цэцэг мэт балчирхан настай ч, мөнхийн үнэнүүдийн тухай ойлголтоороо намайг үргэлж гайхахад хүргэдэг. Би энэ хэлэх үгтэй бэлтгэж байхдаа Есүс Христийн шавь буюу дагалдагч байх нь юу гэсэн утгатай болохыг товчхон тодорхойлж ирүүлнэ үү гэж ач зээ нараасаа нэг бүрчлэн хүссэн юм. Тэгээд тэднээс олон гайхалтай хариултуудыг авсан. Эгээрийн нэг болох найман настай Бенжаминаас дараах хариултаас би хуваалцахыг хүсч байна: “Есүс Христийн шавь байна гэдэг нь



үлгэр жишээ үзүүл гэсэн утгатай юм. Энэ нь номлогч байх хэрэгтэй, номлогч болохоор бэлтгэх хэрэгтэй гэсэн үг юм. Энэ бол бусдад үйлчлэх ёстой гэсэн үг. Энэ нь судруудыг уншиж, залбирч бай гэсэн үг. Энэ бол Ариун Сүнсний өдөөлтүүдийг сонсож, Хүндэтгэлийн өдрийг ариунаар сахьж бай гэсэн үг. Энэ бол сүмдээ явж, ариун сүмд орж бай гэсэн үг.”

Би Бенжаминтай санал нэг байна. Шавь байна гэдэг хийх ёстой бүхнийг хийхийг, Христтэй адилхан болохыг хэлнэ. Бид Түүний зарлигуудыг сахьж, нөхдөдөө үйлчилснээр Есүс Христийн сайн шавь нар болж чадна. Түүний хүсэлд дуулгавартай захирагдах нь Ариун Сүнсний нөхөрлөл, амар амгалан ба баяр баясгаланг түүнчлэн Бурхан тэргүүтний энэхүү гурав дахь гишүүнийг үргэлж дагалддаг аюулгүй байдлыг бидэнд авчирах болно. Эдгээр зүйлс өөр ямар ч замаар ирж чадахгүй. Түүний хүсэлд бүрэн захирагдах нь Аврагч шигээ болоход бидэнд туслах болно. Түүнтэй адилхан болж улмаар Түүнтэй нэг байх нь бидний туйлын зорилго, жинхэнэ шавь байхын мөн чанар, утга учир гэдгийг дахин онцлон тэмдэглэе.

Миний Колония Хуарез Ариун сүмд болон түүний ойролцоох талбайнуудад Сүмийн ах, эгч нар асар хүнд сорилтыг үл харгалзан Бурханд болон бие биедээ өөрсдийн итгэл төгс байдлыг дахин батлан харуулсан байдлыг харсан маань шавь байх жишээ байлаа.

Бид зарлигуудыг сахьж, бусдад үйлчлэн, өөрийн хүслийг Түүний хүсэлд захируулбал Түүний жинхэнэ шавь нар болж чадна гэдгийг би гэрчилж байна. Үүнийг би Есүс Христийн нэрээр гэрчиллээ, амен.

#### Note

1. Жозеф Стейн, Жерри Бок ба Шелдон Харникийн *Fiddler on the Roof* (1964), 61.

# Ариун ёслолын адислалууд

Далын

Ахлагч Дон Р.Кларк

---

*Бид Есүс Христийн цагаатгалд талархалтай байж, баптисмын гэрээнүүдээ шинэчилж, өршөөлийг мэдэрч, Ариун сүнснээс илчлэлт хүлээн авч байгаа үедээ бид адислагдах болно.*

---

Би Айдохагийн Рэксбургд өссөн. Тэнд гэр бүл, найз нөхөд, багш болон удирдагчид маань надад их нөлөөлж, заадаг байсан. Бидний хүн нэг бүрийн амьдралд сэтгэлд хоногшсон, амьдралыг маань бүр мөсөн өөрчилж чадах онцгой туршлагууд тохиолддог билээ. Намайг залуу байхад ч мөн ийм зүйл тохиолдсон юм. Энэхүү туршлага миний амьдралыг өөрчилсөн билээ.

Би сүмд үргэлж идэвхтэй байсан бөгөөд Аароны санваараар дамжуулан өсч хөгжсөн юм. Намайг өсвөр насны хүүхэд байхад манай багш Жэков ах биднээс ариун ёслолын турш юуны тухай бодсоноо картан дээр бичихийг хүссэн юм. Би картаа авч бичиж эхлэв. Жагсаалтын эхэнд урд шөнө хожсон сагсан бөмбөгийн тоглолт болон дараагийн тоглолт зэрэг зүйлсийг бичсэн бөгөөд Есүс Христийн нэр жагсаалтын эхэнд байгаагүй юм.

Ням гараг бүр картан дээр ариун ёслол дээр юу бодсон тухайгаа бичиж байлаа. Шинэхэн Аароны санваартны хувьд ариун ёслол болон ариун ёслолын цуглаан нь шинэ, өргөн цар хүрээтэй мөн сүнслэг утга учиртай болж байлаа. Христийн Цагаатгал намайг өөрчилж байгааг ойлгосон учраас би ням гараг болон ариун ёслолоос хүртэх мөчийг тэсэн ядан хүлээдэг болсон. Ариун ёслолоос хүртдэг өдөр буюу ням гараг

бүр би жагсаалтаа хардаг. Одоо бол миний жагсаалтын эхэнд үргэлж хүн төрөлхтний Аврагчийн нэр байх болсон.

Шинэ Гэрээнээс бид Аврагч дагалдагч нартайгаа Дээгүүр Өнгөрөх баяраар уулзаж байгаа тухай уншдаг.

“Тэр талх авч, талархал өргөөд тэдэнд хуваан өгөхдөө энэ бол та нарын төлөө өгөх миний бие мөн. *Намайг дурсаж үүнийг үйлд* гэж айлдав.

Тийн идэцгээсний дараа Тэр мөн аяга авч, *Энэ нь та нарын төлөө асгарах Миний цусаар тогтоох шинэ гэрээ юм*”<sup>1</sup> хэмээжээ.

Есүс Нифайчуудын дунд айлчлахдаа ариун ёслолын зарчмыг заасан.<sup>2</sup> Би энэ хоёр зорилгын чухлыг мэддэг болсон.

Ерөнхийлөгч Давид О.Мккэй хэлэхдээ “Их Эзэн Сүмийн хамгийн чухал цуглааныг Ариун ёслолын цуглаан хэмээн тодорхойлсон нь надад маш онцгой сэтгэгдэл төрүүлдэг”<sup>3</sup> гэж хэлжээ. Бид ариун ёслолд зөв бэлдэж чадвал ариун ёслол бидний амьдралыг өөрчилж чадна. Би та нарт ариун ёслолоос зохистойгоор хүртэхэд биднийг адислаж чадах таван зарчмын тухай хуваалцмаар байна.

### **Нэгдүгээрт, Есүс Христийн Цагаатгалд талархалтай байх**

Түүний Хүүгийн Цагаатгалыг дурсан санах ариун ёслолын турш Тэнгэрлэг Эцэгт талархалтай байх нь эхний зарчим юм. Дараах түүх нь ариун ёслолыг түгээж байх үед надад тохиолдсон юм.

Намайг диконоор томилсон тэр ням гарагийг хүртэл ариун ёслол миний хувьд тийм ч чухал мэт санагддаггүй байлаа. Тэр өдөр би анх удаа ариун ёслол түгээсэн юм. Цуглааны өмнө диконуудын нэг нь надад ‘Шмидт ахыг харж байгаарай. Тэр унтсан байвал чи сэрээх хэрэгтэй шүү’ гэж сануулсан юм. Ингээд ариун ёслолыг түгээх миний ээлж боллоо. Эхний зургаан эгнээг ямар ч асуудалгүй түгээлээ. Хүүхдүүд болон насанд хүрэгчид талхнаас хүртэж ариун ёслол түгээхэд ямар ч бэрхшээл тулгарсангүй. Дараа нь би Шмидт ахын байнга суудаг долоо дахь эгнээнд хүрлээ. Тэр унтаагүй харин ч сэргэг байсанд би гайхав. Миний талх түгээсэн хүмүүсээс тэр арай өөр байдалтайгаар талхаа их бодлогошронгуй, хүндэтгэлтэйгээр авах шиг санагдсан юм.

“Хэдэн минутын дараа би ус аван дахин долоо дахь эгнээнд дөхөн ирэв. Энэ удаад найзын маань зөв байлаа. Шмидт ах толгойгоо бөхийлгөн сууж, түүний том нүд нь аниатай байлаа. Тэр унтаж байгаа мэт харагдаж байв. Би юу хэлж эсвэл юу хийж чадах билээ? Би хэсэг зуур олон жилийн хүнд хөдөлмөр, бэрхшээл зовлонгоос бий болсон үрчлээтэй, хөгширсөн түүний духыг харж зогслоо. Тэр өсвөр насны хөвгүүн байхдаа Сүмд нэгдэж түүний амьдардаг байсан Германы жижигхэн тосгонд их хавчлага дарамтыг амссан билээ. Би гэрчлэлийн цуглаан дээр түүний энэ түүхийг олон удаа сонсож байлаа. Би сүүлд нь түүний мөрөн дээр зөөлөн хүрч сэрээхээр шийдсэн юм. Намайг хүрэхэд тэр толгойгоо удаан өндийлгөж, түүний хацрыг даган нулимс урсаж байсан ба би түүний нүд рүү харахад хайр, баяр баясгаланг олж харсан юм. Тэр тайван өндийгөөд уснаас хүртэв. Хэдийгээр би тэр үед дөнгөж 12 настай байсан боловч тэр настай ахыг ариун ёслолоос хүртэхэд төрсөн мэдрэмжийг одоог хүртэл тод санадаг юм. Би тэр хүн ариун ёслолын талаар миний өмнө нь хэзээ ч мэдэрч байгаагүй мэдрэмжийг мэдэрсэн гэдгийг ямар ч эргэлзээгүйгээр мэдсэн юм. Би үүнтэй адил мэдрэмжийг мэдэрч үзэхээр шийдсэн билээ.”<sup>4</sup>

Шмидт ах тэнгэртэй холбогдож, тэнгэр түүнд нээгдсэн юм.

### **Хоёрдугаарт, Баптисмын гэрээгээ шинэчилж байгаа гэдгээ сана**

Хоёр дахь зарчим бол бид ариун ёслолоос хүртэхдээ баптисмын гэрээгээ шинэчилж байна гэдгээ санах юм. Судар дээр бичигдсэн Бидний хийдэг амлалтуудын зарим дээр ийн бичсэн байдаг:

“Бурханы хороонд орж, мөн нэг нэгнийхээ ачааг хөнгөн байж болохын тулд мөн гашуудах тэдний хамт гашуудахад. . . Бурханы гэрчлэгч болж зогсох.”<sup>5</sup>

“Эцсээ хүртэл түүнд үйлчлэх шийдвэртэйгээр, Есүс Христийн нэрийг өөрсөд дээрээ авч,”<sup>6</sup> мөн түүний зарлигуудыг дагаж түүнийг үргэлж санаж, харууссан зүрх, гэмшсэн сэтгэлтэйгээр ирэгтүн.”<sup>7</sup>

Ариун ёслолын залбирал нь эдгээр гэрээг сануулдаг юм. Бид ариун ёслолоос хүртэхдээ гэрээний дагуу амьдрах

амлалтаа шинэчилдэг. Би ариун ёслолын залбиралыг оюун ухаандаа болон зүрх сэтгэлдээ цээжлэх нь зүйтэй гэж итгэдэг. Бид багтисм хийлгэхдээ найман настай ч бай, наян настай ч бай тэр өдрийг болон хийсэн гэрээгээ хэзээ ч мартахгүй гэж би найдаж байна.

### **Гуравдугаарт, Ариун ёслолын турш бид нүглүүдийнхээ уучлалыг мэдэрч чадна.**

Гуравдугаарт, ариун ёслолын турш бид нүглийнхээ уучлалыг мэдэрч чадна. Хэрэв бид ариун ёслолын цуглааны өмнө нүглээ наманчлахад цаг гаргасан бол ариун ёслолыг орхихдоо цэвэр ариун мэдрэмжийг мэдрэх болно. Ерөнхийлөгч Боид К.Пакер хэлэхдээ: “Ариун ёслол нь өршөөлийг мэдрэх явцыг шинэчилдэг. Ням гараг бүр ариун ёслол түгээхэд энэ нь өршөөлийг шинэчилж байгаа хэрэг юм. . . Ням гараг бүр бид өөрсдийгөө ариусгаснаар цаг нь ирж биднийг нас барах үед бидний сүнс цэвэр болох болно.”<sup>8</sup> Ариун ёслолоос зохистойгоор хүртэх нь хаан Бенжаминь хүмүүс *баяр хөөрөөр дүүргэгдэж, нүглүүдийнхээ ангижралыг хүлээн авч улмаар тэд ухамсрын амар амгаланг хүлээн авсаны*<sup>9</sup> нэгэн адил мэдрэхэд бидэнд тусалж чадна.

### **Дөрөвдүгээрт, Бид өөрсдийнхөө асуудлыг шийдэх удирдамж хүлээн авч чадна**

Дөрөв дэх зарчим бол ариун ёслолын турш бид асуудлуудаа шийдвэрлэх удирдамж хүлээн авч чадах юм. Боливид намайг номлолын ерөнхийлөгч байхад эхнэр Мэри Анна бид хоёрт номлолын ерөнхийлөгч нарын семинарт Ерөнхийлөгч Айрингтай хамт оролцох боломж тохиосон юм. Энэ хурал дээр тэр хурлаас хэрэгтэй зүйлээ сурч авахын тулд бэлтгэх 3 чухал арга байдгийг заасан. Бид ариун ёслолд ирэхдээ өөрсдийн асуудлуудыг бодож тунгаан, хүүхэд шиг даруухан сурахад бэлэн мөн Бурханы хүүхдүүдэд туслах хүсэлтэй ирэх хэрэгтэй.

Бид ариун ёслолын цуглаанд даруухнаар ирэх юм бол бид өдөр тутмын асуудлуудаа шийдвэрлэж чадах арга замуудыг таньж мэдэх адислалаар адислагдах болно. Бид бэлтгэлтэй, сонсох хүсэлтэй, хоёрдмол сэтгэлээр биш ирэх ёстой. Бидний уншдаг сударт “гэвч болгоогтун би чамд хэлнэ, чи үүнийг

оюундаа *тунгаан бодох ёстой*; дараа нь *энэ нь зөв үү гэдгийг чи надаас асуух ёстой*, мөн энэ нь зөв аваас *цээжин биеийг чинь чиний дотор шатахаар болгоно би*; Иймийн тул *энэ нь зөв юм байна гэдгийг чи мэдрэх болно*<sup>10</sup> хэмээн бичсэн байдаг. Бид асуудлаа шийдвэрлэхийн тулд юу хийх хэрэгтэйгээ мэдэж авч чадна.

### **Тавдугаарт, Ариун ёслолоос зөв зохистойгоор хүртэх нь биднийг ариун сүнсээр дүүргэгдэхэд тусалдаг**

Тав дахь зарчим бол ариун ёслолоос зөв зохистойгоор хүртэх нь бидэнд Ариун Сүнсээр дүүргэгдэхэд туслах юм. Нифайчуудын дундах номлолынхоо үеэр ариун ёслолыг эхлүүлэхдээ Есүс: “энэ талхыг идэх тэр нь өөрийн бодгалийн төлөө миний биеийг идэх ажгуу; Энэ дарсыг уух тэр нь өөрийн бодгальд миний цусыг уух ажгуу; мөн түүний бодгаль хэзээ ч өлсөж, цангахгүй харин ханасан байх болно”<sup>11</sup> гэж хэлсэн. Хэрэв тэд зөв шударгын төлөө өлсөж мөн цангах аваас Ариун сүнсээр дүүргэгдэх болно гэж амлагдсан билээ. Ариун ёслолын залбирал нь бид хэрэв гэрээнийхээ дагуу амьдрах аваас Түүний Сүнсийг үргэлж өөрсөдтэйгөө хамт байлгах болно гэж амладаг.<sup>12</sup>

Ахлагч Мэлвин Ж.Баллард хэлэхдээ: “Ариун ёслолыг удирдахад биднийг бүхэлд нь удирддаг сүнс байдгийг би гэрчилж байна. Та нар сэтгэлийн шарх эдгэрснийг мэдэрч, ачаа чинь хөнгөрөх болно. Зохистой мөн үнэн хүсэлтэй бодгаль нь энэхүү сүнслэг хүнсийг хүртсэнээр тайвшрал болон аз жаргалыг авах болно”<sup>13</sup> гэжээ.

Бид Есүс Христийн Цагаатгалд талархалтай байж, баптисмын гэрээгээ шинэчилж, өршөөлийг мэдэрч, долоо хоног бүр ариун ёслолоос хүртэхдээ Ариун Сүнснээс удирдамж хүлээн авах аваас бид адислагдах болно. Хэрэв ариун ёслолын турш сүсэг бишрэлтэй байж чадвал энэ нь үргэлж хамгийн агуу ариун ёслолын цуглаан байх болно. Би Есүс Христийн Цагаатгалд талархлаа илэрхийлж байна. Тэр амьдыг би мэднэ. Есүс Христийн нэрээр, амен

#### **Эшлэл**

1. Лук 22:19–20; тодруулга нэмэгдсэн
2. 3 Нифай 18-гүзнэ үү.
3. Давид О.Мккэй, Conference Report, 1929 оны аравдугаар сар, 11–15

4. *Book of Mormon Student Manual, Religion 121-122* (1979), 417.
5. Мозая 18:8-9.
6. Сургаал ба Гэрээ 20:37.
7. Сургаал ба Гэрээ 20:77.
8. Байд К.Пакер, *Mine Errand from the Lord* (2008), 196.
9. Мозая 4:3; тодруулга нэмэгдсэн
10. Сургаал ба Гэрээ 9:8; тодруулга нэмэгдсэн
11. 3 Нифай 20:8.
12. Сургаал ба Гэрээ 20:77-г үзнэ үү,
13. Melvin J. Ballard, in Bryant S. Hinckley, *Sermons and Missionary Services of Melvin Joseph Ballard*(1949), 149.

# Их Эзэнд хөрвүүлэгдэв

**Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын**

*Ахлагч Дэвид А.Беднар*

---

*Сайн мэдээг үнэн гэдгийг мэдэх нь гэрчлэлийн үндсэн чанар мөн. Сайн мэдээнд үргэлж үнэнч байх нь хөрвүүлэлтийн үндсэн чанар юм.*

---

Миний өнөөдөр ярих зүйл, Есүс бол Христ гэсэн гэрчлэлийг хүлээн авах, Түүнд болон Түүний сайн мэдээнд хөрвүүлэгдэх хоёрын хоорондох харилцаан дээр төвлөрөх болно. Ер нь бид гэрчлэл болон хөрвүүлэлт гэсэн хоёр сэдвийг тус тусд нь салган авч үздэг. Гэхдээ бид эдгээр хоёр сэдвийг хамтад нь авч үзсэнээр илүү сүнслэг баталгааг болон эрхэм үнэт үзэл бодлыг олж авна.

Би Ариун Сүнсийг хүн нэг бүрт зааварчлан мөн гэгээрүүлэг хэмээн залбиръя.

## **Та нар Намайг хэн гэж хэлэх вэ?**

Төлөөлөгч Петрийн тохинууллаас гэрчлэл болон хөрвүүлэлтийн талаар их зүйлийг бид сурч чадна.

Цезарь Филишийн нутагт очих үедээ Есүс “та нар Намайг хэн гэж хэлэх вэ?” хэмээх их зүйл бодогдуулсан асуултыг шавь нараасаа асуусан.

Петр шулуухнаар:

“Та бол Христ, амьд Бурханы Хүү” гэж хариулсан.

“Есүс түүнд хариуд нь, Барiona Симон оо, чи ерөөлтэй ээ! Учир нь үүнийг чамд мах цус нь биш, харин тэнгэр дэх Миний Эцэг илчилсэн юм” хэмээсэн. (Матай 16:15–17).

Петрийн хариултанд болон Аврагчийн зааварт тодорхой харуулснаар гэрчлэл нь илчлэлтээр хүлээн авсан сүнслэг үнэний талаарх хувийн мэдлэг юм. Гэрчлэл нь Бурханаас ирэх бэлэг бөгөөд Түүний бүх хүүхдүүдэд өгөгдөх боломжтой



билээ. “Үгийн нөлөөлөх хүчийг сориход” (Алма 31:5), “туршихад”, “Ариун Сүнсний таталтанд автагдахад” (Мозая 3:19) мөн Бурханы хувьд сэрэхэд (Алма 5:7 -г үз) шаардлагатай Есүс Христэд итгэх “итгэлийн жижиг хэсгийг” (Алма 32:27) хөгжүүлэн, тэдгээр үнэнийг шударгаар хайгч хэн боловч гэрчлэлийг олж авч чадна. Гэрчлэл нь хувийн хариуцлагыг нэмэгдүүлдэг бөгөөд зорилго, баттай байдал болон баяр хөөрийн эх үүсвэр болдог.

Сүнслэг үнэний гэрчлэлийг эрэлхийлэн, олж авах нь Аврагчид итгэлтэй байж, чин сэтгэлтэйгээр, үнэн хүсэлтэйгээр (Моронай 10:4 -ийг үз) гуйж, эрэлхийлж, тогшихыг шаарддаг (Матай 7:7; 3 Нифай 14:7-г үзнэ үү). Тэнгэрлэг Эцэг амьд мөн биднийг хайрладаг, Есүс Христ бол бидний Аврагч, сайн мэдээний бүрэн дүүрэн байдал нь эдгээр хожмын өдрүүдэд дэлхий дээр сэргээгдсэн гэдгийг мэдэх нь гэрчлэлийн үндсэн хэсгүүд юм.

### **Та хөрвүүлэгдэх үед**

Сүүлчийн Зоогийн үеэр Аврагч шавь нартаа зааж байхдаа Петрт хандан:

“Симон оо, Симон оо, үзтүгэй, чамайг улаан буудай мэт шигшихийн тул Сатан зөвшөөрөл гуйсан:

“Гэсэн ч итгэл чинь сульдахгүйн тулд Би чиний төлөө залбирсан: чи нэгэн цагт дахин эргэж, ах дүүсээ батжуул” (Лук 22:31–32) хэмээн хэлсэн.

Сонирхолтой нь, энэ хүчирхэг Төлөөлөгч нь Эзэнтэй ярьж, хамт алхаж, олон гайхамшигийг нүдээр үзсэн мөн Аврагчийн тэнгэрлэг байдлын талаар бат бэх гэрчлэлтэй байсан. Гэсэн ч Петрт хүртэл Ариун Сүнсний ариусгах мөн хөрвүүлэх хүч чадлын талаар, итгэлтэйгээр үйлчлэх түүний үүргийн талаар Есүс нэмэлт зааврыг өгсөн.

Есүс Христийн сайн мэдээ нь Аврагчийн Цагаатгалаар дамжуулан боломжтой болсон хүний мөн чанарын үндсэн, тогтвортой өөрчлөлтийг шаарддаг. Үнэн хөрвүүлэлт нь Бурханы хүслийг хүлээн зөвшөөрч, дагах сүсэг бишрэл, зүрх сэтгэл, амьдралаа өөрчлөх өөрчлөлтийг авчирдаг бөгөөд Христийн шавь болох шийдэмгий зорилгыг бий болгодог. (Үйлс 3:19; 3 Нифай 9:20 -ийг үз)

Хөрвүүлэлт гэдэг нь гэрчлэл нэмэгдэх, гүнзгийрэх мөн гэрчлэлийн суурь өргөжин тэлэхийг хэлдэг. Бурханаас ирэх илчлэлт нь хувь хүний наманчлал, дуулгавартай байдал болон хичээнгүй байдлын үр дүн юм. Зүрх сэтгэлдээ хүчит өөрчлөлтийг мэдэрснээр мөн Бурханаас төрснөөр (Алма 5:12–14 -г үз) үнэнийг шударгаар эрэлхийлэх хэн боловч хөрвүүлэгдэж чадна. Бид аврал болон өргөмжлөлийн ёслолууд ба гэрээнүүдийг дагаж (С ба Г 20:25 -г үз), “Христэд тууштайгаар итгэн урагш тэмүүлэн” (2 Нифай 31:20), эцсээ хүртэл итгэлтэйгээр тэвчих үед (С ба Г 14:7 -г үз), бид Христ доторх шинэ бүтээл болдог (2 Коринт 5:17 -г үз). Хөрвүүлэлт бол гэрчлэлийн бэлэгт нь талархан Бурханд өөрсдийгөө зориулах бидний өргөл, хайр, үнэнч сэтгэл юм.

### **Мормоны ном дахь хөрвүүлэлтийн жишээнүүд**

Мормоны ном нь хөрвүүлэлтийн тухай сүнслэгээр өдөөх цэдгүүдээр дүүрэн байдаг. Иаковын удам болох Амаликай ийн тунхагласан: “Та нарыг Израилын Ариун Нэгэн болох Христэд ирж, мөн түүний авралаас мөн түүний гэтэлгэлийн хүчнээс хүртээсэй хэмээнэ би. Тийм ээ, түүнд ирэгтүн, мөн өөрийн бүхэл бодгалийг түүнд өргөл болгон өгөгтүн” (Омнаи 1:26).

Ариун Сүнсний хүчээр Есүс бол Христ гэдгийг мэдэж авах нь маш чухал хийгээд шаардлагатай юм. Гэхдээ Түүн дээр хичээнгүйлэн ирж, бүхий л зүрх сэтгэлээ өргөл болгон өгөх нь зөвхөн мэдэж байхаас хамаагүй илүүг шаарддаг. Хөрвүүлэлт нь бүхий л зүрх сэтгэл, хүчин чадал, оюун хийгээд чадлыг маань шаарддаг (С ба Г 4:2 -г үз).

Хаан Бенжаминь хүмүүс түүний заасан зүйлд хариулан, хашгирч “Тийм ээ, бидэнд ярьсан тэр бүх үгсэд тань бид итгэнэ; мөн түүнчлэн, бидэнд хилэнцийг үйлдэх хүслийг үгүй болгох, харин үргэлж сайныг хийх болгон, бидэнд, өөрөөр хэлбэл бидний зүрх сэтгэлд хүчирхэг өөрчлөлтийг үйлдсэн Төгс Хүчит Их Эзэний Сүнсний учир тэдгээрийн гарцаагүйг мөн үнэнийг бид мэднэ” хэмээсэн (Мозая 5:2). Хэлэгдсэн үгсийг хүлээн зөвшөөрч, тэдгээрийн үнэний талаар гэрчлэлийг олж авч, мөн Христэд итгэх итгэлээ хөгжүүлсэн нь зүрх сэтгэлийн хүчит өөрчлөлтийг, илүү сайн болж дээшлэх чанд шийдвэрийг бий болгосон байна.

Хиламаны Номон дахь хөрвүүлэгдсэн леменчүүдийг “үүргийнхээ замд байж, мөн тэд Бурханы өмнө хянамгай алхаж, мөн . . . түүний зарлигуудыг мөн түүний дүрмүүд хийгээд тогтоолуудыг дагахаар чармайна. . . .

“ . . . Мөн тэд ах дүүсийнхээ үлдсэнийг нь үнэний мэдлэгт авчирч болохын тулд тэд шантралгүй хичээнгүйлэн оролдож байна” хэмээн дүрсэлсэн (Хиламан 15:5–6).

Эдгээр жишээнүүдэд тодорхой харагдаж байгаа шиг хөрвүүлэлттэй хамааралтай үндсэн шинж чанарууд нь зүрх сэтгэлийн хүчит өөрчлөлтийг мэдэрч, үргэлжид сайныг үйлдэх хүсэлтэй болж, үүрэг хариуцлагаа гүйцэтгэх зам дээр гарч, Бурханы өмнө хянамгайгаар алхаж, зарлигуудыг сахин, шантралгүй хичээнгүйлэн үйлчлэх явдал юм. Эдгээр итгэлтэй бодгалууд нь Их Эзэнд болон Түүний сургаалд гүн гүнзгийгээр өөрсдийгөө зориулсан нь тодорхой байна.

### **Хөрвүүлэгдэх нь**

Бидний олны хувьд хөрвүүлэлт нь цаг хугацаа шаардсан үйл явц бөгөөд энэ нь хүчтэй буюу сэтгэл хөдөлгөсөн үйл явдлын үр дүнд бий болдог нэг удаагийн явдал биш юм. Шат шатаар, дүрэм дүрмээр, яваандаа, бараг мэдэгдэлгүйгээр, бидний үйл хөдлөл, бодол, үгс, үйлс нь Бурханы хүсэлтэй нэгдэн нэг болдог. Их Эзэнд хөрвүүлэгдэх нь тэвчээртэй мөн шаргуу байдлын аль алиныг нь шаарддаг.

Лемен үндэстэн Самуел, Их Эзэнд хөрвүүлэгдэхэд хэрэгтэй таван үндсэн чанарыг тодорхойлсон: (1) судруудад, ариун бошиглогчдын бичсэн бошиглолууд хийгээд зааварт итгэх, (2) Их Эзэн Есүс Христэд итгэх итгэлээ хөгжүүлэх, (3) наманчлах, (4) зүрх сэтгэлийн хүчит өөрчлөлтийг мэдрэх мөн (5) “сүсэг бишрэлдээ чанд гуйвшгүй” болох юм (Хиламан 15:7–8 -г үзнэ үү). Энэ нь хөрвүүлэлт тийш удирдах хэв маяг билээ.

### **Гэрчлэл болон хөрвүүлэлт**

Гэрчлэл нь хөрвүүлэлтийн үйл явцын эхлэл бөгөөд шаардлагатай зүйл мөн. Гэрчлэл нь эхлэх цэг; энэ нь эцсийн зогсоол биш. Хүчит гэрчлэл нь хөрвүүлэлтийг тавих үндэс суурь нь болдог.

Бидний амьдарч байгаа хожмын үеийн харанхуйн шуурга болон нүгэл хилэнцээс гэрчлэл нь дангаараа биднийг хамгаалж чадахуйц хангалттай биш билээ. Гэрчлэл нь чухал шаардлагатай боловч бидэнд хэрэгтэй сүнслэг хүч чадал болон хамгаалалтыг өгөхөд хангалттай биш. Сүмийн гэрчлэлтэй зарим гишүүд гуйван, замаасаа гарсан. Тэдний сүнслэг мэдлэг болон амлалт нь тэдэнд тулгарсан бэрхшээлүүдийг даван туулахад хангалттай байгаагүй аж.

Мозаягийн хөвгүүдийн номлолын хөдөлмөрөөс гэрчлэл болон хөрвүүлэлтийн хоорондын холбооны талаарх чухал захиасыг харж болно.

“Мөн итгэсэн болгон нь, өөрөөр хэлбэл Аммон болон түүний ах дүүсийн номлолоор, илчлэлт хийгээд бошиглолын суу билгийн, мөн тэднээр дамжуулан гайхамшгуудыг үйлдэх Бурханы хүчний дагуу үнэний мэдлэгт авчрагдсан болгон нь – тийм ээ, . . . Их Эзэн амьдын адил, тэдний номлолд итгэн мөн Их Эзэнд хөрвүүлэгдсэн леменчүүд болгон, . . . хэзээ ч итгэл алдраагүй нь гарцаагүй.

“Учир нь тэд зөв шударга хүмүүс болсон билээ; тэд Бурханы эсрэг . . . дахин тулалдахгүйн тулд тэд эсэргүүцлийн зэр зэвсгээ доош тавьсан билээ.

“Эдүгээ, Их Эзэнд хөрвүүлэгдсэн нь тэд юм” (Алма 23:6–8).

Эдгээр шүлгүүдэд хоёр чухал сэдвийг тайлбарлан үзүүлсэн: (1) *үнэний мэдлэг*, энэ нь гэрчлэл гэж хэлэгдэж бас болно, мөн (2) *Их Эзэнд хөрвүүлэгдсэн*, үүнийг би Аврагчид болон Түүний сайн мэдээнд хөрвүүлэгдэхийг хэлж байна гэж ойлгодог. Ийн гэрчлэл болон Их Эзэнд хөрвүүлэгдэх хоёрын хоорондын хүчтэй холбоо нь тууштай хийгээд шийдэмгий байдлыг бий болгосон бөгөөд сүнслэг хамгаалалтыг өгсөн.

Тэд хэзээ ч холдож яваагүй бөгөөд эсэргүүцлийн зэр зэвсгээ доош тавьсан, ингэснээр тэд Бурханы эсрэг ахин тулалдаагүй билээ. “Эсэргүүцлийн зэр зэвсэг” болох хувиа хичээх байдал, бардамнал мөн дуулгаваргүй байдлаа цааш тавих нь дөнгөж итгэж, мэдэж байхаас илүүг шаарддаг билээ. Эсэргүүцлийн зэр зэвсгээ хаяхын өмнө бид баттай итгэл, даруу байдал, наманчлал болон хүлцэнгүй байдлыг эзэмшсэн байх ёстой. Их Эзэнд хөрвүүлэгдэхэд бидэнд саад болж байгаа

эсэргүүцлийн зэр зэвсгээ та бид эзэмшсэн хэвээр байна уу? Тийм бол бид одоо наманчлах хэрэгтэй.

Леменчүүд өөрсдөд нь заасан номлогч нарт эсвэл Сүмийн сайн хөтөлбөрүүдэд хөрвөгдөөгүй гэдгийг анхаараарай. Тэд удирдагч нарынхаа ааш араншингаас болж эсвэл уламжлалт өв болон эцэг өвгөдийнхөө уламжлалыг хадгалахын тулд хөрвүүлэгдээгүй. Тэд Их Эзэнд – Аврагч болох Түүнд, Түүний тэнгэрлэг байдал болон сургаалд – хөрвүүлэгдсэн бөгөөд хэзээ ч холдож яваагүй билээ.

Гэрчлэл бол Ариун Сүнсний хүчээр олж авсан үнэний сүнслэг мэдлэг юм. Хөрвүүлэгдсээр байх гэдэг нь бид өөрсдийн хүлээн авсан илчлэгдсэн үнэнийг –зөв шударга шалтгаанаар мөн зүрх сэтгэлийн хүсэлтэйгээр үргэлж дагана гэсэн үг юм. Сайн мэдээг үнэн гэдгийг мэдэх нь гэрчлэлийн үндсэн чанар мөн. Сайн мэдээнд үргэлж үнэнч байх нь хөрвүүлэлтийн үндсэн чанар юм. Бид сайн мэдээг үнэн гэдгийг мэдэх ёстой бөгөөд сайн мэдээнд үнэнч байх ёстой.

### **Гэрчлэл, Хөрвүүлэлт болон Арван охины сургаалт үлгэр**

Одоо би гэрчлэл болон хөрвүүлэлтийн хоорондын уялдаа холбоог тод томруун харуулахаар арван охины сургаалт үлгэрийг хэрэглэж болох олон хэлбэрийн нэгийг нь ашигламаар байна. Тав нь ухаалаг, тав нь мунхаг байсан арван охин дэнлүүгээ аван, хүргэнийг угтахаар явсан. Охидын хэрэглэж байгаа дэнлүүнүүдийг нь гэрчлэлийн дэнлүүнүүд гэж бодоорой. Мунхаг охид нь гэрчлэлийн дэнлүүгээ авахдаа тосыг нь хамт авсангүй. Энэ тосыг хөрвүүлэлтийн тос гэж бодоорой.

“Харин ухаалгууд нь [гэрчлэлийн] дэнлүүгээ [хөрвүүлэлтийн] тос хийсэн савны хамт авсан байлаа.

“Хүргэн ирэхгүй удсан тул тэд бүгд үүрэглэж, унтаж эхлэв.

“Гэтэл шөнө дөлөөр хашхирах дуун гарч “Хараач, хүргэн байна. Түүнийг угтаж авцгаа” гэлээ.

“Нөгөө охид бүгдээрээ босож [гэрчлэлийн] дэнлүүгээ бэлдэв.

“Мунхгууд нь ухаалаг охидод, “Бидэнд [хөрвүүлэлтийн тос болох] тосноосоо өгөөч. Бидний [гэрчлэлийн бүүдгэр] дэнлүү бөхөх нь гэсэнд,

“Ухаалгууд нь, “Бидэнд ч, та нарт ч огт хүрэлцэхгүй. Оронд нь худалдаачин уруу очиж, тос худалдаж ав” гэжээ (Матай 25:4–9).

Таван ухаалаг охин хувиа хичээн, хуваалцахыг хүсэхгүй байсан уу, эсвэл хөрвүүлэлтийн тосыг зээлүүлж болдоггүй гэж зөв зүйлийг хэлсэн үү? Зарлигуудыг байнга дагаснаар ирдэг сүнслэг хүч чадлыг өөр хүнд өгч болох уу? Хичээнгүйлэн сурч мөн судруудын талаар тунгаан бодсоноор ирэх мэдлэгийг хэрэгцээтэй нэгэнд дамжуулан өгч болох уу? Итгэлтэй Хожмын Үеийн Гэгээнтэнд сайн мэдээний авчрах амар амгаланг хэцүү бэрхшээл зовлонтой тулгараад байгаа хүнд шилжүүлэн өгч болох уу? Эдгээр асуултуудад өгөх тодорхой хариулт нь Үгүй, болохгүй.

Ухаалаг охидын хэлснээр, бид нар нэг бүрчлэн “өөрсдөө үүнийг худалдаж” авах ёстой. Эдгээр сүнсээр өдөөгдсөн охид мөнгө төлөн худалдаж авахыг яриагүй; харин гэрчлэлийн дэнлүүгээ асаалттай байлгаж чадах хувийн хариуцлага болон хөрвүүлэлтийн тосыг хангалттай байлгахыг хэлж байсан юм. Энэхүү эрхэм үнэт тос нь нэг удаад нэг дуслар - шат шатаар [мөн] дүрэм дүрмээр (2 Нифай 28:30), тэвчээртэйгээр, шаргуу дагаснаар олддог. Түүнийг олох амархан товч зам гэж байхгүй; хамгийн сүүлийн мөчид гэнэт хичээн бэлдэх нь ч боломжгүй юм.

“Иймийн тул, та нар Хүргэн Хүүгийн ирэлтэнд бэлэн байж болохын тулд, ямагт залбиран, дэнлүүгээ бэлтгэж мөн асаан бас тосоо авч яван итгэлтэй байгтун” (С ба Г 33:17).

## Гэрчлэл

Үнэний мэдлэгт ирэн, Их Эзэнд хөрвүүлэгдэх юм бол бид тууштай, хөдөлшгүй байж мөн хэзээ ч төөрөн холдож явахгүй гэдгийг би амлаж байна. Бид эсэргүүцлийн зэр зэвсгээ дуртайяа доош тавих болно. Бид гэрчлэлийн дэнлүүний тод гэрлээр мөн хөрвүүлэлтийн тосны элбэг хангамжаар адислагдах болно. Бид нэг бүрчлэн бүрэн дүүрнээр хөрвүүлэгдсэнээр, гэр бүлүүдээ, найз нөхдөө болон хамт ажиллагсдаа хүчирхэгжүүлэх болно. Эдгээр үнэнүүдийн

талаар би Их Эзэн Есүс Христийн ариун нэр дээр гэрчилж  
байна, амен.

# Биднийг дахин уулзтал Бурхан та нартай хамт байх болтугай

Ерөнхийлөгч Томас С.Монсон

---

*Хэрэв бид өнгөрсөн хоёр өдөр сонссон захиасуудыг зүрх сэтгэлдээ шингээж, гэр орондоо аваачих юм бол агуу ихээр адислагдах болно.*

---

Ах, эгч нар минь ээ, биднийг чухал сүнслэг захиасуудаар цэнэглэсэн энэ удаагийн ерөнхий чуулганаа бид өндөрлөх цаг болоод байна. Миний бие сүнслэг байдлаараа цэнэглэгдэж, сэтгэл санаагаараа өргөгдлөө. Та бүхэн ч гэсэн энэ удаагийн чуулганы онцгой сүнсийг мэдэрсэн гэдэгт би итгэлтэй байна.

Энэ чуулганд ямар нэг хэлбэрээр оролцсон бүх хүмүүст бид чин сэтгэлийнхээ талархлыг илэрхийлж байна. Сайн мэдээний үнэнүүдэд онцгой анхаарал хандуулж, тэдгээрийг агуу итгэлтэйгээр заалаа. Хэрэв бид өнгөрсөн хоёр өдөр сонссон захиасуудыг зүрх сэтгэлдээ шингээж, гэр орондоо аваачих юм бол агуу ихээр адислагдах болно.

Энэ чуулганы захиасуудыг ердийнхөөрөө *Ensign*, *Лиахона* сэтгүүлүүдийн ирэх сарын дугаарт нийтлэх болно. Чуулган дээр хэлсэн үгсийг тэр үед дахин уншиж, захиасуудыг нь тунгаан бодохыг би та нарт уриалж байна. Чуулган дээр хэлсэн үгсийг илүү гүнзгий судалсан үед сүнслэг нөлөө бүхий сургаалуудыг илүү сайн ойлгодгийг би хувийн туршлагаасаа мэднэ.

Бид чуулганы үйл ажиллагааг далай тэнгис, тивийг алгасан урьд өмнө байгаагүй өргөн хүрээгээр газар газрын



хүмүүст хүргэлээ. Бид та нарын заримаас нь алс хол байгаа ч гэсэн, та бүхний сүнснийг мэдэрч, хайр, талархлаа та бүхэнд илгээж байна.

Энэ чуулганаар дуудлагаасаа чөлөөлөгдөж буй Ах нартаа, та бүхний олон жил бүхнээ зориулсан үйлчлэлийн төлөө, би чин сэтгэлийн талархал илэрхийлж байна. Их Эзэний ажилд та бүхний оруулсан хувь нэмрийн ачаар тоо томшгүй олон хүмүүс адислагдсан билээ.

Ах эгч нар аа, би саяхан 85 насныхаа ойг тэмдэглэсэн. Их Эзэний надад бэлэглэсэн эдгээр он жилүүдийн төлөө би талархаж байна. Амьдралынхаа туршлагыг эргэн хараад намайг адисалсан Түүний үй олон адислалын төлөө би баярлан талархаж явдаг билээ. Түүнд болон та бүхэнд чин сэтгэлээсээ үйлчлэхийг хичээсэн үедээ би өөрийн бүх ажил үйлсэд Түүний удирдан чиглүүлэгч гарыг мэдэрдгээ өнөө өглөөний захиастаа онцлон тэмдэглэсэн билээ.

Сүмийн Ерөнхийлөгчийн албан тушаалд өндөр шаардлага тавигддаг. Миний дэргэд байнга үйлчилж, Тэргүүн Зөвлөлийн ажилд бие сэтгэл бүхнээ зориулан, ер бусын чадварлагаар тусалдаг итгэлтэй хоёр зөвлөхдөө би хэчнээн их баярлан талархаж явдаг билээ. Түүнчлэн Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгыг бүрдүүлдэг ах нартаа чин сэтгэлийн талархал илэрхийлж байна. Тэд Их Эзэний зорилгыг хэрэгжүүлэхийн төлөө Далын Чуулгуудын гишүүдтэй цаг үргэлж хамтдаа хөдөлмөрлөж, тэднийг сүнслэг тусламжаар хангаж байдаг юм.

Дэлхий даяарх хайрт Ах эгч нар минь ээ, та бүхнээс тойрог болон салбартаа, дүүрэг болон гадсууддаа хийж байгаа бүх ажлыг би магтан сайшаахыг хүсч байна. Та бүхэн дуудлагат ажилдаа хичээл зүтгэл гарган ажилласнаараа, газар дээр Бурханы хаант улсыг байгуулахад хувь нэмрээ оруулан тусалж байна.

Бид бие биедээ элгэн халуун сэтгэлээр хандаж, тусламж хэрэгтэй болсон үед нь нэг нэгэндээ тусалдаг байцгаая. Бусдыг өөчилж, шүүмжилдэггүй байцгаая, харин аливаад хүлээцтэй хандаж, Аврагчийн хайр, нинжин сэтгэлийн үлгэр жишээг үргэлж дагацгаая. Ингэснээрээ бид бие биедээ үйлчлэх хүсэлтэй байх болно. Эргэн тойрныхоо хүмүүсийн хэрэгцээг

мэдэхээр сүнсний удирдамжийн төлөө залбирч тэдэнд туслахаар урагшилцгаая.

Амьдралдаа зоригтой байцгаая. Бид хэдийгээр аюул заналхийлэл байнга өсөн нэмэгдэж байгаа үед аж төрж байгаа ч Их Эзэн биднийг хайрлаж, бидэнд анхаарал халамж тавьсаар байгаа билээ. Хэрэв бид зөв зүйлийг хийх аваас Тэр үргэлж бидний дэргэд байж, хэрэгтэй үед бидэнд туслах болно. Бид амьдралдаа асуудал, сорилт бэрхшээлийг хүсэн хүлээдэггүй боловч тэдгээр нь бидний амьдралд тохиолдох болно. Бидний хэн нь ч сорилт бэрхшээлээс дархлаажигдаагүй юм. Мөнх бус амьдрал дахь бидний зорилго бол Тэнгэр дэх Эцэгийнхээ адил үргэлж суралцаж, үргэлж өсч хөгжих явдал бөгөөд бид хүнд хэцүү үед л хамгийн их зүйлийг сурч мэдэн, үнэтэй сургамж авах нь олонтоо тохиолддог. Хэрэв бид Есүс Христийн сайн мэдээний сургаалуудыг дагавал бидний амьдрал баяр баясгалангаар бялхах болно.

“Зоригтой бай. Би ертөнцийг ялсан”<sup>1</sup> хэмээн Их Эзэн биднийг урамшуулан зоригжуулсан билээ. Тэр бидний төлөө амьдарч, бидний төлөө амиа өгсөн юм. Тэр бидний нүглийн төлөөсийг төлсөн юм. Түүний үлгэр жишээг дагацгаая. Түүний золиослолыг хүлээн авч нэгэн цагт Түүнд эргэн очиж хамт амьдрахад тэнцэхүйц байхаар зохистой амьдарч агуу баяр талархлаа Түүнд үзүүлцгээе.

Миний төлөө хийдэг та нарын залбиралд би өмнөх чуулганууд дээр талархал илэрхийлдэг байсны адил одоо ч бас талархал илэрхийлж байна. Та нарын залбирал надад хэрэгтэй, та нарын залбирлыг би мэдэрдэг. Ерөнхий эрх мэдэлтнүүд бид та бүхнийг санаж, Тэнгэрлэг Эцэгийн охь манлай адислалууд та нарт ирэхийн төлөө залбирч байдаг билээ.

Хайрт, ах эгч нар минь ээ, бид зургаан сарын дараа дахин уулзана. Тэр үед биднийг дахин уулзтал Бурхан та нартай хамт байх болтугай. Бидний Аврагч бөгөөд Гэтэлгэгч, Есүс Христийн нэрээр, амен.

#### *Эшлэл*

1. Иохан 16:33.

# Есүс Христийн цагаатгалд ИТГЭХ ИТГЭЛ БИДНИЙ ЗҮРХЭНД БИЧИГДСЭН ҮҮ?

**Линда К.Бөртэн**

*Нийгмийн Халамжийн Бүлгийн Ерөнхий Ерөнхийлөгч*

---

*Гэрээ хийн, түүнийгээ сахиж мөн түүндээ баясаж байгаа нь Есүс Христийн Цагаатгал бидний зүрх сэтгэлд үнэхээр сийлэгдсэний баталгаа юм.*

---

Хайрт эгч нар минь, надад ирсэн энэхүү амар бус үүрэг хариуцлагынхаа талаар би хэдэн сарын турш эргэцүүлэн бодож явахад та нар оюун санаа, зүрх сэтгэлд минь байсан юм шүү. Энэхүү үүрэг хариуцлага надад ахадсан мэт санагдаж байгаа хэдий ч, энэ дуудлага Их Эзэнээс Түүний сонгосон бошиглогчоор дамжиж ирсэн гэдгийг мэдэж байгаа нь намайг тайвшруулж байна. Судар дээр “харин миний өөрийн дуу хоолой байна уу, эсвэл миний үйлчлэгчдийн дуу хоолой байна уу, энэ нь яг адил”<sup>1</sup> гэж заадаг.

Энэ дуудлагатай хамт ирдэг агуу бэлгүүдийн нэг нь Тэнгэрлэг Эцэг Өөрийн бүх охидод хайртай гэдэг баталгаа юм. Биднийг хайрлах Түүний хайрыг би мэдэрсэн!

Судруудад би та нарын адил хайртай! Иеремиа номонд зүрх сэтгэлд маань маш дотно санагддаг нэгэн судар байдаг. Иеремиа хэцүү үе, газар нутагт амьдарч байсан ч Их Эзэн түүнд бидний үе болох “хожмын өдрүүд дэх Израилын цугларалтын найдварын цаг үеийг”<sup>2</sup> урьдчилан харахыг зөвшөөрсөн

“Гэвч энэ нь тэдгээр өдрүүдийн дараа . . . гэж ЭЗЭН тунхаглаж байна. “Би Өөрийн хуулийг тэдний дотор хийж, зүрхэн дээр нь Би түүнийг бичнэ; Би тэдний Бурхан, тэд Миний ард түмэн болно.

“ . . . Учир нь тэдний багаас том хүртэл нь тэд бүгд Намайг мэдэх болно.” гэж ЭЗЭН тунхаглаж байна. Учир нь Би тэдний гэм бурууг уучилж, тэдний нүглийг дахин санахгүй.”<sup>3</sup> хэмээн Иеремиа бошиглосон.

Бид бол Иеремиагийн харсан хүмүүс юм. Хууль болон сургаалаа зүрхэн дээр минь бичээч гэж бид Их Эзэнээс хүссэн үү? Иеремиагийн ярьсан Цагаатгалаар ирдэг өршөөл бидний амьдралд ч гэсэн хамаатай гэдэгт бид итгэдэг үү?

Хэдэн жилийн өмнө Ахлагч Жеффри Р.Холланд, хүүхдүүдээ алдсан хэдий ч Солт Лейкийн Хөндийд очихоор зорьж байсан анхдагчдын гүн гүнзгий итгэлийн талаар өөрийн сэтгэгдлээ хуваалцсан. Тэр “Ямар нэгэн хөтөлбөр, олон нийтийн үйл ажиллагаа болгож тэд үүнийг хийгээгүй, харин Есүс Христийн сайн мэдээнд итгэх итгэл тэдний зүрх сэтгэл болон ясных нь чөмөгт байсан учраас тэд үүнийг хийсэн юм” гэжээ.

Ихэд сэтгэл нь хөдлөн тэрээр ийн үргэлжлүүлсэн:

“Зөвхөн тэр итгэл нь л эхчүүдэд талхны хайрцагт хүүхдүүдээ хийн оршуулаад, ‘Амлагдсан нутаг тэнд байгаа. Бид яаж ийгээд тэр хөндийд хүрэх л болно’ хэмээн урагш тэмүүлэхэд нь тусалж байсан.

“Гэрээнүүд, сургаал, итгэл, илчлэлт мөн сүнсний учир л тэд ийнхүү хэлж чадаж байсан юм.”

Холланд ах дараах бодол төрүүлэх үгсээр сэтгэгдлээ төгсгөсөн: “Хэрэв бид ийм байдлыг гэр бүл, Сүм дотроо бий болговол, бусад олон зүйл зөв голдрилдоо орох магадлалтай. Нэг их хэрэг болоод байдаггүй бусад зүйлс алга болох ч юм билүү. Гар тэргэнд бага зэргийн юмс л ачиж болдог гэж би сонссон. Өвөг дээдэс маань юу авч явахаа сонгох шаардлагатай байсан шиг XXI-р зуун биднийг ‘Гар тэргэн дээрээ юу ачих вэ?’ гэдгээ шийдэхэд хүргэж магадгүй. Энэ нь бидний зүрх сэтгэлийн бүтэц, ясан дахь чөмөгт хүрэх тэдгээр зүйлс юм.”<sup>4</sup> Өөрөөр хэлбэл, энэ нь бидний зүрхэн дээр бичигдсэн тэдгээр зүйлс юм!

Нийгмийн Халамжийн Бүлгийн шинэ ерөнхийлөгчийн зөвлөлийн хувьд бид Түүний ажлыг үргэлжлүүлэхийн тулд Нийгмийн Халамжийнхаа гар тэргэнд чухал ямар зүйлсийг ачих ёстой талаар Их Эзэнээс чин сэтгэлээсээ асууцгаасан билээ. Биднийг Түүний хайрт охидод Есүс Христийн Цагаатгалын сургаалыг ойлгоход нь туслаасай гэж Тэнгэрлэг Эцэг хүсч байгааг бид мэдэрсэн. Үүнийг хийхэд бидний итгэл өсөн нэмэгдэж, илүү зөв шударгаар амьдрах хүсэлтэй болно гэдгийг мэднэ. Хоёрдугаарт бид гэр бүл, гэр орноо хүчирхэгжүүлэх шаардлага ямар их байгаа талаар эргэцүүлж байхад Түүний хайрт охидыг гэрээнүүдээ баяртайгаар сахихад нь урамшуулан дэмжээсэй гэж Их Эзэн биднээс хүсэж байгааг бид мэдэрсэн. Гэрээнүүдийг сахихад гэр бүлүүд хүчирхэгждэг. Эцэст нь, Тэр биднийг бусад туслах бүлэг болон санваарын удирдагч нартай хамтран хөгжин дэвжих шаардлагатай хүмүүсийг олж туслаасай гэж байгааг мэдэрсэн. Хүн бүр зүрхээ нээж, Цагаатгалын сургаал, гэрээнүүд болон нэгдмэл байдлыг зүрх сэтгэл дээр нь сийлэхийг Их Эзэнд зөвшөөрөөсэй гэдэг нь бидний чин сэтгэлийн залбирал юм.

Бид Есүс Христ болон Түүний мөнхийн Цагаатгалд итгэх гүн, гуйвшгүй итгэлийг зүрхэндээ эхлээд бичилгүйгээр хэрхэн гэр бүлээ хүчирхэгжүүлж, бусдад туслах билээ? Зүрхэндээ бичих л юм бол бидний Есүс Христэд итгэх итгэлийг нэмэгдүүлэх Цагаатгалын гурван зарчмыг энэ үдэш би та нартай хуваалцахыг хүсч байна. Бид Сүмийн шинэ гишүүн үү эсвэл насан туршдаа гишүүн байсан уу гэдгээс үл хамааран хэрэв эдгээр зарчмыг ойлгох л юм бол энэ нь хүн болгоныг адислана хэмээн би найдаж байна.

**Зарчим 1: “Амьдралд маань шударга бус санагдаж байгаа бүхэн Есүс Христийн Цагаатгалаар зөв болгогдоно.”<sup>5</sup>**

Бид та нартай хамт Аврагч Есүс Христийн Цагаатгалыг гэрчилдэг. Хүнд хүчир олон төрлийн сорилтууд хийгээд бэрхшээлүүдийг даван туулснаар бидний гэрчлэл та нарынхтай адил зүрхэн дээр маань бичигддэг юм. Тэнгэрлэг Эцэгийн аз жаргалын төгс төлөвлөгөө, уг төлөвлөгөөний гол цөм нь болсон Аврагчийн Цагаатгалын талаар ойлгоогүй үед эдгээр сорилтуудтай нүүр тулах нь шударга бус санагдаж

болно. Хүн болгон хүнд бэрх сорилтуудтай тулгардаг. Гэвч итгэлтэй нэгний зүрхэнд “Амьдралд маань шударга бус санагдаж байгаа бүхэн Есүс Христийн Цагаатгалаар зөв болгогдоно” хэмээн бичигдсэн байдаг.

Энэ амьдралд бидэнд зовлон, бэрхшээлүүд тохиолдохыг Их Эзэн яагаад зөвшөөрдөг вэ? Нэг үгээр хэлэхэд энэ нь бидний өсөлт хөгжилтөнд зориулсан төлөвлөгөөний нэг хэсэг юм! Бид мөнх бус байдлыг өөрсдийн биеэр мэдрэхийн тулд дэлхий рүү ирэх боломж байгааг мэдээд “баярлалдан уухайлсан”.<sup>6</sup> Ахлагч Даллин Х.Өүкс, “Таатай нөхцөл, амар амгалан байдалд байснаас зовлон зүдгүүр, бэрхшээлийг туулах нь бидэнд хэрэгтэй хөрвүүлэлтийг илүү хурдан авчирдаг”<sup>7</sup> гэж заасан.

Итгэлтэй анхдагч эгчийн жишээ энэ нь үнэн болохыг харуулдаг. Мари Луйс Вокер 17 насандаа Жон Т.Морристой, Миссури мужийн Сэйнт Луис хотод гэрлэжээ. Тэд Гэгээнтнүүдтэй 1853 онд тал хөндийг туулан, гэрлэснийхээ нэг жилийн ойн дараахан Солт Лейкийн Хөндийд орж иржээ. Тэд аяллынхаа турш бусад Гэгээнтнүүдийн адил гачигдан зовж шаналж байв. Гэвч тэдний зовлон Солт Лейкийн Хөндийд ирсний дараа ч дууссангүй. Нэг жилийн дараа тухайн үедээ 19-тэй байсан Мари: “Бид хүүтэй болсон. . . Түүнийг хоёр гуравхан сартай байхад нэгэн үдэш . . . ямар нэгэн зүйл надад, ‘Чи бяцхан үрээ алдах болно’ гэж шивнэсэн юм.” гэж бичиж байж.

Өвөл нь хүүгийнх нь бие нь муудсан байна. “Бид чадах бүхнээ хийсэн, . . . гэвч хүүгийн бие улам бүр муудсаар л байлаа . . . Хоёрдугаар сарын хоёронд тэр нас барахад . . . би мах цусныхаа тасархайгаас салах гэдэг гашуун аяганаас уусан.” Түүний зовлон нь үүгээр дууссангүй. Маригийн нөхөр бас өвдөж хүүхдээ алдсанаас гурван долоо хоногийн дараа нас баржээ.

Мари бичихдээ: “Арван хэдэн насандаа, хориодхон хоногийн дотор нөхөр хүүхдээсээ хагацсан би гэдэг хүн төрөл төрөгсдөөсөө хэдэн зуун бээрийн цаана үл таних нутагт, уул овоо шиг их зовлон зүдгүүртэй яахаа мэдэхгүй байхдаа . . . үхэж, хайртай хүмүүстэйгээ нэгдэх юмсан гэж бодож байж билээ” гэжээ.

Мари үргэлжлүүлэн: “Ням гарагийн нэгэн үдэш би найзтайгаа алхаж явлаа. . . . Би нөхрийнхөө үгүйд маш их ганцаардаж байгаагаа бодон гашуунаар цурхиран уйлж байхдаа оюун санаандаа үзэгдэл мэтээр өөрийн авирах ёстой амьдралын эгц толгодыг харсан бөгөөд үүний бодит байдлыг маш хүчтэйгээр мэдэрч билээ. Гүн хямрал над дээр ирсэн ч, дайсан хэзээ бидэн рүү дайрахаа мэддэг, *[Аврагч Есүс Христ] маань аврахаар агуу хүчтэй билээ. Эцэгийн өгсөн тусламжаар би энэ цагт миний эсрэг чиглэсэн мэт санагдах бүх хүчүүдтэй тулалдах чадалтай байсан.*” гэжээ.<sup>8</sup>

Мари 19-хөн насандаа, энэ амьдралд шударга бус санагдаж байгаа бүхэн – бүр хамгийн гүнзгий зовлон шаналал ч гэсэн - зөв болгогдож чадна мөн болгогдох болно гэсэн баталгааг Цагаатгал бидэнд өгдгийг сурчээ.

**Зарчим 2: Бидэнд эгэл эрэгтэй буюу эмэгтэй хүнээ ялан дийлж Есүс Христийн жинхэнэ шавь болох хүчийг Цагаатгал олгодог.**<sup>9</sup>

Сайн мэдээний сургаал буюу зарчмыг сурсан гэдгээ мэдэх арга бидэнд байгаа. Энэ нь бид хүүхэд ч ойлгож чадах арга замаар сургаал буюу зарчмыг зааж чаддаг болох үед мэдэгддэг. Хүүхдэд Цагаатгалыг ойлгохоор заахад туслах үнэ цэнэтэй эх сурвалж Хүүхдийн Хэсгийн хичээл дээр байдаг зүйрлэл билээ. Энэ нь биднийг энэ чухал сургаалыг ойлгохыг хүсэж буй өөрсдийн хүүхэд, ач зээ эсвэл өөр итгэл бүхий найз нөхдөдөө заахад тусална.

“Замаар явж байсан нэг эмэгтэй өөрөө гарч чадахааргүй нэгэн нүхэнд уначихжээ. Юу ч хийсэн тэр гарч чадахгүй байв. Тусламж дуудахад хажуугаар нь өнгөрч байсан сайхан сэтгэлтэй хүн түүнийг сонсоод нүх рүү шат буулгаж өгөхөд тэр эмэгтэй ихэд баярлажээ. Ингэснээр тэр эмэгтэй нүхнээс гарч эрх чөлөөгөө эргүүлэн олох боломжтой болжээ.

“Бид нүхэн дэх эмэгтэйтэй адил юм. Гэм нүгэл үйлдэх нь нүхэнд унахтай адил бөгөөд бид өөрсдөө үүнээс гарч чадахгүй. Хажуугаар нь өнгөрч байсан сайхан сэтгэлт хүн эмэгтэйн тусламж хүсэн орилохыг сонссонтой адилаар Тэнгэрлэг Эцэг бидэнд аврагдах замыг өгөхөөр өөрийн Цорын Ганц Хүүгээ явуулсан. Есүс Христийн цагаатгалыг нүх рүү шат буулгахтай харьцуулж болно; энэ нь нүхнээс гарах арга

хэрэгсэл болдог.”<sup>10</sup> Гэвч Аврагч шат буулгахаас илүү ихийг хийдэг. Тэр “нүх рүү ороод биднийг аврахын тулд уг шатыг ашиглах боломжийг олгодог.”<sup>11</sup> “Нүхэнд байсан эмэгтэй шатаар авирч гарах ёстой байсан шиг бид хүннээсээ авирч гарахын тулд гэм нүглээ наманчилж, сайн мэдээний зарчмууд болон ёслолуудыг дагаж, Цагаатгалыг амьдралдаа хэрэгжүүлэх хэрэгтэй юм. Тэгээд бид чадах бүхнээ хийсний дараа, Цагаатгал биднийг Тэнгэрлэг Эцэгийнхээ өмнө эргэн очиход зохистой болох боломжийг олгодог.”<sup>12</sup>

Саяхан надад Бурханы хайрт охин, Чили дэх Сүмийн шинэ гишүүн, орчин цагийн анхдагчтай уулзах завшаан тохиолдсон. Тэр хоёр хүүтэй ганц бие ээж. Тэр Цагаатгалын хүчээр өнгөрснөө ардаа орхин Есүс Христийн жинхэнэ шавь болохыг хичээнгүйлэн чармайж байгаа билээ. Түүний тухай бодоход надад Ахлагч Дэвид А.Беднарын заасан зарчим санаанд орж ирдэг: “Есүс Христ дэлхий дээр бидний төлөө үхэхээр ирсэн гэдгийг мэдэх нь нэг хэрэг, учир нь энэ бол Христийн сургаалын үндэс болоод суурь юм. Гэвч Их Эзэн Өөрийн Цагаатгалаар мөн Ариун Сүнсний хүчээр биднийг удирдаад зогсохгүй хүчирхэгжүүлэн бидэн дотор *амьдрахыг* хүсдэгт бид талархах хэрэгтэй.”<sup>13</sup>

Намайг Чили дэх эгчтэй мөнхийн амьдрал руу хүргэдэг зам дээр хэрхэн үлдэх талаар ярьж байхад тэр урамтайгаар энэ зам дээрээ үргэлжлүүлэн байсаар байна гэдгээ батлан хэлсэн билээ. Тэр амьдралынхаа ихэнх үеийг замаас гадуур өнгөрөөсөн бөгөөд амьдралдаа эргүүлж авахыг хүсэхээр нэг ч зүйл замаас гадуурх тэр “хэсэгт” нь байхгүй гэж мэдэгдсэн юм. Цагаатгалын зөвшөөрөгч хүч тэр эмэгтэй дотор байлаа. Энэ нь түүний зүрхэн дээр бичигдэж байна.

Тэр хүч бидэнд хүннээс авирч гарах боломжийг өгөөд зогсохгүй Тэнгэрлэг Эцэгийнхээ өмнө эргэн очиход хөтлөх давчуу бөгөөд нарийн замаар үргэлжлүүлэн явах хүчийг өгдөг.

### **Зарчим 3: Эцэгийн Өөрийн хүүхдүүдэд зориулсан хайрын хамгийн агуу баталгаа нь цагаатгал юм.**

Ахлагч Өүксийн сэтгэл догдлуулам бодлыг эргэцүүлэн бодох нь бидэнд тус болох болно: “Өөрийн Хүүгээ бидний гэм нүглийн төлөө үгээр хэлэхийн аргагүй зовлон шаналыг



туулуулахаар илгээх нь Тэнгэрлэг Эцэгт хэчнээн хэцүү байсныг төсөөлөн бод доо. Хүн тус бүрт зориулсан Түүний хайрын хамгийн агуу баталгаа нь энэ юм!”<sup>14</sup>

Бидний гэм нүгэл, зүрхний шаналал, хувийн амьдралд маань шударга бус санагдах бүхний төлөө зовохоор Өөрийн Төрсөн Ганц, төгс төгөлдөр Хүүгээ илгээсэн хайрын тэр агуу үйлдлийнх нь төлөө бид Тэнгэрлэг Эцэгтээ хандан өвдөг сөхрөн даруухнаар талархан залбирах ёстой.

Ерөнхийлөгч Диетер Ф. Угдорфын нэгэн эмэгтэйн талаар саяхан ярьсныг нь санаж байна уу? “Олон жилийн турш зовлон бэрхшээлийг туулж ирсэн нэгэн эмэгтэй нулимс дуслуулан ингэж хэлжээ, ‘Би өөрийгөө үрчийж, урагдаж, бохирдож, зүй бусаар ашиглуулж мөн толботсон 20-тын доллартай адил болохыг ойлгосон юм. Гэвч би одоо ч гэсэн 20-тын доллар хэвээрээ. Би ямар нэгэн хэмжээний үнэ цэнэтэй. Хэдийгээр их сайхан харагдахгүй, элэгдэж, муудсан хэдий ч би 20 долларын үнэ цэнээ алдаагүй л байгаа’”<sup>15</sup> гэж хэлсэн.

Энэ эмэгтэй өөрийгөө Тэнгэрлэг Эцэгийн хайрт охин бөгөөд Тэрээр Өөрийн Хүүгээ зөвхөн түүнийг хувь хүний хувьд нь цагаатгахаар явуулах хэмжээний үнэ цэнэтэй гэдгээ мэддэг. Сүмийн эгч бүр энэ эмэгтэйн адил Бурханы хайрт охин гэдгээ мэдэх ёстой. Тэнгэрлэг Эцэгт бид үнэ цэнэтэй гэдгээ мэдэх нь гэрээнүүдээ сахиж байгаагаа өөрчлөхөд хэрхэн нөлөөлөх вэ? Түүнд үнэ цэнэтэй гэдгээ мэдэх нь бидний бусдад үйлчлэх хүсэлд хэрхэн нөлөөлөх вэ? Түүнд үнэ цэнэтэй гэдгээ мэдэх нь бидний мэддэг шиг Цагаатгалыг гүн гүнзгий ойлгох хэрэгтэй байгаа тэдгээр хүмүүст туслах хүслийг маань хэрхэн нэмэгдүүлэх вэ? Хүн бүр Цагаатгалын сургаалыг зүрхэн дээрээ гүнзгий бичихэд Их Эзэн Өөрийгөө эргэж ирэхэд биднийг ямар болсон байгаасай гэж хүсдэг шиг тийм хүмүүс болж эхэлнэ. Бид Түүний жинхэнэ шавь гэдгийг Тэр олж харах болно.

Есүс Христийн Цагаатгал бидний зүрхэнд “хүчит өөрчлөлтийг” авчрах болтугай.<sup>16</sup> Бурханы тэнгэр элчийн тунхагласан “агуу их баясгалангийн баярт мэдээ”<sup>17</sup> болох энэхүү сургаалыг ойлгосноор бид хаан Бенжаминь хүмүүсийн мэдэрснийг мэдэрнэ гэдгийг би амлаж байна. Тэд Цагаатгал

тэдний амьдралд хэрэгжихийн төлөө хүчтэйгээр залбирсны дараа, “тэд баяр хөөрөөр дүүргэгдсэн байв”<sup>18</sup> мөн “. . . түүний зарлиглах, бүх зүйлд, түүний зарлигуудад дуулгавартай байж, Бурхантайгаа түүний тааллыг гүйцэлдүүлэх гэрээ хийхэд бэлэн”<sup>19</sup> болцгоосон. Гэрээ хийж, түүнийгээ сахиж мөн түүнд баясах нь Есүс Христийн Цагаатгал бидний зүрхэн дээр үнэхээр бичигдсэний баталгаа болдог юм. Эгч нараа, эдгээр гурван зарчмыг санаарай:

1. “Амьдралд маань шударга бус санагдаж байгаа бүхэн Есүс Христийн Цагаатгалаар зөв болгогдоно.”<sup>20</sup>
2. Бидэнд эгэл эрэгтэй буюу эмэгтэй хүнээ ялан дийлж Есүс Христийн жинхэнэ шавь болох хүчийг Цагаатгал олгодог.<sup>21</sup>
3. Цагаатгал бол Эцэгийн Өөрийн хүүхдүүдэд зориулсан хайрын хамгийн агуу баталгаа юм.

“Гэвч энэ нь тэдгээр өдрүүдийн дараа . . . гэж ЭЗЭН тунхаглаж байна. “Би Өөрийн хуулийг тэдний дотор хийж, зүрхэн дээр нь Би түүнийг бичнэ; Би тэдний Бурхан, тэд Миний ард түмэн болно.”<sup>23</sup> Цагаатгалын эдгээр зарчмуудыг зүрхэн дээр маань бичиж өгөхийг Их Эзэнээс гүйгаач гэж би урьж байна. Би эдгээр нь үнэн гэдгийг гэрчилж байна. Есүс Христийн нэрээр, амен.

#### Эшлэл

1. Сургаал ба Гэрээ 1:38.
2. *Old Testament: Gospel Doctrine Teacher's Manual* (2001), 198.
3. Иеремиа 31:33–34; нэмэлт орсон болно.
4. Жеффри Р.Холланд, “Roundtable Discussion,” *Worldwide Leadership Training Meeting*, 2008 оны 2 сарын 9, 28.
5. *Миний Сайн Мэдээг Номло: Номлогчийн Үйлчлэлд Зориулсан Удирдамж* (2004), 52.
6. Иов 38:7.
7. Даллин Х.Өүкс, “The Challenge to Welcome,” *Лиахона*, 2001 оны 1 сар, 42.
8. Мари Луйс Вокер Моррисын намтар (Линда Кяар Бөртэний эзэмшил дэх хувь).
9. Дэвид А.Беднар, “Цагаатгал ба бидний амьдрал дахь аян,” *Лиахона*, 2012 оны 4 сар, 12–19.
10. *Primary 7: New Testament* (1997), 104.
11. Жозеф Фиелдинг Смит, *Doctrines of Salvation*, нэгтгэсэн Брюс Р.МакКонки, 3 боть. (1954–1956), 1:123.
12. *Primary 7*, 104.
13. Дэвид А.Беднар, *Лиахона*, 2012 оны 4 сар, 14.
14. Даллин Х.Өүкс, “Love and Law,” *Лиахона*, 2009 оны 11 сар, 26.

15. Диетер Ф. Угдорф, "You Are My Hands," *Лиахона*, 2010 оны 5 сар, 69.
16. Алма 5:12–14 -г үз.
17. Мозая 3:3.
18. Мозая 4:1–3 -ыг үзнэ үү.
19. Мозая 5:2–5 -ыг үзнэ үү.
20. *Миний Сайн Мэдээг Номло*, 52.
21. Дэвид А. Беднар, *Лиахона*, 2012 оны 4 сар, 12–19 үзнэ үү.
22. Даллин Х. Өүкс, *Лиахона*, үзнэ үү, 2009 оны 11 сар, 26.
23. Иеремиа 31:33; бичмэлийг нь нэмэв.

# Үүрэг хариуцлагадаа үлэмж сэргэг байх нь

Нийгмийн Халамжийн бүлгийн Ерөнхий  
Ерөнхийлөгчийн Зөвлөлийн нэгдүгээр зөвлөх  
*Кароль М.Стефенс*

---

*Бид сүнслэг байдлын хувьд сэргэг байхад, бид гэр  
бүлүүд болон орон гэрээ мөн бусдад туслах байдлаа  
илүү сайнаар хүчирхэгжүүлэх болно.*

---

Нийгмийн Халамжийн бүлгийн Ерөнхий Ерөнхийлөгчийн Зөвлөлд дуудагдсаныхаа дараа би надаас өмнө үйлчилж байсан эмэгтэйчүүдийн тухай илүү ихийг мэдэхийг хүсч байгаага мэдэрсэн юм. Нийгмийн Халамжийн бүлгийн хоёр дахь Ерөнхий Ерөнхийлөгчийн Зөвлөлийн нэгдүгээр зөвлөх Зина Д. Янг эгчийн заасан зүйлд миний сэтгэл ихэд хөдөлсөн билээ. Тэр хэлэхдээ, “Эгч нар минь, өөрсдийнхөө үүрэг хариуцлагад маш их сэргэг байцгаая.” Бисэргэгболонүүрэг хариуцлагагэдэг үгсийг эргэцүүлэн бодож судраас нэмж хайсан билээ.

Шинэ гэрээн дээр Паул өөрийн өдрүүд дэх гэгээнтнүүдэд заахдаа:

“Цаг үеийг, нойрноосоо сэрэх цаг хэдийнээ болжээ . . . аврал одоо бидэнд улам ойрхон байна.

“Шөнө өнгөрч, өдөр ойртов. . . гэрлийн зэвсгүүдийг агсацгаая.”<sup>2</sup>

Мормоны Номонд Алма өөрийн хүмүүст Бурхантай гэрээнд орж байгаа тэдгээр хүмүүсийн нандин үүргүүдийн тухай заав:

“та нар Бурханы хороонд орж, мөн нэг нэгнийхээ ачааг хөнгөн байж болохын тулд мөн түүний хүмүүс гэж нэрлэгдэх хүсэлтэй байж, үүрэлцэхэд бэлэн байв;

“Тийм ээ, мөн гашуудах тэдний хамт гашуудахад; тийм ээ, тайтгарал хэрэгтэй тэднийг тайтгаруулахад, мөн ямар ч цагт мөн бүх зүйлд Бурханы гэрчлэгч болж, . . .

“Эдүгээ би та нарт хэлнэ, хэрэв энэ нь та нарын зүрхний хүслэн байх аваас, тэр өөрийн Сүнснийг та нар дээр илүү элбэгээр юүлж болохын тулд, та нар түүнд үйлчилж мөн түүний зарлигуудыг дагана хэмээн гэрээ байгуулснаа түүний өмнө гэрчилж, Их Эзэний нэрээр баптисм хүртэхэд юу нь та нарт болохгүй байх билээ?

“Мөн эдүгээ хүмүүс эдгээр үгийг дуулаад, тэд баярласнаас алгаа ташин, мөн ийн хашгирцаав: Энэ бол бидний зүрхний хүслэн билээ.”<sup>3</sup>

Янг эгчийн хэлсэн үг, мөн эдгээр судрын эшлэлүүд намайг бидний энэ өдрүүдэд сэргэг байх ёстой “үүргүүдийн” тухай бодоход хүргэсэн.

Бид баптисм хүртэхдээ гэрээнд ордог. Ахлагч Роберт Д.Хейлс заахдаа, “Бид гэрээнд орж, түүнийгээ сахиснаар дэлхийгээс гарч Бурханы хаант улс руу ордог.”<sup>4</sup>

Бид өөрчлөгддөг. Бид өөр харагдаж, мөн өөрөөр хийж үйлддэг. Бид Бурхантай гэрээнд орж, Түүний охид болсон учраас бидний сонсож байгаа, уншиж байгаа, мөн хэлж байгаа зүйлс ч өөр болдог.

Бид батлуулахдаа Ариун Сүнсний бэлгийг хүлээн авч, биднийг удирдаж, тайвшруулж, мөн хамгаалах Бурхан Тэргүүтний нэг гишүүний байнгын нөлөөг авах эрхтэй болдог. Бид хийсэн гэрээгээ үл ойшоон эргээд дэлхий рүү уруу татагдах үед тэр биднийг сэрэмжлүүлдэг. Ерөнхийлөгч Бойд К.Пакер бидний хэн нь ч “эхлээд Ариун Сүнсний өдөөлтөөр сануулга авалгүйгээр ноцтой алдаа гаргадаггүй”<sup>5</sup> гэжзаасан.

Энэ бэлгийг хүлээн авч, Сүнснийг ямагт хамт байхын тулд бид зохистой байж, зүрхнийхээ нөхцөл байдлыг шалгахдаа соргог байх ёстой. Бидний зүрх зөөлөн байна уу? Бид даруу, сурахад хурдан, номхон дөлгөөн зүрхтэй байна уу? Эсвэл Сүнснээс ирэх тэрхүү зөөлөн өдөөлтүүдээс биднийг сатааруулах дэлхийн тэр дэндүү их чимээ шуугианыг бид хүлээн зөвшөөрснөөр бидний зүрх сэтгэл аажмаар хатуурсаар байна уу?

Биднийг баптисм хүртэхэд, зүрх маань өөрчлөгдөж Бурханы хувьд сэрсэн. Бид мөнх бус амьдралынхаа аялалд хөгжин дэвжиж байх үед, өөрсдөөсөө дараах асуултуудыг тогтмол асууж байх хэрэгтэй. “Хэрэв [миний] зүрх сэтгэлийн өөрчлөлтийг эдэлсэн бол, . . . [би] одоо тийн мэдэрч чадна уу?”<sup>6</sup> Хэрэв үгүй бол яагаад вэ?

Эртний олон гэгээнтнүүд “энэ хүчит өөрчлөлтийг зүрх сэтгэлээрээ эдэлсэн.”<sup>7</sup> Энэ нь тэднийг үүргээ биелүүлэхэд нь хүчирхэгжүүлэх ариун сүмийн адислалуудыг хүлээн авахад сэрээсэн. Науву дахь эртний гэгээнтнүүд баруун зүг рүү аялахаасаа өмнө ёслолуудыг хүлээн авч гэрээ хийхийн тулд “ариун сүм рүү өдөржингөө бүүр шөнө болтол”<sup>8</sup> явж байсан.

Науву дахь Нийгмийн Халамжийн бүлгийн Сара Рич эгч, “Их Эзэний өргөөнд бидний хүлээн авсан адислалууд их байлаа. Тиймдээ ч бид олон зовлон зүдгүүрийнхээ дунд баяр хөөртэй тайван байж, бидний өмнө байгаа үл мэдэгдэх аялалд тэр биднийг удирдаж мөн дэмжих болно гэсэн Бурхандаа итгэх итгэлтэй байсан билээ”<sup>9</sup> гэж хэлсэн.

Аврагчид итгэх итгэлээр өөрчлөгдсөн зүрхтэйгээр мөн Түүний Цагаатгалын хүчээр тэд үйлдэхдээ сэргээсэн. Тэд зүрхнийхээ угаас Гетсемани цэцэрлэгт өөрсдийнх нь төлөө зовсон учраас тэдний хувийн зовлон бэрхшээлийг ойлгодог Аврагч тэдний өмнө байсныг мэддэг. Тэр тэдний айдас, эргэлзээ, өвдөлт, мөн ганцаардлыг мэдэрсэн. Тэр тэдний уй гашуу, хавчлага, өлсгөлөн, гарз хохиролын төлөө зовсон. Тэр эдгээр бүх зүйлсийн төлөө зовсон уу, Тэр тэдэнд, “Эцэж туйлдсан, хүнд дарамт үүрсэн хүмүүс ээ, бүгд Над уруу ир. Би та нарыг амраая”<sup>10</sup> гэж хэлдэг.

Тэгээд тэд ирсэн. Тэд бошиглогчдод итгээд, түүнийг дагасан. Тэд тэдний аялал урт, мөн үүрэг нь хүнд гэдгийг мэдэж байсан. Тэд золиослол шаардагдах болно гэдгийг мэдэж байсан ч итгэлээрээ тэтгэгдэж, өөрсдийн гэрээндээ үнэнч байж мөн сүнслэг байдлаараа бэлтгэгдсэн.

Наувуг орхихоос өмнө бүлэг Гэгээнтнүүд хүчээр явахаас аргагүй болсон ариун сүмийнхээ цуглааны танхимд тэд зурвас үлдээжээ. Үүнд, “Их Эзэн бидний золиослолыг харсан: бидний жишээг дагаарай”<sup>11</sup> гэжээ.

Саяхан би тойргийнхоо залуу эрэгтэйчүүд хийгээд залуу эмэгтэйчүүдтэй анхдагч нарын аялалд оролцсон билээ. Өглөө бүр би өөрөөсөө, “Миний золиослол юу вэ? Би тэдний жишээг хэрхэн дагах вэ?” гэж асууж байлаа.

Аялалын хоёр дахь өдөр, гар тэргээ бараг арвангурван километр түрээд бид “эмэгтэйчүүдийн түрэлт” хэмээн нэрлэгддэг газар ирсэн билээ. Эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээсээ тусгаарлагдаж, эрэгтэйчүүдийг урагш толгодын дээш явуулсан. Гар тэргээ толгод руу түрж эхлэхдээ би хөгшин залуу манай санваартан эрэгтэйчүүд замын хоёр талаар жагсан зогсоод малгайгаа аван эмэгтэйчүүдээ хүндэтгэж байхыг харав.

Зам эхэндээ амархан байсан ч удалгүй гүнзгий элсэнд зоогдож, мөн толгод ч илүү цавчим болж ирэв. Би толгойгоо бөхийлгөөд хамаг хүчээрээ түрж байгаад хэн нэгний угзрахыг мэдрээд харгал манай залуу эмэгтэйчүүдийн нэг, хөршийн маань охин Лекси байхыг харав. Тэр өөрийнхөө гар тэргийг орой дээр нь авааччихаад, бидэнд тусламж хэрэгтэй байгааг хараад, эргээд гүйгээд иржээ. Бид орой дээр гараад, би эргэж гүйгээд өөрийнхөө араас ирэгсдэд туслахыг хүссэн ч амьсгаа маань хэтэрхий дээр гарчихсан, мөн зүрх маань нэг бус удаа санаанд минь *цус харвалт* гэж орж ирсэн тийм их хүчтэйгээр цохилж байв! Би бусад залуу эмэгтэйчүүд гар тэргээ буулгаад бусдадаа туслахаар гүйхийг талархалтайгаар харж байлаа.

Бүгд уулын орой дээр гараад бид хэдэн хором гарган төрсөн сэтгэгдлээ тэмдэглэлийнхээ дэвтэрт бичсэн билээ. Би: “Би өөрийгөө бие махбодын хувьд хангалттай сайн бэлдээгүй учраас өөрийнхөө араас ирэгсдэд туслах хүчгүй байв. Надад дахин хэзээ ч гар тэрэг түрэх хэрэгцээ гарахгүй байж болох ч би эгч нараа сүнслэг байдлаар нь унагахыг хэзээ ч хүсэхгүй байна!” гэж бичсэн юм.

Энэ бол намайг гэр бүл хийгээд бусдад хүлээсэн үүргүүддээ сүнслэгээр сэрээсэн нандин туршлага байсан. Аялалын туршид би сурсан зүйлээ эрэгцүүлэн бодож байсан.

Эхлээд би гар тэргээ ганцаараа *түрж* байсан, одоо *чүргэлжлүүлэн* түрсээр байгаа эгч нарынхаа тухай бодсон. Тэр гар тэргэний хэсэгт байсан эмэгтэйчүүдийн ойролцоогоор 20 хувь нь замын хагаст ганцаараа байсан юм. Эдгээр

эмэгтэйчүүдийн зарим нь гэрлээгүй, зарим нь нөхрөөсөө салсан, зарим нь бэлэвсэн байсан. Олонх нь өрх толгойлсон ээж нар байсан.<sup>12</sup> Тэд бүгд хамтдаа—гэрээт охидууд, хөгшин залуу, амьдралын өөр өөр нөхцөл байдалд байсан ч нэг зам дээр адил зорилгын төлөө түрж байв.

Хэрэгцээтэй байгаа эгч нартаа гүйн очиж тусалж байгаа эгч нар хурдан ажиглаж, хэрэгцээг олж харж, хүрч очоод тусладаг харагддаг буюу харагддаггүй аврагч нарыг надад санагдуулсан юм.

Их Эзэний хэлсэн: “би та нарын нүүрний өмнө явах болно. Би та нарын баруун гар талд мөн та нарын зүүнтээ байх болно, мөн миний Сүнс та нарын зүрх сэтгэлд, мөн миний тэнгэр элчүүд та нарыг дэмжихийн тулд та нарын эргэн тойронд байх болно”<sup>13</sup> гэсэн үгийг би бодож үзсэн.

Замын хоёр талаар жагссан эрчүүд бол итгэлтэй, дуулгавартай, мөн гэрээгээ сахигчид байсан юм. Бурхан Өөрийн хүүхдүүдийг адислахад хэрэглэдэг хүч болох санваарын хүч нь биднийг өргөж, хүчирхэгжүүлж, мөн дэмжиж байлаа. Тэд бол бид хэзээ ч ганцаараа биш гэдгийн сануулга юм. Бид гэрээнүүдээ сахих юм бол энэ хүчийг өөрсөдтэйгөө ямагт хамт байлгаж чадна.

Би аялалынхаа үед гэр бүлээсээ салж тэднийг ганцаарангаар нь тодорхой хугацаанд гар тэргийг түрүүлэхээр орхиж явсан эрчүүдийн тухай бодсон. Олон эрэгтэйчүүд аялалынхаа явцад нас барсан. Зарим хөвгүүд нь өөрсдийн төрсөн нутагт номлолд үйлчлэхээр үлдсэн. Зарим нь гэр бүлүүдээ Солт Лейкийн Хөндийд ирэхэд нь бэлдэхээр эртхэн явсан байв. Зарим нь гэрээгээ сахихгүй байхыг сонгосноор, сонголтоороо байхгүй байв.

Өмнө явсан тэдгээр хүмүүстэй адил өнөөдөр олон хүмүүс төгс биш байдалд амьдарч байна. Бид төгс төгөлдөр байдлыг үргэлжлүүлэн зааж мөн үүнд тэмүүлснээр энэ нь биднийг зам дээр маань хөгжин дэвжүүлсээр “Их Эзэнд найдагчдад”<sup>14</sup> зориулж амлагдсан бүх адислалуудаа хүлээн авах боломжуудад бэлдэх болно.

Бидний хүн тус бүр маань амьдралдаа бэрхшээлүүдтэй учирсаар байх болно. Энэ мөнх бус амьдрал сорилтын цаг бөгөөд бидэнд ирсээр байх бэрхшээлүүдээсээ юу сурснаа



сонгох сонголтоо ашиглах боломжуудтайгаа байсаар байна.

Бурханы охидын хувьд, “мөнхийн гэр бүлийнхээ холбоонд Тэнгэрлэг Эцэгтээ хэзээ нэгэн өдөр эргэн очих хийгээд адислалууд болон хүчээр дээрээс хишиг хүртэхийг зөвшөөрөх Ариун Сүмд хүлээн авдаг авралын ёслолууд нь бидний гаргаж байгаа золиослол бүрийн мөн хичээл зүтгэл бүрийн үнэ цэнэд хүрнэ”<sup>15</sup> хэмээн Ерөнхийлөгч Томас С. Монсоны заасныг мэдсэн учраас итгэлтэйгээр зам дээрээ үргэлжлүүлэх болно.

Зөвхөн аялалдаа гарсан байх нь хангалтгүй юм. Бид үүрэг хариуцлагадаа сэргэг байж, Цагаатгалын тайвшруулагч, хүчирхэгжүүлэгч, боломжийг олгогч, мөн эдгээгч хүчинд ирснээр итгэлтэйгээр үргэлжлүүлэх ёстой юм.

Эгч нар аа, би та нарт хайртай. Би та нарын ихэнхийг нь өөрийн биеэр танихгүй чби *та нарын хэн болохыг* мэднэ! Бид Түүний хаант улс дахь гэрээгээ сахидаг охид бөгөөд гэрээгээрээ дамжуулан дээрээс хишиг хүртэгсэд билээ. Бид үүргээ биелүүлэхээр бэлтгэгдсэн.

Нийгмийн халамж нь эмэгтэйчүүдийг итгэл болон хувийн зөв шударга байдлаа нэмэгдүүлэхэд сүнслэгээр сэргэг байлган мөнхийн амьдралын адислалуудад бэлтгэдэг. Өөрсдөөсөө эхэлцгээе. Байгаа газраасаа эхэлцгээе. Өнөөдөр эхэлцгээе. Бид сүнслэгээр сэргэг байснаар бид гэр бүл, гэр орноо илүү сайн хүчирхэгжүүлж мөн бусдад туслах болно.

Энэ бол авралын ажил бөгөөд Цагаатгалын хүчирхэгжүүлэгч мөн боломжийг олгогч хүч юм. Бид хэн бэ гэдэгтээ сэргэг бай. Үүрэг хариуцлагадаа сэргэг бай. Бид бидэнд хайртай Тэнгэрлэг Эцэгийн охид юм. Би энэ бүгдийг Есүс Христийн нэрээр гэрчилж байна, амен.

#### Эшлэл

1. Зина Д.Х.Янг, in *Woman's Exponent*, 1877 оны 10 сарын 15, 74.
2. Ром 13:11–12.
3. Мозая 18:8–11.
4. Роберт Д.Хейлс, “Modesty: Reverence for the Lord,” *Лиахона*, 2008 оны 8 сар, 21.
5. Бойд К.Пакер, “How to Survive in Enemy Territory,” *Лиахона*, 2012 оны 10 сар, 35.
6. Алма 5:26.
7. Алма 5:14.
8. *Daughters in My Kingdom: The History and Work of Relief Society* (2011), 29.
9. Сара Рич, in *Daughters in My Kingdom*, 30.
10. Матай 11:28.
11. In *Daughters in My Kingdom*, 30.
12. Компанийн жагсаалт болон түүхээс Жолене С.Алфиний

- хийсэн судалгаанаас; *Tell My Story, Too*, 8th -үзнэ үү. (2012).
13. Сургаал ба Гэрээ 84:88.
  14. Исаиа 40:31.
  15. Томас С.Монсон, "The Holy Temple—a Beacon to the World," *Лиакхона*, 2011 оны 5 сар, 92.

# Их Эзэн та нарыг мартаагүй

Линда С.Рийвис

*Нийгмийн Халамжийн Бүлгийн Ерөнхий Ерөнхийлөгчийн  
Зөвлөлийн Хоёрдугаар зөвлөх*

---

*Бидний Тэнгэрлэг Эцэг болон Аврагч Есүс Христ  
маань биднийг мэддэг мөн бидэнд хайртай. . . . Бид  
зовж зүдэрч байхдаа Тэдний хайр болон нинжин  
сэтгэлийг мэдэрч чадна.*

---

Дэлхийн өнцөг булан бүрт байгаа эгч нартайгаа уулзахдаа бид та нарын гэрчлэлийн хүчинд тань гайхан бахаддаг. Та нарын ихэнх нь Сүмийн нэг эсвэл хоёр дахь үеийн гишүүд билээ. Бид олон эгч нар төрөл бүрийн дуудлагуудад үйлчилж, сүмийнхээ цуглаанд оролцохын тулд их холоос явж, ариун сүмийн нандин гэрээнүүдийг хийж мөн сахихын тулд золиослол гаргаж буйг харсан. Бид та нарыг хүндэлдэг. Та нар Их Эзэний орчин цагийн анхдагчид билээ!

Саяхан, миний нөхөр Мел бид хоёр Австралийн нэг музей үзэж сонирхож байхдаа Молли Лентал гэгч сайн дурын нэгэн хөтөчтэй танилцсан билээ. Тэр 70 гаруй насны эелдэг эмэгтэй байсан бөгөөд бид Моллиг хэзээ ч гэрлэж байгаагүй, мөн хүүхэдгүй болохыг мэдэв. Тэр айлын ганц охин бөгөөд эцэг эх нь олон жилийн өмнө хорвоог орхисон байлаа. Түүний хамгийн ойрын хамаатан болох хоёр үеэл нь өөр тивд амьдардаг юм байна. Гэнэт би Сүнсээр дүүрч, яг л Тэнгэрлэг Эцэг өөрөө надад “Молли ганцаараа биш! Молли бол миний охин! Би түүний Эцэг! Тэр миний гэр бүлийн чухал охидын маань нэг мөн тэр хэзээ ч ганцаараа байгаагүй!” гэж Сүнсээр гэрчлэх шиг болов.

Аврагчийн амьдралаас миний хамгийн дуртай түүхүүдийн нэг нь Лазарын түүх юм. Судар бидэнд “Марта, түүний дүү [Мариа] болон [тэдний ах] Лазарт”<sup>1</sup> Есүс хайртай байсныг хэлдэг. Лазар маш их хүнд өвдсөн байна гэсэн үгийг Есүст хүргэсэн ч Есүс тэр даруйдаа ирээгүй. “Энэ өвчин . . . Бурханы Хүү алдаршуулагдахын тулд, Бурханы алдрын төлөө”<sup>2</sup> гэдгийг тунхаглаж болохын тулд Тэр дахин хоёр өдөр байсан газраа үлдсэн.

Есүсийг ирж явааг сонсоод, Марта Түүнд юу болсон тухай дуулгахаар “угтахаар гарав.”<sup>3</sup> Лазар “булшинд дөрөв хоног болсон байв.”<sup>4</sup> Уй гашууд автсан Марта эргэн гэр рүүгээ гүйгээд, Мариад Их Эзэн ирснийг хэлэв.<sup>5</sup> Гүн эмгэнэлд унасан Мариа Есүсийн байсан газар ирж, Түүнийг хараад хөлд нь унан уйлжээ.<sup>6</sup>

Сударт үргэлжлүүлэн “Есүс түүний уйлахыг . . . хараад сүнс нь гүнээ шаналж, сэтгэл нь хөдөлж,” түүнийг хаана тавьсныг нь асуужээ.

“Тэд Түүнд, Эзэн, ирээд, үз гэлээ.”<sup>7</sup>

Тэгээд бид судар дахь хамгийн энэрэнгүй, хайраар дүүрэн “Есүс уйлав”<sup>8</sup> гэсэн үгсийг уншдаг.

Төлөөлөгч Жеймс Е.Талмейж бичихдээ: “Уй гашууд автсан хоёр бүсгүйн . . . дүр төрх Есүсийг [тэдэнтэй хамт] гашуудахад хүргэсэн. Тэгснээр Тэр сүнснийхээ угаас санаа алдаж, гүнээ гашуудсан.”<sup>9</sup> Энэ туршлага бидэнд Аврагчийн нигүүсэл, бусдын зовлонг ойлгодог чанар ба хайрыг гэрчилдэг бөгөөд Тэнгэрлэг Эцэг маань хүн нэг бүрийн төлөө цаг үргэлж бидний өвчин эмгэг, гэм нүгэл, гай зовлон зэрэг амьдралын шаналлуудыг маань мэдэрч байдаг.

Хүндэт эгч нар аа, Тэнгэрлэг Эцэг ба Аврагч Есүс Христ маань биднийг мэддэг мөн хайрладаг. Бид ямар нэгэн байдлаар зовж, шаналж байгааг Тэд мэддэг. Тэд, “Чи одоо шаналж зовж байгаа чинь зүгээр юм аа, учир нь удахгүй бүх зүйл сайхан болно. Чи эдгэрэх болно, эсвэл нөхөр чинь ажилтай болох болно, эсвэл тэнүүлчилж одсон хүүхэд чинь эргэж ирэх болно” гэж хэлдэггүй. Тэд бидний зовлон шаналлыг гүнээ мэдэрч, бид Тэдний хайр болон нигүүлслийг зовж шаналах үедээ мөн мэдэрч чадна.

Алма ийн гэрчилсэн:

“Мөн тэрээр бүх төрлийн өвчин мөн зүдгүүрүүд мөн уруу таталтуудыг тэвчих болно; мөн энэ нь тэр өөрийн хүмүүсийн шаналал мөн өвчнүүдийг өөр дээрээ авах болно гэсэн тэрхүү үг биелэгдэж болохын тулд бөлгөө.

“Мөн тэрээр үхлийг өөр дээрээ авах болно, . . . нигүүлслээр дүүргэгдэж болохын тулд, тэрээр бие махбодийн дагуу өөрийн хүмүүсийг тэдний сул байдлуудынх нь дагуу хэрхэн халамжлахыг мэдэж болохын тулд, тэрээр өөр дээрээ тэдний сул дорой чанаруудыг авах болно.”<sup>10</sup>

Хэрэв бид Аврагч болон Тэнгэрлэг Эцэг маань биднийг мэддэг болов уу эсвэл Тэд биднийг *хэр сайн* мэддэг бол хэмээн бодож байвал бид Оливер Каудерид хэлсэн Аврагчийн үгсийг санах ёстой.

“Үнэнээр, үнэнээр, би чамд хэлнэ, хэрэв чи дахин нэмэлт гэрчийг хүсэх аваас, чи зүрх сэтгэлдээ эдгээр зүйлүүдийн үнэний талаар чи мэдэхийн тулд надад хандан залбирсан тэр шөнийг оюундаа санагтун”<sup>11</sup>.

Аврагч өмнө нь түүнд хандан, “Бурханаас өөр чиний санаа бодол хийгээд зүрх сэтгэлийн тань хүсэл эрмэлзлэлийг мэдэх хэн ч үгүй гэдгийг чи мэдэж болохын тулд”<sup>12</sup> гэж тунхагласан.

Аврагч Оливерт тэрхүү гуйлтын залбирлын нарийн учиг бүрийг, тийм ээ яг хэдэн цагт, яг тэр шөнийг тодорхой мэдэж байгаагаа сануулсан.

Олон жилийн өмнө нөхөр маань маш ховор өвчнөөр ихэд хүнд өвдсөн юм. Өдөр хоногууд өнгөрч, түүний биеийн байдал улам бүр доройтох тусам би түүнийг үхэж байна даа гэдэгт итгэх болсон. Би өөрийн айдсыг хэнд ч хэлээгүй. Бид өнөр өтгөн, залуу гэр бүл бөгөөд мөнхийн гэрлэлт маань хайраар дүүрэн сайхан байсан болохоор нөхрөө алдаж, хүүхдүүдээ ганцаар өсгөх болно гэсэн бодол намайг ганцаардал, цөхрөл тэр бүү хэл уур хилэнтэй болгосон. Би Тэнгэрлэг Эцэгээсээ холдсон гэдгээ хэлэхээс ичиж байлаа. Олон өдрийн турш би залбирахаа больж, төлөвлөхөө больж, уйлсаар өнгөрөөдөг байлаа. Эцэст нь би ганцаараа энэ бүгдийг хийж чадахгүй гэдгийг ухаарсан.

Олон өдрийн дараа анх удаагаа би өвдөг сөхрөн, Түүнээс холдсондоо уучлал эрэн, сэтгэлийн минь гүнд хуримтлагдсан

бүхнээ Түүнд дэлгэн хэлж, эцэст нь хэрэв энэ нь Түүний надаар хийлгэхийг хүссэн тэр зүйл бол би үүнийг хийх болно хэмээн зүрх сэтгэлээ Тэнгэр дэх Эцэгтээ уудалсан юм. Түүнд бидэнд зориулсан төлөвлөгөө байх ёстой гэдгийг би мэдэж байсан.

Намайг өвдөг сөхрөн, хамаг зүрх сэтгэлээ нээж байх тэр үед маш тааламжтай, үнэхээр амар амгалан, энхрий зөөлөн мэдрэмж надад мэдрэгдсэн юм. Яг л хайрын дулаан хөнжлөөр өлгийдөөд авах шиг болж билээ. Энэ нь бараг Тэнгэрлэг Эцэг надад “Би үүнийг л мэдэх хэрэгтэй байсан юм” хэмээн хэлж байгаа мэт байв. Би дахиж Түүнээс хэзээ ч холдохгүй гэж шийдсэн. Нөхрийн маань бие бага багаар сайжирсаар, бүр сайн эдгэрсэн юм.

Үүнээс олон жилийн дараа нөхөр бид хоёр 17 настай охиныхоо хажууд өвдөг сөхрөн, түүний амиийг хэлтрүүлэхийг гуйн залбирсан юм. Энэ удаад хариулт нь үгүй гэж байсан ч Аврагчийн хайр болон амар амгалангийн адилхан мэдрэмж урьдын амласан шигээ хүчтэй байгаад зогсохгүй, хэдийгээр Тэнгэрлэг Эцэг маань түүнийг гэр рүү нь эргэн дуудаж байгаа ч бүх зүйл зүгээр сайхан байх болно гэдгийг бид мэдэж байлаа. Бид ачаагаа Их Эзэнд даатгах гэдэг нь юу гэсэн үг болохыг, Тэр биднийг хайрлаж мөн биднийг гашуудан зовж, өвдөж байхад маань бидний төлөө өрөвдөн энэрч байдгийг мэддэг болсон.

Мормоны Номон дахь эцэг хүү хоёрын хамгийн дур булаам хором бол хүү Хиламандаа хэлсэн залуу Алмагийн гэрчлэл юм. Алма өөрийн хийсэн олон гэм буруутайгаа Бурханы өмнө шүүгдэхээр очихдоо “илэрхийлэхийн аргагүй аймшиг” мэдэрч байснаа дүрслэн хэлдэг. Гурван өдөр мөн гурван шөнийн турш өөрийн хамаг гэм нүглийн талаар бодон тарчилж, зовсны дараа тэр наманчилсан мөн Аврагчийн хамт түүний дээр нигүүлслийг илгээхийг гуйсан. Тэр Хиламанд өөрийн өвчин шаналлаа “цаашид” санахгүй байхын баяслыг “хурц бас амтлаг” байсан хэмээн тайлбарласан. Бурханы сэнтийн өмнө “илэрхийлэхийн аргагүй аймшигтайгаар” ирэхийг төсөөлөхийн оронд Алма “Бурхан сэнтий дээрээ . . . сууж” байгаа үзэгдлийг харж, “Бодгаль минь тэнд байхаар тэмүүлсэн бөлгөө”<sup>13</sup> хэмээн тунхагласан.

Хайрт эгч нар аа, бид нүглээ наманчилж, Тэнгэрлэг Эцэг болон Аврагчийнхаа хайр, энэрэл ба талархлын талаар бодох үед “тэнд байхаар [дэндүү ихээр] тэмүүлж”, Тэдний хайрын тэвэрт дахин нэг тэврүүлсэн мэт санагддаггүй гэж үү?

Их Эзэн надад Өөрийн эрхэм охин Молли Ленталыг мартаагүй хэмээн гэрчилж байсан шиг Тэр *та нарыг мартаагүй* гэдгийг би гэрчилж байна! Ямар ч гэм нүгэл, сул дорой байдал эсвэл өвчин шаналал, сорилт, зовлон бэрхшээлийг туулж байсан. Тэр яг тэр мөчүүдийг мэдэж мөн ойлгодог. Тэр та нарт хайртай! Яг Мариа, Марта хоёрт хийсэн шиг яг л тэр зовлонт мөчид Тэр та нарт туслах болно. Тэр бидэнд хэрхэн туслахаа мэдэж байхын тулд Тэр төлөөсийг төлсөн. Өөрсдийн ачааг Түүнд орхи. Тэнгэрлэг Эцэгтээ юу мэдэрч байгаагаа хэл. Түүнд өөрийн өвчин шаналал, зовлон зүдгүүрийнхээ талаар хэлж, дараа нь тэднийгээ Түүнд үлдээ. Судраас өдөр бүр судал. Тэндээс та нар агуу тайвшрал мөн тусламжийг мөн олох болно.

Аврагч маань ингэж асуудаг:

“Учир нь бүсгүй хүн хөхүүл хүүхдээ мартаж, хэвлийнээсээ унасан хүүгээ тэр өрөвдөн хайрлахгүй байж чадна гэж үү? Тийм ээ, тэд мартаж болох юм, гэвч би чамайг мартаж нь үгүй. . . .

“. . . би та нарыг гарынхаа алган дээр сийлсэн.”<sup>14</sup>

“Мөн би та нарын *хэнийг нь ч* зайлан явахыг та нарт зарлиг болгосонгүй, харин ч эсрэгээр та нар тэмтэрч мөн харж болохын тулд надад ирэхийг та нарт зарлиг болгосон; та нар түүнчлэн дэлхийхэнд үйлдэх болно”<sup>15</sup>.

Энэ бол бидний үүрэг хариуцлага. Бид эхлээд өөрсдийгөө мэдэрч, харсны дараа Тэнгэрлэг Эцэгийн бүх хүүхдүүдэд Тэр зөвхөн бидний гэм нүглүүдийг Өөр дээрээ аваад зогсохгүй, бид юу мэдэрч, өөрсдийгөө хэрхэн тайвшруулахыг Аврагч маань мэдэж болохын тулд бидний өвчин шаналал, зовлон бэрхшээл болоод гомдол цөхрөлийг түүнчлэн авсан гэдгийг мэдэрч, харахад нь туслах ёстой. Би Түүнийг Есүс Христийн нэрээр гэрчилж байна, амен.

#### Эшлэл

1. Иохан 11:5.
2. Иохан 11:4.

3. Иохан 11:20.
4. Иохан 11:17.

5. Иохан 11:28 -г үзнэ үү.
6. Иохан 11:32 -ыг үз.
7. Иохан 11:33–34.
8. Иохан 11:35.
9. Жеймс Е.Талмейж, *Jesus the Christ*,  
3 дахь хэвлэл. (1916), 493.
10. Алма 7:11–12.
11. Сургаал ба Гэрээ 6:22.
12. Сургаал ба Гэрээ 6:16.
13. Алма 36:14–22 үз; нэмэлт орсон  
болно.
14. 1 Нифай 21:15–16.
15. 3 Нифай 18:25; нэмэлт орсон  
болно.



# Халамжлагч

**Тэргүүн Зөвлөлийн Нэгдүгээр зөвлөх**

*Ерөнхийлөгч Хенри Б.Айринг*

*Үйлчлэх чадварынхаа хэмжээг мэдээж авснаар та нар хүчирхэгжүүлэгдэж мөн урамшуулагдах болно.*

Энэ үдэш та нартай хамт байгаадаа би баяртай байна. Есүс Христийн Сүмийн эмэгтэйчүүд нь Бошиглогч Иосеф Смитийн ээж Люси Мак Смитийн: “Бид хамтдаа тэнгэрт байж болохын тулд нэг нэгнээ халамжлан, хамгаалж, тайвшруулж мөн зөвлөгөөг хүлээн авдаг байх ёстой.”<sup>1</sup> хэмээн хэлсний дагуу эгч нарын нэгэн бүлэг болон хөгжиж байна.

Бурхантай хамт аз жаргалтай амьдрахаар зохистой байх тухай энэхүү тайлбар нь гурван хэсгээс бүрдэнэ. Нэгдүгээрт, бие биенээ халамжлах. Дараагийнх нь, бие биедээ зааж мөн бусдаар заалгах. Гуравдугаарт, Бурхантай хамт амьдрах явдал юм.

Энэхүү өндөр зорилгод хүрэхийн тулд бие биедээ туслахаар бидний аль хэдийнэ хийчихээд байгаа зүйлүүдийнхээ төлөө Бурханы талархал, өргөмжлөлийг мэдрэхэд тань туслах нь миний өнөөдрийн зорилго харин дараа нь та нарын хамтын үйлчлэлийн хариуд хойшид ирж болох адислалуудаас заримыг тайлбарлах явдал юм.

Бусдыг халамжлах Их Эзэний дуудлагад та нар эрт үеийн эгч нарын адилаар хариулсан. 1856 онд бошиглогч Бригам Янг уулын цасанд боогдсон гар тэрэгтэй анхдагчдад туслахаар явах уу хэмээн Гэгээнтнүүдээс асуужээ. Тусламж хэрэгтэй болсон үед, тэрээр ерөнхий чуулганы үеэр гишүүдэд хандан: “Хэрэв та нар одоо миний зааж байгаа зарчмуудыг хэрэгжүүлэхгүй бол та нарын итгэл, шүтлэг бишрэл, энэхүү итгэлээ үйл хэргээр харуулдаг байдал тань Бурханы селестииел

хаант улсад та нарын хэнийх нь ч бодгалийг аварч чадахгүй. Хээр талд байгаа хүмүүсийг нааш нь авчир. Мөн та бидний материаллаг зүйлс хэмээн нэрлэдэг тэдгээр асуудлуудыг туйлын анхааралтайгаар шийдвэрлэ . . . Ингэж чадахгүй юм бол та нарын итгэл хоосон үг байх болно.”<sup>2</sup> хэмээн хэлжээ.

Юта мужийн олон зуун эмэгтэй түүний уриалгад хариулсан. Тэд өөрсдөө ядуу байсан ч, гай зовлонд нэрвэгдсэн аялагчдад туслахын тулд боломжтой бүхнээ илүүчилж, бусдаас цуглуулсан эд зүйлсээрээ тусламжийн морин тэрэгнүүдийг дүүргэсэн юм. Тэдгээр зоригт эгч нарын нэг нь, “Амьдралдаа хийж байсан ямар ч зүйлээс би ийм их сэтгэл хангалуун байдал, баяр баяслыг мэдэрч байсангүй.”<sup>3</sup> хэмээн тэмдэглэсэн байдаг.

Анхдагчдыг аварсны дараа, цас хайлах үед тэр эгч: “Үйлчлэх хүсэлтэй хүмүүсийн хийх дараагийн зүйл юу байх бол?”<sup>4</sup> хэмээн чин сэтгэлээсээ асууж байсан гэдэг.

Манай эрин үед, дэлхий даяарх зоригтой эгч нарын бүлгүүд итгэлээ олон зуун газарт үйлдлээрээ харуулсан билээ. Тэд хойшид хийх үйлчлэлийнхээ талаар яг адилхан асуултыг чин сэтгэлээсээ залбиран асуудаг.

Та нар мөнх амьдралд хүрэх аян замынхаа өөр өөрсдийн онцгой шатанд явж байгаа. Зарим нь олон жилийн туршлагатай, харин зарим нь мөнх бус амьдралдаа шавь байх аяныг дөнгөж эхлээд байгаа. Хувь хүний түүх болон түүнд тулгарсан сорилт бэрхшээл болгон өөр байдаг. Гэхдээ та нар бүгдээрээ эгч дүүс бөгөөд та нарыг мэддэг, харж хамгаалдаг Тэнгэрлэг Эцэгийнхээ хайртай охид нь билээ.

Та нар хамтдаа гайхамшигтайгаар бие биеэ халамжилж, хамгаалж, тайвшруулдаг . Нэгэн эгчид айлчлагч багшийн хамтрагч, Ариун Сүнс, нөхөр гурав нь хэрхэн үйлчилсэн гайхамшигийг би нэг сарын өмнө гэрчилсэн юм. Аавынх нь хувьд, айлчлагч багш нарынх нь нэгийг удирдан чиглүүлсэн Бурханд болоод та нартаа би талархаж байна.

Биднээс хол, өөр мужид амьдардаг охин Элизабет маань, гурван настай охинтойгоо хамт гэртээ байжээ. Том хүүхэд нь сургуульд ороод дөнгөж долоо хонож байлаа. Элизабет зургаан сартай жирэмсэн байсан бөгөөд эмч нар түүнийг охинтой болно гэж хэлсэн байв. Тэр охиноо төрүүлэхийг

сэтгэл догдлон хүлээж байлаа. Тэр өдөр нөхөр Жошуа нь ажилдаа явчихсан байв.

Гэтэл тэр цус алдаж байгаагаа мэдээд нөхөр рүүгээ утасджээ. Нөхөр нь түүнд түргэн тусламж дуудах хэрэгтэй тэгээд эмнэлэг дээр уулзъя гэж хэлэв. Эмнэлэг тэдний гэрээс 25 минутын зайтай байдаг байв. Түргэн тусламж дуудахаар утасдахаасаа өмнө, тэр хаалга тогшиж байгааг сонсчээ.

Хаалгаа онгойлоод, айлчлагч багшийн хамтрагч нь ирснийг хараад Элизабет их гайхжээ. Учир нь тэд тэр өглөө уулзахаар цаг товлоогүй байлаа. Харин түүний хамтрагчид Элизабетийн гэрээр нь орж, түүнтэй уулзах ёстой гэсэн сэтгэгдэл төрсөн байжээ.

Тэр түүнийг машинд суухад нь тусалж, хамтдаа эмнэлэг дээр Жошуаг ирэхээс хэдхэн минутын өмнө очжээ. Хорь ч хүрэхгүй минутын дотор эмч нар Элизабетийг нярай хүүхдийнх нь хамт аврахын тулд хагалгаа хийхээр шийджээ. Тийнхүү бяцхан охин төрөх хугацаанаасаа 15 долоо хоног буюу 4 сар шахмын өмнө уйлах дуу хадаан энэ дэлхийд мэндэлсэн юм. Охин төрөхдөө 765 грамм жинтэй байсан ч эх, хүүхэд хоёул эсэн мэнд амаржсан.

Люси Мак Смитийн үгс зарим хэмжээгээр тэр өдөр биеллээ олсон юм. Нийгмийн Халамжийн Бүлгийн нэгэн итгэлтэй гишүүн Ариун Сүнсээр өдөөгдөн, Бурханы хаант улсын нэг эгчээ хамгаалж, халамжилж, тайтгаруулсан ажээ. Сүнсээр өдөөгдсөн үйлчлэлийг үзүүлсэн тэр эгч болон өөр мянга мянган эгч өөрсдийн тусалсан эгч нар болоод тэдний хайртай хүмүүсийн төдийгүй, Их Эзэний талархлыг хүлээдэг.

Өөрсдийн үзүүлсэн нигүүлслийн төлөө бараг анзаарагддаггүй хүмүүст талархсан Их Эзэний үгсийг та нар санаж байгаа: “Тэгэхэд Хаан тэдэнд “Үнэнээр Би та нарт хэлье. Та нар эдгээр ах дүүсийн маань нэгэнд нь, тэр байтугай хамгийн дордод нь тийнхүү хандсан бол Надад хийсэн хэрэг.”<sup>5</sup> гэж хэлэх болно.

Харин Нийгмийн Халамжийн Бүлгийн нэгэн эгч яг хэрэгтэй цагт хүрч ирсэн тэрхүү гайхамшиг нь, эгч нарын нэгдмэл хүч чармайлтаар олон дахин нэмэгдэж болно. Бяцхан охиныг мэндэлснээс хэдхэн цагийн дараа бишопоос нь Элизабет, Жошуа хоёрт илгээсэн захидлын хэсгээс уншъя:

“Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгч бүх зүйлийг зохицуулж байгаа. Бяцхан охиныг эмнэлэгт байх хугацаанд Элизабетийг эмнэлэг гэр хоёрын хооронд хүссэн үедээ явахад нь туслахын тулд бид охидыг чинь харах төлөвлөгөө гаргалаа. Бидэнд өмнө нь иймэрхүү зүйлс тохиолдож байсан бөгөөд бид ийм үйлчлэлийг удаан хугацаагаар ч хийж байлаа. Манай эгч нар ийм зүйл тохиолдоход туслахад үргэлж бэлэн байдаг”

Тэгээд бишоп үргэлжлүүлэн: “Ээж нь бусад хүүхдүүдээ өөр газар орхихыг хүсэхгүй байсан үед бид эмнэлэг дээр очиж, хүүхдүүдтэй нь тоглоомын өрөөнд тоглодог байсан” гэсэн.

Мэдээж та нартай зөвшилцөлгүйгээр бид энэ төлөвлөгөөг хэрэгжүүлэхгүй. Бидний хийж болох зүйлсийн талаар санаа зоволтгүй гэдгийг бид захиж байна” гэж уг захианд дурджээ.

Охины минь төлөө тэдний хийсэн зүйл үрийнхээ зулайг үнэрлэж, цээжиндээ тэврэх тэрхүү өгүүлшгүй сайхан мөчийг түүнд бэлэглэсэн юм.

Их Эзэний төлөө дэлхий даяар бусдад үйлчилж байгаа эгч нарын урам хайрладаг үгээр, “Итгэлтэй байгаарай” хэмээн Жошуа, Элизабет хоёрт захиснаар бишоп нь захиагаа төгсгөсөн байлаа.

Хувь хүн бүрийн нөхцөл байдал, туршлагаас үл хамааран тохиох зарим нэг зүйлсийг би та нарт хэлж чадна. Та нар итгэлтэй байх тусам, та нарт цаг зав муутай мэт санагдах үед чинь Их Эзэн тусламж хэрэгтэй хэн нэгэнд үйлчлүүлэхээр олонтоо дууддагийг та нар анзаарах болно. Энэ нь тааламжгүй, бүр боломжгүй мэт санагдаж болох юм. Мөн үйлчлэх дуудлага ирэх үед та нар хэн нэгэнд хэрэгтэй байгаагаа мэдрэхгүй эсвэл өөр хэн нэгэн тусламжийг нь өгөх юм шиг санагдаж мэднэ.

Их Эзэн бидэнд зовж зүдэрч байгаа нэгэнтэй уулзах боломжийг олгож, бид сайн самари хүнийг хийсэн зүйлийнх төлөө бас хийгээгүй зүйлийнх нь төлөө хүндэлдэг гэдгийг санаарай. Хийгээгүй зүйл нь юу байсан бэ гэвэл үл таних, магадгүй бүр дайсан нь ч байж болзошгүй зодуулж, дээрэмдүүлсэн нэгэн аянчин зам дээр хэвтэж байхад сайхь самари хүн дэргэдүүр нь өнгөрөөгүй юм. Тэр уг зодуулсан хүний төлөө чадах бүхнээ хийсэн ба тэгээд бусдыг түүнд

анхаарал, халамж тавихаар болгосон билээ. Гай зовлонд унасан хүнд туслах нь нэг хүний хийж чадахаас илүүг шаардаж буйг ойлгосон учраас тэр ийнхүү үйлдсэн хэрэг.

Ирээдүйд чинь юу ч тохиолдлоо гэсэн энэ түүхийн сургамж нь та нарыг удирдаж чадна. Та нарын хүүхэд ахуй насанд мөн сүүлийн үеийн туршлагауудад ийм сургамжууд бас байсан.

Ядахдаа нэг удаа, магадгүй үе үе, та нар халамж хэрэгтэй нэгэнтэй дайралдаад яах вэ? хэмээн бодсон байж таарна. Өвчилсөн, тахир дутуу болсон, эцэг эх, өвөө эмээ, дүү, хүүхэд эсвэл ах эгч чинь байсан байж болно. Хүмүүний мөрөөдлийг өрөвч энэрэнгүй сэтгэл чинь ялан дийлсэн юм. Тиймээс чи туслахыг санал болгосон байгаа.

Сайн Самари хүний тухай судрын түүхэн дэх аянчинд тохиолддог шиг, шаардлагатай тусламж нь ганцаараа өгч чадахаас илүү удаан хугацааны халамж болж хувирч болно. Самари хүн аянчинд тавих халамжийг буудлын эзэнд шилжүүлэн өгөх шаардлагатай болсон. Бусдад үйлчлэх Их Эзний төлөвлөгөө нь бүлэг хүмүүсийг бэлдэж өгдөг.

Тусламж хэрэгтэй үед гэр бүлийн гишүүдийг бие биедээ туслахыг бишоп болон Нийгмийн Халамжийн Ерөнхийлөгч нар нь үргэлж урьдаг. Энэ зарчим байгаа нь олон учир шалтгаантай. Хамгийн чухал нь, бие биедээ үйлчилснээс ирдэг хайрын адислалыг илүү олон хүнд эдлүүлэх явдал юм.

Та нар тэрхүү адислалыг ажигласан мөн мэдэрсэн. Та нар хэн нэгэн хүнд богино хугацаагаар ч гэсэн үйлчлэх үед, үйлчилсэн хүнээ хайрлах хайрыг мэдэрдэг. Хэрэгтэй тусламжийг үзүүлэх хугацаа нь уртсах тусам, хайрыг улам ихээр мэдэрдэг.

Бид эгэл хүмүүс учраас, хайрын мэдрэмжинд тань ядарч туйлдсан байдал, сэтгэл санаа өөдрөг биш байх явдал саад болж мэднэ. Тиймээс тусламж хэрэгтэй хүмүүст үйлчлэхдээ бусдын тусламж авах боломжийг Их Эзэн бидэнд олгодог. Тийм учраас Их Эзэн халамж үзүүлэгч хамт олныг бий болгосон билээ.

Хэдхэн долоо хоногийн өмнө ариун ёслолын цуглаан дээр, нэгэн залуухан эмэгтэй айлчлагч багш нарын ажлыг зохицуулагч хэмээх дуудлаганд дэмжин батлуулахаар босох

үед би тэнд байсан. Түүнийг энэ ажилд Их Эзэн дуудаж байгаа нь ямар том хүндэтгэл болохыг тэр эгч ойлгосон гэж би бодож байсан. Хүүхэд нь хөдөлгөөн ихтэй байсан учир, Түүний шавь нарын хичээл зүтгэлийг зохицуулах тусламжинд нь, Их Эзэн түүнд ямар ихээр талархаж, түүнийг хайрлах бол гэдгийг намайг хэлж амжаагүй байтал тэр эгч цуглаанаас гараад явчихсан юм.

Тусламж хэрэгтэй хүмүүсийг халамжлахад баг болж ажиллах олон нийтийн хайр, хүч, дэмжлэг хэрэгтэй. Тэр нь Их Эзэнээс та нарын дунд бий болгож байгаа зүйл юм. Тэр та нарын хийдэг аливаа ажлын төлөө та нарыг хайрладаг.

Үйлчилж байгаа хүмүүсээ илүү ихээр хайрлах боломжийг Бурхан та нарт олгодог. Тийм болохоор удаанаар үйлчилсэн хэн нэгэн чинь насан өөд болох үед та нар уйлж, гашууддаг. Тэднийг халамжлах боломжоо алдсан нь тэднээс түр зуур тусгаарлагдсанаас илүү харамсалтай санагдаж болох юм. Нөхөр нь насан өөд болсон тэр долоо хоногт нэгэн эмэгтэй, нөхрийнхөө амьдралын эцэс болтол нь түүнд үйлчлэх боломжтой байсандаа талархан гэрчлэлээ хуваалцаж байхыг би саяхан сонссон. Тэр эмэгтэй нулимсаа харуулсангүй, харин нүүрэнд нь инээмсэглэл тодорч байлаа.

Хүмүүст удаан хугацаагаар, хайр энэрлийн туслалцааг үзүүлэхэд агуу бэлгээр шагнагддаг ч, бидний бие махбод, сэтгэл санааны дэмжлэг болон санхүүгийн боломж хязгаарлагдмал гэдгийг та нар нар мэднэ шүү дээ. Халамжийг удаан хугацаагаар үзүүлж байгаа хүн нь өөрөө халамж хэрэгтэй хүн болж хувирч болно. Тийм явдал тохиолдвол үйлчилж байгаа хүний тань хэрэгцээ улам нэмэгдэж болох юм.

Тусламж хэрэгтэй хүмүүст агуу Халамж Үзүүлэгч Их Эзэн маань Мормоны Номонд ядарсан тэдгээр халамж үзүүлэгчдийн талаар дараах үгсээр, сүнслэг нөлөө бүхий зөвлөгөө өгсөн юм: “. . . нүглүүдийнхээ ангижралыг хадгалан үлдэхийн төлөө—та нар хүн бүр байгаагийнхаа хэрээр ядуустай хөрөнгөө хуваалцаасай хэмээнэ би, өлссөнийг хооллох, нүцгэнийг хувцаслах, өвчтэйд очиж мөн сүнсийг нь мөн биеийг нь ч аль алиныг нь, хүссэнийх нь дагуу тэднийг асрах зэрэг болой. ”<sup>6</sup>

Өөрийгөө хэтэрхий их шахаж, үйлчлэлээ дэндүү удаан үргэлжлүүлдэг хүмүүст Тэрээр ийн сэрэмжлүүлжээ: “Мөн эдгээр бүх зүйл мэргэн ухаанд мөн эмх цэгцэнд хийгддэг байхыг мэдэгтүн; учир нь хүн өөрт нь буй хүчнээс илүү хурдан гүйх шаардлагагүй. Мөн үүнчлэн, тэрээр хичээнгүй байх шаардлагатай, тэгснээр тэр шагналыг хожиж болохын тулд бөлгөө; тиймийн тул бүх зүйл эмх цэгцэнд хийгдэх ёстой.”<sup>7</sup>

Бусдад туслахын тулд чадах бүхнээ хиймээр байдаг, харин бусдад үйлчлэх хүч чадлаа хадгалж үлдэхийн тулд өөрийнхөө хэрэгцээг шийдэхэд ухаалаг байх гэсэн хоёр зарчмын аль нэгийг сонгох хэрэгтэй үед энэ зөвлөгөөг хэрэгжүүлэх нь бэрхтэй байж болно. Бусдыг ийм сонголт хийх гэж хэцүү байдалд орж байгааг та нар харсан байж магадгүй. Нэг жишээ татвал, насан өндөр болоод байгаа хүнийг асрамжийн газар байлгах уу эсвэл өөрөө ядаргаанд орсон ч гэрт байлгаж асрах уу гэдгийн аль нэгийг сонгох хэрэг гарч болох юм.

Авралын төлөвлөгөөний талаар мэддэг зүйл чинь, тийм хэцүү сонголт хийхэд удирдамж болж болно. Энэ нь, эгч нар “зааварчилгаа авах” ёстой гэж Люси Мак Смит яагаад хэлсэн учир шалтгаануудын нэг юм.

Мөнх бус амьдралын бэрхшээл дунд, Бурханы хүүхэд болгонд Их Эзэн зорилго өгдөг гэсэн бат итгэлтэй байх нь ашиг тустай. Бошиглогч Иосеф Смит өөрт нь төгсөшгүй мэт санагдаж байсан сорилт бэрхшээлүүдийг ойлгохыг хичээж байсан үед нь Их Эзэн түүнд авралын төлөвлөгөөний мөн чанарыг зааж: “Мөн тэгээд хэрэв чи үүнийг дажгүй давбал, Бурхан чамайг тэнгэрт өргөмжлөх болно.”<sup>8</sup> хэмээн хэлсэн билээ.

Хүнд бэрхшээлийг туулж байгаа нэгэнд сайнаар туслах сонголт нь: “Хайртай хүнээ “эцсээ хүртэл тэвчихэд” нь хамгийн сайнаар туслах зам болгон би юуг сонгох вэ?” Тэдэнд амьдралынхаа эцэс хүртэл Христэд итгэх итгэлээ бодитой болгоход, мөнхийн амьдралын төлөөх баттай найдвараа хадгалахад, Христийн цэвэр хайр болох энэрлийг хэрэгжүүлэх боломжтой болгох нь бидний үүрэг билээ.

Хаант улсын эгч нар тэрхүү анхаарлаа Аврагч болон Түүний зорилго дээр тавьж байхыг би харсан. Нийгмийн

Халамжийн Бүлэг, Хүүхдийн Хэсэг, Залуу Эмэгтэйчүүдийн уулзаж байсан өрөөнд тарсных нь дараа орж байсан үеэ бодоод үз дээ.

Аврагчийн зураг эсвэл Түүний үгс хичээл, үйл ажиллагааны үед нүдэнд харагдахгүй байж болох ч, тэр үед Түүний Цагаатгалын бодит үнэн хийгээд үнэ цэнийн тухай гэрчлэлийг хэн нэгэн нь мэдэрсэн гэдгийг та мэднэ. Ариун Сүмийн зураг эсвэл “Тэр бүлүүд үүрд хамт байж чадна” гэсэн үгс харагдахгүй байж болно, гэхдээ та тэдний инээмсэглэлд найдвар байгааг харж чадна.

Мөн ухаалаг айлчлагч багш зүдэрч байгаа эгчид өөртөө итгэх итгэлийг олоход нь тусалж байгааг, түүний өөр нэгэнд үзүүлж байгаа үйлчлэл одоо ч хэрэгтэй, үнэ цэнэтэй болохыг үнэмшүүлж байгааг миний адил та харж байсан байх. Нийгмийн Халамжийн Бүлгийн агуу ерөнхийлөгч нар тусламж хэрэгтэй хүмүүст зориулж бусдыг халамжлахад туслах арга замуудыг олдог. Тэд эгч нартаа Христийн цэвэр хайраар бие биенээ халамжлахын сацуу сорилт бэрхшээлүүдээ амжилттай даван туулах боломжуудыг бий болгож өгдөг. Халамжийг ядартлаа үзүүлж байгаа түүнийг амарч, бусдын тусламжийг авахыг эелдэгхэнээр ятгаж болох юм.

Сорилт бэрхшээлийг даван туулж байгаа хүмүүсийг шүүмжлэхгүй байснаар эгч нар үүнийг боломжтой болгодог. Хүнд ачаа үүрч байгаа хүмүүсийн ихэнх нь өөрсдөдөө болон өөрсдийн үнэ цэнэд эргэлзэж эхэлдэг. Бид тэдний дутагдалд тэвчээртэй хандсанаар мөн тэдэнд харагдаж байгаа сайн зүйлсийг хөхүүлэн дэмжиж, тусалснаар, тэдний ачааг хөнгөлдөг. Их Эзэн ч тийн үйлддэг. Тусламж хэрэгтэй хүмүүст туслах агуу халамж үзүүлэгчийнх нь хувьд бид Түүний жишээг дагаж болох юм.

Есүс Христийн Сүмийн эгч нарын хамтын хүч чадлын талаар бид олонтоо ярьдаг. Аврагчийг урих аваас Тэрбээр үргэлж тэдний дунд байх болно гэдгийг бид мэддэг.

Бурханы охид эгч нарыг өөрсдийн бүлэгт урьж байгааг бид улам ихээр харах болно. Эгч нар цуглаанд орж ирэн, суудал хайж байх үед, “Нааш ирж, надтай хамт суугаач?” гэж эелдэгхэнээр хэлэх үгсийг тэд сонсох болно.



Эгч нар “тэнгэрт хамтдаа сууж байгааг” Люси Мак Смитийн зөгнөн харснаар бид тэдгээр үгсийг ирээдүйн тэр өдөр сонсох болно. Тэр өдөрт бид ганцхан мөчийн дотор бэлдэж болохгүй. Мөнх амьдралын үгсийг зүрх сэтгэлийнхээ гүнд шингээж, бие биеэ халамжлан, цаг хугацааг үдсэнээс энэ нь ирэх болно.

Биднээс олон нь ирээдүйн тэрхүү агуу өдрүүдэд хамт байхын төлөө би залбирч байна. Тэр өдрүүдийн төлөөх найдвар чинь биелэгдэх болно гэж би та нарт гэрчилж байна. Их Эзэн Есүс Христ, Өөрийн төгсгөлгүй Цагаатгалаар дамжуулан үүнийг бидний хүн нэг бүрд боломжтой болгосон юм. Удирдамж болон үйлчлэлээ тэвчээртэйгээр хийх тусламжийн төлөө, итгэлтэйгээр залбирах залбирлыг чинь Тэнгэрлэг Эцэг сонсож, хариулдаг билээ.

Ариун Сүнс та нарт болон та нарын бүрэн сэтгэлтэйгээр үйлчилж байгаа хүмүүст мөн илгээгдсэн. Та нарт хүч чадал өгөгдөх болно. Мөн та нар үйлчлэх чадварынхаа хэмжээг мэдэхэд сүнслэгээр удирдагдах болно. “Би хангалттай зүйлийг хийсэн үү?” гэж та нарыг эргэлзэх үед Сүнс та нарыг тайвшруулах болно.

Их Эзэн тантай хамт байж мөн Түүний хайртай хүмүүсийн хэрэгцээ, сорилт бэрхшээлүүдэд үйлчлэх үйчлэлд тань Түүгээр бэлтгэгдэж, тэмдэглэгдсэн байх боломжийг олгох болно. Есүс Христийн ариун нэрээр, амен.

#### Эшлэл

1. Люси Мак Смит, *Daughters in My Kingdom: The History and Work of Relief Society* (2011), 25.
2. Бригам Янг, *Daughters in My Kingdom*, 36.
3. Люси Мезерв Смит, *Daughters in My Kingdom*, 37.
4. Люси Мезерв Смит, *Daughters in My Kingdom*, 37.
5. Матай 25:40 тодруулга нэмэгдсэн.
6. Мозая 4:26.
7. Мозая 4:27.
8. Сургаал ба Гэрээ 121:8.